



Орчуулсан: Д. Болдбаатар

МӨРӨН ГОЛЫН ШУЛАМ ХҮҮХЭН

Дэд Дэвтэр

ГАРЧИГ

1. НАЙМДУГААР БҮЛЭГ	12
2. ЕСДҮГЭЭР БҮЛЭГ	28
3. АРАВДУГААР БҮЛЭГ	57
4. АРВАННЭГДҮГЭЭР БҮЛЭГ	75
5. АРВАНХОЁРДУГААР БҮЛЭГ	104
6. АРВАНГУРАВДУГААР БҮЛЭГ	133
7. ШИЙДВЭРЛЭХ ТУЛААН	154

Сян дүү минь миний бодлоор багштан агуйн үүдэнд найман хүлсийн нарс суулгасан бололтой. Дотоод бясалгал үйлдэхдээ... гэж И Да Зинг өгүүлтэл:

Бас л тэнэгтэх нь тэр долоон нарс чинь өвөг, үр, ач гээд харсаар байхад гурван үе байхад чинь нэг хүн яахин суулгаж чадах вэ? гэж Жу Сян Зюнь үгийг нь таслав.

Сян дүү минь чи сайн мэдэхгүй байна. Би чинь багаасаа уул хадаар явж ургамал модтой ойр дөт байсан хүн мэдэлгүй яахав. Энэ долоон нарсны нас нь ойролцоо нэг хүн тарьсан байна лээ гэж И Да Зин хэлэв.

<<Тэгвэл яагаад моддын нарийн бүдүүн>> адилгүй байгаа юм бэ? гэж Жу Сян Зюнь асуув.

<<Би ч гэсэн түүний учрыг бодоод бодоод олохгүй байгаа юм. Тэр бидэнд хамаагүй хэрэг. Харин багш агуйн үүдэнд найман хүлсийн нарсуг суулгаснаар найман хүлсийн алхаагаар явж чадахгүй хүн агуйд орж ирэх аргагүй болгожээ. Тэгэхээр миний бодоход найман хүлсийн алхаа Фу Яогийн найман хүлсийн зургийг ухаж ойлгох түлхүүр болох нь. Сян дүү чи эхлээд найман хүлсийн алхаанд суралц>> гэж И Да Зин өгүүлэв.

Тэгээд найман хүлсийн ёсны тухай Жу Сян Зюньд нарийвчлан хэлж өглөө. Жу Сян Зюнь дотоод бясалгалын хүч их сэргэлэн ойтой хүн тул хоёр хоногийн дотор найман хүлсийн алхаа Фу Яогийн зургийн гол учир зэргийг сайтар ойлгож мэдэв.

И Да Зингийн долоон навчит цэцгийн хорны үйлчлэл эхлэхэд ганцхан хоног үлдлээ.

Гэвч тэдний хэн нь ч энэ аймшигт өдрийг дурссангүй амтат яриа дотно үйлдлээ ч умартан мөнөөх эрдэмд суралцсаар байв. Үнэн сэтгэлтэй улс золгүй хувь тавиланг хүлээн зөвшөөрдөггүй. Тэд маргаашдаа найдлага тавьж байв. Учир нь маргааш гэдэг бол ирээдүй юм.

Ирээдүй ямагт сайн сайхан байдагсан.

Тэд урьдын адил ёс төртэй салцгаан өөр өөрсдийн байшинд буцан ирлээ.

Жу Сян Зюнь дээр Цин Тянь Сянь орж ирэв. <<Бидний явуулсан тавин зургаан шавиас тавин гурав нь буцаж иржээ. Бүгд л...>> хэмээн Цин Сянь Тянь айлтгав.

Цин Тянь Сянь үгээ гүйцээсэнгүй Жу Сян Зюнь ч асуусангүй. Бүсгүй тэр тавин гурван хүний дуулж ирсэн мэдээ юу болохыг мэдэж байв. Гэвч тэр итгэл алдарсангүй. Явсан тавин зургаан хүнээс бас гурав нь ирээгүй банья. Тэгээд ч ялалт амжилт голдуу сүүлчийн мөчид шийдэгддэг билээ.

Бүсгүй ганцаар өрөөндөө үлдэхэд ер бусын хоосон зай сэтгэлийг нь эзэмдэх мэт санагдлаа.

Жу Сян Зюнь ертөнцөөс бараг тусгаарлагдмал байдалд өсөж торнисон. Арван найман насыг туулахдаа хүний урманд ганц удаа аглаг уулнаасаа гарч үзээгүй элбэрэл хайр хатуу чанд нь хосолсон багш, хэлгүй дүлий эмгэн асрагч хоёртойгоо л байдаг. Өдөр тутмын хэрэглэх зүйлийг хөгшин асрагч нь олж ирнэ. Тэдний ууланд хааяа нэг үзэгдэх анчныг эс тооцвол эрэгтэй хүний барааг харж байсангүй. Гэвч тэр эзгүй ууланд анчин эр ч гэсэн тун цөөхөн үзэгддэг байсан билээ.

И Да Зин хэмээх гоо үзэсгэлэнт номын эрийг үзээд арван найман жилийн турш хуримтлагдсан өөр хүйстэнд тэмүүлэх хайрын сэтгэл нь агшин зуурын төдийд бургилан гарсан ажээ.

Ёстой л анхны харцнаас дурлана гэгч болжээ. Анхны дурлал маш хурц үнэнч тэсч байхын аргагүй тэсрэх мэт илэрдэг хойно доо.

Гэвч бүсгүй хувь заяа нь түүнийг хайр сэтгэлтэй учруулна гэж зүүдэлсэн ч үгүй явлаа. Орчлон хорвоод ямар нэгэн үл үзэгдэгч гар бүх юмыг зохицуулж хүн зөвхөн түүний аясыг дагаж байдаг мэт санагдана. Бүсгүй долоон сарын долооны өдөр хайр сэтгэлтэйгээ учирчээ. 7 сарын 7-бол үхэрчин хүү, нэхмэлчин бүсгүй хоёрын учирсан хагацсан өдөр билээ. Үхэрчин хүү нэхмэлчин бүсгүй хоёр жилдээ нэг удаа хараацайн гүүрээр дамжин учирдаг гэсэн домогтой. Харин ирэх жилийн 7 сарын битүүнд И Да Зинтэй хамт байж чадах болов уу?

Тал саран мандаж хашаа хорооны доторхи хараахан унтаагүй байгаа ерөөний цонхоор сүүн туяагаа тусгав. Шувууд үүрэндээ үүрэглэж ямар нэгэн бяцхан хорхой ханын буланд дуугарна. Хорхой шавьж намрын сэрүүнд бээрэн шувуудын ядаргаа зүүд нойрондоо мартагдана.

Гэнэт Жу Сян Зюний чихэнд уйтгартай намуухан уйлан гинших мэт лимбэний дуу сонсогдов. Бүсгүй өөрийн эрхгүй даган дууллаа.

Умрыг зорин луут хөлгөөрөө аялана
 Уугуул Дун Тин нуурандаа яахин буцах вэ?
 Алсын сүмбэр оргилыг ширтэн зогсоход
 Аимн сүнс минь мөрнийг даван ниснэ
 Амраг сэтгэлийн минь зорчих зам хол
 Алдрай хүү минь бидний гуниг яасан их вэ?
 Аяга дүүрэн нулимс мэлмий бүрхэж
 Амрагтаа хадгалсан үгээ хэзээ өчих бол?

<<Сян Зюнь>> хэмээх энэ дуу дуусахад Жу Сян Зюний сэтгэл өөрийн эрхгүй оволзон догдолж И Да Зингийн дэргэд хүрч очоод хамаг нандин бүхнээ түүнд өгмөөр санагдав. Маргааш болбол дууслаа гэсэн үг. Харин өнөөдөр эхнэр нөхөр болчихвол насан туршдаа л эхнэр нөхрийн барилдлагатай болно. Тиймээ үхэл хагацал юуны хамаа байх вэ?

Намрын салхин хасын шүүдэртэй учирваас
Насны богино юуны хамаа байна вэ? гэж эртний найраг шүлгэнд өгүүлсэн нь буй.

Бүсгүй өөрийгөө хүчлэн барих тэнхлээ алдаж байшингаас нисэх мэт гүйн гараад И Да Зингийн цонхны модыг тогшвол чимээ алга.

<<Зин ахаа, Зин ахаа>> бас л чимээгүй.

Жигдхэн зөөлөн амьсгаа Жу Сян Зюний чихийг дэлсэв.

<<Зин ах унтчихжээ. Ердийнх шигээ бөх тайван магадгүй амтат зүүдэнд умбан унтаж байх шиг байна>> гэж тэр бодлоо.

Харин Жу Сян Зюнь шөнийн турш дугхийсэнгүй. Үүрээр өндийн босоод И Да Зин дээр очвол тэрээр өрөөндөө алга байлаа. Өрөөний доторхийг цэмцийтэл цэвэрлэж янзлаад ширээн дээр нэгэн бичиг орхисныг үзвэл И Да Зиний бичиг мөн байлаа.

<<Сян дүү минь урьд шөнө нэгэн ид чадалтай хүн над дээр ирж аврахаар боллоо. Эдгэрээд дахин уулзталаа Сян Зюнь дуугаа үлдээе. Зин ах чинь>> гэсэн байв.

Гэнэтийн энэ явдалд Жу Сян Зюнь ихд цочирдсон боловч мөрөн голын гоц хүмүүс хөвөх үүл мэт олон үнэхээр хэн нэгэн ид чадалтай хүмүүн түүнд тусласан байх нь. Санаа сайтай хүний заяа сайн гэдэг. Хувь тавилан И Да Зинг гаргуунд нь хаяагүй бололтой гэж уужрав.

Түүнээс хойш Жу Сян Зюнь арын хадан агуйд очиж Фу Яогийн 8 хүлсийн зургийн дагуу дотоод бясалгал үйлддэг болов. Тэр гурван сарын дотор И Да Зингийн хоёр жилийн дотор олсон чадварыг эзэмшиж амин цэггүй болгох чадвар бүрэлдэж эхэллээ. Зав чөлөөндөө модон махбодийн бүлгийн арга билгийн мунын эрдмийг сургуулилна. Модон махбодийн бүлгийн гол ажлын Цин Сянь Тянь их төлөв шийдэх аж.

Урт өвөл өнгөрч тоорын цэцэгт уулын хавь орчмын цагаан цасыг тоорын цэцэгс орлон эзлэлээ. Үүр гэгээрэхийн үест Жу Сян Зюнь ганцаараа гэрээс гарч арын уулан дахь нууц агуйд ирлээ. Уулын агаар тув тунгалаг чийг ханхална.

Жу Сян Зюний ард холгүй нэгэн бараан дүрс бүртгэнэн сэмхэн дагана. Бүсгүйг уулын оргилд хүрэхийн ялдамд нөгөө бараан дүрс салахгүй дагаж явсаар нэгэн үхэр чулууны араар нуугдан далд оров.

Жу Сян Зюнь долоон нарсны хоорондуур найман хүлсийн алхаагаар явсаар чулуун агуйны үүдээр явж орлоо. Тэр өдөр бүсгүй урьдаас удаан буюу өглөөнөөс үдшийн бүрий болтол бясалгал үйлдсээр арайхийн дуусгаад агуйгаас гарч долоон нарсны зүг их л хүндэтгэлтэйгээр мэхэсхийн ёслоод явж одлоо.

Жу Сян Зюнь уулын агуйгаас салж ядан холдох үед араас нь сэм дагаж явсаар хадны ард нуугдсан хүн гарч ирлээ. Мөнөөх хүн долоон нарсны дэргэд хүрч очоод найман хүлсийн алхаагаар их л сурмаг явж эхэлбэл төдөлгүй өмнө нь агуйн хаалга цэлсхийн...

Хүн гэгч зүгээр сууж чаддаггүй амьтан ажээ. Жу Сян Зюнь угаас хөдөлгөөнтэй цовоо сэргэлэн охин атлаа И Да Зингийн зааж өгсөн амин цэггүй болгогч нууц арганд автан хамаг анхаарлаа төвлөрүүлж байсны хүчинд урт өвлийг хялбархан давж хавартай золгожээ. Одоо тэр чулуун агуйд очих хэрэггүй болсны дээр модон махбодийн бүлгийн ахлагч нэртэй боловч бүлгийн аар саар ажилд оролцох дургүй тул уйтгарлаж эхэлжээ. Цин Сян Тянь хүний байдал төлвийг андахгүй мэдэх нэгэн тул <<Эндээс холгүй

тоорын цэцэгт суурин тун ойрхон байгаа ахлагч та тийш очиж сэтгэлээ зугаацуулахгүй юу?>> хэмээн ятгав.

Энэ үг Жу Сян Зюньд нэгийг бодогдуулж хоёрыг санагдуулсан тул маргааш өдөр нь ганцаар тоорын цэцэгт суурин руу явлаа.

Тоорын цэцэгт суурин энэ нэг жилийн хугацаанд онцын өөрчлөлт үгүй ажээ. Өнгөрсөн нэг жил И Да Зин төлгийн дэлгүүрээ дэлгэж байсан газар Ли Те Коу, Лю Бань Сянь хоёр урьдын адил зогсоцгоож байна. Лю Бань Сянь бүсгүй гэрээ мартсан гэсэр мэт тэр хавьдаа эргэлдэхийг үзээд алга хамтатган өгүүлрүүн <<Бүсгүй чиний царай байдлыг харвал сэтгэлд чинь ямар нэгэн юм бодогдоод байх шиг. Өчүүхэн би мулгуу тэнэг нь хэтэрсэн боловч хэтийн явдлыг төлөгдөж өгвөл ямар вэ?>> гэв.

Миний сэтгэлдээ бодсон явдлыг чи яахин мэдэх билээ?

Бүсгүй минь чиний сэтгэлийн мухар дахь явдал бүхэн нүүрэн дээр чинь бичээстэй байна шүү дээ. Тэнгэрт тэнгэрийн ёсон гэж буй. Хэрэгт өөрийн зүй гэж буй. Хүнд хувь төөрөг гэж байдаг. Мөхөс миний бодоход охин чи хэн нэгэн хүнийг л хүлээж байгаа юм байна даа.

Төлөгч чи харин сонин хүн үү дээ? Хэрвээ чи цааш нь яриад үнэн байх аваас би гар татахгүй. Хэрвээ худал залбал сайхан мэдээрэй...

Лю Бань Сянь залгуулан өгүүлрүүн <<Бүсгүй минь миний төлөгт буусныг үзвэл та нэгэн номын хүнийг мөрөөдөж байгаа юм байна>>.

<<Чи наад төлөгөө л сайн анхаар. Битгий хүний ярианы өнгийг тандаж худлаа залах гээд бай. Та нарын энэ арга залиг чинь би мэднэ>>.

<<Миний төлгөнд бууснаар бол та мөнөөх номын хүнтэй учран золгохын болзоотой. Таны сэтгэлтэй хүн харь газар яваад удтал эргэж ирээгүй юм байна. Та түүний хойноос сэтгэл их зовж байдаг боловч тийн сэтгэлээ шаналгахын хэрэггүй. Эрхэм нөхөр чинь энэ удаагийн явдлаар зам зуур бага сага саадтай байгаа боловч алсдаа аюул гамшиг алга. Номтой багштай учран эрдмийн үйлс нь олз омог ихтэй байна. Удахгүй та сураг чимээ дуулах болно>>.

Лю Бань Сянь нэгэн залуу гоо бүсгүй төлгийн дэлгүүрийн орчим эргэлдэн нүүр царайнд нь уйтгар гуниг хүсэл мөрөөдөл дүүрэн байхыг хараад хайртай хүн нь харь газар явсан болов уу гэж бодсон билээ. Гэвч Жу Сян Зюний өмссөн зүүсэн нь хээнцэр ганган тул баян айлын эрх охин байх магадлал ихтэй гэж бодсон юм. Ийм баян айлын охид том худалдаачин, номын хүний аль нэгний болзоот хүүхэн байхаас зайлбаргүй гэж бодоод

залж орхитол байндаа тусчихжээ. Харин тэр номын багш эрдмийн үйлс олз омогтой гэдэг нь банзандаа ч туссангүй.

Түүний хэлсэн эдгээр үгс зөв ч юм шиг буруу ч юм шиг эргэлзээтэй тул Жу Сян Зюнь өгүүлрүүн <<За чи битгий олон юм бураад байгтун. Миний хүслэнт хүн одоо чухам аль зүгт байна вэ?>>

Лю Бань Сянь хэсэг зуур их л дүрэмдэн төлөгдсөнөө <<Өмнө зүг галд хамаарна. Гал махбодь аргын талд оршдог. Одоо чинь хаврын дэлгэр улирал эрхэм найз чинь өмнө зүгт л...>> хэмээн түүнийг үгээ дуусгаагүй байтал бүсгүй түүн рүү хэсэг мөнгөн зоос шидчихээд эргэн явлаа. Түүний хэдэн сарын турш сэтгэлдээ бугшуулан байсан бухимдлыг Лю Бань Сяний ганцхан үг дэлбэ татан хаяжээ. Өмнө зүг... Өмнө зүг! Төмөр махбодийн толгойлогч Жинь овогт сайн эр Му Дань Ду хатагтай л хорвоод хосгүй хорч төдийгүй хордсоныг тайлах эрдэм ухаанд төгс гэж хэлж байсансан. Тэр авгай чухам л өмнө зүгт мянган газрын чанад дахь мөрний өмнөд этгээдэд байгаа. Юмыг яаж мэдэх вэ? Тэр нэгэн өдөр Зин ах тэнгэрийн тааллаар Му Дань Ду авгай энэ газар хэрэн хэсэж явахтай таараад түүнийг эмчлэхээр аваад явсан байж болох шүү дээ. Ер нь тэгснээс гарцаагүй. Му Дань Ду хатагтай л долон навчит цэцгийн хорыг эс тайлваас өөр хэн дөнгөх билээ дээ?

Жу Сян Знь модон махобдийн бүлгийн хайсанд яаран хүрч ирээд тус бүлгийн аливаа ажил хэргийг Цин Сян Тяньд даалгаж өгөөд арга билгийн мунаа авч өмнө зүгийг орьж их замаар санаа шулуудан алхлаа.

Жу Сян Зюнь гэрээс гарч өдөр шөнийг ялгалгүй явсаар мянга гаруй газар хол замыг зургаан өдрийн дотор туулжээ. Мөрний өмнөд этгээдэд уул ус тэгшхэн эрвээхэй бужигнан цэцэг дэлгэрээд хаврын амьсгаа бүрнээ орсон байлаа. Жу Сян Зюнь танихгүй газарт ганц хүнийг эрнэ гэдэг далайн ёроолоос ширхэг зүү хайхтай ижил гэдгийг өөрийн биеэр мэдэрчээ. Тэр замдаа тааралдсан мөрөн голынхноос Му Дань Ду авгайг сураглахад бүгд л толгой сэгсрэн өнгөрөх ажээ. Му Дань Ду авгай 5 махбодийн бүлгийнхэн шиг нэр цууд гараагүй, тэгээд ч нууцаар бусдыг хорлож явдаг тул өстөн дайсан олонтой. Хаанаас ч ил гарч зориглох билээ дээ.

Нүд ирмэхийн зуур л хагас сар гаруйн хугацаа өнгөрч хэдийвээр мөрний өмнөд нутгийн хаврын үзэмж зүйрлэшгүй сайхан боловч Жу Сян Зюньд түүнийг шохоорхон явах сэтгэл эс төрнө.

Мөрний өмнөд нутагт цайны газар маш олон. Их хөлийн газраа том цайны газрууд хүн ам сийрэгхэн нутагт багахан шиг цайны газар байх ажээ.

Тэр тусмаа хавь ойрд гацаа тосгонгүй гурван салаа замын зөрлөг энэ газар бас нэг өвсөн овоохой бариад цайны ширээ зассан байх нь үзэгдэнэ. Үүдэнд нь ов товхон буурал толгойтой нэгэн авгай суугаад цай зарж байлаа.

Жу Сян Зюнь энэ өдөр их л яаравчлан явсан тул ам ихэд цангаснаа сая л мэдэж цайны газрын зүг явж очлоо. Настай авгай зочин ирэхийг үзээд хичээнгүйлэн тосож очоод <<Охин минь цай уух нь уу хөгшин би дээд уруулдаа хүргэмгүй <<Луугийн худаг>> хэмээх цайг чанчихаад хүлээж сууна. Амсаад үзвэл ямар вэ?>> гэв. Жу Сян Зюнь аяны богцоо тайлж ширээн дээр тавиад арга билгийн муныг авч <<За>> гэлээ.

Авгай нүүр дүүрэн мишээл гэрэлтүүлж гялалзтал арчсан зэс данхаа зуухан дээрээс авч Жу Сян Зюньд цай аягалж өглөө. Жу Сян Зюнь амсч үзвэл аргагүй л анхилуун үнэр нь хамар амаар сэнгэнэсэн сайхан цай ажээ.

<<Сайхан цай байна>> гэж Жу Сян Зюнь магтлаа.

<<Охин чи аргагүй л юм мэддэг хүүхэд байна. Амсангуутаа цайны амтыг таньж байна шүү. Ертөнцийн ногоон цайны дундаас <<Лууны худаг>> л хамгийн алдартай нь даа. Борооны улирлын өмнө хураасан Луугийн худаг буюу чиний саяын амссан цай бол хамгийн үнэтэй>>.

Жу Сян Зюньд мөнөөх авгайн байдал төлөв яриа хөөрөө эгэл хүмүүн биш юм шиг санагдсанд өөрийн эрхгүй царай зүсийг нь гүйлгэн харлаа. <<Хөгшин би найман наснаасаа цайны газарт ажиллаад өнөө хир тавь шахам жилийн нүүрийг үзэж байна. Цай бэлдэх дэг ёсны талаар чамгүй зүйл сурсан>> хэмээн авгай инээх үед нүүр царай нь жавхаажин духны хэдэн үрчлээс нь алга болоод туйлын энэрэл буянтай харагдах ажээ.

Жу Сян Зюньд өөрийн эрхгүй сонирхол төрж <<Авгай таньд өөр сайхан цай байна уу? Чанаад ирэх аваас ахиу мөнгө өгнө шүү>> гэлээ.

Охин минь чи манай цайны газрыг өнгө зүс муутай гэж бүү голоорой. Харин газар газрын сайн цайнууд бага сага бий шүү. Хэрвээ чи эс голох аваас би одоохон чанаад болгоё.

<<Цайны ёсонд чинь анхны аягыг амсдаг, дараагийн аягыг уудаг, гурав дахь аягыг уувал...>> хэмээснээ <<Илжиг болдог>> гэсэн үгийг хэлсэнгүй Жу Сян Зюнь тачигнатал инээлээ.

Авгай ч мөн дагаж инээгээд <<Юу гэсэн үг вэ? Охин минь цай болгоны төрлөөс амсаад өнгөрвөл болох нь тэр. Цайнд чинь ганцхан навч цэцэгээс гадна чанаж байгаа ус их учиртай байдаг юм. Хөгшин би золоор тунгалаг булгийн ус бараадуулан энэ цайны газрыг байгуулсан. Эзгүй зэлүүд энэ газар охин чиний адилаар цайны дэг ёсыг мэддэг ойлгодог эрхэм

зочин ховор ирэх юм даа. Хөгшин би тань мэтийн эрхэм зочинтой учрах үед баримталдаг зарчим болбоос цайны мөнгө ганц улаан зоос авахгүй. Харин надад байгаа нэр цуутай цай бүхнээс амсаж үзсэний дараа сая салах ёс гүйцэтгэнэ гэж тангараг тавьсан юм. Бүсгүй чи сууж бай. Би шинэ ус авчираад сайхан цай чанаж чамд амсууламз>> хэмээн түүний хариу хэлэхийг хүлээлгүй өвсөн овоохойноос гарч жижиг данхтай ус авчиран зуухан дээр тавьлаа. Тэр өчүүхэн данхтай усыг өргөхийн зуур аахилан амьсгаадахыг үзээд Жу Сян Зюньд түүнийг өрөвдөх сэтгэл төрж ширээн дээр нэг ширэхг мөнгөн зоос орхиод <<Авгай та цайны мөнгөө ав>> гэлээ.

Авгай түүнд мөнгийг нь буцааж өгөөд <<Хөгшин би мөнгө хэрэггүй гэсэн бол авахгүй. Харин би чамд цай буцлах зуур энэ тэрийг ярьж өгч болох юм. Чиний аялгууг сонсвол харь нутгийн хүн шиг байна>> гэлээ. Жу Сян Зюнь толгой дохилоо.

Охин минь чи хэрэг зориг юунд вэ?

Хүн хайсан юмаа.

<<Чиний байр байдлыг ажваас эрсэн хүнээ олоогүй юм шиг байх шив. Хэдийгээр энэ газар эзгүй зэлүүд боловч тав гурван харийн зочин гийчин үүгээр дайран хойш урагшаа явж л байдаг юм. Тэгэхээр би чиний эрсэн хүнийг гадарлаж болох юм шүү>> гэмээн авгай өгүүлэв.

Цайны газрынхан гэж угаас урт чихтэй улс байдаг хойно Му Дань Ду хатагтайн талаар энэ хүн мэдэж магадгүй юм хэмээн Жу Сян Зюнь бодоод <<Авгай би мөрний өмнөд нутгийн Му Дань Дугийнхийг хайсан юм>> гэлээ.

Авгай цочих шиг болсноо <<Чиний хайсан тэр Му Дань Ду хатагтайныг мэднэ шүү>> гэлээ.

Жу Сян Зюний сэтгэлд итгэл найдварын оч улалзан <<Авгай тэр Му Дань Ду хатагтай чинь ямархуу хүн байна дээ?>> гэж яаран асуулаа.

Тэр бол дөч гаруй насны туйлын үзэсгэлэн төгс хорвоод хосгүй баян хүн бөлгөө. Харин бусдын ярихыг сонсвоос хор хэрэглэхдээ гарамгай тул түүнтэй учирсан хүн эрлэгийн элчийн гараас мултрахгүйтэй ижил гэлцдэг хэмээн авгай өчив.

Жу Сян Зюнь өөрийн эрхгүй ухасхийн босоод тэсгэлгүй баярласандаа авгайн гарыг шүүрэн авч <<Тэр чинь яг мөн байна>> гэлээ.

Ёо ёо хэмээн авгай дуу алдан орилоход Жу Сян Зюнь сая л нэг сэхээ орон авгайн гарыг нь өвдтөл базсанаа сулруулан тавиад харваас авгайн гар дээр таван хурууны ор гарсан үзэгдэнэ. <<Авгай минь уучлаарай намайг>> гэж тэрээр аргадлаа.

Авгай гараа амандаа ойртуулж удтал үлээснээ <<Охин минь гар чинь яасан их хүчтэй байна>> гэлээ.

<<Авгай танаас нуух юу байхав. Би бол модон махбодийн бүлгийн толгойлогч Жу Сян Зюнь байна. Хэрэв танд тааламжтай байвал намайг дагуулаад Му Дань Ду хатагтайнх руу аваачиж өгөхгүй юу? Би танд хүссэн хэмжээний мөнгийг чинь өгье>> гэлээ.

<<Чи түүнтэй уулзаж яах гэсэн юм бэ?>>

<<Миний нэг найз 7 навчит цэцгийн хоронд хордсон юм. Тэгээд түүнээс аврал эрж яваа юм л даа>> гэв.

<<Журамт бүсгүй Жу минь ертөнцөд Му Дань Ду авгайгийн эдгээж чадахгүй хор гэж үгүй. Тэр лав эдгээж дөнгөх нь гарцаагүй>>.

<<Авга минь тэгвэл бид явцгаая>> хэмээн Жу Сян Зюнь бослоо.

Тэгтэл авгай огт хөдөлсөнгүй. Зуухан дээрхи жижиг данхтай цайгаа гөлрөн суух ажээ. Данхтай ус буцлан цагаан уур савсуулах бөгөөд данхны таг нь доргин дуугарна.

Хоёр дахь удаагаа оргиллоо. Одоо нэг буцалчихвал ч сайхан цай болно доо хэмээн амандаа үглэв.

<<Авгай минь бид эртхэн хөдөлвөл яасан юм бэ?>> гэж Жу Сян Зюнь хэллээ.

<<Ганц хоёр хором хүлээхэд цаад хүн чинь амь тавьчихгүй биз дээ. Ийм сайхан цайг амсахгүй явна гэдэг чинь амны хишигээ гээх байгаа даа>> гэж хэлэх зуур түүнд буцалсан цайгаа аягалан өргөн барилаа.

Жу Сян Зюнь цайг тосон авахынг зуур авгайн нүдэнд муу санаа атаа хорслын бараан сүүдэр үзэгдэх шиг болоход даруй түүний аягатай гарыг шүүрэн авч амин судлыг атгаж авлаа. Авгайн гар амин судлаа атгуулсан даруй аягатай цайгаа алдан асгалаа.

<<Чи чухам ямар учиртай хүн бэ?>> хэмээн Жу Сян Зюнь уурсан асуулаа.

<<Муу хар шулам эм чи миний хөлийн угаадсыг ууснаа мэдэж байна уу?>> хэмээн авгай алгуур атлаа туйлын ёжтойгоор инээлээ.

Жу Сян Зюнь түүний бугуйг улам чанга атгаж <<Чи чухам юун хүн бэ? үнэнээ эс хэлвээс би чиний амин судлыг тас атгалаа шүү>> хэмээн хашграв.

<<Чаддаг юм бол чи тэг л дээ. Ертөнцөд хорч Му Дань Дугийн амин судлыг тас атгадаг хүн байдаг юм уу?>> гэж авгайн инээхэд

Жу Сян Зюнь тэсгэлгүй уурлан түүний бугуйг хүчлэн атгаваас авгай жишим ч үгүй байх агаад харин өөрөө ухаан алдан унав.

Тэр төдөлгүй сэргэн үзвээс сүрэл дэвсгэр дээр хэвтэж байх ажээ. өрөөнд тас харанхуй түүний хамаг бие хүчгүй атлаа өвдөж зовох юм үгүй байгаа тул ямар ч байсан гадуур шарх аваагүй бололтой.

Тэр хорджээ! Чухам юунд хордсон байх вэ? Тэр хайртай хүнаа хайж явсаар мөрний өмнөд нутаг дахь Му Дань Ду авгайн гэрт ирээд цайнаас нь ууж хордсон хэрэг байх нь. Энэ энэрэнгүй сайхан царайтай авгай яахаараа түүнийг хордуулдаг билээ. Яриа хөөрөө үйл хөдлөл нь соёлтой ийм хүн муу санаа агуулж байдаг байх нь байна шүү. Бүсгүй багшаасаа холдон явахын өмнө тэр нэгэн шөнө <<Чи ертөнцийн хүний үнэн үгийг худал, худал үгийг үнэн гэж бодож яваарай>> гэж багш нь хэлж байсансан. Үнэхээр ч багшийнх нь хэлдэг үнэн байжээ. Жу Сян Зюний дотор харуусал хорсол зэрэгцлээ. Тэр мөнөөх авгайг харсан даруйдаа л алах хэрэгтэй байв. Юунд түүний худал үгийг итгэж сонсов оо. Тэр авгай өөрийгөө ухаан алдахын нь өмнө хорч Му Дань Ду гэж хэлсэн. Тэгэхээр би түүний хорлолд автжээ.

Авгай түүний сэргэснийг мэдээгүй бололтой. Ямар нэгэн юмыг шир ширхийлгэн оролдоно. Өвсөн овоохойд өтгөн утаа баагьж толгой эргүүлэн нойр хүргэх боловч ер бусын анхилууун үнэртэй ажээ.

<<Ээжээ та энд юугаа хийж байгаа юм бэ?>> хэмээн овоохойн гаднаас нэгэн залуухан охины дуу сонсогдлоо. Тэр даруй гэрэл гялсхийн овоохойд нэгэн охин орж ирэлээ.

Жу Сян Зюнь амьсгаа даран хүлээв.

<<Цин Ся хэрвээ чи намайг дахин ээжээ гэж дуудах юм бол би үнэн голоосоо уурлана шүү. Чи Му Дань Ду хатагтай охин ээж чинь намайг тоож шавь оруулсан байхад би улам даварч чам шиг охинтой болъё гэж яахин зориглох билээ>> хэмээн авгай уурсав.

<<Ганц өдрийн багш насан туршийн ээж минь билээ та миний хувьд юу ч гэж дуудсан ялгаагүй>> гээд охин инээв. Энэ хорчийн шавь өдийд ирдэг нь юу ч билээ дээ хэмээн бодож байсан Жу Сян Зюний дотор түүнийг Му Дань Ду хатагтайн охин гэдгийг дуулаад итгэл найдвар төрөв.

<<Шавь минь чи цаад дэвсгэр дээр хэвтэж байгаа гоо охиныг хараач. Тэр Му Дань Ду хатагтайн гэрт очиж хорны ерөндөг гуйх гэж яваа юм байх. Гартаа бас нэг арга билгийн муна барьчихаж. Тэгэхээр нь би миний шавиас өөр охин тийм үзэсгэлэнтэй атлаа арга билгийн муна хэрэглэж яахин болох билээ гэж санаад түүнийг муужруулчихаад байна>>.

Арга билгийн муна гэнээ багшаа тэр чинь ямар хорны ерөндөг авах гэсэн юм бол оо? Хэмээн нөгөө охин их л гайхширан асуулаа.

Тэр 7 навчит цэцгийн хорны ерөндөгийг авах юм байх. Танай ээж чинь миний найруулсан 7 навчит цэцгийн хорыг эмчилж чадах юм болов уу даа? Үзээд алдъя... хэмээн авгай хэллээ.

<<Багшаа та түр азнаж бай. ямар амьтан баавгайн зүрх, барсын цөс идчихсэн болоод хорч Ду авгайг зорьж ирдэг билээ. Шавь нь эхлээд нэг хараадахъя>> гээд охин сийрсэн дэвсгэрийг чиглэн ирлээ.

Жу Сян Зюнь амьсгаа хураан хүлээлээ. Охин тосон дэн барьсаар дэвсгэрийн өмнө хүрч ирээд гэнэт хүйтнээр инээх дуу алдаж <<Битгий маяглаад байж үз Жу Сян Зюнь минь нүдээ нээгээд хар даа>> гэв. Жу Сян Зюнь нүдээ нээн харвал өмнө нь модон махбодийн бүлгийн толгойлогч асан Му Цин Ся зогсож байлаа. <<Ёстой л өст хүн өлийн даваан дээр гэгч боллоо доо. Жу Сян Зюнь минь ийм нэг өдөр ирдэг байжээ>> хэмээн Му Цин Ся ёстой инээжээ.

ХУЛСАН ЛИМБЭНИЙ АЯЛГУУН ДАХЬ МЯНГАН ГАЗРЫН ЗҮҮД ХЭМЭЭХ НАЙМДУГААР БҮЛЭГ

И Да Зин тэр орой хэнтэй ч учирсан юм бахйгүй гав ганцаар модон махбодийн бүлгийн хайсангаас гарч холдон явжээ.

Эдгэрэх найдлага алга болсон тул Фу Яогийн 8 хүлсийн зургийнучрыг Жу Сян Зюньд талйлбарлаж өгөөд санаа амарч модон махбодийн бүлэг Жу Сян Зюнь болон хүний орчлонтой салах ёс гүйцэтгэхээр шийджээ. Тэр хорын үйлчлэл эхлэхээс өмнө явах ёстой. Хэрвээ 7 навчит цэцгийн хор үйлчлээд эхлэх юм бол 7 сүв нь илжирч аажмаар ясандаа хүртэл идэгдэж явсаар үхдэг билээ. Тэрбээр хайртай хүнээ ийм гутамшигтай юм бүү үзээсэй гэсэндээ явах ёстой. 7 сүв нь илжирээд ойртохын аргагүй үмхий самхай ханхалж тэсвэрлэхийн аргагүй өвдөх болно. Голын хайртай хүндээ тийм гутамшигийг харуулж яахин болох билээ? Тийм учраас тэр цаасан дээр хэдэн үг биччихээд амар тайван газар үхлээ хүлээхээр шийдсэн юм. <<Урьд шөнө мөрөн голын чадалтантай учирлаа>> хэмээсэн бичиг үлдээсэн нь Жу Сян Зюньд бяцхан найдлага үлдээж үхсэн хойно нь ч гэсэн түүнийг хүлээх болно. Цаг хугацаа гэдэг бол удах тусам хүний зовлонг нимгэлэх чадалтай. Жил сар өнгөрөх тусам Жу Сян Зюнь түүний үхсэнийг ойлгож зовлоноо

аяндаа мартаж болно гэж тэр бодсон билээ. Сарны туяан дор хөнгөний тамираа хэрэглэн замын бартаа зүг чигээ ялгалгүй нисэх мэт хурдалсаар 100 гаруй газар замыг тун хурдан тууллаа. Үүрийн гэгээ тэмдгэрэх үест тэнгэрийн хаяа зугуухан ягаарч аажимдаа шаргалтсаар гал улаан наран цухуйлаа. Ургах нарны аясаар түмэн бодис сэргэж амьдралын үнэ цэнийг түүнд улам ихээр ойлгуулав. Тэр өдий олон жил хээрээр гэр хийж хэцээр дэр хийн явахдаа өнөөдрийнх шиг ингэтлээ амьдралын үнэ цэнийг мэдэрч байсан нь үгүй билээ.

7 навчит цэцгийн хор өнөөдрөөс эхлэн үйлчилж эхэлнэ. И Да Зин хорвоод 20 гаруй жил наслахдаа бусдад хор хүргэж явсангүй. Үхэвч санаа амар байх ажээ. Энэ богинохон насандаа Жу Сян Зюнь хэмээгч гоо бүсгүйн хайрын сайхныг амталж үзлээ. Одоо үхсэн ч юунд харамсах билээ.

Үнэхээр хоргодох юм үгүй гэж үү? Гэвч түүний сэтгэлийн мухарт бүдэгхэн харуусал салахгүй эргэлдэнэ. Дээд тэнгэр түүнийг ийм залуугаар нь нас нөгцөөх байсан юм бол Жу хүүхэнтэй учруулах хэрэг юу байв аа.

Энэ бүхнийг эргэцүүлэн бодох зуур түүний сэтгэл зүрх өмрөн унах мэт санагдана. Түүнийг эргэн эргэн харсаар холдох тусам бүсгүйн сэтгэл түүнийг улам ихээр үгүйлэн санаж байгааг тэрээр мэдэж байлаа. Тэр хулсан лимбээ гаргаж ирээд <<Сян Зюнь>> ахэмээх аялгууг тоглож эхлэв. Тэр аялгуу дуундаа хамаг бодол санаа сэтгэл зүрхээ шингээгээд тоглох зуур хэн нэгэн хүн түүнтэй хоршин дуулахыг анзаарсангүй. Тэр аялгууг тоглож дуустал цаад бүсгүйн дуу хоолой уул талаар цуурайтан сонсогдсоор байх тул И Да Зин сая л сэхээ авч ухасхийн босоод <<Сян дүү минь ээ>> хэмээн хашгирав. Гэвч хэн ч хариу эс дуугарах ажээ.

И Да Зин ухасхийн гүйсээр арав гаруй газар зам туулбал өмнө нь нэгэн бумбын ёсны гэлэнмаа хувцастай эмэгтэй хүн цааш явж байх үзэгдэнэ. И Да Зин түүн рүү дөхөж очоод <<Өршөөгөөрэй. Би таныг үймүүлчихэв үү дээ?>> гээд буцаад явах гэтэл цаад гэлэнмаа авгай нь <<Зогс>> хэмээн захирангуй дуугарахад түрүүчийн дууны уян налархай өнгө аяс өчүүхэн төдий ч үгүй ажээ. Гэвч тэр авгай эргэж харсангүй. Үсэнд нь алаг цоог мөнгөн сор суусан үзэгдэнэ. И Да Зин түүн рүү мэхэсхийн ёслоод эрхэм та юу гэх гэсэн бол хэмээн асууваас <<Чи муу балай эр Сян Зюнь дууг аялах ямар эрхтэй билээ>> хэмээн гэлэнмаа авгай зандран асуулаа. Хятадын эртний аялгуу Сян Зюнь хэдэн зуун жил үе улиран ирсэн хэн ч тоглож болох эрхтэй биз дээ. Ёстой түрэмгий хүн юм гэж бодсон боловч

түүнтэй үг сөргөх хүсэл байсангүй. <<Хэрэв таньд захиж хэлэх юм үгүй бол би ингээд явахаас даа>> гэв.

<<Чи миний хэлснийг тоомсорлохгүй байх шив дээ>> асуултанд тодорхой хариулахгүй бол чи явах гээд үз л дээ гайгүй гээд гэлэмаа авгай ёстой инээв.

И Да Зин түүнтэй үг сөрөхийг бодсонгүй арагш эргэн явахаар завдвас цаад хүмүүн ардаа нүдтэй мэт эргэж ч харсангүй нэгэн оосортой тоосны гүвүүрийг мөрөн дээгүүрээ арагш шидвээс И Да Зингийн хоёр хөлийг ороон авлаа. Түүний ийм хурдан хөдлөхийг нь үзвээс зэвсгийн эрдэм огтхон ч чадахгүй И Да Зин байтугай тэргүүн зэргийн гарамгай баатар эр ч бултаж зайлахад нэн бэрхтэй бизээ. Мөнөөх тоосны гүвүүр И Да Зингийн шагайг баглан авлаа. Түүний нэгэн үзүүр нь махан нүдээр бараг эс харж чадахаар нарийхан төмөр утсаар холбогдсон агаад тэр хүн гараа ялимгүй өргөтөл И Да Зин газар харуулдан ойчлоо. <<Авгай та яасан ёсгүй хүн бэ? Би өөрийнхөө лимбийг үлээх танд ямар хамаа байна вэ? Сонсох дургүй аваас чихээ бөглөчихвөл болох биш үү? Гэтэл учир зүггүй гэмгүй хүнийг зодоод байдаг нь ямар учиртай юм бэ?>> хэмээн И Да Зин сандран өгүүлэв.

<<Аа чи бас намайг хараан зүхнэ үү? Аминаасаа уйдсан хүн үү чи?>> хэмээн гэлэнмаа авгай асуулаа.

<<Мөхөс би ном эрдмийн мөр хөөсөн хүн. Яахин таныг харааж зүхэж чадах билээ?>> хэмээн И Да Зин гайхширан өгүүллээ.

<<Аа чи намайг хүний хэлсэн үгийн учрыг ойлгохоо больсон амьтан гэж бодоо юу? Чихээ бөглөөд явж байг гэдэг чинь юу гэсэн үг вэ? Ёстой уур хүрмээр золиг юм>>.

Хэдийгээр гэлэнмаагийн хэлсэн үг ихэд этгээд инээдэмтэй мэт санагдавч өөрийнх нь хэлсэн үгэнд бас ч гэж хатуу утга байсны сая олж анзаараад <<Авгай та өчсөнд үгэнд минь өө ярьсан үгэнд минь ял зэм байх аваас өршөөн соёрхоно уу?>> гээд ухасхийн ёслохыг завдтал гэлэнмаа авгай утасны үзүүрийг дахин татвас И Да Зин хяргуулсан сонгино мэт налмагнан уналаа.

<<Авгай минь би таны өмнө сөгдөн мөргөж өршөөлийг эрье>> гээд И Да Зин гашуунаар инээвхийлэхэд

<<Би чамайг тавиад явуулахад бэрх биш. Харин чи надад алдар нэр саяын хашгирсан Сян Зюнь дүү минь гэдэг чинь ямар учиртай хүн болохыг хэлж өгвөл барав. Хэрэв гэжөөд байх юм бол Хн...>>

<<И Да Зингийн бардам сэтгэл гэнэт оргилон хөөрч хэрэв чи надаас сайтар гуйх юм бол ганц хоёр юм хэлж өгч болох юм. Харин ингэж хатуурхаад байх юм бол Хн...>> хэмээн аман дотроо бувтналаа.

Өөрийнх нь хэлсэн аялгууг дууриаж байна гэдгийг ойлгосон гэлэнмаа авгай <<Хэрвээ би хатуурхвал чи хэлэхгүй байх юм уу?>> гэж асуув. Тийн хэлэх мөртлөө гартаа барьсан утасныхаа үзүүрийг огцом чангалан таваас И Да Зингийн шагайны яс тасрах гэж буй мэт өвдөх боловч шүд зуун тэслээ. Түүний гол тасартал өвдөх өвчнөө тэсвэрлэн байх зуур мөнөөх гэлэнмаа авгай дотороо туйлын их гайхалд автаж байлаа. Түүний энэхүү цагаан алтан оосор нь үсний ширхэгээс хэдэн хувь нарийн боловч туйлын уян хатан хязгааргүй бөх билээ. Хэрвээ энгийн хүн хөл ийн ороолгуулсан ахул түүний шагай нь тасрахаас өөр аргагүй. Тэр өөрийн дотоод хүчээ зугуухан нэмсээр хамаг хүч нь чиндээ тулах үед гэнэт эсрэг этгээдийн дотоод хүч цагаан алтан оосрыг даган түүний өөдөөс довтлон ирэхийг үзвээс нэг үе сулран нэг үе чангарч эсрэг этгээд түүнийг зохистой хэрэглэж чадахгүй байгаа нь мэдэгдэнэ. Харин түүний хуримтлуулсан дотоод хүчний хэр хэмжээ нь зэвсгийн эрдмийн ертөнцийн хамгийн нэртэй баатар боловч ийм өндөр чадварыг зэмших нь нэн бэрх бизээ. И Да Зингийн хөл тэсвэрлэшгүй өвдөх үед түүний биеийн дотоод хүчин улаан гэрд цагаас өөрийн мэдэлгүй оргилон гарч түүний биеийг бүрхэн хамгаалахад цаашлан цагаан алтан утсаар дамжиж тоосны гүвүүрийн эзний дотоод хүчтэй мөргөлдсөн юм. Хэрвээ гэлэнмаа авгайн дотоод хүч түүнийхээс дутахгүй их байгаагүй бол тэр лав дотоод шарх авч үхэхээс гарцаагүй байлаа. Хэдий тийм боловч гэлэнмаа авгайгийн гар нь бадайран өвдөх агшинд арван хэдэн жилийн турш мөрөн голоор явсангүй. Гэтэл зэвсгийн эрдмийн ертөнцөд ийм айхтар дотоод хүчтэн гарсан байдаг байна шүү гээд түүнтэй дотоод хүчээр үргэлжлэн тэмцэхийг орхиж тоосны гүвүүрээ султган энэ хүний яриа хөөрөөг сонсоос тун залуу хүн шиг атлаа дотоод хүч нь яагаад ийм их байдаг билээ. Гэтэл энэ их хүчийг огтхон ч ашиглаж чадахгүй байгаа нь ямар учиртай юм бол доо гэж дотроо бодлоо.

И Да Зин ухасхийн босож суугаад шагайгаа хоёр гараараа үрж гэлэнмаа авгайгийн гарын хатуу чангыг хорсон бодож суулаа. Энэ үед гэлэнмаа ухасхийн үсрээд түүний өөдөөс харан зогслоо. Тэрээр нүүрэндээ саа торгон гивлүүрийг унжуулсан тул царай зүс, нас намбыг ялган тогтоохын аргагүй ажээ. Харин гивлүүрийн сэжүүрнээс цухуйх санчигны хэдэн үс ов тов бууралтсан байхыг үзвэл нас нилээд явсан хүн бололтой.

Тэрбээр тоосны гүвүүрийг И Да Зингийн толгой дээр өргөж <<Чи чухам хар цагаан аль замын хүн бэ? Ганц үг худлаа өчвөл амьгүй болно шүү>> гэж мэдээрэй гэж зандарлаа.

И Да Зин би өргөж тэтгэх аав ээжгүй өнчин өрөөсөн хүн. Үхвэл үхнэ л биз. Харамсах юу байх вэ? хэмээн санаа алдав.

<<Чи муу ёстой нимгэн заяатай чимххэн дотортой хүн юм. Чи сая Сян Зюнь дүү минь гээд орилоод байгаагүй бил үү? Гэтэл чи одоо өөрийгөө ганц бие хүн гэдэг чинь юуг эсэн үг вэ? Цаад хүндээ ганц үг ч гэсэн дамжуулж хэлэхгүй юмуу? >> гээд хүйтнээр инээв.

И Да Зин хэсэг зуур дуугаа хурааж сууснаа <<За яахав хэрэв та хожмын өдөр Сян Зюнь дүүтэй минь тааралдвал миний үхсэн тухай муу мэдээг хэрхэвч түүнд дуулгаж болохгүй шүү. Харин намайг эрдэм чадалтай хүнтэй учраад хороо анагаахаар явсан гээд хэлчихвэл болох нь тэр>> гэв.

Гэлэнмаа авгайн дууны өнгө зөөлөрч <<Чиний тэр Сян Зюнь дүүгийн овгийг хэн гэдэг юм бэ? Чи юунд хордсон юм бэ? Би чамд тус болж болох юм шүү>> гэлээ.

И Да Зин санаа алдсанаа <<Өөрийн Жу Сян Зюньтэй хэрхэн учирсан. Хожим нь Хуо Шао Чуньтай нөхөрлөж 7 навчит цэцгийн хор идсэн болон өнөөдрийг хүртэлхи бүхий л явдлаа нэгд нэгэнгүй хэлсэн боловч Жу Сян Зюньд өөрийн дотоод бясалгалын гоц эрдмийг хэрхэн зааж сургаснаа ярьсангүй>>.

<<7 навчит цэцэг, цэцэг нь навч навч нь цэцэг анхилуун үнэр нь хязгааргүй алах хор нь авралгүй...>> хэмээн гэлэнмаа авгай амандаа үглэснээ <<Алив хүү минь чи гараа өгдөө би судсыг чинь барьж үзээдхье>> гэв.

Гэлэмаа түүний бугуйнд тоосны гүвүүрийн нэг үзүүрийг хүргээд амьсгаа түжин судасны цохилтыг чагнасаа <<Золиг минь чи үнэхээр ус уух хувьтай хүн юм байна. Чи амь аварсан ачтандаа мөргөхгүй юугаа хүлээсэн юм бэ?>> гэлээ.

И Да Зин тэсгэлгүй ихээр баярлаж уруул нь өмөлзөн <<Ав... авгай минь... та үнэхээр 7 навчит цэцгийн хорыг эмчилж чадна гэж үү дээ?>> хэмээн асуув.

<<Чи итгэхгүй байгаа бол болихгүй юу?>>

<<Би итгэлгүй яахав. Та бол амьд бурхан бодиства байна. Таны амь аварсан ачийг хэзээ ч мартаггүй>> хэмээн И Да Зин газарт сунан мөргөлөө.

Гэлэнмаа авгай тэсгэлгүй инээд алдан <<За яахав би чиний амийг аваръя. Харин миний чамд сануулах сахил цээр олон шүү. Аль нэгийг нь зөрчих юм бол аюулт хорыг чинь анагааж эдгээх нь битгий хэл амь насаа ч алдана гэж мэдээрэй>> гэв.

<<Ямар ч айхтар сахил цээр байсан мөхөс би ёсоор нь дагах болно.

<<За тэгвэл чи сонсож бай. Нэгдүгээрт чи надад шавь орох ёстой>>.

<<Бурхан хувилгаан минь та өчүүхэн боол намайг шавиа болгон авч үз>> хэмээн И Да Зин гүн хүндэтгэлтэйгээр мөргөв.

Гэлэнмаа авгай их л ихэмсэгээр <<За чи бид хоёр одоо багш шавь хоёр боллоо. Хоёрдахь журам нь гэвэл үүнээс хойш чи багшийнхаа өмнө Жү Сян Зюнь гэдэг тэр эм шулмын нэрийг дурсахгүй байх хэрэгтэй>> гэхэд

<<Яагаад?>>

<<Гурав дахь сахил нь яагаад гэж хэзээ ч битгий асууж бай. Багш чинь юу ч гэж хэлсэн түүнийг гүйцэтгэх ёстой>>.

И Да Зин юу ч дуугарсангүй. Тэр ам нээх болгондоо гэлэнмаагийн сэтгэлд таарахгүй үг хэлчихээд байгаа билээ.

Гэлэнмаа авгай дахин ам нээж <<Дөрөв дэхь сахил бол үүнээс хойш юм асуухад дуугүй зогсоод байж болохгүй. Багш чинь юу ч гэж хэлсэн номхон зогсоод за гэж хариулж байх ёстой>> гэв.

И Да Зин ухасхийн босоод толгой бөхийн <<За>> гэлээ.

<<Тав дахь сахилын тухайд одоохондоо санаанд орохгүй байна. Сүүлд чамд хэлж өгье. Явцгаая>> гэлээ. Гэлэнмаа хөнгөний тамир хэрэглээгүй тул туйлын удаан алхана. И Да Зинд ямар нэгэн эм засал хийгээгүй боловч хорны үйлчлэл эхлэх долоо дахь өдөр амар тайван өнгөрч ч ямар ч ажиг сэжиг илэрсэнгүй. И Да Зингийн дотор баяр гуниг хослоно. Баярладагийн учир гэвэл одоо болтол өвчин зовлонгүй амар амгалан байгаа боловч 7 навчит цэцгийн хор биед нь хадгалагдсаар байгаад сэтгэл бас шаналсан хэвээрээ байлаа. Дотроо ийн бодож явсан боловч багшаас зориглон ам нээж асуусангүй. Бүрэнхий болохын үед гэлэнмаа нэгэн модыг түшиж суугаад <<Шавь минь чамд хуурай идэх юм байхгүй биз>> гэж асуув.

<<Багшаа шавь чинь үхлээ хүлээж байсан амьтан юуныхаа хуурай идэх юм авч гарах билээ дээ?>>

<<Багш чинь их ядарч байна. Чи нэг хоолны ая бодооч>>.

Энэ эзгүй газар хаанаас хоол унд олох билээ? гэж И Да Зин бодсоноо арга буюу хөдөлж мөөг түүн усанд буцалгаад гэлэнмаагийн өмнө барилаа. Гэлэнмаа авгай нүүрний саа торгон гивлүүрийг үл мэдэг яраад хоол идэх

гэснээ И Да Зин өмнө нь зогсож байхыг үзээд дүрсхийтэл уурлаж <<Тав дахь сахил бол чи миний нүүрийг хэзээ ч эгцлэн харж болохгүй. Сайн санаж яваарай. Чи миний нүүрийг харсан тэр цагаас эхлэн хорын хөнөөл үйлчилж эхлэнэ>> гэв.

И Да Зин ихэд гэмшсэн байдалтай эргэн явахаар завдтал <<Дөрөв дэхь сахил чинь юу билээ? Мартчихлаа гэж үү?>> хэмээн гэлэнмаа асуулаа.

И Да Зин толгой гудайн эргэн харж <<За>> гэлэ.

Тэр шөнөдөө өөр үг хэлэлцсэнгүй. Хоёр гурав дахь өдөр гэлэнмаа авгай хөнгөний тамир хэрэглэн нисэх мэт хурдлан явлаа. И Да Зин чухам хаашаа авч явааг зориглон асууж чадсангүй. Дуугүй л дагаж явав. Азаар Жу Сян Зюнь түүнд хөнгөний тамирын нууц аргыг зааж өгсөний дээр дотоод хүч ихтэй тул алдалгүй дагаж явлаа. Харин гэлэнмаа нас ахимагийн дээр эмэгтэй хүн тул хэдийгээр хөнгөний тамир сайтай ч гэсэн аяндаа тамир хүч нь суларч байгаа шинж мэдэгдэн амьсгаадах болжээ.

Дөрөв дэхь өдөр нэгэн уулын хавцалд орох үед гэлэнмаа авгай өөрийн алхаагаа саарууллаа. Энэ хавийн нутаг хэдийгээр умард зүгт багтах боловч хавь орчмыг бор хулсан ой бүрхсэн байлаа. Гэлэнмаа авгай гэнэт ойролцоох хулсан байшинг зааж <<Чи нэг давхарт амьдрах боно шүү. Дээшээ нэг ч алхам ойртож болохгүй>> гэлээ.

Хоёр дахь өдрийн өглөөний хоолны дараа гэлэнмаа хорыг эмчлэх талаар юу ч дурссангүй. Хашаан доторхи хулсан сандал дээр суугаад И Да Зинд өгүүлрүүн <<Шавь минь чи гараа нааш нь сунга даа>> гээд түүний бугуйг өвдөг дээрээ тавьж нүдээ анин анхаарлаа төвлөрүүлж судсыг барин суулаа. Удтал ийн суусны эцэст сая нүдээ нээж <<Шавь чи багшдаа үнэнээ хэл. Чи үнэхээр долоон навчит цэцгийг идсэн үү?>> хэмээн асуулаа.

<<Шавь нь худал хэлж яахин зүрхлэх билээ?>>

<<7 навчит цэцгийн дараа үнэхээр сармагчингийн толгой идсэн биз дээ?>>

<<Бүх юм миний ховдог зангаас л болж байгаа хэрэг. Өвчин эмгэг өмгөр амаар дамждаг гэсэн ардын зүйр үг аргагүй үнэн юм даа>>

<<Түүнээс гадна чи өөрөө ямар нэгэн төрлийн хордлого тайлах эм уугаагүй хэрэг үү?>>

<<Намайг 7 навчит цэцэг идсэний дараахан гал махбодийн бүлгийн сайн эр Хуо Шао Чунь түүнд хорны ерөндөг байгаа. 7 хоногт нэг үрлийг, 10 хооод хоёр үрлийг гэх мэт явсаар долоон долоо 49 хоногийн дараагаар долоон үрлийг ууж хорыг цэвэрлэдэг гэж байсан билээ. Гэтэл тэр хожим нь

ертөнц дээр 7 навчит цэцгийн хорны ерөндөг гэж бахгүй. Би чиний санааг тайвшруулж амин цэггүй болгогч 8 хүлсийн зургийг олж авах гэж байсан юм хэмээсэн билээ. Тэр үед Жу Сян Зюнь уурлан сэлмээр түүний далны ясыг цоо хатгасан юм>>.

<<Түүний хэлсэн нь худал үг бишээ. 7 навчит цэцгийн хорыг ертөнцөд анагаах юм туйлын ховор. Харин хожим нь чи Хуо Шао Чунгийн газар доорхи зооринд юу болсныг яриач>>.

<<Онц юм болоогүй. Бүгдээрээ л үхлээ хүлээж сууцгаасан... үгүй ээ Хоу Шао Чунь тэнд зуун ширхэг хорт могой, 100 ширхэг хилэнцэт хорхой зэргийг тэжээгээд хооронд нь алалцуулсан юм байна лээ. Тэгээд хамгийн сүүлд ганцхан хилэнцэт хорхой үлдэж бусдынхаа хорыг шингээж авсан юм байжээ. Тэр хилэнцэт хорхой Жу Сян Зюнийг хатгах гэхээр нь би түүнийг хараад цохиж алсан юм. Гэтэл болгоомжгүйн улмаас бугуйн дээрээ хазуулчихаж билээ. Тэр даруй Жу Сян Зюнь амаараа хорт цусыг хэдэн удаа сорж өгсөн.Түүнээс хойш онцын зовиургүй эдгэсэн дээ>> гэв.

Гэлэнмаа хэсэг зуур бодол болон сууснаа <<Аа тийм байх нь. За шавь минь чи сонсож байн. Энэ 7 навчит цэцэг бол ертөнцөд дийлдэшгүй хор байгаа юм. Үүнийг тайлдаг ерөндөг гэж үгүй. Би харин чамд нэг зэвсгийн эрдмийн аргыг зааж өгье. Чи түүгээр байнга хичээллэж байх аваас энэ хорны аюулаас гэтлэн давж чадна>> гэлээ.

И Да Зин тэсглэгүй их баярлаж <<Тун их баярлалаа.Багшаа...>> гэв.

<<Одоохондоо баярлаад хэрэггүй. Энэ дасгалыг хийхэд маш хатуу сахилтай байх хэрэгтэй>>.

<<Бас л сахилтай байх юм гэж үү?>>

<<Сахилгүй аваас санваартан болж чадахгүй гэсэн үг байдаг юм. Харин төдий олон бишээ. Чи хичээлийн анхны өдрөөс эхлэн цаад шулам хүүхнээ бодож ч болохгүй>>.

<<Бодож ч болохгүй гэнэ ээ?>>

<<7 навчит цэцгийн хор нь мөрөөдөл хүслээс үүдэн үйлчлэл нь эхэлдэг юм. Хэрвээ чи тэр шулмыг бодоод эхлэх юм бол багш чинь чамайг аврах аргагүй боллоо гэсэн үг. Бодож болохгүйгээс гадна тэр шуламтай гэрлэх асуудал чинь усанд туссан сар, толинд туссан цэцэг гэж бодоорой>>.

И Да Зин хэсэг зуур дуугаа хурааж зогссоноо гэнэт гэлэнмаагийн зүг мэхэсхийн ёсолж <<Багш таны сайхан сэтгэлийн ачийг мартаггүй. Гэвч таны энэ зарлигийг өчүүхэн шавь би ёсчилон дагж чадахгүй нь. Шавийн энэ өчүүхэн амийг Сян дүү минь аварсан юм. Би ганц хоногийн настай байсан ч

түүнийгээ санан дурссаар үхэх болно. Хорны үйлчлэл эхлээд үхлээ ч гэсэн сүнс минь түүнийг дагаж тэтгэн хамгаалах ёстой. Хэрвээ би амьд байх хугацаандаа түүнийг бодож ч болохгүй юм бол үхсэнээс юугаараа өөрц байх вэ? Заяа муутай шавь би чинь таны ачлал энэрэлд багтах хувьгүй ажээ. Би ингээд явъя даа>> гэв.

<<Чи надаас холдоод хичнээн удаан амьрах юм бэ? тэнэг золиг минь ертөнцийн эрчүүд бүгд улааныг үзэж урваж шарыг үзэж шарвадаггүй бил үү? Чи чинь ямар лут амьтан болоод тэдэнтэй адилгүй дүр эсгэж байгаа юм бэ? Цаад шулам чинь юугаараа илүү болчихоод чи амь насаа ч хайхрахгүй зүтгээд байгаа юм бэ? Ертөнцийн хүхнүүд мундсан биш? Багш чинь хожим чамд цаад шулмаас чинь хэдэн хувь илүү сайхан хүүхэн олж өгье>> хэмээн гэлэнмаа авгай зандрал.

<<Далайн ус арвин ч гэсэн амны цангаа гаргах биш дээ>> хэмээн И Да Зин өгүүлэв. Гэлэнмаа дуугаа намссган <<Шавь минь чиний дотоод хүч чинь ертөнцөд хэнийг ч дээрээ гаргахгүй. Хэрэв чи тоост ертөнцийн амьдралаас ангижирч нэгэн сэтгэлийн үзүүрийг барьж зэвсгийн эрдмээр хичээллэх аваас хэдхэн сарын дараа мөрөн голын тэргүүн зэргийн сайн эр болж алдар нэрээ дуурсгах болно. Хэдхэн жилийн дараа л нэгэн үеийн зэвсгийн эрдмийн ертөнцийн олон баатруудын тэргүүн магнайд заларна шүү дээ. Чи энэ бүхэнд сэтгэл чинь хөдлөхгүй байна гэж үү? Юунд арьсанд боосон араг ясны төлөө насан туршийн алдар нэр ашиг сонирхлоо умартана вэ?>>

И Да Зин тас тас хөхрхөн <<Хэрэв би Сян дүүгээ гэх юм бол өөрөө ёстой амьд хүүр болон хувирна. Эзэн хаан болоод ч юуны утга байх билээ>> гээд явахыг завдав. <<Ертөнцөд чам шиг ийм этгээд эрийг үзсэнгүй. За яахав би хожмын буяныг бодож цаад шулмаа санан мөрөөдөж байх эрхийг чинь өгье. Чамд ч бас зэвсгийн эрдмээ зааж биеийг чинь эмчилье>> хэмээн гэлэнмаа авгай өгүүлэв. И Да Зин тэсгэлгүй баярлаж эргэн хараад <<Гялайлаа. Багшаа>> гэв. Гэлэнмаа өгүүрүүн <<тэр өдөр чи тун сайхан лимбэддэг гэдгийг мэдсэн. Чи одоо багшдаа <<Сян Зюнь>> аялгуугаа дахин нэг тоглож өгөхгүй юу?>> гэлээ. И Да Зин лимбээ шүүрэн авч <<Сян Зюнь хэмээх аялгууг тоглож эхлэв.

<<Сян Зюнь>> бол Чу улсын нэрт яруу найрагч Цюй Юаний бүтээл бөгөөд балар дээр цагт нэгэн хаан умард зүгт аянд яваад эзгүй хээр газар осолд орж үхэх үед түүний хайртай хоёр хатан араас нь сураглан явсаар Дун Тин нуурын орчимд нөхрийнхөө тухай золгүй мэдээг дуулж эмгэнэн

гашуудсаар нуурын усанд үйж үхсэн тухай домгийг өгүүлдэг юм.Т үүнээс хойш Дун Тин нуурын эргээр толбот хулс их ургах болсон нь хоёр хатны нулимс юм гэж нутгийнхан нь ярилцдаг. Энэ бол туйлын эмгэнэлтэй уянгалаг хайрын тухай домог бөгөөд яруу найрагчийн уран чадвараар улам ч их элэг эмтрэм сонсогддог билээ. Сян Зюнь хэмээх аялгуу эгшгийн хэлээр энхээг хайрын эмгэнэлийг намуухан хүүрнэхэд гэлэнмаа бүхнийг умартсан мэт зогсож байснаа аялгуу дууссаны дараа хэсэг зуур бодлогоширон сая л ам нээж <<Чи тун сайхан хөгжимдөх юм. Чам шиг залуухан номын хүн илд мэс агсаад явж байх нь зохимжгүй. Тэгэхээр багш чинь чамд толбот хулсны салхи гүйцэгч 18 цохилт гэдэг зэвсгийн эрдмийг зааж өгье. Өөрөөр хэлбэл чи энэ лимбээрээ л бусадтай тулалдаж болно гэсэн үг. Ямар вэ?>> гэв.

И Да Зин тэсгэлгүй баярлан <<Баярлалаа багшаа. Сян дүү минь Сян Зюний салхи гүйцэгч 18 илдийн аргатай, би толбот хулсны салхи гүйцэгч 18 цохилттой болох тул ямар сайн хэрэг вэ?>> гэв.

<<Сян Зюний салхи гүйцэгч 18 илдийн арга юугаараа гоц гойд болоод чи миний энэ толбот хулсны 18 цохилттой адилтгаж зүрхлэнэ вэ? За чи сонсож бай. Энэхүү 18 цохилт бол чи өөрийнхөө энэ лимбээр дайсныхаа амин цэгийг цохиж хөнөөнө гэсэн үг. Хүний биеийн амин цэг туйлын олон боловч цэг дарах зодооны арга бол 36 гол цэгийг голлодог>>. Багш нь ийнхүү түүнд цэг дарах аргыг зааж өгсний дараа залгуулан өгүүлрүүн <<Чи бид хоёр одоо нэгэнт багш шавь хоёр болсноос хойш би чамаас юугаа нуух вэ? Багш чинь уг нь өмнөд нутгийн хүн. Толбот хулсанд тун их дуртай. Манай гэрт хэдэн зуун му газар хулс тариалсан байдагсан. Хожим нь би энэ газар нүүдэллэн ирээд сэтгэл зүтгэл гарган оролдсоор энэ хулсан ойг ургуулсан юм. Би сүүлийн хорин жил эндээ даяанчилан сууж өөрийгөө хүрэн хулсны гэлэнмаа гэж нэрлэх болсон билээ. Би чиний хулсан лимбэ манай нутгийн аялгууг сайн тоглодогийг чинь бодоод шавиа болгон авсан юм. Би сүүлийн 10 гаруй жил оролдож буй болгосон толбот хулсны салхи гүйцэгч 18 цохилтын аргаа чамд өвлүүлэн өгч байна. Багш чинь ертөнцийн амьдралаас тасарсан хүн. Харин чи хожмын нэгэн өдөр мөрөн голоор алдар нэрээ дуурсгах үедээ өөрийгөө хүрэн хулсны гэлэнмаагийн шавь хэмээн зарлаж багшийнхаа нэрийг бага ч гэсэн гаргана биз дээ>> хэмээн өгүүлэх зуур түүний дууны өнгөнд хязгааргүй их гаслан гуниг сонсогдож байлаа. И Да Зин багштайгаа хамт байх энэ хэдэн хоногийн хугацаанд багш нь баярлаж уурлах нь амархан сонин хүн юм даа гэж бодож байсан боловч өнөөдрийн

энэ үгийг дуулаад түүний сэтгэлийн шаналанг бага сага мэдэрлээ. Тэгээд туйлын үнэнчээр <<Шавь чинь таны ачийг хэзээ ч умартахгүй>> гэв.

Хүрэн хулсны гэлэнмаа өөртөө их л итгэлтэйгээр инээд алдан <<Би ч өмхий шавь чамайгаа буруу сонгоогүй юм байжээ>> гэв. Үүнээс хойш И Да Зин багшийгаа даган зэвсгийн эрдэмд шамдан суралцсаныг өгүүлэх юун.

<<Өст хүн өлийн даваан дээр учирлаа гээд яах юм бэ? Чи намайг тас цавчаад л зүйл дуусгачихвал болох нь тэр>> хэмээн Жу Сян Зюнь дахин ухаан алдсан дүр үзүүлээд хэрэггүй болсныг ойлгон өгүүлэв.

<<Тас цавчаад хаячихна гэнэ үү? Их амар юм болох нь ээ. Миний багш хорч Дү авгай хичнээн олон янзын хортойг чи мэдэх үү? Чи түүний 810 төрлийн хорыг амсаж үзэж байж сая эрлэгийн орныг зорих болно доо>> гэж Му Цин Ся заналтайгаар өгүүллээ.

Гэтэл хорч Дү авгай хажуунаас оролцон <<Бас тэгээд ч зогсохгүй чиний ээж Му Дань Ду хатагтай түүний идсэн хорыг ерөндөгөөрөө тайлж байх болно. Ийнхүү нэг нь хордуулж нөгөө нь анагаасаар 809 хор идсэний дараа хамгийн сүүлд нь 7 навчит цэцэг өгөх болно>> гэв.

<<Манай ээж тэгвэл багшийн хэрэглэсэн хорыг эдгээж дөнгөхгүй юм шив дээ>> гэж Му Цин Ся инээв.

<<Багш чинь болохоор бүтэн жилийн турш хор найруулах аргаа бодоод ээж чинь болохоор түүнийг анагаах аргаа боловсруулаад мөн таарав аа. Энэ хөөрхөн охин өөрийн нэг найзын уусан 7 навчит цэцгийн хорыг тайлах ерөндөг олохоор танай ээжийг сураглаж ирсэн юм. Хүүхдүүд та нарын доторхи бодлыг би толинд туссан дүрс шиг сайтар харж байна. Чи ээжийгээ надаас илүү гараасай гэж бодож байгаа биз дээ. Гэвч 7 навчит цэцгийн хор бол тун төвөгтэй. Заавал сармагчингийн тархи идэж байж л үйлчилж эхэлдэг. Гэвч би хөөрхий гэмгүй амьтныг алж хороогоод юугаа хийх вэ? Бурхан минь. Өөр амар хялбар арга бодно оо>> гэв.

Хэрвээ энгийн цагт тоо тоомшгүй олон хүний амь хөнөөсөн энэ авгай бурхан сахиусаа дуудан залбирахыг үзсэн бол Жу Сян Зюнь тэсгэлгүй инээх байсан биз ээ. Тэрбээр одоо энэ хорт шулам шиг авгай түүний бие дээр 810 төрлийн хороо туршиж үзнэ гэдгийг дуулаад хэдийгээр төрөлхийн цес ихтэй хүн боловч энэ удаа өөрийн эрхгүй дагжин чичирлээ.

<<Му Цин Ся чи тусыг усаар хариулдаг шударга журмыг умартсан адгийн шаар чамайг яахин мөрөн голын хүн гэх вэ?>> хэмээн Жу Сян Зюнь уурсан хашгирав.

<<Чи миний нөхрийг хорсолтойгоор хорлон нэгэн үеийн сайн эрийг эрэмдэг амьтан болгон хувигачихаад надтай юуныхаа ач тус хэлцэнэ вэ? Чи миний модон махобдийн бүлгийн толгойлогчийн суурийг хуурч эзлэхийг эрэмдэг юуныхаа шударга журам энэ тэр гэж чалчина вэ? Шулам минь чи бод хоёрын өс хонзон энэ насандаа дуусахгүй хойт насандаа үргэлжлэх болно гэдгийг мэдтүгүй>> хэмээн Му Цин Ся өгүүлэв.

<<Чиний нөхөр гэмгүй хүнийг хорлож өөрөө нүгэл үйлдсэн тул амьд явах ч учиргүй байсан юм. Харин ч би түүнийг эрэмдэг болгоод орхисон нь дээдийн заяа. Харин толгойлогчийн суурийг эзэлсэн тухайд гэвэл өөрөө түүнийгээ найр тавиа биз дээ. Танай модон махобдийн бүлгийн арга билгийн муна чинь энд байна. Тийм их ховор живэр эд юм бол аваад явбал болоо биш үү?>>

<<Уг нь би толгойлогчийнхоо сууриар нөхрийгөө сольж авъя гэж бодсон юм. Гэтэл миний нөхөр хаана байна вэ? Чи тэр мөрөн голын зальхай этгээд И Да Зинтэй нийлээд миний нөхрийг хаашаа нуусан хэрэг вэ?>>

<<Чи үнэхээр түүнийгээ олоогүй хэрэг үү?>>

<<Чи л болоод бас мэдэхгүй байгаа байх даа>>

<<Итгэх эсэх нь чиний мэдэх хэрэг. Биднийг явах үед цаадахь чинь газар доорхи агуйдаа үлдсэн шүү дээ>>.

<<Тэр агуй зоорь байтгауй тэр хавийн хашаа хороо тосгон суурины хөрсийг би гурван тохой сэндийлж үзсэн. Хөөрхий миний нөхөр цагийг эзэлсэн их баатар одоо үхсэн амьд нь ч мэдэгдэхгүй болчихлоо. Би ямар заяагүй амьтан бэ...>> хэмээн Му Цин Ся нулимс дуслуулан өгүүлэв.

Хорч Дү авхай хийж байсан ажлаа орхин гүйж ирээд үнс шороо болсон гараар түүний нулимсыг арчин <<Хонгор шавь минь битгий уйл чиний өшөөт хүн чинь нэгэнт бидний гарт орсноос хойш одоо яаж хонзонгоо авах чинь чиний мэдлийн хэрэг шүү дээ>> гэлээ.

<<Би энэ шуламд 810 төрлийн хор идүүлсний дараа өөрийн гараар 7 навчит цэцгийн хорыг идүүлж 7 сүв нь ээлжлэн илжирч мах нь өм өм ялзран ойчих үед өөрийн гараар зүрхийг нь сугалж нөхрийнхөө өшөөг авах болно>> хэмээн Му Цин Ся шүд зуун өгүүлэв.

Жу Сян Зюнь үхлээ зоригтой хүлээхээр шийдэж <<Миний дотоод хүч нэгэнт үгүй болж амьсгалаас өөр амьдын тэмдэг алга. Багш шавь та хоёр

ямар л хортой муухай арга байна түүнийгээ даруй хийгээд хэрэв би ганц удаа ёолж өчүүхэн амиа гуйх аваас би Жу овогт биш болог>> гэлээ.

Жу Сян Зюнь ухаан ороод үзвэл эргэн тойрон гял цал болсон тансаг сайхан өрөөнд байгаагаа мэдэрлээ. Тэрвээр одоо хааны ордонтой зүйрлэж болохуйц хээнцэр гоёмсог том танхимын дундахь нэгэн зөөлөн түшлэгтэй сандалд сууж байх ажээ. Өмнө нь элдэв төрлийн амтат жимс тэргүүтнийг өрж үнэт торгон хөшигтэй энэхүү ордны дотор эртний чамин хийцтэй эдлэл хэрэглэлийг хэдэн том дэнлүү өдөр мэт хурцаар гийгүүлэх ажээ.

Ордны эзэн гэж гоо сайхан царайтай сувд эрдэнийн зүүлт үнэт торгон эдлэл хувцас хэрэглэсэн 40 гаруй насны буянтай сайхан царайтай авгайн дэргэд Му Цин Ся хүүхэн сууж байлаа. Мөнөөх эрхэмсэг хатагтай хөмсөг зангидан <<Цин Ся танай багш чинь ийм цэцэг цэврүү шиг сайхан охинд халимын шүрмэс хэмээх ийм хортой бодис уулгадаг нь яаж байгаа юм бэ? Би хэрвээ цаг тухайд нь түүний амийг авраагүй бол үхсэн хойно ч гэсэн царай зүс нь хувирч нүүрс шиг хар юм болох байлаа шүү!>> гэв.

Му Цин Ся тас тас хөхрөн <<Манай багш чинь хорч Дү авгай болохоос биш хувилгаан бодисатва биш шүү дээ>> гэв.

<<Хэрвээ ийм бузар нүгэл үйлдээд байх юм бол 18 тамын ёроол дахь аюуш тамд унах болно доо>> хэмээн хатагтай хөмсөг зангидан өгүүлэв.

<<Манай багш диваажин дэндүү бага зайтай хэрийн хүнийг багтааж шингээдэггүй. Ертөнцийн хүмүүсийн олонхи нь тамд унах тавилантай гэдэг юм. Тэгээд ч манай багш шиг айхтар хорч байхгүй бол ээж та өөрөө ч гэсэн хийх ажилгүй болно биз дээ>>.

Жу Сян Зюнь тэр хоёрын ийн өгүүлэхийг сонсоод өөрөө Му Дань Ду хатагтайн гэрт ирсэнээ гадарлалаа. Өмнө суугаа энэ ихэмсэг хатагтай бол Му Цин Сягийн ээж Му Дань Ду хатагтай байв. Тэрбээр хараа тогтоон хатагтайг сайтар ажваас түүний нүүр царай нэг л танил дотно юм шиг санагдлаа.

Му Дань Ду хатагтай түүнд аядуу намуун дуугаар <<Охин минь бие чинь гайгүй биз дээ чи хэдэн өдөр тайван байж уурлаж болохгүй шүү. Чи яахаараа энэ хорч авгайн гарт орчихдог байна даа>> гэв. Жу Сян Зюнь хатагтай түүнд ийм эелдэг зөөлөн хандахыг үзээд өөрийн эрхгүй самсаа нь шархираад явчихлаа. Гэвч тэр зэвсгийн эрдмээр хичээллэдэг хүн учраас

угийн омог бардам зантай тул бөхөлзөж тонголзохыг хүссэнгүй. <<Хатагтай та Му Дань Ду гуай мөн үү?>> хэмээн асуув.

<<Тийм байна>> хэмээн Му Дань Ду хатагтай инээв.

Жу Сян Зюнь ухасхийн босоод түүнд мөргөх гэсэн боловч хамаг бие нь мэдээ алдраад огтхон ч хөдөлж болсонгүй. Арга буюу алгаа өмнөө хавсарч хатагтай таны их нэрийг тань эртнээс нааш дуулж ирсэн билээ. Өчүүхэн би танаас нэг зүйлийг асууж лавлах гэсэн юм. Болох уу? гэв.

Му Дань Ду хатагтай бололгүй яахав гэхэд

<<Миний нэг найз 7 навчит цэцгийн хорыг идчихээд үйлчлэл эхлэх 7 дахь хоног дээрээ алга болчихсон юм. Тэгээд мөхөс би ертөнцөд элдэв төрлийн хорыг танаас илүү анагаах хүнгүй тул сайн санаат найз минь тантай учирч аюул гамшигаас хэлтэрсэн байж юу магад гэж бодоод нааш зорин ирсэн билээ>> хэмээн Жу Сян Зюнь өгүүлэв.

<<Хорыг эдгээх аргын хувьд онгирч байгаа юм биш хөгшин намайг гүйцэх хүн байхгүй болов уу? Харин 7 навчит цэцгийн хувьд гэвэл түүн шиг айхтар эд байхгүй. Харин түүнийг чинь ганц дөнгөхгүйдээ ичиж байна. Түүнээс гадна хөгшин би сүүлийн 10 хэдэн жил мөрөн голоор үзэгдсэнгүй. Эрхэм найзтай чинь танилцах хувьгүй ажээ>>.

Жу Сян Зюнь ихэд балмагдан <<Тэгвэл хэдэн сарын өмнө хэн нэгэн хүн ирж энэ хорны ерөндөгийг авсан уу?>> гэхэд

<<Энэ хорыг хэрэглэхэд төвөгтэй. Уусан хүн ч ховор байдаг тул над дээр тийм хүн ирнэ гэж үү>> хэмээн Му Дань Ду хатагтай толгой сэгсэрлээ.

<<Аа би одоо л ойлголоо>> хэмээн Жу Сян Зюнь дотроо халаглан өгүүлэв. Тэр хэдийгээр гоц сэргэлэн боловч хайртай хүндээ муу юм тохиолдсон үед дандаа сайн тийш бодож явсан ажээ. Харин сая Му Дань Ду хатагтай 7 навчит цэцгийн хорны ерөндөг гэж байдаггүй гэж хэлэхэд сая л бүгдийг ухаарлаа. Зин ах нь энэ хор эдгэршгүй аюултай гэдгийг мэдээд түүний сэтгэлийг зовоохгүй гэсэндээ зайлан одсон байх нь. Тэр нууц агуу дахь 8 хүлсийн зургийн нууцыг тайлдаг нь ч зориудын төлөвлөсөн хэрэг байжээ. Тэр зэвсгийн эрдмээр хичээллэдэг хүн түүндээ ухаангүй хайртай. Хорвоод хосгүй зэвсгийн эрдмийн аргатай учрах юм бол түүндээ ухаан санаа нь сатаараад нэг хоёр жилийн дараа хайртай хүнийхээ золгүй учралыг ойлгох боловч цагийн уртад зовлон нь нимгэрэх болно гэдгийг тэр ойлгосон байна. Мөрөн голын эрдэм чадалтантай учирлаа. Хожмын өдөр уулзая гэдэг нь ёстой л усанд туссан саран толинд ойсон гэрэл байх нь ээ. Энэ өдөр Зин ахын хөсрий яс нь хөдөө хээр хэвтэж байгаа байх даа. Зин ах

минь та намайг хуурах учиргүй байсан юм. Та намайг сайн яваасай гэсэн хүсэл чинь сананд багтамгүй аймшигтай үхэлтэй учрууллаа шүү дээ хэмээн бодох зуур Жу Сян Зюний нүдний аяганд сувдан нулимс дүүрээд хацрыг даган зугуухан урслаа.

Му Цин Ся түүнийг хараад цангинатал хөхрөн Жу Сян Зюнь минь чи одоо үхсэн амьдын хагацал гэж юу байдгийг ойлгов уу? Чи хорт гараараа бусдыг алж байх үедээ цаад хүний чинь гэрт хайрт гэргий нь нөхрөө хүлээгээд суугааг бодож төсөөлдөггүй байсан биз дээ. Чи Хуо Шао Чунг эрдэмдэг болгож байхдаа миний атгахан зүрх өмрөн унана гэдгийг бодож үзсэн үү? гэв. Му Дань Ду авгай ухасхийн хайртай охиноо тасхийтэл алгадваас Му Цин Сягийн хацарт 5 хурууны ор зурайн үзэгдэв. Чи хэзээ ийм айхтар цэвдэг хүйтэн сэтгэлтэй болчихоод бусдын зовлонгоор бах таваа хангадаг болоо вэ? хэмээн тэрээр асуулаа.

<<Хатагтай та түүнийг зэмлэх хэрэггүй. Би урьд нь энэ тухай үнэхээр боддоггүй байж>> хэмээн Жу Сян Зюнь амандаа бувтнав.

Му Цин Ся хорссон хацраа үрж байснаа ухасхийн Жу Сян Зюний эмзэг цэгийг хатгалаа. Яг энэ үед нэгэн өвөрмөц үнэр өөдөөс нь сэнгэнэхийн сацуу Жу Сян Зюнь ухаан алдлаа. Үүнээс хойш Жу Сян Зюнь Ду авгайн хэрэглэсэн биетэй биегүй амттай амтгүй есөн жорын хорыг 10 хэдэн хоногийн турш өдөр алгасахгүй хүртэн шөнө орой болохын хэрд Му Дань Ду авгайн гэрт хүргэгдэн очсон байдаг боллоо. Му Дань Ду хатагтай түүнийг эмчлэн анагаагаад буцаан хорч Ду авгайн гэрт буцаан хүргэнэ. Ийнхүү Жу Сян Зюнь өөрийн мэдэлгүй эмийн сав хорны хүүдий болон хувирла.

Энэ өдрийн орой Жу Сян Зюний хамаг бие ямар ч хүчгүй амьсгалах төдий агаад хэнээс ч царай алдан гуйж үзээгүй тэрээр <<Хатагтай та өршөөл энэрлээ хайрлан өчүүхэн намайг эмчлэлгүй даруйхан үхүүлж өгөөч>> хэмээн гуйхад Му Дань Ду хатагтай ихэд энэрэнгүй өнгөөр <<Тэнэг минь би тэнгэрийн өмнө амьд хүн үхэх гэж байхад гар сунгаж туслахгүй байж яахин болох билээ?>> гэв.

<<Тэр 810 төрлийн хортой нэг нэгээр хэрэглээд байвал би энд хэдэн жил тарчлах болно шүү дээ>> хэмээн Жу Сян Зюнь өгүүлэв.

Му Дань Ду хатагтай <<Арга алга даа охин минь хорч Ду авгай тун сонин хүн. Түүний санааг хэн ч өөрчилж эс чадна>> гээд Му Дань Ду хатагтай санаа алдлаа.

Хорч Ду авгай Му Дань Ду хатагтай аль аль нь л сонин улс байлаа. Нэг нь хордуулж нөгөө нь эдгээгээд эцэс төгсгөлгүй өрсөлдөөн болж буй мэт

санагдана. Энэ арван хэдэн хоногийн дотор өдөр нь Ду авгайгийн орой нь Ду хатагтайн гэрт хүргэгдэн очих боловч Му Дань Ду хатагтайн гэр чухам хаана байдгийг мэдэж эс чадна. Гэвч энэ газар Ду авгайн цайны газраас өөр эргэн тойрны хэдэн арван газар ганц айл амьтан үгүй байтал Му Дань Ду хатагтайн гэр хааны ордон мэт тансаг ямар ч байсан жирийн гацаа тосгонд баймгүй ажээ. Энэ асуулт Жу Сян Зюний хувьд тайлагдамгүй оньсого байлаа.

Энэ өдрийн орой Жу Сян Зюнь мөн л сийрсэн дэвсгэр дээрээ хэвтэж байна. Хорч Ду авгай зуухны өмнө тутаргын сүрэл галлаж тогогонд ямар нэгэн юм чанана. Му Цин Ся гаднаас орж ирээд <<Багшаа та өнөөдөр энэ шуламд ямар бэлэг бэлтгэв ээ>> хэмээн асуулаа.

<<Хөөрхөн шавь минь чи өнөөдөр багшдаа баярлах болж дээ. Багш нь өнөөдөр 7 навчит цэцгийн хорыг амархан бэлдэх жорыг гагрган авлаа. Өнөө орой танай ээж түүнийг хэрхэн анагаахыг үзье л дээ>> хэмээн хорч Ду авгай инээхэд Му Цин Ся алга ташин хөхөрч <<Ёстой сайхан хэрэг байна даа. Багшаа тэгвэл энэ хорт шулам тун удахгүй эрлэг хааныд залрах нь ээ>> гэлээ.

Осолгүй тэгнэ. Танай ээж чинь багшийн чинь адил эрдэм ухаан сураагүйгээс хойш одоо яах гэхэв гэлээ.

Жу Сян Зюнь ийн хэлэлцэхийг сонсоод айх нь бүү хэл харин ч баярлахаас наахнуур юм бодогдов. Тэр одоо үхэхийг юман чинээ тоохоо болиод энэ эцэсгүй зовлонгоос түргэн гэтлэхийн түүс болоод байлаа. Хорч Ду авгай тогооны тагийг сөхөж найруулсан хороо хутгаж үзсэнээ <<Галаа унтраа охин минь энэ хор сайхан найрчээ. Одоо цаад гоо охиныг замд нь үдэх л үлдлээ>> гээд аяганд шингэн хорноос дүүргэв. Му Цин Ся өгүүлрүүн <<Багшаа энэ хорт шуламтай нөхрийнхөө өмнөөс тооцоо бодох ёстой юм. Энэ удаа би түүнд үйлчилнэ> гэлээ.

Хорч Ду авгай түүнд аягыг өгөв. Сайн бариарай. Битгий асгачихаарай даа. Наадах чинь чинь алтнаас ч үнэтэй эд шүү гэлээ.

Му Цин Ся аягатай хорыг шүүрэн авч Жу Сян Зюний өмнө хүрээд <<Журамт бүсгүй Жу минь энэ бол ертөнцөд таарах ерөндөггүй 7 навчит цэцэгийн хор байгаа юм. Чи одоо И Да Зин ахынхаа явсан замаар одож очсон газар нь хүрэх болж дээ>> гэв.

Хорч Ду авгай ч түүний араар тойрон сийрсэн дэвсгэрийн өмнө хүрч ирээд зогсоход Му Цин Ся залгуулан өгүүлрүүн <<7 навчит цэцэг эдгээх аргагүй гэлцдэг. Хэдэн өдрийн орой ууваас миний ээж тэр ерөндөгийг

олчихож болох юм. Харин өнөөдөр уулгавал тэнгэр бурхан ч тус болж чадахгүй. Миний багш гарцаагүй ялна гэсэн үг>> гэв.

<<Эмэгтэй хүүхдийн элэг буруу гэж аргагүй л үнэн үг юм даа. Ээжээсээ илүү багшдаа сайн байдаг байна шүү>> хэмээн Ду авгай алга ташин хөхин баясна.

<<7 навчит цэцгийн амт таагүй байж мэднэ. Би туслах уу даа? Гээд Му Цин Ся Жу Сян Зюнийг ширтэн харав>>.

<<Баярлалаа.Зин ах минь 7 навчит цэцэг идэж үхсэн. Би хамт үхэж чадаагүйдээ одоо болтол харамсч явдаг юм. Энэ хүслийг минь гүйцээж өгсөн журамт бүсгүй Му чамд баярлах ёстой>> гээд хамаг хүчээ шавхан өндийн суугаад Му Цин Сягийн гараас аягыг шүүрэн авч буцлам халууныг ч эс тоон гүд гүд хийтэл залгилан дуусгав. Энэ эм гэдэс рүү оруут л Жу Сян Зюнь ухаан мэдрэлээ алдан уналаа.

НОМЧ БААТАР МӨРӨН ГОЛД ТОДОРСОН НЬ ХЭМЭЭХ ЕСДҮГЭЭР БҮЛЭГ

Толбот хулсны 18 цохилт нийтдээ 18 аргатай. Арга мэх бүхэн нь гурван хувирлыг агуулна. И Да Зин хэдийгээр эрдэмд шаргуу дотоод хүч ихтэй боловч зэвсгийн эрдмээр урьд нь хичээллэж байгаагүй энэ талын өчүүхэн ч ойлголтгүй тул хэдхэн сарын дотор энэ олон хөдөлгөөнийг сурна гэдэг туйлын бэрх санагдана. Гэвч 18 цохилтын аргандаа нилээд дөртэй болж эхэлсэнд багш нь их л баяртай байлаа.

Хоног хугацаа харвасан сум мэт өнгөрч И Да Зин өвлийн сар өнгөөрөөгүй гэж бодож байтал модны навч соёолон гарч иржээ.Энэ өдрийн өглөө эрт И Да Зин хашаан дотор толбот хулсны 18 цохилт аргаа сургуулилж байтал хүрэн хулсны гэлэнмаа ард нь ирж удтал харан зогссоноо <<Шавь минь чи энэ ууланд ирээд хэр зэрэг удав даа>> хэмээн асуулаа.

И Да Зин сургуулиа больж багшийн амрыг эрээд 184 хоног хэмээн хариуллаа.

Багш нь цочих мэт болсноо даруй инээж <<Чи ийм тод санаж байхыг бодвол өдөр хоног сар жил мэт удаан санагдаж байгаа биз дээ. Чиний сэтгэлд цаг мөч тутам Жу Сян Зюнь хэмээх тэр шулам эргэлдэж байгааг чинь би мэдэж байна. Цаад шулам чинь юу нь сайхан болоод чи мартаж

чаддаггүй байна аа>> гэв. И Да Зин багш маань үргэлж л Сян дүүг минь гутаан доромжилж байх юм гэж бодоод нүүрэндээ тааламжтай бус өнгө аяс тодруулан <<Багш хэрвээ өөр хэрэггүй аваас шавь нь явах уу даа>> гэлээ.

<<Байж бай би чамтай ярих юм байна>>.

И Да Зин газар суух үед багш өгүүлрүүн <<Янагийн нүд сохор гэж яах аргагүй үнэн үг шүү. Чи Жу Сян Зюнийг ертөнцийн хамгийн сайхан бүсгүй гэж боддог бололтой. Өнөөдөр багш чинь чиний нүдийг нээж нүүрийг баясгая. Худгийн ёроол дахь мэлхий чи хорвоо дэлхийд цаад шулмаас чинь хавьгүй илүү сайхан хүүхэн байдгийг мэдэж авах болно>> гэв.

<<Багшаа наадахь чинь юу гэсэн үг вэ?>>

<<Чи анх надад шавь орж байх үед би чамд цаад шулмыгаа март би өөрт чинь ер бусын үзэсгэлэнтэй сайхан бүсгүй олж гэрлүүлнэ гэснийг мартаа юу?>>

И Да Зин анх шавь ороход хүрэн хулнсы гэлнэмаа үнэхээр тэгж хэлж байсныг саналаа. Гэвч тэр үед онцын юм болгож бодоогүй байсан юм. Гэтэл багш нь өнөөдөр ямар өвчин нь хөдлөөд тэр үгээ дахин давтдаг билээ. Ийн бодоод яаран сөхөрч өгүүлрүүн <<Багшаа шавь би таны зарлигийг дагаж чадашгүй нь>> гэхэд хүрэн хулсны гэлэнмаа дүрсхийн уурлаж <<Хагас жил өнгөрөөд байхад тэр шулмыг санасаар байна уу? Багшийн тогтсон хэргийг тэнгэр бурхан байсан ч өөрчилж чадахгүй>> гэлээ.

<<Би Сян дүүтэйгээ хуримын болзоотой. Түүнийгээ тэрсэлж яахин болох билээ? Хэрвээ энэ явдал гадуур тархаад И овогт намайг журам ёсгүй хүн хэмээн хэлэцвэл багш таны нэр нүүрэнд ч муухай бш үү?>>

<<Чи өмхий нэр нүүрээ бодох чинь надад хамаагүй хэрэг. Харин миний чамд үзүүлэх гээд байгаа хүүхэн бол миний охин байгаа юм>>.

<<Охин гэнэ үү? Багш гэлэнмаа атлаа юуных нь охин байдаг билээ?>> хэмээн дотроо гайхан бодов.

Багш нь түний санааг ойлгов бололтой. <<Ертөнцөд хар байгаад замын дундаас сахил хүртсэн гэлэнмаа нар бишгүй байдаг шүү дээ. Би онгирч байгаа юм биш. Миний охины зүс царай тэнгэрийн дагинаас ч хэдэн хувь илүү. Шатар, хөгжим, зураг, уран бичлэгт гарамгай мэргэшсэн. Чам шиг номын хүнд аргагүй тохирох бүсгүй байгаа юм. Би анх чиний амийг аварч эрдэм ном сургадаг нь Жу Сян Зюнь та хоёрын төлөө хийсэн хэрэг гэж бодоо юу? Би охиноо амь шигээ хайрладаг. Хэрвээ алт шиг охин минь хэнд ч хэрэггүй амьтантай суучихаад дарлуулж явбал би яах болж байна вэ? Тийм учраас би чамайг сонгон эрдэм сургасан билээ>> гэв.

И Да Зин хэсэг зуур тонгойн бодлогоширч сууснаа гэнэт ам нээж <<Багш минь та миний энэ зэвсгийн эрдмийг эвдэж орхихгүй юу>> гэлээ.

Багш нь хүйтнээр инээн <<Юу гэнээ чи надтай багш шавийн журмыг таслахаар шийдээ юу>> гэв.

<<Багш та анх ийм санаа төрсөнөө одоогийх шиг ингэж тодорхой ярьсан бол би хэзээ ч танд шавь орж эрдэм сурахгүй байсан юм. Одоо харамсавч оройжээ. Багш та одоо шавийн эрдмийг эвдэж орхивол таарна. Таны элбэрэлт ачийг хойт насандаа үхэр морь болон хувирч түмний нэгийг ч атугай хариульъя>>.

<<Чи их амар юм ярьж байна. Сурсан эрдмийг эвдэлж гээж болдог бил үү?>>

<<Хэрвээ багш та нигүүлсэн үзвээс шавь би түүнийг насан туршдаа дахин хэрэглэхгүй. Би угаас мөрөн голын төлөгч хүн Сян дүүгээ дагуулаад төлгөө тавиад явж байваас болох нь тэр>>

<<Чи ийм амархан хамаг хэрэг болчихно гэж бодоо юу?>>

<<Миний өчүүхэн амийг багш та аварсан. Хэрвээ өөр арга үгүй бол та буцаан авахад шавь надад гомдох юм алга>>.

<<Хүрэн хулсны гэлэнмаа нэг хүргэн сонгосон нь хадам эхийнхээ сайхан сэтгэлийг ойлгодоггүй амьтан таарч гээд мөрөн гол даяар тархаж орхивол би ямар нүүрээрээ бусдын царай харах билээ. Түүнд орвол чамайг одоо тонилгож хаячихаад хамаг хэргийг дуусвагавар болгоё>> гээд багш нь гараа өргөн зулайг нь тоншихоор зэхлээ. И Да зин энэ үед толбот хулсны 18 цохилтын аргаас гадна дотоод хүчээр амиа хамгаалах талаар багагүй зүйл мэдэх болсон боловч нүдээ анин амиа найр тавин хүлээлээ. Багшийнх нь гар түүний зулайд хүрсэнгүй цээж рүү нь хорсолтоёо өгшиглөлөө. Хэдийгээр амь насанд нь халгүй боловч цээж нь тэсэхийн аргагүй өвдөнө. <<Хойшоо ухарч доошоо малтсан амьтан чиний утсын чинээ улаан амь чинь сохор зоосны үнэгүй юм гэж үү? Авъя гэсэн хүн болгонд найр тавиад байж болох хэрэг үү? Чи ийм байдлаар явах юм бол мөрөн голд очоод хэд ч онолгүй хэлхээтэй яс болно доо. Хүрэн хулсны гэлнмаа үхэх гэж байж малгайгаа тэгшлэх гэж оролддог номын тэнэг шавь авчихаад тэр нь хүнд алуулчихаж гэнэ ээ гэж ярьж байвал надад сайхан байх уу>> хэмээн толгой түрүүгүй загнаж гарав.

Багш нь түүнийг бас л сорьж үзсэн болохыг И Да Зин ойлгоод <<Багшийн сургаалд талархая>> гэлээ. Багшийнх нь дуу ихэд аядуу зөөлөн болж шавь минь чи номын хүн ертөнцийн ороо бусгаа ёс ялангуяа мөрөн

голынхны хүчтэй нь хүчгүйгээ идэж зальтай нь зальгүйгээ чадаж явдаг муухай дэг жаягийг мэдэхгүй. Би чамд хоёрхон үг захъя. Чи үүнийг сэтгэлдээ санаж явах аваас сайн нөхөр мэт тусыг өгнө. Энэ болбоос ертөнцийн хүний үнэн үгийг худал, худал үгийг үнэн хэмээн бодож болгоож яваарай. Энэ үгийг чамд хэлээд ч чи сонсохгүй сонслоо ч мөн итгэхгүй гэдгийг би мэдэж байна. Гэвч чи өөрөө л мэдхэ хэрэгтэй. За чи одоо эндээс яв даа гэлээ.

И Да Зин тэсгэлгүй гайхан <<Багшаа энэ чинь юу болох нь энэ вэ?>> гэвэл багш нь өгүүлрүүн <<Ертөнцөд ирсэн гийчин буцдаг номтой. Багш шавь ч мөн ялгаагүй. Одоо цаана чинь мөрөн гол даяараа самуураад байна. Чи одоо сурсан эрдмээ хэрэглэх цаг чинь боллоо. Тэгээд ч чиний голын хайртай Жу Сян Зюнь шулам чинь чамайг хүлээж байгаа шүү дээ>> гэлээ.

Энэ хагас жилийн турш хамт байх хугацаанд багш нь зарим үед зэрлэг догшин мэт санагдах үе байвч их л дотносон ижилссэн байжээ. Салан одохын мөч ирэх үед сэтгэл нь багшаасаа нэг л холдож ядна. <<Чамайг явахаас өмнө багш чинь Жу Сян Зюнь та хоёрын сэтгэлийг амрах нэгэн баяртай мэдээ дуулгая. Чиний бие дэх хор нэгэнт үгүй болсон>>.

<<Гялайлаа багшаа>>.

<<Надад таларлахын хэрэггүй. Чи бид хоёр анх уулзаад судсыг чинь барихад хордлогын ямар ч шинж байгаагүй. Чи болохоор 7 навчит цэцэг идсэн гээд байдаг. Гэтэл хожим чиний ярихыг сонссод хилэнцэт хорхойд хатгуулсныг мэдсэн билээ. Ертөнцийн хувь тавилан гэж сонин юм. Чи хорыг хороор гэж сонссон уу?>>

И Да Зин тэсгэлгүй баярлан <<Хилэнцэт хорхойн хор 7 навчит цэцгийн хорыг дийлсэн хэрэг үү?>> хэмээн асуулаа.

<<Багш чинь 10 хэдэн жилийн өмнө нэгэн уранхай номнон дээрээс 7 навчит цэцгийн хорыг хороор тайлдаг гэж бичсэн байхыг үзсэн юм. Харин чухам ямар хороор тайлдаг нь байгаагүй. Ерөтөнцийн хор олон чухам алийг гэж мэдэх билээ дээ? Хэрвээ ийм учрал тохиолдоогүй бол ганцхан хилэнцэт хорхойн хор ч гэсэн дангаараа чамайг тонилгож дөнгөнө>>.

<<Муу Сян дүүгээ дэмий айлгачихаж дээ>>.

<<Дахиад л өнөөхөө дурсаад эхлэв үү? Би чамайг охинтойгоо суулгаж дөнгөхгүйгээс хойш энэ талаар ярихаа байя. Чи харин уулнаас буусны хойно миний охинд сүй бэлэг бэлдэж болно биз дээ>>.

<<Номын охин дүүд ямар бэлэг бэлдэх билээ та хэлэгтүн. Шавь би амь насаа өрөх байлаа ч гэсэн хамаагүй түүний төлөө зүтгэх болно>> хэмээн И Да Зин хэллээ.

Хүрэн хулсны гэлэнмаа санаа алдаад <<Жу Сян Зюнь гэдэг бяцхан шулам аль насандаа хийсэн буяны үрийг эдэлж хорвоод хосгүй ийм шударга үнэнч эртэй учирдаг байна даа. Шавь минь чи уулнаас буусны дараа надад төмөр, ус, гал, шороо 4 махбодийн бүлгийн толгойлогчдын суурийг булааж миний охины сүй бэлэг болгон авчрах хэрэгтэй. Модон махобдийн бүлгийн толгойлогчийн хувьд гэвэл Жу Сян Зюнь гэж тэр бяцхан эм шуламдаа үлдэг. Миний охинд 4 том бүлгийн толгойлогчийн эрх мэдэл ирнэ гэдэг бага юм биш>> гэж өгүүлэв.

Багшийн хэлэх үг хийх үйлдэл бүхэн нь мөн хачин шүү. Ертөнцөд эд мөнгө, эрдэнэс баялгаар инж сүй бэлддэг байтал хэзээ бүлгийн толгойлогчийн суурийг сүй бэлэг болгож байлаа даа гэж И Да Зин болдсон болов аман дээрээ <<Багш та сая хэлэхдээ номын охин дүү зэвсгийн эрдэм чадахгүй гэж байгаагүй биш үү? Нэгэнт л зэвсгийн эрдэм чаддаггүй юм бол бүлгийн толгойлогчийн суурийг эзэлж яах гэсэн юм болоо?>> гэхэд хүрэн хулсны гэлэнмаа уурсан <<Зэвсгийн эрдэм чаддаггүй ч гэлээ бас сурч болдог юм байга биз дээ. Чам шиг тэнэг мангуу нь дэндсэн үхэр шиг өмхий эр хагас жилийн дотор толбот хулсны 18 цохилтыг сурчихаж байхад миний охин шиг ухаантай сэргэлэн хүн 10, 20 хоногийн дотор хорь гучин цохилт байсан ч сурна>> гэлээ.

И Да Зин хулганан <<Багшаа миний сурсан өчүүхэн эрдэм чадлаар...>> гэхэд

Хүрэн хулсны гэлэнмаа бас л дүрсхийтэл уурлан <<Чи өөрийнхөө эрдэм чадлыг дорд үзнэ гэдэг чинь намайг дорд үзэж байгаагаас ямар ялгаа бахй вэ?>> гэв.

<<Багшийн үгийг зөрчиж яахин болох билээ? Шавь би алтан амиа хайрлахгүй зүтгэн охин дүүгийн сүй бэлгийг бүтээх болно>>.

<<Чи наанаа ингэж хэлж байгаа боловч цаагуураа Жу Сян Зюнийг бодож хэлж байгаа биз дээ би мэдэж байна аа>> хэмээснээ хүрэн хулсны гэлэнмаа дуугаа зөөлтгөн <<Шавь минь чи өөр хүнд ч гэсэн ийм үнэнч сэтгэлээр хандаж байгаад чинь багшийнх нь сэтгэл тааламжтай байна>> гэлээ.

Жу Сян Зюнь сэхээ орон үзвэл мөнөөх Му Дань Ду хатагтайн гоёмсог өргөөнөө сандал дээр хамаг бие нь хүч тамираа алдан суух ажээ.

<<Ээжээ би багшийн талд орж байгаа юм биш шүү. Гэхдээ миний бодоход та наадахь шулмыгаа бодсон хэрэг биш харин танд наадхынхаа хорыг тайлах ерөндөгийг гарган авах арга олдохгүй тул та багшид дийлдлээ гэж бачимдан сандарч байгаа хэрэг биш үү?>> гээд Му Цин Ся тас тас хөхөрлөө.

<<Эмэгтэй хүүхдийн элэг буруу гэж яасан үнэн үг вэ?>> хэмээх зуур Му Дань Ду хатагтайн нүүр улсхийхийг үзвээс Му Цин Ся түүний голыг олоод хэлчихсэн бололтой.

Багш, ээж, хорч Ду авгай, Му Дань Ду хатагтай хор ерөндөг... гээд энэхүү үгс Жу Сян Зюний тархинд эргэлдсээр эцэст нь тэр чухам ямар учиртайг ойлгож авлаа. Тэрээр хорч Ду авгай, Му Дань Ду хатагтай хоёрын эцэс төгсгөлгүй мөрийцөөний хэрэгсэл болон хувирчээ. Нэг нь түүний биед хор хүргэж нөгөө нь түүнийг анагаан хэн чадалтайгаа үзэж байгаа хэрэг байх нь. Тэрээр анх Му Дань Ду хатагтайг зовлон гамшигаас гэтэлгэгч хомьсим бодиства хэмээн бодож байснаа эцэст нь хорч Ду авгайн адилаар хүн алахдаа нүдээ цавчдаггүй шулмын хаан болохыг нь ойлголоо. Тэд нам нийлэн сэм хуйвалдаж хүн алах ажлаар бах зугаагаа хангаж байдаг улс байжээ...!

Му Дань Ду хатагтай охиныхоо юу гэж хэлэхийг ч тоосонгүй Жу Сян Зюний дээрээс тонгойн зөөлөн дуугаар <<Хонгорхон охин минь битгий сандрагтун хоёулаа тайван үзэцгээнэ ээ. Ертөнцөд хэн нэгэн хүн хор хүргэсэн байхад түүнийг тайлах арга гэж байх л ёстой. Чи тайван байж үз хоёулаа ямар ч байсан хэд хоногоос нэг арга олцгоох болно>> гэв.

Энэ ямар танил царай вэ? гэж Жу Сян Зюнь түүнийг анх харахдаа бодож байсан бодол нь түүний тархинд дахин харван орж ирлээ.

Өө нээрээн тийм байх нь. Хорч Ду авгайгийн царайтай туйлын адил байна. Нэг нь залуувтар цагаан царайтай эрхэмсэг баян харин нөгөөдөх нь хөгшин эцэнхий туранхай ядуу хоосон болохоос биш энэ хөмсөг, нүд, уруул ам зэрэг нь яг л нэг хэвээр цутгасан мэт адилхан юм. Түүний дээр хоёулаа Ду овогтой байна. Тэгэхээр тэд өрсөлдөгч дайснууд биш өвөр зуураа сэм хуйвалдсан хамсаатнууд байх нь. Тэрээр анхнаасаа л сэтгэлдээ энэ тухай таамнаж байсан боловч өөрөө түүнийгээ хүлээн зөвшөөрч зүрхлээгүй билээ.

Яагаад гэвэл тэр амь хэлтрэхийн жаахан ч атугай найдлагаа Му Дань Ду хатагтайд тавьж байсан юм.

Хүн гэдэг амьтан гарцаагүй байдалд орчихсон ч гэсэн чимхийн төдий жаахан найдлагаа орхиж гээдэггүй амьтан ажээ.

Му Дань Ду хатагтай Жу Сян Зюнь өөрийг нь сонжин харахыг үзэж улам ч эелдэг зөөлнөөр хандаж <<Охин минь чи санаа зоволтгүй ээ Му Дань Ду хатагтай намайг байхад цаад хорч Ду авгайн хорон санаа амжилт олохгүй гэдэгт найдаж болно>>.

Жу Сян Зюнь хүйтнээр <<Хатагтай байдал нэгэнт ийм болсноос хойш худал хуурамч өгөөмөр дүр үзүүлээд яах гэсэн юм бэ?>> гэлээ.

Му Дань Ду хатагтай цочин гөлөрч <<Хүүхэн минь наадахь чинь юу гэсэн үг вэ? Чи чинь арай солиороогүй биз дээ?>> гэв.

Жу Сян Зюнь өгүүлрүүн <<Би урьд нь ухаан самуурч байсан шиг байна. Харин одоо бол үгүй. Би хэзээ ч ийм ухаан саруул байгаагүй санагдана. Хүн гэдэг үхэхийн өмнө ухаан санаа нь саруулсдаг гэлцдэг. Ду хатагтай би бол нэр гарсан бяцхан шулам билээ. Хүн алж хүрээ талж явахдаа хэзээ ч гар зөөлөн хандаж байгаагүй. Би тухайн үеийн сэтгэлийн хөдлөлөөр л хүн алдаг байсан. Баярлах гомдох бэрхшээх алин боловч сав л хийвэл хүн алдаг байлаа. Тэгэхдээ хүнийг сайн муу эр эм гэж ялгагдаггүй байсан шүү. Ду хатагтай та намайг хэт цэвдэг сэтгэлтэй гэж бодохгүй байна уу?>>

<<Охин минь гэмээ мэдэж байгаа бол гэгээрэхийн тэмдэг гэдэг юм даа>> гэж Му Дань Ду хатагтай хэлэв.

Жу Сян Зюнь толгой дохин <<Хатагтай танд их баярлалаа. Би багаасаа өнчин өрөөсөн өссөн болохоороо тань мэтийн сургааль айлдах хүнтэй учирч байгаагүй. Харин миний багш болохоор тань мэт буян үйлдэхийг зааж сургахгүй харин ертөнцийн нүгэл болгоныг үйлдэж бай гэдэг байсан юм. Тэрээр надад ертөнцийн хүмүүний үнэн үгийг худал худал үгийг үнэн гэж бодож яваарай гэх мэтээр сургадаг байсан юм шүү дээ. Би багаасаа багшийн дээрхи сургаалиар хүмүүжсэн болохоор хорт муу үйлийг тоо тоомшгүй ихээр үйлдсэн. Харин би мөрөн голоор явах болсноосоо хойш миний муу санаа бас л дутуу боловсорсон болохыг олж мэдсэн юм. Миний сэтгэлд бас чиг сайн сэтгэлийн үр хөврөл үлдсэн ажээ. Тиймийн тулд мөрөн голынхны тавьсан урхи зангад орчихоод байгаа юм. Тухайлбал танай багш хорч Ду авгай хорвоод хосгүй хор найруулагч байтал би түүний нүд нүүрийн энэрэл буянтай мэт санагдахад хууртаад түүнд итгэсэн билээ.

Харин миний бодоход түүнд нэгэн сайн чанар байгааг хэлэхгүй өнгөрч болохгүй. Тэрээр хүн алахаас биш амьтан алдаггүй. Үнэн хэрэгтээ амьтан хүн хоёрыг харьцуулж яахин болох вэ? Тэгээд ч тэр хүн алах хутгаа сугандаа нуудаггүйг нь бахдаж эр хүн шиг хүн гэж бодож байна. Харин та болбоос нэрэн дээрээ хор тайлагч боловч нидэр дээрээ бас л хүн алагч яргачин юм байна. Тийм болохоор би танай эгчийг биширч дүү нь болох таныг үзэн ядаж байна>> гэлээ.

Му Дань Ду хатагтайн царайд гайхширал тодрон амандаа <<Эгч нь гэж хэн дүү нь гэж бас хэн байх билээ>> хэмээн бувтнав.

Жу Сян Зюнь өгүүлрүүн <<Танай эгч гэж хорч Ду авгай дүү нь гэж их нэр нь даяар дуурссан Му Дань Ду хатагтай та болохыг би тэнэг хүн ойлгогдохоор тод хэлсэн санагдана>> хэмээн Жу Сян Зюнь хэллээ.

<<Ха ха ха>> хэмээн Му Цин Ся гэнэт тачигнатал инээн газар өнхрөн унаад хоёр нүднээсээ нулимс гартал хөхөрч байснаа гэнэт инээхээ больж <<Ээжээ та наадхийнхаа дэмий балай донгосохыг бүү сонсогтун. Хүн үхэхийнхээ өмнө ингэж худлаа үнэн донгосдог юм гэнэ лээ. Харин хоёулаа одоо жинхэнэ ажлаа ярьцгаая. Та тэгээд манай багшийг ялж дөнгөнө гэж бодож байна уу?>> хэмээн асуув.

Му Дань Ду хатагтай царай барайн <<Цин Ся ээж нь ч энэ удаа баларсан байхаа бүрмөсөн балраад байна>> гэлээ.

Му Дань Ду хатагтай уртаар санаа алдан хажуу тийшээ өнхрөн унах агшинд Му Цин Ся самбаачлан түүний хэдэн хөдөлгөөнгүй болгодог цэгийг нь хатгаж орхив.

Му Цин Ся Жу Сян Зюний өмнө хүрч ирээд түүнийг ар нуруундаа үүрч гадагшаа яаран зүглэв. Энэхүү хэрэг явдал хэдхэн хормын төдий л болсон тул Жу Сян Зюнь бүүр алмайрч орхив.

Жу Сян Зюнийг Му Цин Ся үүрсээр их танхимын голд байх нэгэн жижиг хаалгаар гарахад өөдөөс нь түнэр харанхуй угтан авлаа. Жу Сян Зюнь Му Цин Сягийн нуруун дээр үүрүүлчихээд нэгэн шатаар дээшээ өгсөж байгаагаа мэдэрлээ. Ийн явсаар сэрүүн салхи нүүрийг нь үлээхээд нүдээ нээн харвал Му Цин Ся түүнийг үүрсээр нэгэн хуучин булшны доороос гарч ирж байлаа.

Саран авхай тэнгэрт мандан энэ хавийн булш бунхнуудыг гийгүүлэх бөгөөд хойд талд нь хэсэг төгөл ой байхаас өөр эргэн тойронд юу ч үгүй мэлцийм тал үргэлжилэхээс бус гоёмсог орд харш гэх юмны бараа туруу ч алга байлаа. Тэрээр арай чөтгөртэй учирсан юм гэж үү? Хорч Ду авгай Му

Цин Ся нар бүгд чөтгөр шулам байсан юм гэж үү дээ? Тэрээр энэ арван хэдэн хоногийн дотор чөтгөрийн хүрээлэлд байсан юм биш байгаа даа. Хүн алахдаа нүдээ цавчдаггүй асан Жу Сян Зюнь энэ удаа хамаг бие нь хүйт даагаад явчихлаа.

Му Цин Ся түүнийг газар тавьж нэгэн булшны чулууг түшүүлэн суулгаад өврөөсөө нэгэн үрэл гаргаж түүний ам руу чихээд <<Жу овогт дүү минь наад үрлээ идсэний дараагаар удахгүй хөдөлж чаддаг болно. Чи санаа зоволтгүй ээ наанаа хөдлөхгүй сууж бай. Би хурдхан шиг нэг ажил амжуулчихаад эргэн ирж чамайг үдэн явуулах болно>> гэлээ.

Ийн хэлчихээд Жу Сян Зюнь хариу хэлэхийг ч хүлээлгүй доош бөхөсхийн мөнөөх булшны зүг эргэн орлоо.

Хэдхэн агшид болсон энэхүү хэрэг явдал түүний өнгөрсөн арван хэдэн хоногт үзэж туулсан үйл явдлаас ч илүүтэй хачин сонин санагдсан бөгөөд чухам юу болоод байгаагийн учрыг тэрээр ухан ойлгож чадсангүй. Харин Му Цин Сяг далд орсны дараагаар л Му Дань Ду хатагтайн орд өргөө нь нэгэн булшны доор байрладаг учраас газар дээр байхад ажиглагддаггүй байсан юм байна гэдгийг л мэдэж авлаа. Му Цин Сягийн үг яриаг сонсоход багшдаа илүү юм шиг атлаа яагаад тэрээр гэнэт түүнд туслахаар болдог билээ. Тэр Му Цин Ся өөрт нь 7 навчит цэцгийн хор уулгаж байхдаа хичнээн их үзэн ядаж хорсож занасан байдалтай байсныг эргэн саналаа. Тэгээд Му Цин Ся лав өөрийн гараар өшөөгөө авхаар шийдээд түүнийг хорч Ду авгай болон Му Дань Ду хатагтай нарын гараас мулталсан бололтой гэсэн бодол сэрхийн орж ирлээ. Тэр одоо түүнийг яаж тамлан зовоох болдоо. Хорч Ду авгайн хэрхэн тамлаж байсан нь түүнд бага санагдсан юм байх даа.

<<Түүний эргэн ирэхийг хүлээх хэрэггүй. Эндээс хурдхан шиг холдох хэрэгтэй>> гэж өөртөө хэлээд ухасхийн босох гэсэн боловч хөдөлж ч чадсангүй. Хамаг бие нь өөрийн мэдэлгүй болсон байлаа. Шөнийн харанхуй улам өтгөрч хурын бараан үүлс гэгээн цагаан саранг халхаллаа. Арын төгөл ойгоос шилүүсний дуун хэн нэгэн инээх мэтээр зэвүүн дуулдаж хамаг биеийг арзайлгана. Хуучин булшны цаанаас ямар нэгэн хээрийн амьтан толгойгоо бултайлган харах мэт санагдаж зэрлэг жирхрээ зэвүүнээр дуугарах нь сэтгэлд хүйтэн.

Жу Сян Зюньд шөнийн энэхүү байдал хачин аймшигтай санагдаж эхэллээ. Түүнд одоо хорч Ду авгай Му Дань Ду хатагтай хэн ч байсан гэсэн хамаагүй дэргэд нь хань болж байгаасай гэсэн этгээд бодол төрлөө. Му Цин Ся яагаад эргэж ирэхгүй байн вэ? Тэр эргэж ирээд түүнийг яаж ч тамлан

зовоодог байлаа гэсэн хамаагүй энэхүү эзгүй зэлүүд хүүрийн газар ганцаараа байснаас хавьгүй дээр санагдана.

Хагас цаг орчим болоод Му Цин Ся эргэн ирлээ. Тэр энэ удаа хуучин булшны доороос биш зүн өмнө зүгээс гүйн гарч ирлээ. Гартаа Жу Сян Зюний цайны газарт орхисон арга билгийн муныг барьжээ.

<<Гайгүй болж байна уу?>> хэмээн Му Цин Ся асуухад Жу Сян Зюнь хариу хэлсэнгүй. Тэр сая сэтгэлдээ Му Цин Сяг үгүйлж байсан бол одоо түүнийг үзэн ядахын сэтгэлдээ шатаж байлаа. Түүний өмнө байгаа энэ үзэсгэлэнтэй атлаа атаа хорсолтой хүүхнээс болоод тэр өдгөө ийм байдалд ороод байгаа билээ. Хэрвээ түүний нөхөр нь 7 навчит цэцгийн хороор Зин ахыг нь хордуулаагүй бол тэр өнөөдөр мөрний өмнөд нутагт ирэхгүй байсан. Мөрний өмнийг зориогүй бол хорч Ду авгай, Му Дань Ду хатагтай гэсэн хоёр хамсаатантай учирч хорны хүүдий болон хувирахгүй байсан юм...

Тэрээр Му Цин Сяг хорсолтойгоор ширтэн харж байлаа.

Му Цин Ся уртаар санаа алдаад гэнэт хоёр гараа сунгаж Жу Сян Зюний ар зоонд байдаг <<Тахилын тавцан>> хэмээх цэг дээр алгаа наалаа. Тэр даруй Му Цин Сягийн хоёр алгаар дотоод хүч дамжин түүний бие рүү урсан орж ирэхийг мэдрэв. <<Чи чинь яаж байн вэ?>> хэмээн Жу Сян Зюнийг гайхан асуухад Му Цин Ся <<Бүү дуугар>> гэлээ.

Хоёр цаг гаруй ийн байсны эцэст Му Цин Ся хамаг бие нь тамирдан ядарсан бололтой хоёр гараа буулгаж өгүүлрүүн <<Миний дотоод хүч үүнээс илүү гарахгүй юм шиг байна. Жу овогт дүү минь чи одоо ингээд яв даа. Нэг аятайхан газар олж хэд хоног амраад буцах аяаа бодсон чинь дээр. Чиний дотоод хүч чинь удахгүй сэргэнэ>> гэлээ.

Жу Сян Зюнь амиа аврагдсаныг сая л ойлголоо. Гэвч тэр яахаараа түүний амийг авардаг билээ. Тэр хоёрын өс хонзон далай мэт арвин биш билүү?

Му Цин Ся түүний нүдэнд тодорсон гайхширлыг олж хараад <<Жу овогт дүү минь чи надаас юу ч асуухын хэрэггүй. Хүн эхийн хэвлийгээс төрөөгүй байхад л төөрөг заяа нь цаанаасаа зурагдсан байдаг шиг байна. Хүн заяа төөргийн эрхээс гажиж яахин чадах билээ?>> гэв.

<<Му эгчээ... Та яагаад намайг аварч байгаа юм бэ? Би чинь таны өстөн дайсан биш билүү?>>

<<Үгүй хаанаас даа чи миний өстөн дайсан биш>> хэмээн өгүүлэхийг үзээд Жу Сян Зюнь ихэд гайхан <<Би таны хэлсэн үгийг ерөөсөө ухахгүй байна>> гэхэд Му Цин Ся <<Чи байтугай би ч өөрөө олон зүйлийн учрыг

олохоо байчихлаа. Хүн үхэхийн өмнө ухаан санаа нь саруул болдог гэж чиний хэлдэг түмэн зөв. Би үхэх нь болоогүй болохоороо л ийм тэнэг мангуу хэвээрээ байгаад байж магадгүй. Харин би чамаас нэгэн зүйлийг хүсэлт болгон гуйх гэсэн юм>> гэв.

<<Му эгч та миний өчүүхэн амийг аварсан болохоор надад талархаж хэлэх үг ч олдохгүй байна. Му эгч танд ямар хүсэлт байна вэ? Түүнийг хэл л дээ>> хэмээн Жу Сян Зюнь өгүүллээ.

<<Миний багш хорч Ду авгай хэдийгээр хийж буй үйл нь хэний ч айдас хүрмээр харгис атлаа дотоод сэтгэл нь сайхан хүн юм шүү. Хөөрхий тэрээр эмэгтэй хүний нэг насны амьдралд үзэж туулаад баршгүй их зовлон гамшгийг амссанаас болод ийм янзтай болчихсон юм. Тэрээр бусдыг хордуулах талаар өөр түүний зэрэг зиндаанд очих хүн гэж үгүй боловч зэвсгийн эрдмийн хувьд тийм гоц гойд юм байхгүй. Миний санахад хожим хойно чи мөрөн голыг доргиож зэвсгийн эрдмийн ертөнцөд хаан суух буй за. Тиймийн тул эрт орой хэзээ нэгэн цагт багш маань чиний гарт орох нь лавтай. Тэр цагт чи миний нүүрийг бодоод багшийн маань амийг хэлтрүүлж өгөх буй за>> гэлээ.

<<Му эгчээ санаа амар байгтун>> гэх зуур Му Цин Ся гагц багшийгаа захиж ээжийгээ дурсахгүй байгааг анзааран <<Харин Му Дань Ду хатагтайг яах вэ?>> гэлээ.

<<Тэр үхчихсэн. Үүнээс хойш мөрөн гол даяар гагц хорч Ду авгай гэж байхаас биш Му Дань Ду хатагтай гэж байхаа больсон>> гэж Му Цин Ся гунигтай өгүүлэв.

Газар дорхи орд өргөөнд байхад Му Цин Ся ээжийнхээ эмзэг сэтгэлийг дайруулсан үг хэлэхэд уулаас омог бардам зантай Му Дань Ду хатагтай бахардан унахад нь Му хүүхэн түүнийг авраагүйгээр эс барам харин ч түүний хөдөлгөөнгүй болгодог цэгийг хатгаж тэр самбаандаа Жу Сян Зюнийг барын амнаас салган гаргаж ирсэнийг санаад Жу Сян Зюний сэтгэл эвгүйрхэн халгаж ядсан байдалтай <<Му эгчээ арай надаас болоод танай ээж чинь...>> гэв.

Му Цин Ся түүний үгийг таслан <<Тэр аль эрт үхэх ёстой байсан юм>> гэлээ.

<<Гэхдээ тэр чинь таны төрсөн эх биз дээ>> хэмээн Жу Сян Зюнь хоёр чихэндээ итгэсэнгүй асуулаа.

<<Тэр л түүний алдаа болсон юм>>.

Жу Сян Зюнь түүний ингэж хэлэхэд бүүр ангайтлаа гайхан хэрвээ тэр өөрийнх нь амийг авраагүй байсан бол алгадаж тэр ч байтугай алахаас буцахгүй байлаа.

<<Му эгчээ би танц цаад талд юу байдгийг мэдэхгүй боловч хүн жаргал даадаггүй гэдэг нь болж байгаа юм биш биз гэдгийг хэлмээр байна. Би бол багаасаа эцэг эхгүй өнчин өрөөсөн өссөн болохоор багшийнхаа гар дээр өдий зэрэгтэй болсон. Багш маань надад төрсөн охиноосоо өөрцгүй ханддаг байсан л даа. Гэвч би зүүд нойрондоо хүртэл ээжтэй байхыг хүсэн мөрөөдөж ээжээ гээд уйлан босч ирдэг байж билээ>> гэж хэлэх зуур Жу Сян Зюний нүдэнд нулимс гялтганан <<Гэтэл та...>> гэв.

Му Цин Ся түүний толгойг тэврэн авч элгэндээ наагаад <<Чи юу ч мэдэхгүй ээ Жу овогт дүү минь би багш, ээж хоёрынхоо хэн нэгийг сонгох хэрэгтэй байсан юм. Тэгээд багшийгаа сонгож авлаа. Өөрөөр хэлбэл миний багш, ээж хоёр буюу хорч Ду авгай, Му Дань Ду хатагтай хоёр чинь өөр өөр улс биш нэг хүн байгаа юм!... Одоо чи ойлгов уу? Үгүй ээ мэдээжийн хэрэг тийм амар хялбар ойлгохгүй байх. Энэ дундахь учир шалтгааны холбоосыг бурхан сахиус ч ойлгоход нэн бэрхтэй>> гэлээ.

Жу Сян Зюнь гашуунаар инээмэглэн <<Му эгчээ та бүүр миний толгойг ганц сайн эргүүлж орхилоо>> гэхэд Му Цин Ся зугуухан өгүүлрүүн <<Урьд цагт нэгэн гэнэн цайлган охин ер бусын үзэсгэлэнтэй баатар эрд дурлажээ. Гэтэл цаад эр нь түүнийг өрөөсөн нүдээрээ ч тоож харсангүй. Гэвч нэгэн өдөр гэнэ цайлган охин хүслэнт залуугийнхаа идээ ундаанд хүсэл оргилуулагч шидэт эм хийж түүнд уулгаад түүнтэйгээ нэгэн шөнийн эр эм бололцсон гэдэг>> гэхэд Жу Сян Зюнь <<Тэр баатар эр түүнд хайргүй атлаа яагаад түүнтэй эр эм бололцдог билээ? Ёстой өөдгүй амьтан байж>> хэмээн өгүүлэхэд Му Цин Ся залгуулан <<Хамаг гай барцад тэр шиэт эмнээс үүдсэн хэрэг>> гэхэд Жу Сян Зюнь толгой сэгсрэн <<Ямар ч хүчтэй эм байгаад сэтгэлгүй хүнийг сэтгэлтэй болгочихно гэхэд би л хувьдаа итгэхгүй>> гэлээ. Му Цин Ся өгүүлрүүн <<Жу овогт дүү минь ертөнцөд сонин хачин юм элбэг баян гэдгийг чи бага балчир болохоороо яахин ойлгож мэдэх билээ дээ>> гэлээ.

Жу Сян Зюнь сая л Му Цин Сягийн хэлдэг эр эм бололцохын учрыг ойлгож өөрийн эрхгүй царайгаа улалзуулан өгүүлрүүн <<Тэгээд тэр хоёр эр эм бололцоод гэнэн цайлган охин сэтгэлт хүнтэйгээ учирч амар сайхандаа жаргаа биз дээ? Өөр ямар нэгэн муу үр дагавар гарсан юм уу?>> гэж асуухад Му Цин Ся өгүүлрүүн <<Эр эм улс хамтран амьдрахад хайр сэтгэл

голлох үүрэгтэй. Гэтэл нөгөө гоо залуу баатар охинд өчүүхэн ч хайр сэтгэлгүй болохоор яахин тэндээ тогтож сууж чадах билээ дээ? Маргааш өдөр нь гэрээс гарч яваад дахин эргэж ирээгүй гэдэг. Хөөрхий охин сэтгэлийн тамд унаж нөгөө сэтгэлтэй хүнээ үзэн ядаж чадахгүй гагцхүү өөрийн тэнэг булай үйлдлээ хорсон бодсоор хорвоод хосгүй хор найруулах эрдэмд суралцжээ. Тэр цагаас хойш өдөр нь хүн амьтныг хордуулан зугаагаа гаргаж шөнө нь тансаг сайхан орд өргөөнөө залран хордуулсан хүнийхээ хорыг эдгээх үйлээр хорвоо дэлхийн өдөр хоногийг өнгөрөөж байдаг болсон байна>>.

<<Аа би одоо л хамаг учрыг ойлголоо. Өдөр нь хорч Ду авгай байгаад шөнө нь Му Дань Ду хатагтай болон хувирдаг байсан юмуу? Гэвч тэр сэтгэлтэй залуу нь дэндүү хорон муу санаатай хүн юм. Хожим би түүнтэй тааралдвал 18 илдийн аргаараа тасар татан хаях болно. Манай багшийн надад байнга л хорвоогийн эрчүүдэд олигтой хүн байхгүй гэж сануулдаг нь ийм учиртай байжээ>> хэмээн Жу Сян Зюнь хэллээ.

<<Жу дүү минь тэр хүн чинь сайн муу алин боловч миний эцэг гэдгийг сайн бодоорой доо>> хэмээн Му Цин Ся сандран өгүүлэхэд Жу Сян Зюнь <<Му эгчээ та дэндүү зөөлөн сэтгэлтэй юм. Тийм ач энэрэл журам ёсгүй эцгийг хорвоо дэлхий дээр үлдээгээд ямар хэрэг байна даа? Би л байсан бол хөөрхий золгүй эхийнхээ өмнөөс өшөөг нь авах байсан>> гэлээ.

<<Ертөнцийн олон хэргийн дундаас сэтгэлийн тооцоог бодоход хамгийн хэцүү гэсэн үг байдаг юм. Чухам хэн нь хэнийгээ хуурсан гэдгийг хэлэхэд нэн бэрх л дээ. Одоо нэгэнт Му Дань Ду хатагтай үхсэнээс хойш энэ ертөнц дээр ганц хорч Ду авгай л үлдлээ. Тийм болохоор Жу дүү чи намайг ээжтэйгээ дахин хамт байх боломж олгосон өгөөмөр ачийг чинь би насан туршдаа мартахгүй>> гэж Му Цин ся өгүүлэв.

Ийн өгүүлэх зуур гэнэт дууны өнгөө өөрчлөн <<Бяцхан шулам минь чи нэгэнт 7 навчит цэцгийн хорыг уусан болохоор амь аврагдах ерөндөг гэж үгүй. Хэдхэн хоногийн дараа үхэх болно. Адилхан мөрөн голын хүмүүс юм байна гэдгийг бодолцон би чамайг энэ удаа тавьж явуулъя. Чи хурдан явахгүй юугаа хүлээсэн юм бэ?>> гэж хэллээ.

Му Цин Сягийн дууны өнгө аяс гэнэт ийн хувирахыг үзээд Жу Сян Зюнь ихэд гайхан балмагдаж хариу хэлж завдаагүй байтал гэнэт хуучин булшны араас нэгэн хатангир туранхай сүг сүнс шиг юм гарч ирээд зэвүүнээр хөхөрч <<Хөөрхөн шавь минь наадахь чинь явахаасаа өнгөрсөн дөө>> гэлээ.

Хорч Ду авгай албин чөтгөр мэт сүүтгэнэсээр тэдний өмнө хүрч ирэн зогслоо.

И Да Зин уулнаас буусан даруйдаа шууд л модон махбодийн бүлгийг зорьж Жу Сян Зюньтэй уулзахаар явлаа.

Нэг номыг дуусгахад нөгөө номын хийморь сэргэж байдаг гэгчээр И Да Зин толбот хулсны 18 цохилтыг гартаа оруулснаар түүний хөнгөний тамир ч ихээхэн сайжирчээ.

Шар бүрийн үед цааш замаа хөөж явтал хэн нэгэн хүн түүний араас <<Хөөе И овогт зулбасга уу даа?>> хэмээн хашгирах сонсогдов.

Тэр мөрөн голоор үзэгдээд ганц ч хоноогүй байтал хэн түүнийг таньж ийн нэр усаар дууддаг билээ? гэж санаад эргэн харвал анжис мөрлөсөн нэгэн хүн түүний араас нисэх мэт хурдлан айсуй. Тоорын цэцэгт сууринд харж байсан шороон махбодийн бүлгийн толгойлогч Ту Ди Хан болохыг тэрээр төвөггүй танилаа.

Агшин зуурын төдийд Ту Ди Хан И Да Зингийн өмнө хүрч ирэхэд И Да Зин <<Ту ах та надтай уулзах ямар хэрэг байна даа?>> гэхэд Ту Ди Ханы нүд гархилан эргэлдэж <<Хэрэг зориггүй бол чамаар яах болж байна>> гэлээ.

Ту Ди Хан салахгүй зууралдаад байж мэдэх хүн тул түүнтэй цаг үрэхийг хүссэнгүй гараа элгэндээ барьж <<Ту ах замын хүзүү урт зааны хүзүү богино гэдэг дээ. Хожим хойно хойчийн маргааш эргэж уулзвал яасан юм бэ?>> гэлээ.

Хүрэн хулсны гэлэнмаа хэдийгээр адайр түрэмгий зантай боловч юмны наад цаадхыг ухаж бодохдоо сайн хүн тул И Да Зинг явахаас өмнө мөрөн голынхны хэлэлцдэг үг яриаг чамгүй зааж сургасан билээ. Харин И Да Зин угаас номын хэнээтэй хүн тул тэр зангаараа хэлж заасан үгсийг ном цээжилж байгаа мэт яс тогтож авсанаас бус саяын хэлсэн үгс нь мөрөн голынхон ихэвчлэн дараа уулзаж өс хонзонгоо тайлъя гэсэн далд утгатай болохыг нь ухаж ойлгож аваахгүй юм.

Ту Ди Хан цочисхийх мэт болж <<Энэ тэнэг чинь юу болод ийм дэмий балай юм яриад эхлэх нь энэ вэ>> гэхэд

<<Мулгуу дүү би чинь мөрөн голоор яваад удаагүй сурсан эрдмээр ч мөхөс тул ах та аядуу зөөлөн хандах буй за>> хэмээн И Да Зин залгуулан өгүүлэв.

<<Чи чинь бүр тулалдахаар шийдээ юу?>> хэмээн Ту Ди Хан хэлэв.

<<Мөхөс миний өчүүхэн эрдэм чадлаар яахин таны энд зэрэгцэж чадах билээ? Гэвч хааяа нэг тулалдахад ганц нэг удаа азаар ялах тохиолдол байхыг хэн мэдэх вэ>> хэмээн И Да Зин хэллээ.

Ту Ди Хан ихэд уурсан <<Чи тулалдаж эхлээгүй байж яаж ялах дийлэхээ мэдэж байгаа хэрэг вэ? Алив муу турсага минь хоёулаа эр чадлаа үзэцгээе>> гэв.

И Да Зин Ту Ди Ханыг тулалдахаар зэхэхийг үзэж дотроо ихэд бачимдан сандарч <<Наадах чинь юу болж байн вэ? би хэдийгээр эрдэмт багшаар чамгүй эрдэм заалгасан боловч тантай тулалдах хүсэл алга>> гэв.

Хүрэн хулсны гэлэнмаа угаас өөртөө итгэлтэй байхыг голлодог хүн тул И Да Зинд эв найрыг эрхэмлэх бууж өгөх талын хэл яриа ганцыг ч зааж өгөөгүй юм. И Да Зин Жу Сян Зюньтэй л уулзахаар яарч Ту Ди Хантай орооцолдохыг хүсэхгүй боловч эсрэг этгээдтэйгээ эвээ ололцон явах үг хэлийг мэдэхгүйн улмаас улам ихээр сандарч өөрөө өөрийгөө ял зэмд унагаж байлаа.

Ту Ди Хан өөрийг нь басамжилж байна хэмээн уур нь шатаж <<Танай багш чинь хэн бэ?>> гэлээ.

<<Манай багш бол өнөөгийн зэвсгийн эрдмийн ертөнцийн сүмбэр оргил болсон хүн байдаг юм даа>> хэмээн И Да Зин өгүүллээ.

<<Тэгвэл Жинь Кан Лун баатар байх нь ээ>> гэж Ту Ди Хан асуулаа.

<<Жинь баатрыг яахин манай багштай эн зэрэгцүүлж болох юм бэ?>> хэмээн И Да Зин хэллээ.

<<Тэгвэл Хуо Шао Чун баатар уу, журамт бүсгүй Му Цин Ся юу эсвэл Шуй Да Юнь баатар уу?>> хэмээн асуух тоолонд И Да Зин толгой сэгсрэхийг хараад <<Ам нь халж арай шороон махбодийн бүлгийн толгойлогч Ту Ди Хан биш биз дээ. Үгүй хаанаас даа. Ту Ди Хан би 8 төрөлдөө сохор явлаа ч ийм адгийн тэнэг мангуу хүнийг шавиа болгож авахгүй>> гэлээ.

И Да Зин учир зүггүй толгой сэгсрэн <<Таны саяын нэрлэдэг хүмүүс өнөөгийн мөрөн голын зартай баатрууд яах аргагүй мөн боловч яахин манай багштай эн зэрэгцүүлж болох билээ? Тур тусмаа таны хувьд ярих юм бол зэвсгийн эрдэм, хүн чанар аль ч талаараа гэсэн хүний хүндэтгэл хайрыг булаахаар хүн мөн үү дээ>> гэлээ.

Чи хэн болоод намайг ийм өчүүхэн багад үзнэ вэ? Алив хоёулаа эр чадлаа үзэлцээд чи миний анжисны ирийг гурвантаа даван гарч чадах аваас би танай багш аргагүй мөрөн голын сүмбэр уул юм байна гэдгийг хүлээн зөвшөөрье гэлээ.

Энэ хүн Хуо Шао Чун, Шуй Да Юнь нартай хамсан Жу Сян Зюнийг бүслэн довтолж байхдаа хамгийн хэрцгий догшин нь байхыг харж мэдсэн тул яахин зориглон тулалдах билээ. Яаран арагш ухраад

<<Хаанаас даа И Да Зин би яахин сурсан эрдэм эр бяраараа өчүүхэн дордсыг дээрэлхэж чадах билээ?>> гэв.

Төмөр, мод, ус, гал, шороо 5 махбодийн бүлгийн толгойлогчдын дунд Ту Ди Хан үг хэлээр хамгийн бэрхэд тооцогдох боловч өнөөдөр И Да Зингийн өмнө ийнхүү хошуугаа таглуулсан гүц шиг дуугүй гүлдийж зогсож буйгаа мэдрээд инээд алдан <<И баатар эрхэм дээдэс минь мөхөс би таны эрдэм чадал ид хавыг нүдээр үзэж биеэр амсмаар байна>> гэлээ.

<<Үгээ ч зөв олж хэлж чадахгүй гэдэг нь. Өнөөдөр зэвсгийн эрдмийн ертөнцөд манай багш хүрэн хулсны гэлэнмаагаас өөр хэн эрхэм дээдэс гэж өргөмжлүүлэх эрхтэй билээ>> хэмээн И Да Зин өгүүлэхэд

Ту Ди Хан түүний багшийнхаа нэрийг ам алдахыг үзээд толгойгоо гилжийлгэн хэсэг зуур бололхийлсэнээ <<Чиний багшийн нэрийг чинь тэгвэл хүрэн хулсны гэлэнмаа гэдэг байсан юмуу гэвч урьд өмнө сонсогдож дуулдаж байгаагүй юм байна шүү>> гэлээ.

<<Тэр чинь аргагүй шүү дээ. Манай багш чинь ертөнцийн амьдралаас тасраад аглаг ууланд даяанчилан суусаар олон жил болж байгаа юм. Түүнийг байхгүй хойгуур мөрөн голынхон эрх мэдлээ булаалдан тэмцэлдэж байгаа нь бурхангүй газрын бумба галзуурна гэгч болж байгаа юм даа>> гэж И Да Зин хэлэв.

Ту Ди Хан өгүүллрүүн <<И баатараа чи ямар алдаа гаргаснаа мэдэж байна уу?>>

<<Ямар алдаа гаргасан юм бэ?>>

<<Хэрвээ чи багшийнхаа нэрийг хэлэхгүй чигээрээ байсан бол би ямар ч хүн байх юм билээ гээд чамд аядуу зөөлөн хандаж болох байсан юм. Харин чи одоо хэн ч нэр усыг нь урьд өмнө дуулж мэдээгүй хүний нэрийг дурдаад эхлэхээр би одоо айх эмээх зүйлгүй болж модон махбодийн толгойлогч Му Цин Сягийн өшөөг авч чамайг тонилгох болно доо>> гэж Ту Ди Хан инээв.

Тэрээр ийн өгүүлээд анжисны хошуугаа түүн рүү чиглүүлэн дайрч эхлэв. И Да Зин ир нь гялалзсан хурц анжисны үзүүр түүнийг чиглэн довтлон ирэхийг үзээд сандран арагшаа ухартал хөл нь модны хожуулд тээглэн золтой л тээглэн уначихсангүй. Анжисны үзүүр сүүдэр мэт дагасаар энэ удаа түүний цээжийг биш ялимгүй дээшээ өргөгдөн толгойг нь хяргахаар чиглэлтэй болсон байлаа. Толгойгоо алдчихвал юугаараа хоол идэх болж байна гэсэн шүү юм бодогдсон боловч чухам яах учраа олохгүй балмагдах хооронд нөгөө хөнгөний тамир салхи гүйцэгч 18 цохилт хаашаа алга болсныг бүү мэд.

Тэрээр ийн арга мухардан байх үед шумуулын дүнгэнээ мэт үл мэдэгхэн атлаа ер бусын тод дуун гарч <<Гал махбодийн үг эргэж түүний тахилын тавцан цэгийг довтол>> хэмээн хэлэх нь сонсогдов.

И Да Зин гайхах баярлах хосолж <<Багшаа багшаа та хаана байна вэ. шавь нь балраад байна шүү>> гэлээ.

<<Сандарсан үедээ сахиус бурхнаа санах>> гэгч болж байх шив дээ. Одоо чиний багш чинь өөрийн биеэр ирлээ ч чамайг аврахаас өнгөрсөн байхаа хэмээн хэлэх зуур анжисны хошуу нь И Да Зингийн хоолой дээр тулан ирлээ. Сандрахад самбаа төрдөгийн үлгэрээр И Да Зин багшийнхаа зааснаар түүний хажуугаар тойрон цахилгаан мэтээр хурдан шалмаг хөдөлж ард нь гарлаа.

Ту Ди Хан гайхан сандарч <<Энэ чинь ямар чөтгөр шүглэхээрээ ийм айхтар болчихдог байна вэ?>> хэмээн өгүүлээд эргэж завдаагүй байтал И Да Зингийн долоовор хуруу нь түүний тахилын тавцан цэгийг дарж амжжээ. Хэрвээ тэр дотоод хүчээрээ ялимгүй довтолвол Ту Ди Хан амь тавих нь гарцаагүй байв.

И Да Зин баяралн <<Багшийн арга ч аргагүй лут юмаа. Шавь нь түүнийг гартаа оруулаад авлаа>> гэв.

Нөгөө шумуулын дүнгэнээ шиг дуу хөхрөх нь сонсогдож <<Өмхий золиг минь чи юундаа баярласан юм бэ? Хурдан наадхаа алаад шороон махбодийн бүлигийн толгойлогчийн ширээг охины минь сүй бэлэг болгон аваач>> гэв.

И Да Зингийн царай үрчийж <<Би хүн алж чадахгүй байхаа...>> гэлээ.

Баатар эрс ид чадлаа үзэж байхад яахин хормын төдий ч алгуурлаж болох билээ дээ. И Да Зингийн бувганаж байх хооронд Ту Ди Хан самбаачилан биеэ огцом мурин эргэж анжисны хошуу түүнийг дахин чиглэн ирэхэд И Да Зин бултахаас өөр аргагүй байдалд хүрэв. Ту Ди Хан тэр

хооронд нэгэн алд орчим газар үсрэн холдоод <<Ичгэвтэр юм болох шахлаа>> гэж бодов.

<<Харамсалтай хэрэг боллоо. Шавь минь толбот хулсны 18 цохилт бол хорвоод хосгүй эд шүү. Чи сайн хичээгээрэй. Багш нь явлаа>> хэмээн багш нь өгүүлэв.

<<Багшаа би таныг байхгүй бол би яах болж байна вэ...>> хэмээн И Да Зин хашгирсан боловч дахин хариу хэлэх сонсогдоснгүй.

Хүрэн хулсны гэлэнмаа И Да Зинг явсны дараа сэтгэл түвдсэнгүй араас нь сэмхэн дагасан юм. Тэрээр Ту Ди Хантай тулалдах үед аюулд ороод байхад нь авиа дамжуулан нууцад хүрэх аргаар түүнд мултрах аргыг зааж өгөөд байнга ингээд байвал түүнийг бие даах чадваргүй амьтан болгочихно гэж санаад явсан нь дээр юм байна гэж шийдсэн юм.

Түний хэрэглэсэн авиа дамжуулан нууцад хүрэх арга нь зөвхөн хэлэх гэсэн хүнд л очдог болохоос биш бус хүн тохой залган суусан ч түүнийг сонсож чаддаггүй онцлогтой юм. Тиймийн тул Ту Ди Хан анхлан И Да Зинг ганцаараа яриад эхлэхээр нэг их онц юм болгож бодоогүй боловч дараа нь түүний довтолгоон гэнэт ширүүсээд эхлэхийг үзэж нилээд болгоомж төрөн <<Энэ золиг чинь үнэхээр сайн багшийн шавь болчихсон юм биш байгаа. Сайн эр санаагаа таниулдаггүй. Дахан доороос эр гэдэг үг бий шүү. Наанаа мангар царайлж байгаад цаагуураа яаж ч хорлож мэдэх юм. Ту Ди Хан би насаараа тэр олон тулааныг туулж өнгөрөөчихөөд ийм амьтны гарт ялагдаж болохгүй>> хэмээн сэтгэлээ.

Тийн бодоод анхаарлаа хөвчлөн түүнийг хүлээлээ.

И Да Зин багшийнх нь зааж өгсөн ганц арга мэх бардам түрэмгий Ту Ди Ханы омгийг дарахыг хараад өөртөө ихэд итгэл төрж хүн алж чадахгүйгээ мэдэх боловч багшийнхаа охинд 4 махбодийн бүлгийн толгойлогчийн суурийг булаан эзэлж сүй бэлэг болгон өгөхөөр ам гарснаа санаж өгүүлрүүн <<Ту баатраа саяынхыг эс тооцож дахин шинээр эхэлвэл ямар вэ?>> гэхэд Ту Ди хан <<И баатар та өөрөө ямар болзол тавихыгаа хэл л дээ>> гэв.

<<Хоёулаа гурав тулалдаад гурав дийлсэн нь ялсан болог>> гэлээ.

Ту Ди Ханы сэтгэл сэрхийж зэвсгийн эрдмийнхэн тулалдахдаа гурваас хоёр ялсан нь дийлдэг байтал гурав тулалдаж гурав ялна гэдэг чинь юу гэсэн үг билээ. Энэ тэнэг юугаа бодсон юм бол доо гэж бодов.

<<Ту баатар хариу эс хэлэхийг бодоход зөвшөөрч байгаа хэрэг байлгүй. Би багшаасаа толбот хулсны салхи гүйцэгч 18 цохилт хэмээх нэгэн

өвөрмөц аргыг сурсан билээ. Энэ бол манай багш ертөнцийн хамаг зэвсгийн эрдмийн дээжсийг цуглуулан шимийг нь бүрдүүлж буй болгосон арга мэх юм. Арван хэдэн жилийн турш санаандаа бодож болгоож буй болгосон энэ арга нь харсанаа халддаг халдсанаа дийлдэгээрээ онцлогтой. Мөхөс би ултай суурьтай сурч чадаагүй боловч ямар ч байсан өөртэй чинь байх гэж бодож байна. Би түүнэс гурав тулалдахдаа гуравхан мэх л хийнэ. Хэрвээ ганц мэх маань л амжилт олохгүй байх аваас би бүрмөсөн ялагдлаа гэсэн үг>> гэж И Да Зин хэллээ.

Ту Ди Хан бол мөрөн гол даяар нэрд гарсан том бүлгийн толгойлогч хүн энэ мэтийн доромжлолыг яахин тэвчиж чадах билээ. Нүүр нь хүрлийтлээ уурлан хүйтнээр инээгээд <<И баатрын энэ мэт ид чадлыг үзнэ гэдэг мөхөс миний хувьд гурван төрөлдөө ч баярлаад баршгүй хувь тохиол мөнөөс мөн. Олон үг олиг болдог гэж үг бий. Ту би И баатар таньтай амь хайрлахгүй хүчээ гарган үзэхэд бэлэн байна>> гэлээ.

И Да Зин <<Зэвсгийн эрдмийг шалгаруулахад хатгаж шүргэх төдийгээр хэн нь ялсанаа шийдэж болно. Заавал амь насандаа хүрэх хэрэг юу байсан юм бэ? Тэгээд ч би гурван удаа дараалан ялваас танд тавих нэгэн хүсэлт байгаа>> гэж хэлэв.

Ту Ди Хан өгүүлрүүн <<И баатар та үг байвал шулуухан өчигтүн. Юунд эх зах нь мэдэгдэхгүй олон үг нуршина вэ>>

<<Ту баатар та аргагүй л ухаантай хүн шиг хүний санааг сайтар ойлгож байна шүү. Хэрвээ гурав тулаад гурван ялалт байгуулбал таны шороон махбодийн бүлгийн толгойлогчийн суурийг би авна шүү>> гэж И Да Зин хэллээ.

<<Модон махбодийн бүлгийн толгойлогчийн суурийг бяцхан хүүхэн шулам эзэлсэн. Харин чи түүнээс хоцрохгүй гэсэндээ миний эрх мэдэлд санаархаж байгаа хэрэг юм биз дээ>> гэж Ту Ди Хан хэллээ.

И Да Зин толгой сэгсрэн <<Үгүй ээ хаанаас даа мөхөс би яахин мөрөн голынхонтой тэмцэж тэрсэж чадах вэ? Би танай үлдсэн дөрвөн бүлгийн толгойлогчийн суурийг булаан эзлээд багшийнхаа охинд сүй бэлэг болгон өгөхөөр амласан юм. Түүнээс биш өөрөө болохыг огтхон ч хүсээгүй>> гэв.

Бүлгийн толгойлогчийн суурийг эзлэн бүсгүй хүний сүй бэлгэнд өгнө гэнээ. Ёстой хачин хэрэг байна даа хэмээн мөрөн голоор өдий толон жил тэнэсэн хэрнээ үзэж дуулаагүй юмаа сонсоод Ту Ди Хан гайхширан бодоод хүйтнээр инээн <<Танай номын дүү охин чинь дэлхий дахины дөрвөн их бүлгийн толгойлогчийн суурийг ганцаараа эзэгнэдэг лут хүн юм даа>> гэлээ.

<<Харамсалтай нь модон махбодийн бүлгийн толгойлогчийн суурийг миний Сян дүү эзэгнээгүй бол тавууланг нь нэгэн дор гартаа оруулаад авбал багшийн маань охин бүр ч илүү сүр хүчтэй болох байлаа даа>> хэмээн И Да Зин халаглан өгүүллээ.

И Да Зин ийн өгүүлэх зуур Ту Ди Ханыг өчүүхэн төдий ч тоомсорлохгүйн зэрэгцээ мөрөн голын аруухан баатар Жинь Кан Лунг ч юман чинээ бодохгүй өнгө аяс илэрхий тул амьсгаа нь уурандаа хариугүй багтран хариу эс хэлж чадаад анжисныхаа хошууг өргөн дайрахар зэхлээ. И Да Зин сандран толгой сэгсрээд <<Байзаарай. Та бид хоёр чинь тоглоомын дүрэм журмаа тогтоогүй байгаа юм шиг байна шүү>> хэмээн толгой гилжийлгэн бодолхийлж байснаа гэнэт хамаг учрыг ойлгосон мэт <<Аа мэдлээ. Та чинь надаас ялагдвал яах хэрэгтэйг асуугаагүй байгаа юм байна шүү дээ. Энэ бүхнийг тохирчихвол би тулалдахад бэлэн байна>> гэлээ.

Түүний хэлж ярьж байгаа нь өөрийн үг биш бөгөөд багшийн зааж өгсөн үгсийг л яс цээжилсэнээ дуржигнуулж байгаа нь энэ байлаа. Харин Ту Ди Ханы хувьд бол түүний яриа түүнийг үл тоомсорлон доромжилон гутааж байгаагаас өөрцгүй байв. Гэвч тэрээр уур хилэнгээ аль болохоор дарж байсны учир гэвэл сая И Да Зингий тулалдаж байгааг үзвэл ердийн нэгэн жулдрай бандийн арга мэх биш байсан тул хашир байлгүй горьгүй гэж бодсоных юм. Мөрөн голын хашрууд сэтгэлийн хөдлөлөөр аливаа асуудалд шийдэхийг цээрлэдэг учир хүйтнээр <<За яахав хэрвээ би ялах юм бол яах ёстой болж байна даа?>> хэмээн асуув.

<<Өчүүхэн би таны болгоосныг дагаж болох юм>> гэлээ.

Ту Ди Хан өгүүллүүн <<Надад нэг охин дүү бий бөгөөд хэрвээ ялах юм бол танаас нэгэн зүйл авч охин дүүгийнхээ инжинд явуулна даа>> гэхэд И Да Зин <<Та ямар зүйл авах гэсэн юм бол>> хэмээн асуув. Ту Ди Хан өгүүллүүн <<Мөхөс би эрхэм таны тэргүүнийг авах болно>>. И Да Зин түүнийг сонсоод байдгаараа гайхан <<Толгой хүний инжинд явж болдог байх нь ээ>> гэхэд Ту Ди Хан <<Яагаад болдоггүй билээ. Охин дүү минь чиний гавлын ясыг орон доороо тавьчихаад шээсний саваа болгож болох юм шүү дээ>> гэлээ.

И Да Зин пүй пай болон дуу алдаж <<Завхарсан юм ялагдаад толгойгоо алдах тэгээд бас эмэгтэй хүний инжинд явуулаад адаг сүүлд нь шээсний сав болон хэвтвэл ч мөн горьгүй хэрэ ээ. За яахав сайн эрийн ам тангараг гэдэг уул шиг бат суурьтай байх учиртай. Нэгэнт ам алдсан бол

харамсаад яах вэ. Харин гурав тулалдаж гурван удаа ялалт байгуулахыг хичээх хэрэгтэй юм>> гэлээ.

Тийн өгүүлээд бүсэндээ хавчуулсан хулсан лимбээ гаргаж толбот хулсны 18 аргын эхний гурван мэхийн шившлэгийг уншиж гүйцээд <<Багшаа багшаа шавь чинь тулалдлаа шүү>> хэмээн хэдэнтээ хашгирсан боловч чихэнд мөнөөх шумуулын дүнгэнээ шиг чимээ дахин дуулдсангүй. Бодвол багш нь үнэхээр явсан байлаа.

И Да Зин хулсан лимбээ цээжний өмнүүр хөндөлсүүлэн бариад өгүүлрүүн миний эхний мэхийг <<Хаврын салхи хаяа дэрлэх>> гэж нэрлэдэг юм. Би энэ мэхээрээ чиний зүүн хавирганы <<Цагийн үүд>> цэгийг хатгах болно. Болгоомжтой байж үзээрэй гэлээ.

Ту Ди Хан мөнөөх сонин зэвсгийг үзээд нилээд болгоомж төрсөн юм. Хулсан лимбэ ердөө хоёр тохой орчим урт агаад аливаа богино зэвсэг хэрэглэж байгаа хүмүүс цэг дарахдаа гаргуун байдаг билээ. Гэвч өөрийн цээжний өмнө барьсан анжисны хошууг дээд зэргийн гангаар ширээж хийсэн бол И Да Зингийн лимбэ жирийн нэг хулс төдий тэгээд ч ар нурууг нь халхлах анжисны иш хэдийгээр модоор үйлдсэн эд боловч таван тохой орчим урт тул барьсан зэвсгийн талаар тийм ч амар хүний доор орохгүй гэсэн бат итгэл түүнд байлаа. Түүний зэрэгцээ дайсан этгээд нь хийх арга мэхээ хэлээд зогсохгүй аль цэг рүү довтолохоо хүртэл мэдэгдэж байгаа нь үхэл нь ирсэн хулгана муурын сүүлээр оролдож байгаагаас өөрц юу байх билээ.

И Да Зин үгээ гүйцэд хэлж дуусав уу үгүй юу довтолгоонд орж ирэхэд түүний алхаа гишгээ нь нүд гүйцэж харахын эцэсгүй түргэн шалмаг хөдөлж хулсан лимбээ сунган түүний баруун тал руу хатгалаа. Ту Ди Хан дотроо <<Баларсан юм боллоо. Энэ золиг чинь зүүн талыг довтолно гэж хэлээд баруун тал руу довтолдог байн шүү>> гэж бодов.

Ийн бодох зуур И Да Зин бүр хажуу дэргэд нь тулж ирсэн бөгөөд Ту Ди Хан хашир хүн гэсэндээ арагш ухран хулсан лимбэний цохилтоос бултан цээжээ халхлан байсан анжисны хошууг зүүнээс баруун тийш ширвэвээс И Да Зин салахгүй дагалдахын зэрэгцээ үл мэдэг тонгойн анжисны ирнээс бултаагүй бол түүнд хоёр хэсэг хяргуулах байлаа. Гэвч И Да Зин тэгтлээ сандарч бултсангүй ялимгүй гэдрэг зайлсхийхэд анжис түүний өмнүүр хэдхэн ямхын зайтай өнгөрөв. Харин Ту Ди Ханы анжис хүнд зэвсэгт тооцогдох тул түүнийг ширвэхийн дагуу бие нь ч гэсэн бас даган ханарахыг

самбаачилан И Да Зин хулсан лимбээ сунган түүний зүүн суган дахь цагийн үүд цэгийг хатгаж орхилоо.

И Да Зин өгүүлрүүн <<Эрхэм та зэвсгийн эрдмээр хичээллэдэг хүн байна даа бага сага ч гэсэн цэргийн аргад суралцахад гэмгүй юм шүү. Сунь Зыгийн цэргийн аргад үнэнийг худал худлыг үнэн болгож бодогтун гэсэн байдаг юм шүү дээ. Өөрөөр хэлбэл би чиний баруун талыг довтолсон боловч цаад санаа маань зүүн талыг чинь довтолж байгаа хэрэг. Заасан эрдмээ сайн сургаж чадаагүй багшийн чинь ч буруу бас бий дээ>> хэмээн халаглав.

И Да Зин амандаа ийн халаглах нь бага балчир хүүхдийг сургаж байгаагаас өөрцгүй бөгөөд арагш гурван алд үсрэн холдож өгүүлрүүн <<Нэгдүгээр тулаанд би яллаа. Одоо хоёулаа хоёрдахь тулаанаа хийе дээ. Сайн сонсож байгаарай. Миний хоёр дахь мэхийг <<Урин салхи унгирлаар наадах гэдэг юм. Чиний баруун талын тамганы үүд цэгийг довтлох болно>> гэлээ.

Ийн өгүүлж гүйцээд хулсан лимбээ өргөх нь удын навчисаар наадах салхин мэт хөнгөн зөөлөн санагдана. Харин хөлийн алхаа гишгээ нь албин чөтгөр ч болов гйцэхэд нэн бэрхтэй ажгуу. Энэ удаа амиа алддаг байлаа ч хамаагүй баруун талаа л яс хамгаалах хэрэгтэй юм шүү. Бусад цэгийг энэ хатгаж онолоо ч гэсэн хэлсэн үгэндээ хүрсэнгүй гээд бухаж булзахад боломжтой. Тэр дэмий балай цэргийн арга надад ямар хамаа байсан юм бэ хэмээн Ту Ди Хан бодож амжив.

Тэрээр анжисны хошуугаа доош даран тамганы үүд цэгээ ягштал хамгаалж чиний наад хулсан лимбэ чинь миний анжисыг ямар цоо хатгачих юм биш дээ гэсэн шүү юм бодож зогслоо.

И Да Зингийн хулсан лимбэ унгирлаа наадах урьхан хаврын салхи шиг эргэлдэн тоглож Ту Ди Ханы нүдийг эрээлжлүүлж орхив. Түм буман хулсан лимбэ өмнө нь эргэлдэн бүжихэд Ту Ди Хан төрөлхийн биеэ хамгаалах зөнгөөрөө ялимгүй цочин хөдөлтөл И Да Зингийн хулсан лимбэ сананд багтамгүй зүгээс Ту Ди Ханы анжис бие хоёрын хоорондуур гулган орж түүний зүүн талын тамганы үүд цэгийг хатгалаа.

Ту Ди Хан тэсэртлээ уурлаж айх хослон нүүр нь шатсан цаас шиг үрчийж орхив.

Хэрвээ Ту Ди Хан түүнийг 7 навчит цэцгийн хор хүртсэн хэрнээ өнөө хэр эсэн мэнд яваа гэдгийг дуулж мэдсэн бол ямар нэгэн гайхамшигт учралт гарамгай багштай тохиосон байж таарна гээд ямар ч байсан сэрэмжтэй байх

байсан юм. Гэвч төмөр, ус, гал, мод, шороо 5 махбодийн бүлгийнхэн мөрөн гол даяараа нэр алдраа дуурсгаад өнө удаан жил болсон тул аливаа хүн болоод бүлэг нэг л нэр алдраа дуурсгавал түүнийгээ амьнаасаа илүүтэй хайрладаг нь ёс билээ. 5 махбодийн бүлгийнхэн ямар нэгэн баатарлаг үйлс тухайлбал хэн нэгэн сөргүү хулгайг даран сөнөөсөн хэргийн тухай мэдээ нь далавчтай мэт бусдад түгэн тархдаг юм. Харин гал махбодийн толгойлогч Хуо Шао Чун далны ясаа Жу Сян Зюньд хугалуулж модон махбодийн бүлгийн толгойлогч Му Цин Ся өөрийн толгойлогчийн сууриа түүнд булаалгасан хэрэг тэр болгон өргөн тархаж чадаагүй юм. 5 махбодийн бүлгийнхэн энэ мэдээг өөр зуураа мэдээлэхдээ хамаг буруу хэргийн эзэн хэнгэргийн дохиураар Жу Сян Зюнийг нэрлэж харин Хуо Шао Чунгийн 7 навчит цэцгийн хорыг И Да Зинд уулгасан тухай дурсаагүй өнгөрсөн тул хэн ч энэ тухай мэдэхгүй байсан юм. Ганц нэг хүн мэдэж дуулсан байлаа ч ямар зоригтон 5 махбодийн бүлгийн дотоод булайг дэлгэж өөртөө лай ланчиг хурааж зүрхлэх билээ дээ.

Энэ удаа Ту Ди Хан И Да Зинг ганцаараа явж байхыг хараад номын хэнээтэй болсон энэ эрийг барьж авч гал, модон махбодийн бүлгийн өшөөг авах нөгөө талаар түүнийг барьцаанд авсанаар Жу Сян Зюнээс сэргийлж болно гэж бодсон билээ. Тэгтэл мөнөөх элэг барья гэж бодсон номын эр нь ийм айхтар байхын чинээ даанч бодоогүй билээ.

И Да Зин арагш ухран суурьтай зогсоод <<Хоёрдахь тулаанд би ялж чи ялагдлаа. Гурав тулж гурав ялахад ганцхан тулаан үлдлээ шүү. Болгоомжтой байгаарай. Миний одоо хийх мэхийг <<Хаврын салхи хараацайг хазайлгах>> гэдэг юм. Чиний ...>> хэмээн хэлэх үгээ гүйцээгүй байтал Ту Ди Хан юутай хээтэйгээ түүн рүү дайран орж ирлээ. Ту Ди Хан уг нь түүнийг эхэлж дайруулаад мэхэн дээр нь ашиглаж унагая гэж бодож байсан боловч хоёуланд нь ялагадсан тул энэ удаа түрүүлж өөрөө дайрахаар шийджээ. Учир нь эхэлж дайраад болохгүй бол ухарчихаж болно. Энэ удаа халз тулаанаар тэнцчих л юм бол түүний гурван ялалт талаар болох тул өөрөө яллаа гэсэн үг гэж боджээ.

И Да Зин тулалдааны туршлага нимгэн тул гайхасхийн алмайрч <<Чи яагаад дүрэм журмаа сонсохгүй байгаа юм бэ?>> гэлээ.

Ийн хэлж байхын зуур Ту Ди Хан түүнээс алд хэрийн зайтай ирсэн байлаа. Ту Ди Хан дайснаа басамжилах сэтгэл нь цэрвэн болгоомжлохоор солигдсон тул алд хэрийн зайнд ирээд И Да Зинд хэтэрхий ойртон цэгээ хатгуулахаас сэрэмжилэн зогслоо.

Түүний анжис өмнө өгүүлж байснаар хог, чулуу, тоосгоны хэлтэрхий, ваарны өөдөс гээд нууц зэвсэг дүүргэсэн байдаг бөгөөд нэг товхлуурыг дартал мөнөөх нууц зэвсгүүд царцаан сүрэг мэт И Да Зинг чиглэн ирэв.

Харин азаар энэ үед И Да Зин хаврын салхинд хараацай хазайх мэхээ хийж дээшээ үсрэхтэй таарсан бөгөөд Ту Ди Ханы нууц зэвсэг их төлөв байгаа оносонгүй. Цөөн хэдэн тоотой нь түүний хөлийг оносон боловч И Да Зин нэгэнт Фу Яогийн 8 хүлсийн зургаар хичээллэн хамаг амин цэгээ алга болгож чадсан тул түүнийг яах билээ дээ. Ту Ди Хан мэлрэн гайхаж байхын зуур И Да Зин түүний толгой дээгүүр дүүлэн нисэх зуур хулсан лимбээрээ зуун уулзвар цэгийг дарчихаад хөнгөн зөөлнөөр ард нь бууж <<Хаврын салхи хараацайг хазайлгах мэхээрээ чиний зуун уулзвар цэгийг довтолдог>> юм гэж дуусгаагүй үгээ гүйцээв.

Ту Ди Хан модон тахиа мэт хэсэг зуур хөдөлгөөнгүй байснаа мөрлөсөн анжисаа газар хаячихаад эргэн явахаар завдав.

<<Байзаарай байзаарай. Та чинь ямар дүрэм журам мэддэггүй хүн бэ>> хэмээн И Да Зин сандран асуув.

Ту Ди Хан эргэж ч харалгүй дороо зогсоод <<И баатар та миний бүлгийн толгойлогчийн байр суурийг авах хэрэгтэй гээ биз дээ. Түүнийгээ таньд өгчихлөө өөр юу хэрэгтэй юм бэ>> гэв.

<<Надад өгчихлөө гэнээ?>>.

<<Энэ анжис бол манай бүлгийн нандин эрдэнэ байгаа юм. Хэн түүнийг эзэмшинэ вэ тэр хүн бүлгийн толгойлогч болох учиртай юм. Одоо анжис чиний болсоноос хойш надтай хэлцэх өөр юу байх вэ>>.

И Да Зин ийм амархан бүлгийн толгойлогч болчихно гэж бодоогүй тул эргэлзээ нь арилж өгсөнгүй. Хэрвээ хэн нэгэн хүн энэ анжисыг хулгайлчихвал булаан авчихвал тэр хүн бүлгийн толгойлогч болох хэрэг үү гэж бодсоноо Жу Сян Зюнь модон махбодийн бүлгийн толгойлогчийн суурийг залгамжлах үед хичнээн сүр хүчтэй ёслол болж байсныг санаад <<Ту баатраа таны эрдэм чадал хэдийгээр миний энд хүрэхгүй надад ялагдсан боловч таныг гутаан доромжлох хүсэл алга. Харин ч би таны эрдэм чадал хүн чанарыг биширч байна>> гэлээ.

Тэрээр багшийнхаа зааж хэлсэн үгийг дуржигнуулахаас биш түүний үг яриа нь Ту Ди Хааны хувьд дээдийн доромжлол мэт сонсогдож байгааг ухаарч сэхээрсэнгүй. Ту Ди Хан гашуунаар инээмсэглэн <<Нэгэнт ялсан болохоор И баатар та яах нь дурын хэрэг. Надад хэлээд байх юу байх вэ гээд бусад цагт уран хошуугаараа улаан хөлтийг урдуураа алхуулдаггүй Ту

Ди Хан номын хэнээтэй энэ эрд ялагдсандаа бантаад өөр хэлэх үг гарсангүй>>.

И Да Зин өгүүллрүүн <<Би өөрт чинь итгэхгүй байгаа хэрэг биш шүү. Мөрөн голын сайн эрсийн хэлсэн үг хийсэн ажил хоорондоо зөрдөггүй гэдгийг би сонссон. Гэхдээ л манай багш надад ертөнцийн хүний үнэн үгийг худлаа, худлаа үгийг үнэн болгон бодож яваарай гэж захисан л даа. Эрдэмт багшийн сургаалыг дагалгүй эндэж осолдож яахин болох билээ>> гэв.

<<И баатар та тойрч булзалгүй хэлэх гэсэн үгээ хэл л дээ>> гэж Ту Ди Хан өгүүллээ.

И Да Зин өгүүллрүүн <<Эртний үгэнд дэнг асаахгүй бол гэрэлтдэггүй , үгийг өчихгүй болвоос ойлголцохгүй, ёсыг хэлэлцэхгүй аваас гэгээрэхгүй гэсэн байдаг. Тийм болохоор хоёулаа сайн муугаа эртхэн хэлэлцээд авсан нь дээр шүү>> гэв.

Ту Ди Хан өөрөөсөө илүү чалчаа хүнтэй учирчихсанаа ойлгож мэтгэж маргахыг хүссэнгүй.

<<Шинэ бүлгийн толгойлогч тодорно гэдэг дэг жаягийн дагуу үйлдэх асуудал мөнөөс мөн. Яахин ийм хөнгөн хуумгай хандаж болох билээ>> хэмээн И Да Зин өгүүлэв.

Ту Ди хан <<Аа мөн би одоо л ойлголоо. И баатар та наад анжисаа үүрээд намайг дагаад яв даа>> гэв.

И Да Зин хөмсөг зангидан өгүүллрүүн <<Би үүнийг чинь мөрлөж дасаагүй шүү дээ>> гэлээ. Ту Ди Хан <<Манай бүлгийн ёсонд энэхүү анжисыг дээдлэн 8 үеийн толгойлогч нар нандин эрдэнээ болгож тахиж ирсэн бөгөөд толгойлогчоос өөр хэн ч түүнд гар хүрэх эрхгүй юм>> гэлээ. <<Тэр чинь л харин хэцүү хэрэг байна даа>> хэмээн өгүүлэх зуур доош сөхрөн анжиснаас ямар нэгэн бэлгэ тэмдэг болгочихоор эд зүйлийг эрэлхийлэн хайлаа. Тэрээр жинхэнээсээ шороон махбодийн бүлгийн толгойлогч болох хүсэл байгаагүй тэгээд ч өдөржин энэ хүнд анжисыг мөрлөн дэвэн дэлхийг хэрэн хэсч явна гэдэг хүсүүштэй хэрэг биш байв. Тэр сайтар эрж бхайсан боловч анжиснаас салгаад авчихаар зүйл олж чадсангүй ядаж анжисны иш мод боловч чухам ямар модоор хийснийг бүү мэд төмөр шиг хатуу эд байлаа.

Шороон махбодийн бүлгийн хайсан гэж гаднаас нь харвал бөөн овоолоостой шар шавар төдий байв. Харин дотроо бол их л уужим агаад ганц ч хүн үзэгдсэнгүй. Урд хэсэг нь хойд хэсгээсээ нилээд өндөрдүү бөөн овоолоостой шороон дээр анжисаа тавиад Ту Ди Хан гартаа дотоод хүчээ хураан анжисны толгойг наймантаа дүнгэнүүлэн цохилоо. Ту Ди Хан И Да Зинд хандан <<Энэ бол манай бүлгийн чухал хэргийг болзсон дохио тэмдэг байгаа юм>> хэмээн хэлэв. И Да Зин толгой дохих зуур шороон хайсангийн дотор битүү нүргээн дуугарч чихний хэнгэрэг хагалчих шахав. Хэрвээ дотоод хүч багатай хүн байсан бол ухаан алдан унах байсан нь гарцаагүй. Ту Ди Хан хамаг уур хорслоо дотоод хүчтэйгээ хамтатган анжисыг найман удаа цохихдоо нөгөө талаар И Да Зинд дотоод хүчнийхээ хэр чадлыг гайхуулж байгааг ойлгож ядах юмгүй байв. И Да Зин инээд алдан <<Ту баатар ч аргагүй л айхтар их дотоод хүчтэй хүн юм даа>> гэлээ.

Ту Ди Ханы нүүр нь улсхийсэн боловч хариу дуугарсангүй.

Удаж төдөлгүй шороон хайсангийн дөрвөн өнцөгт буй хаалга онгойн дөрвөн хэсэг хүн бөөн хүмүүс шавааралдан орж ирэхэд уужим саруул танхим бараг дүүрэх шахав. Шороон махбодийнхон ихэвчлэн тариачин гаралтай улс байдаг тул хөдөөх хэв маягаа хадгалсан байх ажээ. Бүгдээрээ л оготор богино хувцастай бөгөөд ганц нь ч урт дээл өмсөөгүй байлаа. Харин өндөр тавцан дээр зогссон И Да Зин тэднээс хавьгүй өөр харагдаж байв. Шороон махбодийнхон жагсаал гэдгийг мэддэггүй тул тэрүүхэн тэндээ шавааралдан зогсоно.

<<Бүлгийн толгойлогчийн амрыг эрье>> хэмээн нэгэн дуугаар зэрэг өгүүлэлдэх нь л нэгэн бүлгийн сургуультай улс гэдгийг илтгэх ганц үзүүлэлт болж байлаа.

Ту Ди Хан олон шавь нараа тойруулан хараад хоолой засан өгүүлрүүн <<Олон ах дүү нараа Ту Ди Хан би та бүхний эндүү хайраар арван хэдэн жилийн турш бүлгийн толгойлогчийг хийж ирлээ. Манай шороон махбодийн бүлгийнхэн нэгэн санаатай байсны үрээр өөрийн нэр сүрээ цуурайтуулж таван махбодийн бүлгийн дунд өөрийн гэсэн байр суурьтай болсон юм. Гэвч... гэвч... гээд хөдөөгийнхний нэрээ боддог нэрэлхүү зангаар юу хэлэхээ мэдэхгүй хэсэг зуур балмагдсанаа <<... Гэвч таван махбодийн бүлгийнхний дунд төмөр, мод, гал, усан махбодийн бүлгийнхэн бүгд бичиг цэргийн эрдэмд гарамгай баатруудыг сонгон бүлгийн толгойлогчоо сонгосон байдаг бол ганцхан манай шороон махбодийн бүлэг л эрдэм чадлаар мөхөс Ту Ди Хан намайг толгойлогчоороо сонгосон нь бүлгийн ажил үйлс дэгжин

бадрахад дэм тус болж чадахгүй байгаа юм. Иймд би сайтар бодсоны эцэст энэхүү их нэр нь хол ойр дуурссан номч баатар И Да Зинг урьж шороон махбодийн бүлгийн толгойлогчийн сууринд залахаар шийдлээ. Тэгээд... тэгээд...>>

Ту Ди Хан ийнхүү нэр нүүрээ хамгаалсан хэдэн үг хэлэхийн ялдамд И Да Зинд <<Номч баатар>> гэсэн цаасан малгай өмсгөсөнд И Да Зин туйлын их баярлаж байсан авай. Учир нь тэрээр мөрөн голоор хэрэн хэсэгч баатар эрс бүгд өөрийн гэсэн сайн муу нэр хочтой байдаг ба адгийн наад зах нь тоорын цэцэгт сууринд төлгийн дэлгүүрээ нээсэн хоёр мэрэгчийн нэг нь <<Лю Бань Сянь>> (Хятадаар <<Лю овогт хагас хувилгаан>> гэсэн үг), нөгөө нь <<Ли Те Коу>> (Хятадаар <<Ли овогт төмөр амт>>) гэсэн хочтой байдаг билээ. Тэрээр одоо нэгэнт мөрөн голын хэрэг явдалд хутгалдан оролцох болсон тул өөрийн гэсэн алдар нэртэй болох нь юу юунаас өмнө шийдэх хэрэгтэй асуудал байсан юм. Харин <<Номч баатар>> гэдэг алдар нь түүний сэтгэлд ихэд ницсэний учир гэвэл нэг талаар түүний номын хүн гэсэн утгыг илэрхийлж нөгөө талаар мөрөн голоор явагч сайн эр гэсэн утгыг илтгэж байгаад буй юм. Энэ мангуу гэмээр шороон толгойт Ту Ди Хан хоромхон зуурын төдийд ийм сонсголонтой сайхан нэр бодож олох юм гэж санасангүй.

Ту Ди Хан <<Тэгээд...>> гэж ээрэн мууран цааш ярьж чадахгүй гацахыг үзээд залгуулан авч <<Ту овогт толгологч манай бүлгийн эгнээг эрдэм чадалтай эрэлхэг баатруудаар дүүргэх үүднээс дөрвөн зүгт сайн эрсийн сураг ажгийг тандан явсан ажээ. Тэгээд дээд тэнгэрийн хишгээр Ту баатар надтай учран миний өчүүхэн жаахан эрдэм чадлыг үзэж шинэ бүлгийн толгойлогч болохоыг хичээнгүйлэн гуйсан юм. Мөхөс би ч хэрээ мэдэлгүй түүний хүсэлтийг хүлээн авсан билээ. Би ч гэсэн энэ суурин дээр удаан тогтохыг хүсэхгүй ба хожмын өдөр хойчийн маргааш эрдэм чадал нь хосолсон эрэлхэг баатар эр тодрон гарах аваас энэхүү хүндэт суудлыг найр тавин өгөх болно>>.

Түүний хэлсэн энэ үг хаа очиж голыг нь олсон байв. Далдуур Ту Ди Хантай тулалдаж ялсан гэдгээ батлахын зэрэгцээ олон шавь нарынх нь өмнө түүний нэр нүүрийг гутаасангүй өнгөрч чаджээ.

Ту Ди Хан түүнд дотуураа сэмхэн баярлаж өгүүлрүүн <<Номч баатар И бол мөрөн гол даяар олон таарахгүй идтэн баатар мөн. Зэвсгийн эрдэмд гоц шалгарснаас гадна хүн чанараар ч олноос онцгойн тул би түүнийг бүлгийн толгойлогчоор тохоон томилохоор шиддсэн билээ. Олон ах дүү та нарт өөр саналтай хүн байхгүй гэдэгт итгэж байна>> гэв.

Олон бүгдээр нэгэн дуугаар <<Бүлгийн толгойлогчийн шийдвэрийг бултаар дагацгаана>> хэмээн өгүүлцгээв.

Ту Ди Хан хоёр гараар анжисыг дээр өргөн газар сөгдөв. И Да Зин түүнийг хоёр гардан авбал мөнөөх анжис хүнд гэдэг нь жигтэйхэн лав дал наян жин элбэг байгаа ажээ. Хөөрхий Ту Ди Хан түүнийг өдөржин мөрлөж явна гэдэг хэрэндээ л зовиуртай байсан байлгүй.

И Да Зин анжисыг гардан авахд Ту Ди Хан түүнд дөрвөн салбар хайсангийн эздийг танилцууллаа. Шороон махбодийн бүлгийн салбар хайсан нь мөн л анжис, борной, арчуур, тануур гэсэн газар тариалангийн нэр бүхий ажээ. Тэдний барьсан зэвсэг нь хүртэл дээрхи нэртэйгээ ижил зүйлс байлаа.

И Да Зин өгүүлрүүн <<Эрхэм ах дүү нараа манай багш бол мөрөн голын сүмбэр уул бөгөөд миний сурсан зэвсгийн эрдэм та бүхнийхээс тэс өөр. Харин Ту баатар бол манай бүлгийн зэвсгийн эрдмийг олон жил бясалган суусан энэ талын арвин баялаг туршлагатай хүн тул түүнийг дэд толгойлогч болгоход та бүхэн талгалзахгүй гэж бодож байна>> гэв.

Олон бүгдээр нэгэн дуугаар <<Бүлгийн толгойлогчийн зарлигийг дагая>> хэмээн хашгиралдав.

Зэвсгийн эрдмийн ертөнцөд угаас ялсан нь хаан ширээнд заларч ялагдсан нь орох орон ч үгүй болдог бичигдээгүй хууль байадаг ба И Да Зин түүнийг гаргуунд нь гаргаад хаячихаагүйд Ту Ди Хан дотроо түмэнтээ баярлаж байлаа. Тэрээр алга хавсран мэхэсхийж <<Бүлгийн толгойлогчийн хишигт мөргөө>> гэхэд олон бүгдээр залгуулан авч <<Найр наадмыг үүсгэн бүлгийн шинэ толгойлогчоо угтан авцгаая>> гэлээ.

Тэдний найр хурим гэж ширээ санда л идээ будаа засах гэсэн ойлголт үгүй ба газар сууцгаан архийг том том аягаар залгилцгаан махыг гараараа барин амаараа зулгаан идэцгээх ажээ. Номын улс угаас хээгүй байдаг тул И Да Зин тэдэнтэй дорхноо ижилдэн дасаж дээл хувцсандаа архи тос үсрэхийг ч эс хайхран идэж ууж гарлаа. Тэр угаас архи даахдаа сайн тул шөнө дунд өнгөрөхөд нилээд согтсон байв.

Найрлан байх зуур Ту Ди Хан шинэ бүлгийн толгойлогчийн зэвсгийн эрдмийг магтах ба хэн нэгэн хүн гэнэт <<Бүлгийн толгойлогч та бидэнд ямар нэгэн арга мэхийг үзүүлж нүдийг нээн нүүрийг баясгаач>> хэмээн санал тавилаа. Олон бүгдээрээ түүний саналыг дэмжин уухайлав. <<Эдгээр олон шавь нар хэдийгээр намайг аман дээрээ дэмжиж байгаа боловч араар таагүй байгаа улс цөөнгүй буй за. Хэрвээ ямар нэгэн олигтой юм үзүүлж

чадахгүй бол бүлгийн толгойлогчийн сууриа хадгалахд хүндрэлтэйгээс гадна алсдаа амь насанд ч халтай байж мэдэх юм. Гэвч юугаа үзүүлдэг билээ дээ. Толбот хулсны 18 цохилтын аргаас үзүүлээд тийм уран нарийн арга мэхийг энэ хөдөөгийн тариачин голдуу улс учрыг нь ухаж ойлгохгүй. Шороон махбодийн бүлгийн зэвсгийг харахад хатуугийн тамирыг голлодог улс шиг байна лээ хэмээн бодож байснаа жонийтол инээгээд өгүүлрүүн <<Би гадагш гарахдаа дандаа энэ хүнд анжисыг үүрч явна гэдэг төвөгтэй. Тийм болохоор би энэ анжиснаас нэгэн хэсэг итгэмжлэх бэлгэ тэмдгийн зүйлсийг сонгон авч биедээ эрдэнэ мэт нандигнан хадгалсугай гэж шийдлээ>> гэв.

Ийн өгүүлэх зуур доош сөгдөн сууж хоёр хуруугаараа анжисны хошууг чимхээд дотоод хийгээ улаан гэрд цэгээс гарган хоёр гартаа хураагаад хүчлэн татваас хатуу ган төмөр анжисны ирнээс хундаганы амсарын чинээ том хэсэг хугаран унаж ирлээ.

Олон шавь нар номын төрхтэй энэ дорой эр ийм айхтар хатуугийн тамир үзүүлнэ гэж санасангүй тул бүгд дуугаа хураан чимээгүй болцгоолоо.

Энэхүү анжисны төмөр нь дээд зэргийн ганг дахин дахин ширээж хийсэн эд билээ. Шороон махбодийн бүлгийн ердийн нэг шавь байтугай хэдэн арван жил хатуугийн тамираар хичээллэсэн Ту Ди Хан ч гэсэн ийм зүйл үзүүлэн гэж саналтгүй билээ. И Да Зин өдөр мөнөөх анжисыг тэмтэрч үзээд зориг хүрээгүй боловч өдгөө архины халуундаа ийм шийдэлд хүрсэн хэрэг ажээ.

И Да Зин хоёр хуруугаар гэрэл наадуулан ойлгох анжисны төмрийг толгой дээрээ өргөн олноы зүг харуулаад <<Үүнээс хойш манай бүлгийн итгэмжлэх тэмдэг нь энэ болог. Хэн энэ хэсэг төмрийг эзэмшинэ вэ тэр хүн манай бүлгийн толгойлогч байх болно>> гэлээ.

Тэрээр сэтгэлдээ ихэд омогшин байхын сацуу <<Багш өөрийн охиноо хорвоод хосгүй үзэсгэлэн гоо бүсгүй гэж байсан. Хожим хойно дөрвөн бүлгийн толгойлогч болчихоод энэ хүнд анжисыг өдөржин мөрлөн явна гэдэг таагүй хэрэг. Харин одоо энэ өчүүхэн төмрийг биедээ авч явах болсноор амар боллоо>> хэмээн бодов.

И Да Зин шороон хайсангийн дотор гурван хоног найрлахдаа ёстой л нэг ангайж идэн алцайж хэвтэнэ гэдгийн амт шимтийг мэдэрч байв. Тэр багаасаа өнчин өрөөсөн өсч ядуу зүдүүгийн зовлонг амссан бөгөөд хэзээ ч ингэж хүний хүндлэлийг эдэлж үзээгүй юм. Тиймийн тулд ар ажлаа ч уамртсан байлаа. <<Хүн болгон л ном эрдэмд шамдаж ихэс сайд болохыг

мөрөөддөг. Хаад ноёд болж эрх ямба эдэлнэ гэдэг ийм сайхан болоод л тэд эрх мэдлийн төлөө үхэлдэн тэмцдэг байх нь ээ. Нэг муу шороон махбодийн бүлгийн толгойлогч ийм ямбатай байхад тэд хаад ноёд болох гэдэг нь аргагүй юм байна>> хэмээн бодлоо.

Нэгэн өдөр архи ууж байх зуур И Да Зин <<Ойрдоо модон махбодийн бүлгийн толгойлогч Жу Сян Зюний байдал ямар байгаа билээ>> хэмээн асуулаа.

Ту Ди Хан тэр хоёрын дотно харьцаатай гэдгийг урьдаас мэдэх тул үнэнээр нь өчрүүн <<Модон махбодийн бүлгийн ах дүү нарын өгүүлэхийг сонсвол Жу бүлгийн толгойлогч мөрний өмнөх нутгийг зорьж Му Дань Ду хатагтайтай уулзан 7 навчит цэцгийн хор гэлүү нэг юм олж ирэхээр явсан гэсэн. Түүнээс хойш одоо болтол сураг чимээ үгүй гэнэ лээ>> гэв.

И Да Зин гэнэт аягатай архиа тавиад <<И Да Зин минь дээ, И Да Зин минь чи ч мөн ачийг умартаж журмыг тэрсэлсэн өөдгүй эр юм даа...>> гэлээ.

ХАЙР ДУРЛАЛ ХАРДАХЫН СЭТГЭЛ ХЭМЭЭХ АРАВДУГААР БҮЛЭГ

Хорч Ду авгай Му Цин Сягийн замыг таглан инээж өгүүлрүүн <<Тулгандаа удсан үнс төрхөмдөө үлдсэн бүсгүй үр хоёр адилхан гэж үнэн юм даа. Му Дань Ду хатагтай тэр ёсыг мэдэхгүй байсаар төрсөн охиныхоо гарт амь алдлаа>> гэв.

Му Цин Ся гэнэт хорч Ду авгайгийн өмнө сөгдөн нулимс мэлтэрүүлэн <<Ээжээ та охиныхоо нүүрийг бодож түүнийг өршөөж соёрх хэрвээ таны гараас амьд мэнд мултарсан хүн гарвал та түүнийг дахин хөндөхгүй гэсэн бичигдээгүй хууль байдаг биш үү>> хэмээн гуйлаа.

Хорч Ду авгай өгүүлрүүн <<Хөгшин миний гаргасан журмыг яахин зөрчиж болох билээ. Гэвч надад нэг арга байна аа. Тэр аргаар наад шулмын чинь амийг ч хэлтрүүлэхгүй өөрийн гаргасан журмаа ч зөрчихгүй байж болно. Хөгшин би үнэрч сайн хамартайгаас үнэхээр сайн толгойтой төрсөн юм шүү>> гээд илбэ үзүүлж байгаа мэтээр өврөөсөө нэгэн аягатай зүйл гарган ирвэл дөнгөж сая гал дээрээс гаргасан мэт халуун уур савсуулан даргилан буцлах ажээ. Ду хорч их л бахдалтайгаар инээд алдан <<Би дахин нэг 7 навчит цэцгийн хор буцалгаад аваад ирлээ. Хөөрхөн үр минь энэ журамт бүсгүй Жу урьд нь нэг аягыг уусан юм чинь дахин нэг аягыг уухад юу

нь болохгүй аж даа. Би энэ аягатайгаар түүнийг алсын замд нь үдэж байгаа хэрэг. Энэ аягатайг л уучих юм бол санаа амар явж болно. Тэгэхээр би өөрийн гаргасан журмаа ч зөрчихгүйгээс гадна бяцхан шулмыг газар дээр нь хөнөөж болох биш үү>> гэв.

Му Цин Ся уурлах сандрах хослон <<Ээжээ та юу хэлж байгаагаа мэддэг ч болоосой!>> гэлээ.

Түрүүнээс хойш дуугаа хураан суусан Жу Сян Зюнь гэнэт тэдний ярианд оролцон <<Та хоёр битгий хэрэлдэцгээ. Би наад хорыг чинь уучихвал барав. Му эгчээ танд их барярласан шүү. Хэрвээ миний Зин ах үхээгүй байгаад хожим тантай тааралдвал намайг ингэж үхсэнийг хэрхэвч хэлж болдоггүй юм шүү. Эс тэгвээс тэр удаан амьд явж чадахгүй. Миний эргэн ирэхийг хүлээж бай гэж хэлээрэй...>> гэв.

Му Цин Ся нулимс мэлмэрүүлэн <<Хөөрхий дүү минь би чиний хэлснийг ёсчилон гүйцэтгэнэ. Би чамд үнэхээр атаархаж байна. Хэрвээ миний Чун ах надад тийм үнэнч байсан бол би түүний төлөө түмэнтээ үхэвч гомдох юм алга. Жу овогт дүү минь хэрвээ чи азаар амьд мэнд гараад хожмын өдөр Чун ахтай минь уулзвал намайг үхсэн гэж хэлээрэй. Тэгвэл түүний сэтгэл амрах болно...>>

Жу Сян Зюнь энэ үед Му Цин Сягийн өгсөн үрлийг ууснаар биеийн хорыг тайлсан боловч энэ олон өдөр янз бүрийн хор идсээр хамаг бие нь өчүүхэн ч тэнхээгүй болсон байлаа. Ду авгай түүний дээрээс тонгойн зөөлөн намуун дуугаар <<Алив хөөрхөн охин минь наадхаа уучих авгайнхаа өгсөн аягатайг уучихвал хамаг хэрэг сайнаар төгсөн. Миний үгэнд ороорой>> гэв.

Му Цин Ся гэнэт гүйж ирээд аягатай хорыг булаалдан <<Ээжээ наад хороо нааш нь өгчих. Охин чинь танаас гуйя харин та Жу овогт дүүг тавиад ячвуулчих тэр үхэж болохгүй яагаад гэвэл түүнийг хайртай хүн нь хүлээж байгаа. Харин охин чинь уучихвал хорвоо дэлхий дээр намайг гэж санаж сарвайх хүн байхшбиш амар болно>> гээд цааш нь юм хэлж чадсангүй нус нулимсандаа хахаж цацан дуугүйболов.

Хорч Ду авгай бие зайлан холдоод хөмсөг атируулан <<Чи ямар юмны учир ойлгодоггүй хүн бэ. Энэ хорыг чинь хэн дуртай нь ууж боддог юм уу>> гэв.

Түүний хэлж байгаа үгийн өнгө нь хэн нэгэнд хор биш ямар нэгэн эм уулгах гэж байгаатай адилхан өнгөөр сонсогдоно.

Жу Сян Зюнь Му Цин Сягийн хэлж байгаа үгэнд хязгааргүй их гомдол гутрал байгааг ухааран ойлгосон боловч түүнийг ятгаж хориод нэмэргүй

гэдгийг мэдэж <<Му эгчээ наад хорыг чинь надад зориулсан болохоор би уух ёстой. Миний Зин ах 7 навчит цэцгийн хор уугаад өөд болсон болохоор би ч гэсэн адилхан хор ууж үхвэл зохих биш үү. Хэрвээ Зин ахын минь хор эдгэрсэн байх аваас миний ч гэсэн бас эдгэрч болно шүү дээ. Хэрвээ тэр шар булгийн дор хүрсэн байх аваас би энд ганцаар амьд байх нь ямар утга байх вэ>> гэлээ.

Ийн өгүүлж байх зуур гэнэт арын төгөл ойгоос хулсан лимбийн яруу аялгуу алгуур зөөлөн эгшиглэх нь зүрхний амрагаа санан дурсах сэтгэлийг илэрхийлэх ажээ. <<Сян Зюнь>> үү дээ хэмээн Жу Сян Зюнь гэнэт их дуунаар өгүүлээд <<Зин ахаа би энд байна.Сян дүү чинь энд байна>> хэмээн хашгирав.

<<Юуны чинь Зин ах болоод явчихав аа. Энэ охин чинь солиорч байгаа юм биш биз дээ>> хэмээн хорч Ду авгай өгүүлэв.

<<Ээжээ та байз даа үнэхээр нэг хүн ирэх шиг боллоо шүү>> хэмээн Му Цин Ся өгүүлэв.

Хорч Ду авгай толгой сэгсрэн <<Би хамартаа л итгэнэ үү гэхээс биш нүд чихэндээ итгэж сураагүй хүн. Харин энэ хорыг наад шулам чинь хурдан уух ёстой гэдгийг л би мэдэж байна>> гэлээ.

Ийн өгүүлэх зуур тэрээр Жу Сян Зюний толгойг барин авч ам руу нь цутгах маягтай болж эхлэв. Энэ үед лимбэний дуу улам тодсон бүр чихний үзүүрт хангинах нь хэн нэгнийг эрж хайж байх мэт санагдана.

Хэзээ ч дайсныхаа өмнө шантарч үзээгүй Жу Сян Зюнь энэ үед гэнэт хачин өрөвдмөөр харц үзүүлэн зөөлөн дуугаар <<Та жаахан хүлээ л дээ миний Зин ах ирж байна. Би түүнтэй хэдхэн үг яриадахъя үгүй ээ би түүний ганцхан харчихаад л наадах хорыг чинь уух болно. Би танаас гуйж байна шүү дээ>> гэлээ.

<<Хэрвээ чиний тэр Зин ах энэ тэр чинь ирэх юм бол наад 7 навчит цэцгийн хор чинь хүртэлцэхгүй юм болно. Надад хаанаас тийм их хор байх билээ дээ>> хорч Ду авгай хэлэв.

Ийн өгүүлэх зуур түүний ам руу хорыг цутгахаар завдав. Гэтэл арын төгөл ойгоос нэгэн хүний бараан дүрс гялсхийн гарч ирэх нь цахилгаан цахиж буй мэт хурдтай агаад яах ийхийн зуургүй хорч Ду авгайгийн ард ирж зүүн гараараа түүний ар нурууны амин цэгийг хатгахаар завдан нөгөө гараараа хортой аягыг булаан авахаар сарвайв.

<<Зин ахаа!>> хэмээн Жу Сян Зюнь ориллоо.

Гэвч И Да Зин түүнийг анхаарах юмгүй дайсантайгаа тулалдана. Хорч Ду авгай эсвэл хортой аягаа алдаж ар нурууны амин цэг рүүгээ хатгуулах эсвэл амин цэгээ орхиж аягатай хороо Жу Сян Зюньд цутган уулгах хоёр сонголт үлджээ. Тэрээр хэдийгээр зэвсгийн эрдмийн хувьд байдаг л нэг боловч хөдөлгөөний хурд эвсэл сайтай нэгэн ажээ. Биеэ хагас мурын И Да Зингийн гараас мултран холдож амжлаа. Үнэн хэрэгтээ И Да Зин түүнийг Жу Сян Зюньээс айлган холдуулах зорилготойгоос бус амь насанд нь хүрэх санаа агуулаагүй юм. Тийм тулд толбот хулсны 18 цохилтын аргаар хэд хэдэн мэх хийж хорч Ду авгайг хэдэн алхам холдууллаа.

Жу Сян Зюний өдрийн бодол шөнийн зүүд оболж явсан хүн нь дээд тэнгэрээс бууж ирэх мэт гэнэт гарч ирэхэд сэтгэлд нь наран мандах мэт баяраар гийхийн зэрэгцээ түүний хэрэглэж байгаа арга мэх нь Сян Зюний салхи гүйцэгч 18 илдийн аргатай нэг л адилхан мэт санагдахад өөрийн эрхгүй ихэд гайхаж байлаа. Түүний хэрэглэж байгаа арга мэх болгон дайсныхаа амин цэгийг онилсон байхыг үзээд <<Зин ахаа наадхынхаа аминд хүрч болохгүй шүү>> хэмээн хашгирав.

И Да Зин угаас хүн алах саннаагүй дээр энэ удаа хорч Ду авгайг аль болохоор холдуулах бодол агуулж байсан тул Жу Сян Зюний ийн хэлэхийг сонсоод <<Миний бяцхан шулам хэдий завандаа амжиж бяцхан бодистава болон хувичихаа вэ>> гэхэд Жу Сян Зюнь <<Наадахь чинь Му Цин Ся эгчийн багш нь үгүй ээ ээж нь байгаа юм шүү. Тийм болохоор шархдуулж ч болохгүй>> гэлээ.

Хорч Ду хамгаалан ухрахаас биш хариу цохилт хийх тэнхэлгүй болсон байлаа. Хэрвээ И Да Зин түүнийг алья гэж бодсон бол тэрээр аль хэдийн хулсан лимбэний цохиолтонд амь тавьсан байх байсан буй за. Тэгсэн атлаа тэрээр Жу Сян Зюний хэлэх үгийг сонсоод хэрээ тавилгүй мөчөөрхөж <<Хэн чамаар өрөвдүүлэх гэсэн юм бэ>> гэх зуур урагш ухасхийн дайрахдаа амь насаа алдахаас буцахгүй болсныг үзвэл дайсантайгаа хамт амь тавья гэж бодсон бололтой.

Му Цин Ся гэнэт санаа авсан бололтой <<И ахаа болгоомжтой байгаарай. Ээжийн биеэр дүүрэн хор байгаа шүү>> гэлээ.

Хорч Ду авгай насан туршдаа хор найруулах эрдэмд суралцсан тул хамаг биедээ хор агуулж явдаг бөгөөд өнөөдөр зэвсгийн эрдмээр сайнаа үзэхгүй гэдгээ мэдэж яадаг ч байсан И Да Зинг тэврэн авч хордуулж алахаар шийджээ. Түүний энэ санааг гадны хүн мэдээгүй байтал төрсөн охин нь санаа авахуулахыг үзээд багтартлаа уурлан <<Эмэгтэй хүүхдийн элэг

буруу гэж яасан үнэн үг вэ. Чи надад туслаж төрсөн ээжийгээ уурлуулж алсан бол одоо энэ гоо залууд туслаж намайг алах чинь дутаа юу>> хэмээн хашгирав.

Му Цин Ся нүүрээ даран уйлна.

<<Му бүсгүй санаа зоволтгүй. Танай ээж чинь намайг яаж ч чадахгүй. Би ч гэсэн түүнд гэм болохгүй>> гэлээ.

Хэдийгээр аман дээрээ ийн хэлэх боловч тэрээр хорч Ду авгайгийн биеэр дүүрэн хор байгаа гэхийг сонсоод нилээд болгоомжтой байх боллоо. Хорч Ду авгай хортой аягаа барьсан чигээрээ алгуурхан дөтлөнө. Сарны туяан доор түүний нүд нь ногоорон харагдах нь жижүүдэс төрүүлэм ажээ.

И Да Зин ам нааж <<Авгай минь хоёулаа эвлэрвэл яасан юм бэ>> хэмээн асуув.

Хорч Ду авгай ихэд уурсан <<Гайгүй байлгүй хорч Ду надтай учирсан хүмүүс үхэж байж л салдаг юм даа. Гэтэл бас эвлэрэх юм ярьж байдаг байна аа бас>> гэв.

<<Сян дүү тэндээ хөдөлгөөнгүй суугаад байхыг бодоход хордсон болотой. Хэр зэрэг айхтар хордсон бол доо. Энэ авгай хэдийгээр зэвсгийн эрдмийн хувьд гавихгүй боловч хамаг биенд нь хор шингэсэн юм байна. Гэтэл ядаж миний энэ хулсан лимбийн цохилтын арга биед нь заавал ойртож очих хэрэгтэй болоод байдаг. Яадаг юм билээ?>> хэмээн И Да Зин бодолхийлнэ.

Ийн бодох зуур хор Ду авгай түүнийг Жу Сян Зюний зүг алгуурхан шахсаар байлаа. <<Сян дүү маань хамаг зэвсгийн эрдмийн чадвараа алдсан бололтой. Хэрвээ энэ авгай түүн рүү хүрч очих юм бол тэрээр биеэ хамгаалах чадалгүй байх нь. Өөрөө яадаг ч байсан ч хамаагүй энэ авгайг түүнд ойртуулж болохгүй>> гэж И Да Зин бодлоо.

Тэгээд тэрээр ээлж дараалан хэдэн арга мэх хийсэн нь бүгд хорч Ду авгайгийн амин цэгийг онилсон байлаа. Хорч Ду авгай арга байхгүй болсныг мэдээд эцсийн арга болгон аятай хорроо түүний нүүр рүү цацав.

Жу Сян Зюнь Му Цин Ся нар зэрэг дуу алдацгаалаа. Хэдийгээр 7 навчит цэцгийн хор дотуур ууж байж үйлчилэх болов хорч Ду авгай юу ч хийсэн байж мэдэх тул тэд ийн сандарцгаажээ.

Харин азаар И Да Зин Ту Ди Хантай туладах үедээ хэрэглэсэн <<Хаврын салхин хараацайг хазайлгах>> мэхээ хийсэн нь онож агаарт хэдэн алд өндөр үсрээд хорч Ду авгайгийн дээгүүр дүүлэн гарахад цацсан хор түүний биед хүрсэнгүй бөгөөд харин И Да Зин түүний ард зөөлөн бууж

цахилгаан мэт түргэн шалмаг хөдлөн хорч Ду авгайгийн хөдөлгөөнгүй болгодог цэгийг дарж орхилоо.

Хорч Ду авгай хорны аягаа тас зуураастай чигээрээ дуу алдан унав.

Му Цин Ся ч ээжийнхээ зүг ухасхийн гүйж очлоо.

Харин И Да Зин Жу Сян Зюний зүг гүйж очоод түүнийг түшин авч асууруун <<Сян дүү минь чи зүгээр биз дээ>> гэлээ.

Жу Сян Зюнь түүнийг тасхийтэл алгадаж аваад эхэр татан уйллаа.

<<Сян дүү минь чи намайг зэмлэх чинь аргагүй. Чи миний төлөө энэ их зовлонг амссаны чинль төлөө би энэ насан туршдаа...>> хэмээн И Да Зин хэлэв.

<<Энэ насан туршдаа яана гэж? Би чамайг хүлээж эрж хайж хичнээн их явсан гэж санана. Гэтэл чи ямар хүүхний урхинд орчихоод санаа урвасан болдоо>> хэмээн Жу Сян Зюнь өгүүллээ.

Му Цин Ся ээжийнхээ дэргэд гүйн очоод <<Ээжээ та сэргээч сэргээч>> хэмээн хашгирав.

Хорч Ду авгай гэнэт <<Чи юу болоод хашгирч гууглаа вэ. Хүн юу ч гэж бодох юм билээ>> гэсэнээ И Да Зингийн зүг хандан <<И баатраа таны эрхэм алдрыг асууж амжаагүй юм байн шүү>> гэв.

<<Мөхөс миний нэрийг Да Зин гэдгээ> гэж И Да Зин мэхэсхийн хариуллаа.

<<И Да Зин гэнэ ээ, И Баатар>> хэмээн хэсэг зуур азнаснаа дахин <<Эрхмийн багш ямар хүн байдаг билээ?>> гэв.

И Да Зин хэсэг зуур эргэлзсэнээ <<Эрхмээ багшийн өөрийн зөвшөөрөлгүйгээр түүний эрхэм алдрыг мөхөс би хамаа бусаар бусдад өгүүлж яахин болох вэ>> гэлээ.

Хорч Ду авгай энэ үед туйлын тайван амгалан болж өгүүлрүүн <<Шавийг нь олсноос хойш багштай нь учирч болох байлгүй>> гэлээ.

Ийн өгүүлээд гэнэт ухасхийн босож ирлээ. Тэрээр янз нь дотоод хүчээрээ хатгуулсан хөдөлгөөнгүй болгогч цэгийг тайлж чадсан бололтой.

Хорч Ду авгай И Да Зингийн зүг хандан <<И баатраа гурван сарын дараа чамайг багштайгаа цуг 7 навчит цэцгийн хор амсахыг урьж байна. Хөгшин би бидний чухам хэн нь хорвоод хосгүй хорч хорон санааны эзэн байх нь вэ гэдгээ үзмээр байна>> гэв. Ийн өгүүлж дуусаад гартаа мөнөөх 7 навчит цэцгийн хор хийсэн хоосон аягаа барьсаар Му Цин Сяг ч хайхралгүй яваад өглөө.

Саран баруунаа хэлбийж газар дэлхийг өдөр мэт гийгүүлнэ. Хуучин булшны дунд болзоот залуу хосууд л үлджээ. И Да Зин Жу Сян Зюнийг тэврэн авч асууруун <<Сян дүү минь чи гайгүй болов уу?>>

Жу Сян Зюнь И Да Зингийн энгэрт наалдан юу ч хариулсангүй нүдээ тас анин намуун дуугаар <<Зин ах минь би таныг яасан их санав аа. Ёстой санаж үхэх шахсан шүү>> гэв. И Да Зин ч түүнийг тас тэврэн эрүүгээрээ түүний хонгорхон хар гэзгийг шөргөөнө.

Жу Сян Зюнь гэнэт нүдээ нээж <<Зин ахаа хоёулаа бушуухан энэ золигийн газраас олдоё>> гэлээ.

<<Чиний дотоод хүч чинь сэргээгүй байхад яахин явж болох билээ. Би эхлээд чамд дотоод хүчнээсээ жаахан өгөөдөхье. Тэгээд явцгаая>> гэлээ.

Жу Сян Зюнь тийчигнэсээр босож ирээд <<Одоохон явцгаая энэ газар чөтгөр шүглэсэн байх>> гэлээ.

И Да Зин түүний судсыг барьж үзвэл биеийн тамир нь туйлын доор орсноос бус өөр ямар нэгэн онцын нөлөөгүй тул түүний үгэнд орж замаа хөөлөө. Тэрээр Жу Сян Зюнийг гараараа түшин явав. Удаан хугацаагаар холдон үхлийн савраас амьд мэнд үлдсэн хоёрын сэтгэл баяр хөөрөөр дүүрч орчлон ертөнцөд тэднээс жаргалтай улс байхгүй мэт санагдана. Буцах замаа хөөсөн гэснээс сарны туяанд цэцэгсийн дунд сайхан хосууд зугаацан явна гэж тодорхойлбол оновчтой байх байсан буй за.

<<Чи хаачсан бэ? Хэн чиний 7 навчит цэцгийн хорыг анагаасан бэ? Чи хэнээсээ ийм айхтар зэвсгийн эрдэм сураа вэ?>> хэмээн асуухад И Да Зин тэр өдөр модон махобдийн бүлгээс гараад хэрхэн багштайгаа учирсан түүнд багш нь толбот хулсны 18 цохилтын аргыг зааж дараа нь уулнаас буугаад хэрхэн шороон махобдийн бүлгийн эзэн болсон зэргийг өгүүлсэн боловч багш нь охиндоо сүй бэлэг бэлдэх тушаал өгснийг л хэлсэнгүй.

Жу Сян Зюнь хэсэг зуур дуу гарсангүй. Энэ хагас жил хүрэхгүй хугацаанд И Да Зин ийм гайхамшигтай учралтай тохион жирийн нэгэн номчоос шороон махбодийн бүлгийн толгойлогч болсон гэхэд нэг л итгэмээргүй санагдаад байв. Гэвч сая тэр хорч Ду авгайтай тулалдаж байхыг үзвээс зэвсгийн эрдэмдээ сайн боловсорч чадаагүй боловч үнэхээр уран нарийн арга мэхүүдийг хослуулан хийж байсан билээ. Тэгээд ч түүн шиг дотоод хүч ихтэй хүнд хагас жилийн хугацаанд зэвсгийн эрдмийн нэгэн төрлөөс суралцана гэдэг тийм хүнд хэрэг биш юм. Жу Сян Зюнь энэ бүхнийг эрэгцүүлэн бодож гүйцээд гэнэт <<Зин ахаа таны багш чинь арай хүрэн хулсны гэлэнмаа биш биз дээ?>> хэмээн асуулаа.

<<Чи ямар мундаг юм бэ? Арай далдыг хардаг болсон юм биш биз? Үүнээс хойш би чамайг дарь эх гэж дуудаж байя>> гэлээ.

Жу Сян Зюнь инээд алдан <<Тэр ч арай хэтэрнээ. Харин би таныг хожим номын дүү гэж дуудаж байх хэрэгтэй болох нь ээ>> гэв.

И Да Зин өгүүлрүүн <<Өө би чамайг жаахан хөөргөчихсөн чинь даварсаар даварсаар давгийн оронд гарах нь ээ>>. Жу Сян Зюнь <<Хаанаас даа багш шавийн барилдлага ёсоор бол багшдаа түрүүлж шавь орсон нь номын эгч сүүлд шавь орсон нь номын дүү болох нь зүйн хэрэг бус уу. Тэгэхээр та ямар ч байсан намайг номын эгчээ гэж дуудах болж дээ. И Да Зин давхийн цочиж <<Тэгвэл манай багш чинь бас чиний багш байсан юм уу?>> гэлээ.

Жу Сян Зюнь санаа алдан <<Би чиний зэвсгийн эрдмийн арга мэхийг харангуут л энэ талаархи таамаг сэтгэлд сэрхийн орж ирсэн юм. Харин багш маань яагаад чамайг шавь болгон авсан юм бол доо гэдэгт л би ерөөсөө нэг л итгэж өгөхгүй байна. Манай багш уулаасаа эрэгтэй хүнийг үзэж чаддаггүй. Ертөнцийн өмхий эрчүүдэд ганц ч олигтой амьтан байхгүй гэдэгсэн. Харин муу өмхий золиг чи аль насандаа хийсэн буяны үрийг амсаж манай багшийн нүдэнд торж өртсөн юм бол доо>> гэлээ.

И Да Зин инээд алдаж <<Тэнэг хүн тэнгэр заяатай гэдэг байхаа. Багш маань ухаантай хүн болохоороо чам шиг анхилуун цэцэг шиг шавьдаа бас нэг өмхий золигийг олж өгөөд уран хажингийн жаргалыг эдлүүлэхгүй бол болохгүй гэж бодсон байлгүй дээ>> гэлээ.

Жу Сян Зюнь өгүүлрүүн <<Дахин дэмий балай юм яриад байвал би уурлалаа шүү>> гэлээ.

И Да Зин багшийгаа өөрийн охинтой албадан суулгах гээд байсныг санаж хожим юу болдог бол доо гэж бодоод үнэхээр дуугаа хураалаа.

Жу Сян Зюнь асууруун <<Чи чинь яагаад хэлгүй хүн шиг болчихов оо. Уурлачихав уу. Чамайг тэгж хэлэхэд чинь миний сэтгэлд сайхан байсан л даа>> гэв.

Энэ үед үүр манхайн цайлаа. Тариан талбад тариачид газраа хагалан тосгоны хүүхнүүд ялмын модны навчийг цуглуулна. Найртай хонгор салхи хацар нүүрийг билбэн налгар шар наран ар зооноос тааламжтайяа ээнэ. Амраг хосууд мишээл дүүрэн харцаар хамаг сэтгэлээ ойлголцон явсаар нэгэн гацаанд ирвэл Жу Сян Зюнь туйлын их өлсөж байгаагаа сая л мэдлээ. Хоёул нэгэн жижиг зоогийн газар оров. И Да Зин шороон махбодийн бүлгийн толгойлогч болсноор урьдынхтайгаа харьцуулашгүй болж сохор улаан зоосны хойноос явдаг номын хүн байхаа больсон байна. Ханцуйнаасаа хэдэн мөнгөн зоос гаргаж ирэхэд түүнтэй цуг мөнөөх шороон махбодийн бүлгийн анжисны хэлтэрхий цуг ойчлоо. Жу Сян Зюнь угаас хурц нүдтэй тул түүнийг олж хараад шүүрэн авч асууруун <<Энэ чинь юу юм бэ?>> гэв.

И Да Зин инээд алдаж <<Шороон махбодийн бүлгийн толгойлогч болоод өдөржин тэр хүнд том анжисыг үүрч явна гэдэг бэрх ажил юм. Тийм болохоор би наадахь хэсгийг чинь таслан авч бүлгийн толгойлогчийн бэлгэ тэмдгээ болгосон билээ>> гэв.

Жу Сян Зюнь ч мөн инээд алдан <<Чи мөн айхтар болсон байна шүү>> гээд мөнөөх анжисны хэлтэрхийг эргүүлж тойруулан үзэж байснаа <<Гялалзсан ямар хөөрхөн эд вэ? Зин ах надад өгчих юм байгаа биз дээ>> гэлээ.

И Да Зин Жу Сян Зюнийг гэнэт ийм юм хэлэн гэж бодож байгаагүй тул хэсэг зуур балмагдсанаа инээн <<Баатар эр би мөрөн голоор анх гарч ирэнгүүтээ 5 махбодийн бүлгийн шороон махбодийн бүлгийн хайсангийн эзэн болсон билээ. Манай бүлгийн бэлгэ тэмдгийг яахин бусдад хамаа бусаар бэлэглэж болох вэ? Журамт бүсгүй Жу та үнэхээр санаа байх аваас ид чадлын хүчээр булаан авч болох юм шүү>> гэлээ.

Жу Сян Зюнь түүнийг тогтоон ширтэж <<Наад амаа мэдээч>> гэлээ. Гуанз зоогийн газар, буурчийн газар зэрэгт есөн хэлийн улс хөлхөлдөж байдаг юм. И Да Зин мөрөн голын туршлага өчүүхэн ч үгүй тул тоглоом наадам хийж байх зуур өөрийн болоод Жу Сян Зюний алдар нэр хэргэм зэргийг дурдчихсан байлаа. Жу Сян Зюнь нүдний булангаар хавь ойрыг сэрэмжлэн хартал өглөө эрт болохоор зоогийн газар төдий л олон хүн байсангүй. Харин нүдэндээ галтай нүүрэндээ цогтой зоогийн газрын зарлага хүү мөрөн дээрээ алчуур тохон орж ирсэн зочин гийчинтэй мэнд амраа

мэдэлцэнэ. Жу Сян Зюнь <<Наадахь чинь тийм ховор живэр эд юм уу. Ямар хүүхэнд бэлэглэх гэж байгаа бол доо>> гэлээ.

Сэтгэлээс хайр үүдэлтэй хайртай бол хартай гэгчээр Жу Сян Зюний хэлсэн үг голыг оножээ. Шороон махобдийн бүлгийн энэхүү бэлгэ тэмдгийг И Да Зин өөрийн багшийн охины сүй бэлэгт бэлдсэн билээ. Зүс царайг нь ч хараагүй багшийнх нь охин түүний хувьд багштай нь адилхан ариун дээд санагдах ажээ. Гэвч энэ бүхнийг хоёр гурван үгээр түүнд тайлбарлан ярих сэхээ төрсөнгүй. И Да Зин арга буюу <<Сян дүү минь дэмий балай яриагаар яах гэсэн юм бэ>> гэлээ.

Жу Сян Зюний сэтгэлд хар сэжгийн сүүдэр төржээ. Тэрээр И Да Зинтэй төдий л удаан нөхөрлөөгүй тэгээд ч өнгөрсөн хагас жилийн хугацаанд түүнтэй өөр ямар ч хүүхнүүд учраа билээ гэж тэрээр бодож суулаа.

Жу Сян Зюнь тэр санаагаа мэдэгдсэнгүй инээд алдаж <<Зүгээр тоглож байхад яасан их сандарч байх юм бэ Зин ахаа. Би хэдийгээр нэг их онцын хүнд шарх аваагүй ч гэсэн тав арав хоногтоо язгуурын хий маань нөхөгдөж чадахгүй байхаа. Гэтэл явах зам маань хол тул яаж явган явах вэ? Та нэг тэрэг хөлслөөд ир. Хоёулаа унаа хөсгөөр газар дөхье>> гэлээ.

Энэ газар нь их замаас алслагдсан мөрний өмнөх бяцхан гацаа тул морь тэрэг мэтийн зүйлс туйлын ховор ажгуу. И Да Зин удтал эрэн сурагласны эцэст гацааны баруун этгээдэд байх илжиг луусны бяцхан зах дээр ирлээ. Илжиг луусны зах нэртэй оловч усны одос үхэр голдуу цөөн хэдэн туранхай илжиг л байх ажээ. Илжигэнд хөллөх тэрэгний тухайд гэвэл бүр ч ярилтгүй ажээ. Нэгэн сайн санаат хүмүүн <<Манай эндхийн Жао овогт баянд хэдэн сайн аргамаг хүлэг бий. Чи яах вэ тийшээ очоод үз л дээ>> хэмээн зааж өглөө.

Жао баяных гацааны хойд хэсэгт байдаг тул И Да Зин явсаар хагас цагийн дараа тэднийд хүрчээ. Азаар Жао баян их л уриалгахан хүн таарч өргөөнийхөө их танхимд цай идээгээр зочлов. Харин И Да Зин түүний аргамаг хөлгийг худалдан авах тухай яриа өдөөхөд түүний царай барайгаад явчихлаа. Баячууд аргамаг сайн хөлгийг муур, нохой тэжээдгийн адилаар байлгадаг ба байшин саванд байлган будаа тариагаар хооллодог ажээ. Түүнээс бус унаа хөсгийн зориулалтаар хэрэглэнэ гэсэн ойлголт үгүй байдаг ажэ. Эрхэм сайн зочин гийчин ихэс дээдэс ирэхийн үест эрдэнийн хөлгүүдээ гайхуулан үзүүлэх дуртай. <<Хөлөг морио зарна гэдэг уруудаж доройтохын эхлэл гэдэг. Жао овогт би арай ч тиймдээ тулаагүй байна. Эрхэм зочин та

ирсэн замаараа буц даа>> хэмээн Жао баян хэллээ. И Да Зин дахин сайтар гуйж үзэх гэсэн боловч Жао баян аягаа ширээн дээр тавьж өрх гэрийн даамалд <<Зочныг үдэн гарга>> гэв.

И Да Зин арга буюу алга хавсран салах ёс гүйцэтгэлээ.

Үнэн хэрэгтээ И Да Зин мөрөн голын туршлага нимгэнээс ийн гар хоосон хоцорчээ. Мөрөн голын сай эрс ийм хэцүү байдалд ороод байгаа бол зоригоо чангалан илдээ сугалж хөлөг сайн морьдыг булаан авч явах учиртай. Харин зориг зүрх муутай нэг нь шөнө дүлээр хашаа хороо даван орж адуу малыг хулгайлан оддог билээ. Шударга журмын талынхан аваас хэдэн мөнгөн зоос сууринд нь үлдээж <<Эрхмээ мөхөс би энэ газар хөл явгараад эрдэнийн хөлгийг эзэмдэн явлаа. Үнэ өртөгт хэдэн мөнгөн зоос үлдээсэн шүү>> гэж хашгирахаа ч бас мартаггүй учиртай юм. Хорон муу санаатнууд нь эзэн баяныг алж эд хөрөнгийг талаад хөлөг морьдыг хөтлөн явах нь тухайн цагт ердийн үзэгдэл болсон хэрэг байлаа.

Гэтэл хэн И Да Зин шиг ингэж бөхөлзөж тонголзож байх вэ дээ.

И Да Зин арга буюу нөгөө илжиг луусны зах орж нэг туранхай илжиг худалдан аваад эргэн ирэхэд Жу Сян Зюнь бараа туруугүй алга болсон байв.

И Да Зин туйлаас их бачимдан сандарлаа. Жу Сян Зюний хамаг дотоод хүч алга болсон бөгөөд хорч Ду авгай битгий хэл адгийн муу хулгайч луйварчин хүртэл түүнийг олзлон явъя гэвэл алга урвуулахын төдий хэрэг байлаа. Гэвч энэхүү зоогийн газар алалдан тулалдсаны ул мөр хараахан үгүйд тэрээр ялимгүй санаа амарлаа. Тэгээд мөнөөх сэргэлэн байрын зарлага залууд хандан <<Өршөөгөөрэй сая танай зоогийн газар хоол идэж байсан бүсгүй хаашаа явчихав>> гэв.

Мөнөөх зарлага түүнийг үл тоосон байдалтай ширвэн хараад <<Манай мөхөс зоогийн газар түмэн газрын амьтан хүн гэдэс нь өлсөхөөрөө ирж цадахаараа гарч явдаг болохоор өчүүхэн би яахин хэн бүхний хаашаа явсын г мэдэх билээ. Эрхэм гүнтэн та чухам хэнийг хэлж байгаа юм бол доо>> гэв.

И Да Зин инээд алдан <<Яагаав өнөө өглөө надтай цуг ирдэг хүүхэн>> гэлээ.

Зоогийн газрын үйлчлэгч уур нь бадран <<Та чинь ямар хаашаа хүн бэ. Манай зоогийн газар өдөртөө хэдэн зуун хүн хүлээн авч хооллож ундалж байдаг. Хэрвээ орж гарсан хүн болгоныг бүртгээд байвал манай бид яахин ашиг орлоготой ажиллах билээ>> гэв.

И Да Зин зоогийн газрынхан бүгд л шунахай улс байдагсан хэмээн бодоод өврөөсөө хэсэг мөнгөн зоос гарган зарлагын өвөрт чихэн <<Тэр бүсгүйн бие чилээрхүү байгаа юм л даа. Ганцаараа зам мөрөө хөөнө гэвэл туйлаас хүчиртэй. Тиймийн тул эрхэм та надад хаашаа явсныг зааж өгөхгүй юу>> гэлээ. Гэтэл мөнөөх зарлага түүний гартаа барьсан мөнгийг буцааж <<Мөхөс би зөвхөн хоол архи зөөхөө л мэддэг. Зочин гийчид үнэ цэнэтэй зүйлс тэр тусмаа авч яваа хүнээ өөрөө харж хамгаалж явах ёстой юм шүү дээ>> хэмээн уурсан өгүүлээд эргэн явснаа хоёр алхуут амандаа <<Чам шиг ёс журам ном судар ярьсан хүн яаж тэр аймшигт шулам бүсгүйтэй хамт байж болдог байна аа>> хэмээн үглэх нь сонсогдов.

И Да Зин <<Шулам бүсгүй>> гэх хоёр үгийг сонсоод огло үсрэн түүний өмнө гарч <<Чи сая юу гэв ээ>> гэтэл зарлага залуу номын дүртэй энэ хүний хөл гарын хөдөлгөөн ийм хурдан түргэн байна гэж санасангүй тул ихэд балмагдан <<Би юу ч гэж хэлээгүй шүү дээ>> гэлээ. И Да Зинд зарлага залуугийн байдал их л сэжигтэй санагдсан тул Жу Сян Зюнь түүний гарт орсон байвал яана гэсэн битүү түгшүүр төрж түүний баруун мөрийг атган авч өгүүлрүүн <<Би чамаас л хүнээ нэхнэ дээ>> гэтэл мөнөөх залуу загас мэт түүний гараас мултран гарахад И Да Зин хий мөргөлөө. <<Хүүе чи чинь ийм хүн байсан юм уу>> гээд И Да Зин түүний далны яснаас шүүрэн авлаа. Зарлага залуу яахин И Да Зингийн гарын аяыг даах билээ дээ. Далны ясаа атгуулчихаад орь дуу тавин ориллоо.

Зоогийн газрын даамал чимээ шуугианыг сонсон гарч ирэв. Тэр хүн гайхмаар туранхай өндөр хүн байлаа. Харин нэлмэгэр том хувцас өмссөн нь яг л хулсанд хувцас өлгөсөн мэт үзэгдэнэ. <<А Сань чи яагаад зочин гийчнийг үймүүлээд байгаа билээ>> хэмээн амандаа үглэх ажээ. Түүний нэлмэгэр ханцуйнаас үүсэн хүчит салхи ар нуруунаас нь дайран ирэхийг И Да Зин мэдэрлээ. И Да Зин зарлагыг орхиод хүчит дайснаа амдан угтахаар зэхэв.

Гэтэл даамал юу ч болоогүй мэт алга хамтатган <<Манай энэ гэж юу ч мэдэхгүй тэнэг амьтан байгаа юм. Хэрвээ буруу зөрүү зүйл гаргасан байх аваас эрхэм зочин та өршөөн нигүүлсэн үү>> гэлээ. И Да Зин <<Бололгүй яахав бололгүй яахав>> гэлээ. Даамал асууруун <<Эрхэм та дотны найзаа хайж байгаа гэсэн үү>> гэхэд И Да Зин <<Тиймээ та зааж айлдахгүй юу>> гэв. Даамал <<Тэгвэл эрхэм та намайг дагаад явна уу>> гэлээ.

Мөнөөх зоогийн газрын арын хашаан даамлын гэр байшин байдаг юмсанжээ. Даамал түүнийг агуулан нэгэн өрөөнд оруулваас Жу Сян Зюнь

тэнд нэгэн ширээний ард сууж байх бөгөөд өмнө нь хэдэн төрлийн зоог зууш өрсөн байлаа. И Да Зингийн санаа ихэд амарч <<Жу бүсгүй минь чи зүгээр биз дээ>> гэлээ. Жу Сян Зюний хоёр нүд нь хөдлөхөөс биш ямар ч дуу гарахгүй сууна. И Да Зин <<Би нэг илжиг худалдаад аваад ирлээ. Хоёулаа зам мөрөө хөөцгөөе дөө>> гэхэд Жу Сян Зюнь бас л дуугүй байх ажээ. И Да Зин нэг л юм болж гэж бодоод дөхөн очиж түшээд авах гэтэл тэр өнхрөн ойчоо.

И Да Зин гайхан балмагдаж даамлын өмнө эргэж очоод <<Чи түүний цэгийг дарсан юму уу?>> хэмээн хашгирахад даамал инээд алдаж <<Би энэ шулмын хамгаалагч нь ямар хүн байгаа юм болдоо гэж бодож байтал чи муу байсан юм уу?>> гэв. И Да Зин өгүүлрүүн <<Бид чамтай өс хонзон байхгүй. Гэтэл чи яагаад түүнд хор хүргэж байгаа билээ>> гэхэд даамал <<Тэнгэрт тэрслүү бүлгийн хорт шулмыг харсан бүхэн жигшиж халдсан бүхэн алж байх учиртай юм даа!>> гэлээ.

И Да Зин гайхан балмагдаж <<Тэнгэрт тэрслүү бүлгийнхэн гэнээ тэр чинь юу байдаг юм бэ?>> гэлээ.

Даамал өгүүлрүүн <<Миний бодоход эрхэм та шулмын бүлгийн хүн биш шиг бололтой. Гэсэн атлаа яагаад шударга замынхантай шөргөөцөлддөг билээ. Тэнгэрт тэрслүү бүлгийнхний хорон муу үйл савандаа багтахая байсан. Тийм болохоор тэд мөрөн голынхны хамтын дайсан билээ. Гэтэл эрхэм та яахаара энэ заваан юм руу халтиран ордог билээ>>.

И Да Зин анх удаа л мөрөн голоор үзэгдэж байгаа болохоор Тэнгэрт тэрслүү бүлэг гэж юу байдгийг яахин мэдэх билээ. Гэвч Жу Сян Зюнь түүнд сэтгэл зүрхээ өгсөн тул юу боллоо гэж түүнийг хөндлөнгийн хүнээр доромжлуулж болох билээ дээ. И Да Зин хүйтнээр инээвхийлэн <<Өчүүхэн надад түүний ямар бүлгийнх гэдэг нь хамаа байхгүй. Харин Жу бүсгүй миний анд нөхөр тул түүнийг зүгээр орхиж болохгүй учиртай юм даа>> гэлээ.

Даамал инээд алдан <<За тэгвэл өөрөө мэддээ. Эрхэм нөхөр чинь манай зоогийн газар жаахан тохь алдсан байж мэднэ. Өчүүхэн би түүний хөдөлгөөнгүй болгодог цэгийг дарсан юм. Та өөрөө түүний дарагдсан цэгийг тайлж анд нөхрөө аваад буц даа>> гэлээ.

Жу Сян Зюнь мөрний өмнөд нутагт ирээд өс зангидсан хүн нэгээхэн бээр ч үгүй юм. Гэвч мөрөн голынхны дунд сураг чимээ дуулдахдаа түргэн тул тэнгэрт тэрслүү бүлгийнхэн үзэгдэх болсон тухай их бага хар цагаан замын бүлгүүд дорхноо дуулцгаасан байна. Жу Сян Зюнь И Да Зинг морь тэрэг олж ирэхээр гарсан дару сэтгэлд нь түмэн зүйлийн юмс бодогдож

уураа зоогийн газрын зарлагад гарган түүнтэй ам хэл шөргөөцөлдөөд эцэст нь алганд авсан юм. Гэтэл гай болж энэ зоогийн газрыг мөрний өмнөд нутгийн нэгэн бяцхан бүлэг нээсэн бөгөөд зоогийн газрын эзнийг <<Мөрний өмнөд нутгийн удаахь төмөр хуруут>> гэж алдаршсан байлаа. Өөрөөр хэлбэл цэг дарах зодооны аргаар мөрөн гол даяар хоёрдугаарт ордог гэсэн үг юм. Тэр цэг дарахдаа үнэхээр гаргуун тул түүнд цэгээ даруулсан хүнийг тэр өөрөө л тайлж өгөхгүй бол бус хүн яаж ч чаддаггүй байлаа. Жу Сян Зюний хувьд ердийн цагт байсан бол түүнийх шиг хэдэн хүн ч ирсэн айл юмгүй бөгөөд тэрээр хамаг биеийн дотоод хүчээ алдсан тул түүний гарт ороод яаж ч чадахгүй болсон юм.

И Да Зин өгүүлрүүн <<Өс хонзонг өвөрлөж болохгүй гэж хэлдэг шүү дээ. Эрхэм та өөрөө миний найзын дарсан цэгийг тайлж болгоох ажаамуу>>.

Даамал инээд алдан <<Мөрний өмнөд нутгийн удаахь төмөр хуруут би гагцхүү цэг дарж чадахаас биш тайлж чаддаггүй юм даа>> гэв.

И Да Зин түүнд хэн болохоо үзүүлэх омог сүр нь бадарч <<Номч баатар И Да Зин би цэг дарж чадахгүй харин хүнээр цэг тайлуулахдаа муугүй шүү>> гэлээ.

Даамал түүнийг номын төрхтэй байдаг л нэг эр биз гэж санаад нэг их юм бодсонгүй. <<Тэгвэл би танаас ганц хоёр арга мэх сурч авъя байз>> гэлээ.

И Да Зин <<Хэдэн арга мэх үзүүлж бололгүй яахав. Харин манай багш надад дорой багшаас дорой шавь төрдөг гэж сургасан билээ. Тэрээр хүнтэй тулалдахаасаа өмнө багшийнх нь алдар нэрийг заавал асууж байгаарай. Хэрвээ тулалдаж болохоор хүн байвал тулалд. Тулалдаад нэрээ гутаах хн байвал больчихож бай гэж сургасан юм. Тийм болохоор та эхлээд эрхэм багшийнхаа алдар нэрийг хэлж болгооно уу>>.

И Да Зингийн ийн өгүүлэх нь даамлын уур унтууг хүргэж орхив.

Гэвч мөрөн голын туршлага ихтэй хүмүүс баярлах хорсохоо нүүрэндээ илрүүлдэггүй тул тайвнаар <<Танай багш чинь тэгвэл айхтар хүн байх нь. Мөрний өмнөх нутгийн тэргүүн хуруутын шавьтай тулалдаж болно биз дээ>> гэлээ.

И Да Зин толгой сэгсрэн <<Манай багш өгүүлэхдээ мөрөн гол даяар өөрсдийгөө тэргүүн удаахь гэх мэтээр өргөмжилсөн улсууд төдийлөн айхтар амьтас байдаггүй гэж манай багш айлдсан билээ. Тэрээр тиймэрхүү амьтадтай тулалдаж нэр сүрээ гутаахын хэрэггүй тавиад явуулчихаж байх хэрэгтэй гэж хэлсэн юм. Багшийн сургаалыг дагахгүй байж яахин болох вэ.

Тийм болохоор эрхэм та Жу бүсгүйн даруулсан цэгийг тайлж болгооно уу>> гэлээ.

Жу Сян Зюнь хөдөлж ярьж чадахгүй боловч ухаан санаа нь хэвийн тул дотроо И Да Зинг хараан зүхэж <<Муу хар номын хэнээтэй солиг чинь түүний бодийг хурдан хөтөлчихгүй юундаа ингэж цэц булаалдана вэ>> гэж бачимдана.

И Да Зин үнэн хэрэгтээ даамлаас ихэд болгоомжилж байсан юм. Учир нь сая зоогийн газар түүний ханцуйн салхи нь тийм их хүчтэй ирж байхыг тэр мэдэрсэн билээ. Тэгэхээр тэнэг мангар дүр үзүүлэн түүний өөг илчилж авахыг эрмэлзэж байгаа нь энэ юм.

Даамлын санаа түүнээс ч гүн тул дотроо ихэд бачимдан уурлаж байсан ч аман дээрээ тайвнаар <<Эрхэм та надтай гар зөрүүлэхгүй аваас би явж ажлаа хийе дээ>> гэлээ. И Да Зин түүний явах гэж буйг хараад Жу Сян Зюний цэгийг яаж тайлах аргаа мэдэхгүй тул ихэд сандран <<Хүүе байзаарай...>> гэлээ.

Ийн хэлэх зуур даамлын хоёр хуруу цахилгаан мэт гялсхийн И Да Зингийн хэнхдэг хэвлийн хоёр амин цэгийг хатгаж орхилоо. И Да Зин сандран түүнээс бултах гэсэн боловч яахин завдах билээ.

Даамал гайхсандаа бүүр учраа олохоо больчихов. Учир нь тэрээр эсрэг талынхаа амин цэгийг онож хатгасан бол гарцаагүй ялах байтал И Да Зингийн урлаан гэрд цэгээс гарсан өвөрмөц дотоод хүч хоёр хуруугаар нь дамжин түүний биед шингээд 5 цул 6 савыг нь эргүүлээд хаячихав уу даа гэмээр өвтгөв. Харин хэнхдэгийнх нь амин цэг түүний хоёр хурууг соронзон мэт татаж орхилоо.

Даамлын урт хулс шиг бие тахийн доошилж И Да Зинтэй дотоод хүчээрээ тулалдах аргагүй байдалд орлоо. И Да Зин ихэд баясан даамлын ар нурууны эмзэг цэгийг хатгаад <<Мөрний өмнөд нутгийн удаахь төмөр хуруут гэж иймхэн амьтан байсан юм уу. Тэгэхээр ачит багшийн минь хэлсэн сургаал аргагүй үнэн байжээ>> хэмээн хэлэв.

Даамал нүдээ анин царайн нь хувхай цайгаад <<Би ялагдсан тул надад одоо хэлээд байх юм юу байхав. Чи Жу бүсгүйгээ аваад зам мөрөө хөө дөө>> гэлээ. И Да Зи <<Чи Жу бүсгүйн ямар цэгийг хатгасан бэ>> гэхэд даамал <<Хэнхдэгийн гол цэгийг хатагсан гэлээ. И Да Зин тэсгэлгүй уурлаж <<Би чинь чамайг овоо нэр сүртэй хүн юм байх гэж бодож байтал чи ийм өөдгүй хүн байсан юм уу>> гэхэд даамлын царай улсхийн үг дуугарч чадсангүй.

Хэнхдэгийн гол цэг бол хүний цээжин бие буюу хоёр хөхний хооронд байдаг юм. Жу Сян Зюнь хамаг дотоод хүчээ барсан тул түүнийг эсэргүүцэж чадаагүй билээ. Гэтэл мөрний өмнөд нутгийн удаахь төмөр хуруут тамиргүй мөхөс эмэгтэйн цээжин биенд хамаа бусаар хүрнэ гэдэг их л ёсгүй хэрэг байсан ажгуу. И Да Зин уг нь түүгээр цэгийг тайлуулна гэж бодож байсан боловч яахин тэр бузар амьтнаар түүний бие махбодид хүргүүлэх билээ. Тэрээр шүд зуун Жу сян Зюний ард гараад тахилын тавцан цэг дээр алгаа тавьж дотоод хүчээрээ үйлчиллээ. Жу Сян Зюний царай алгуур гэрэлтэн ухасхийн босоод газарт хэвтэж байсан даамлын тархин дээр дэвсвээс түүний тархи зад үсрэн амь тавьлаа. Жу Сян Зюнь энэ хүнийг тэсгэлгүй ихээр үзэн ядаж байсан тул хэдийгээр өөрийн дотоод хүч алга болсон боловч И Да Зингийн дотоод хүчийг биеэрээ гүйлгэн хөлдөө шингээгээд ийн дэвсэж түүний амийг егүүтгэсэн ажээ.

И Да Зин түүнийг үзээд <<Чи яагаад түүнийг алчихав аа>> гэв.

Жу Сян Зюнь ихэд өсөрхсөн байртай <<Ийм адгийн амьтныг амьд үлдээгээд яах гэсэн юм бэ>> гэлээ.

Жу Сян Зюнь түүнд <<Чи цаадахь зарлага залууг дуудаад ир. Би нэг арга оллоо>> гэв.

И Да Зин түүний чухам ямар учиртайг мэдэхгүй тул нөгөө залуу дээр очин <<Танай даамал чамайг дуудаж байна>>. Залуу даамлыгаа дуудаж байна гэхэд яахин эс очих билээ. Хаалгыг түлхэн ороод даамал газарт хэвтэж байгааг хараад ам нээн хашгирахын завдал өгөлгүй Жу Сян Зюний арга билгийн муна түүний толгой дээр данхийтэл буулаа.

Жу Сян Зюнь хамаг биеийн тэнхээ алдарсан бололтой суудалдаа лагхийтэл суугаад <<Би мөрний өмнөд нутгийнхныг үзэн ядаж байсан минь үүгээр жаахан намжлаа>> гэв.

И Да Зин санаа алдаад <<Сян дүү минь чи арай дэндүү харгис байгаа юм биш үү. Мөрний өмнөд нутгийн удаахь төмөр хуруут хэдийгээр чамд буруу хэрэг хийсэн нь үнэн боловч үхэх ялд унах байсан гэж үү. Дээр нь бас энэ зарлага ямар ч гэмгүй хүн шүү дээ>> гэлээ.

<<Тийм гэж үү>> хэмээн Жу Сян Зюнь инээвхийлээд <<Би чинь нэрд гарсан бяцхан шулам болохоор өөр яах хэрэгтэй билээ дээ. Харин яаж И бүлгийн толгойлогч таны хараанд өртсөн юм бол доо>> гэв.

И Да Зин угаас номын томоотой хүн авч хувь заяаны төөргөөр мөрөн голын хэрэгт хутгалдан Жу бүсгүйтэй танилцаад үхэх сэхэхийн уулзварт явж байж дахин уулзсан даруйдаа түүнийг ийн зэмлэх нь таарамжгүй гэдгээ

мэдэж хүчээр инээвчхийлээд <<Чи ганц хоёр үг хэлсний төлөө ингэж байгаа юм чинь хожим яаж хорвоог хамт туулна гэж бодоо вэ>> гэлээ.

<<Хожим гэнэ ээ. Хожим юу болохыг хэн яаж мэдэх билээ дээ хэмээн Жу Сян Зюнь бодлогоширон өгүүлснээ <<За хурдхан явцгаая эс тэгвээс албаны цэрэг ирж биднийг баривчилна гэвэл баларсан юм болно>> гэлээ.

И Да Зин ч түүний санааг дэмжин хашаанаас гарч Жу Сян Зюнийг туранхай илжигэндээ мордуулаад умард зүгийг зорин хөдөллөө.

Илжигээ зогсоо зайгүй ташуурдсаар орой болохын хэрд бас нэг жижиг гацаанд ирэв. <<За одоо гайгүй байлгүй дээ хүн амины хэргээс холдож амжсан байх>> хэмээн Жу Сян Зюнь хэлэв.

И Да Зин гайхан <<Яагаад>> гэж асуув.

Жу Сян Зюнь инээд алдан <<Та нар шиг номын улс л иргэний төлөө гэж явдаг байх. Өнөөдөр миний хүн амины хэрэг хийсэн газар энэ гацаатай нэг хошууных биш байж таарна. Тэгэхээр тэр гацааны мөрдөгч түшмэл өөрийн хошууны төвд очиж албан бичиг шийтгүүлэн дараа нь энэ гацааг хариуцдаг хошууны төвд ирэн нөгөө бичгээ батламжуулж явсаар байтал нанадаж арав хонох болно. Тэгэхээр бид шороон махбодийн толгойлогч таны зоос мөнгөөр энэ газар хэд хоног амарч биеэ сувилаад явахад юу нь болохгүй байхав>> гэлээ.

И Да Зин түүний ухаан сэргэлэнг гайхан бахдаж <<Чи ч хошуу тамгын түшмэл хийж байсан мэт тэдний ажлыг аргагүй сайн мэдэж байна шүү>> гэв.

Жу Сян Зюнь <<Хүн болгоны мэддэг чаддаг зүйл өөр гэж энэ дээ. Шүлэг ном, дэг ёс, шударга журам, эрдэм сурлага зэрэг нь та мэтийн номын улсийн эрхэлдэг ажил байх. Харин ярьсан зүйлсийг хүн алж хүрээ талж явдаг мань мэт нь мэдэхгүй өөр хэн мэдэх билээ>> гэв.

Тэр хоёр ийн явсаар нэгэн буурчийн газар хүрэлцэн ирээд И Да Зин амаа нээж завдаагүй байтал Жу Сян Зюнь өмнөөс нь буудлын эзэнд өгүүлрүүн <<Бид хоёр эхнэр нөхөр хоёр улс байгаа юм. Танай энэ газраар дайран өнгөрөхдөө хэсэг зуур үдэллэн буух хэрэгтэй болсон тул дээд зэргийн нэг өрөө олгохыг хүсье>> гэлээ.

И Да Зингийн нүүр улсхийн ичиж Сян дүү мөн галзуу шүү гэж бодож байлаа. Тэр хоёр хамтдаа нэг өрөөнд ороход тэрээр элдэв авир зан гаргахгүй нь ойлгомжтой боловч хожим хойно муу юм модон улаатай гэгчээр тархвал түүний ариун нэрэнд тортог суух бусуу. Жу Сян Зюнь ийн өгүүлэх зуур түүн рүү нүд ирмэхийг хараад угийн ухаалаг сэргэлэн хүн тул ямар нэгэн юм бодоо биз дээ гэж санан дуугүй байлаа.

Буудлын зарлага тэр хоёрыг дагуулан арын хашаан дахь дээд зэргийн тохилог өрөөнд оруулав.

Жу Сян Зюнь И Да Зингээс хоёр лан мөнгө авч түүнд өгөөд <<Дээд зэргийн зоог шүүс бэлтгэж нааш авчирагтун. Хариулт мөнгийг өрөө аваарай>> гэж тушаалаа. Зарлага ч байдгаараа бөхөлзөж тонголзож гарч явлаа. Түүнийг гарсны дараа Жу Сян Зюнь И Да Зинд хандаж <<И ахаа би арай дэндүү хэрэг хийчихээгүй байгаа>> гэж асуухад И Да Зин толгой сэгсэрлээ. Жу Сян Зюнь <<Яагаад>> гэхэд И Да Зин <<Сян дүү угаас хэлсэн үг хийсэн хэрэг чинь цаанаа бодолтой байдаг>> гэж хэлэх үгийн өнгө нь үнэн сэтгэлээсээ гэдгийг гэрчилнэ. Жу Сян Зюнь <<Миний номын хэнээтэй Зин ах худлаа хэлж чаддаггүй нь сайхан шүү>> гэв. Тэрээр цааш нь залгулан <<Миний дотоод хүч байхгүй болсон болохоор хэрвээ та л хамгаалж байхгүй бол хэн хэний маань санаа амрахгүй шүү дээ>>. Тэгээд ч мөрний өмнөд нутагт хүний сэтгэл тааруухан тул хянуур болгоомжтой байлгүй болохгүй гэхэд И Да Зин <<Чиний хэлдэг аргагүй зүйтэй. Гагцхүү чиний ариун нэрд сэв суух бий вий>> гэв. <<Мөрөн голоор явж байгаа хүн тоост ертөнцийн дэг жаягийг дагах учиргүй. Тэгээд ч цагаан замын шударга бүлгүүд бүгд намайг бяцхан шулам гэж нэрийддэг биш билүү. Тэгэхээр юуных нь ариун нэр сүр байх вэ дээ>> гэлээ.

Мөнгө байхад бүх юм амар хялбар бүтдэг хойно зарлага удаж төдөлгүй дээд зэргийн амттай сайхан хоолнуудыг барьсаар ирж ширээ дүүргэн заслаа. И Да Зин <<Журамт бүсгүй Жу та болгоо>> гэхэд Жу Сян Зюнь ч инээд алдан <<Номч баатар И та ч гэсэн болгоо>> гэлээ.

И Да Зин угаас шударга хүмүүн тул сэтгэлдээ бодож байгаа бүхэн нь царайнд нь илрэн харагдах ажээ. Түүний царайд ямар нэгэн битүү түгшүүр үзэгдэхийг гярхай Жу Сян Зюнь ажиглаж <<Зин ахаа таны сэтгэлд юу бугшин хургана вэ. Надад хэлж санаа амрахгүй юмуу>> гэлээ.

И Да Зин хэсэг зуур дуугүй сууснаа гэнэт ам нээж <<Бидэнд дараа ярих хоног хугацаа их байгаа тул хожим болцгооё. Харин би чамд одоо дотоод хүчнээсээ хуваалцвал ямар вэ>> гэлээ.

<<Хэдийгээр чиний дотоод хүч минийхээс хавьгүй их боловч миний дотоод хүчийг бүрэн тэнхрүүлье гэвээс наанадаж долоо хоног хэрэгтэй. Тэгээд ч дотоод хүчээр үйлчилэхэд санаа сэтгэл тайван байхгүй бол солиорч галзуурч ч мэдэх юм шүү дээ>>. Харин бид хэд хоног амарч эхлээд таны сэтгэлд байгаа сэжиг тааврын бараан үүлийг арилгавал ямар вэ гэж Жу Сян Зюнь хэллээ.

И Да Зин урдах хундагатайгаа авч тамшаалсанаа <<Сян дүү минь чи үнэхээр тэнгэрт тэрслүү бүлгийн хүн юм гэж үү?>> хэмээн асуув.

<<Тиймээ би тэнгэрт тэрслүү бүлгийн хүнээр зогсохгүй тэдний бүлгийн эн тэнцүү эрхтэй 15 элчийн нэг билээ>> хэмээн Жу Сян Зюнь толгой дохив.

<<Тэнцүү эрхтэй элч гэнээ?>>

<<Чи миний үгийг битгий таслаарай би чамд бүгдийг ярьж өгье>> гээд Жу Сян Зюнь алгуур яриагаа эхэллээ.

ЗАМЫН ХҮЗҮҮ УРТ ХЭМЭЭХ АРВАН НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Жу Сян Зюнь аажуухан өгүүлрүүн <<Зин ахаа өнөөдөр би танд бүх үнэн түүхийг ярьж өгье>> хэмээгээд И Да Зиний хувьд шал өөр танихгүй ертөнцийн тухай гоц сонин үлгэрийг хүүрнэн өгүүлж эхлэв.

100 жилийн өмнө зэвсгийн эрдмийн ертөнцөд Дин И Жао хэмээх нэртэй нэгэн илдчин тодрон гарсан ажгуу. Тэрээр ямар ч хүнтэй тулалдсан ганцхан халз тулаанаар л бүхнийг шийддэг тул тэрээр мөрөн голоор үзэгдээд удаагүй боловч Дин И Жао буюу монголоор <<Халз тулаанч баатар>> гэсэн эрхэм алдрыг хүртжээ. <<Сайн эрс үзэлцэхэд эхний тулаанаар л хамаг бүхэн шийдэгдэх ёстой. Хэрвээ эхний тулаанаар ялж чадахгүй бол түүнээс цааш дайсандаа ид чадлаа гаргах боломж олгодог. Тийм болохоор эхний тулгаралтаар л ялах ялагдахаа шийдэх ёстой. Дараагийн удаагийн тулаан ч гэдэг юмуу эсвэл хэдэн зуун удаа халз тулгарч байж сая нэг муу юм ялдаг хүн бол хичнээн нэр алдраа дуурсгасан баатар сайн эр байгаад ч ямар хэрэг байх вэ. Нэг муу шалдан бандиас ялгаагүй>> гэж Дин И Жао холдэг байжээ.

Дин И Жаогийн ч эрдэм чадал үнэхээр гаргуун тул дэлхий дахины аруухан баатар эрсийг юман чинээ тоож үздэггүй байсан юм. Анх тэнгэрээс хэтийдсэн агуу санаа өвөрлөж байсан авч оноогдсон заяа хэлтгийн улмаас төмөр махбодийн нэгэн салбар хайсангийн эзний зарц зардсан болж явжээ. Арван насандаа төмөр махбодийн бүлгийн шавиар орж 25 наслахдаа арван таван жил бүлгийнхээ эрдмийг сурахдаа <<Алтыг зуун галд хайлуулах>> гэсэн ганц эрдмийг л боловсруулахаас биш бусад арга мэхийг тоож үздэггүй байлаа. Багш нь түүнийг хичнээн зодож загналаа ч тусыг эс олдог байлаа.

Тэгээд багш нь түүнийг эрдмийн амтыг мэдэрч эрдүү баатар явах хувьгүй хүн юм гэж үзсэн боловч эрт бүлэгт элссэнийг нь бодож багахан шиг хэргэм зэрэг олгосноос өөр гавьтай шан харамж хүртээгүй ажээ.

Гэвч үнэн чанартаа Дин И Жао гоц ухаантай зэвсгийн эрдмийн мөн чанарыг уланд нь хүргэж ойлгохыг хичээдэг нэгэн байсан ажгуу. Түүний хичээллэж байсан <<Алтыг зуун галд хайлуулах>> арга мэхийг тэрээр 15 жил сураад эрмийн чанад гэж байдаг бол түүнд хүрсэн гэнэ. Түүний дээр тэр хүнээс илүү дотоод хүчтэй тул түүнтэй хослон мөрөн гол даяар ганц ч баатар сайн эр дээрхи аргыг даван дийлж чадахгүй байсан нь учиртай аж. <<Ганц аргаа л бодож болгоож өөрийн богож авбал барав. Ертөнцийн зэвсгийн эрдэм олон. Алийг нь гэж сурч барахав>> гэж тэрээр хэлдэг байлаа. Тэрээр өөрийн гэсэн бүлгийг үүсгэн буй богосныхоо дараа өөрийн алдарт <<Алтыг зуун галд хайлуулах>> аргаа өөрчлөн <<Нэгэн галаар зуун алтыг хайлуулах>> болгон нэрлэжээ. Өөрөөр хэлбэл галын хүч чинээндээ тулахад алт хичнээн их ч байлаа гэсэн ширээж болно. Заавал галыг зуу дахин ноцоохын хэрэггүй гэж бодсон ажээ. Тэгээд насан өндөр болсон хйоноо мөнөөх алдарт аргаа бас л өөрчлөн <<Ганц гал ганц алт>> хэмээн нэрийдсэн байна. Тэгээд аглаг ууланд даяанчилан сууж өөрийн үүсгэн буй богосон аргаа улам нягтлан судалсаар <<Галгүй алтгүй>> гэсэн алдарт аргаа буй богожээ. Тэрээр зэвсгийн эрдмээр хорвоод хосгүй болж <<Зуун галаар алтыг хайлуулах>> аргыг буй болгоод байхдаа төмөр махбодийн бүлгээс урвасан юм. Төмөр махбодийнхон өөрийн бүлгээс урвсан ёсгүй шавийг залхаахаар бусад 4 махбодийн бүлэгтэй хүч хамсарсан ч түүний шинээр буй болгосон бүлгийг дийлж хүч хүрээгүй гэдэг. <<Зуун галаар алтыг хайлуулах>> арганд зуугаас багагүй мөрөн голын сайн эрс насан эцэслэсэн ажээ. <<Нэг галаар зуун алтыг хайлуулах>> арга нь боловсорч ирэх үест өөрийгөө хорвоод хосгүй зэвсгийн эрдмийг эзэмшиж чадлаа гэж үзсэн баатар эрс түүнийг хайж очоод амиа алдах нь олонтоо болжээ. <<Нэг гал нэг алт>> аргынхаа үндсийг олсон үед бас л түүн рүү халдаж зүрхэлсэн арван сайн баатар эр амиа алджээ. <<Галгүй алтгүй>> аргын үед Дин И Жао аглаг ууланд даяанчилан сууснаас гадна тэр аргын зүйрлэшгүй аюумшигтайг гадарлах болсон сайн эрс түүний зүг алхахаас ч жийрхдэг болсон нь ойлгомжтой. Тийм ч учраас зэвсгийн эрдмийн ертөнцөд <<Галгүй алтгүй>> аргыг үзсэн хүн нэгээхэн бээр ч үгүй гэнэм. Тэр хүн зэвсгийн эрдэм чадлаар гоц гойдоос гадна зан араншингийн хувьд ч этгээд хачин нэгэн байсан ажээ. Хэдийгээр сурсан зэвсгийн эрдмийн хувьд хэнийг ч

бараадуулахгүй боловч насан туршдаа ганц ч шавьгүй байдсан гэдэг. Тэрээр шавь авна гэдэг бол хүний ухаарч гэгээрах замд нь саад тээг болно гэсэн үг. <<Бидний өвөг дээдэс маань бидэнд өвлүүлж үлдээсэн зүйлс чамгүй их байна. Күнз, Мэнз Лаозы, Жуанзы гээд л хүн бүхэн л өөр өөрийн гэсэн сургаал номлолоо үлдэсэн. Гэтэл хойчийн үр сад нь өвөг дээдсийнхээ үлдээсэн тэр их оюуны өвийн учрыг олох гэсээр насаа элээж нартыг хэвийлгэж байна. Тэдэнд дээдсийн гэгээн сургаалыг унших гээд өөрөө сэтгэж бодох чөлөө алга. Хэрвээ би шавь авчих юм бол шавь нар маань <<Галгүй алтгүй>> дээдийн эрдмийн ид чадалд бардан дээшилж дэгжихээ бодолгүй явсаар насны бөгсөнд амьтны адаг болон хувирах болно шүү дээ. Эртнээс нааш хичнээн олон эрдэм чадалтан дээдсийн сургаалд автан дэгжиж дээшлэх замаа чөдөрлөсөн бол доо. Харамсалтай хэрэг шүү>> хэмээн халаглан өгүүлдэг байжээ.

Энэ талаар хожим дэлгэрүүлэн өгүүлэх болно.

Дин И Жао 25 настай байх жил төмөр махбодийн бүлгийн толгойлогч Жинь Лэй дал гарч гурван жилийн турш өвчин эмгэгт ороогдон орондоо хадагдсан амьтан болсон байлаа. Нэгэн өдөр тэрээр өөрийн өвчнөө илаарших тэмдэгийг мэдэж өөрийн бүлгийн сайн эрсийг бултаар цуглуулан хойтох ажил явдлаа дуулгахаар шийдсэн байна. Зэвсгийн эрмийн ертөнцөд уулаас насаар ахмадыг нь өндөр суудалд өргөмжилдөгийн дээр Жинь Лэйгийн ууган шавь Жинь Пэй хэдийгээр зэвсгийн эрдмээр гавихгүй оюун ухаанаар гаргуун бус боловч хүний хувьд шударга гүдэсхэн тул бүлгийн шавь нарын хүндлэлийг олсон нэгэн байжээ. Хэдийгээр Жинь Пэй багшийгаа насан эцэслэхэд төмөр махбодийн бүлгийн толгойлогч болно гэдэг асуудал нэгэнт шийдэгдсэн хэрэг боловч Жинь Лэй амьд сэрүүн дээрээ түүнийг олон шавьдаа уламжлан мэдэгдвэл хожим хойчдоо хэрэгтэй гэж бодсон ажээ.

Жинь Лэй хочийн хэргийг олон шавьдаа захиж дуулгахад бүгдээрээ газар сөгдөн нэгэн зэргээр <<Бүлгийн толгойлогч та санаа амар өвчнөө засагтун бүлгийн доторхи аливаа хэргийг олон шавь бид нар таны захисны дагуу хөсөрдүүлэлгүй биелүүлнэ>> гэж хэлжээ.

Гэтэл нэгэн хүн шавь нарын дундаас огтхон ч сөхрөөгүйгээр үл барам их дуунаар инээж <<Хөгжилтэй ч юм шиг хөөрхийлөлтэй ч юм шиг>> хэмээн өгүүлэхийг дуулаад төмөр махбодийн бүлгийн олон шавь нар нийтээр хирдхийн цочицгоолоо.

Жинь Лэйгийн их шавь Жинь Пэй нэгэнт багшийн суурийг залгамжлахаар тогтсоны дээр багш нь өвчтэй тул бүлгийн дотор гарах аливаа асуудлыг өөрөө шийдвэрлэвэл зохилтой гэдгийг ухааран өндийн босож эргэн харваас нэгэн залуу ихэмсгээр тэргүүн өргөн цэх зогсож байх ажээ. Зэвсгийн эрдмийн ертөнцөд угаас зэрэг дэвийн ялгаа их тэгээд ч Жинь Пэн анхны шавь нарын нэг тул дөрөвдүгээр үеийн шавь болох Дин И Жаог танихгүй байлаа.

Жинь Пэн хүний хувьд шударга номхон хүн тул тэсгэлгүй уурлаж байсан ч түүнийгээ дотогш нуун их л тайван дүр үзүүлж <<Чи ямар учиртай хүн билээ?>> гэж асуухад <<Дөрөвдүгээр үеийн шавь Дин И Жао>> гэж хариулжээ. Багшид бараалхан буй энэ үед яагаад сөгддөггүй билээ хэмээн Жинь Пэн дахин асуув. <<Хэрвээ миний өмнө насан өндөр намбатай өвгөн байгаа бол би түүнийг багшаа гэж хүндэтгэн сөгдөн мөргөх нь зүйн хэрэг билээ. Гэтэл харваас авсанд орох болсон сүнс сүлдгүй амьд хүүрнээс ялгаагүй энэ хүнд сөгдөн мөргөн гэдэг утгагүй хэрэг>> гэж Дин И Жао аймшиггүй өчжээ.

Түүний энэ үг хавь ойрынхныг цочоон нийтээр <<Учраа мэдэхгүй урагшгүй тэнэг амьтан чи ах захаа мэдхэгүй байна гэнэ ээ. Бариад ав наадхаа>> гэхэд хэдэн ч хүн зэрэг ухасхийн дайран довтлохоор зэхэв.

<<Байз>> гэж Жинь Пэнд дохиод <<Энэ хүн нас бага цус шингэн атлаа ийн зориглохыг харваас нэг л учиртай хүн биз. Арай сөргүү бүлгийнхэн нааш нь зориуд өдөөж ирүүлсэн заншлаач биш би. Хэрвээ энэ үед олны сэтгэлийг хөөргөдөн илд мэсийг хангинуулбаас багшийн өвчнийг даамжруулж мэдэх юм. Тэгэхээр түүний ирийг мохоож санааг өөр дээрээ татаж чадвал багшийн өвчнийг даамжираахгүй өнгөрч чадна>> хэмээн сэтгээд <<Дин И Жао миний бодоход багш намайг бүлгийн толгойлогчийн сууриа залгамжлуулах болсонд чи сэтгэлдээ хорсон байгаа бололтой. Би хэдий муу боловч гэмээ мэднэ ээ. Эрдэм билгийн хувьд авч яривал би хоёрдугаар номын дүүг гүйцэхгүй. Зэвсгийн эрдэм чадлын талаар гуравдугаар номын дүүг бараадахгүй. Гэвч багшийн зарлиг хүчтэй тул арга буюу зөрчиж чадахгүй энэхүү хэргэм зэргийг тосон авсан билээ. Харин манай багш зэвсгийн эрдмийн хувьд хаан болохын хувьд ийн шийдсэн нь ямар ч байсан цаанаа нэгэн учиртай биз. Хүний хувьд үнэнч шударга итгэл зүтгэлтэйн талаар яривал би хэний ч ард орохгүй гэдгээ бардам хэлж чадах байна. Багшийн эрхэм бие чилээрхсэн боловч манай бүлгийн толгойлогч хэвээрээ байгаа гэдэг нь маргаангүй үнэн. Харин би одоогоор түүний хүнд

албгы түр зуур орлон залгуулж байна. Зуун жилийн дараа багшийнхаа сургаалыг чанд сахин өөрийн бүлгийн нэр алдрыг мандан бадраана гэж би хэлж чадахгүй. Гэвч зэвсгийн эрдмийн ертөнцөд багшийн үүсгэсэн их хэргийг унтраалгүй үргэлжлүүлэхийн төлөө чадлын хэрээр зүтгэх болно гэдгээ би андгайлан тангараглаж чадна гэдгээ хэлэх байна>>.

Шударга журмын талынхан өөрийн бүлгийн толгойлогчдоо сонгохдоо тухайн хүний ёс журамд хэр зэрэг их нэвтэрснийг гол үзүүлэлт болгож үздэг бол сөргүү хар замынхан тухайн хүний зэвсгийн эрдэм чадлыг гол болгодог байсан юм. Иймд Жинь Лэйгээс өгсүүлээд нийтээрээ толгой дохин түүний үгийн үнэн зөвийг зөвшөөрцгөөлөө.

Жинь Пэн цааш залгуулан өгүүлрүүн <<Дин И Жао хэрвээ чи надад таагүй хандах ямар нэгэн шалтаг шалтгаан байдаг бол хоёулаа энэ чуулган тарсны дараа эцэслэн дуусгая. Харин багшийн бие чилээрхүү байгаа энэ үед чамайг элдвийн ёсгүй араншин гаргахыг би зөвшөөрөхгүй>> хэмээн хэлэхэд хэн ч өөдөөс нь өө хэлэх аргагүй үнэн үгс байлаа.

<<Эрхэм номын ахаа танд буруу гэж юу бахйв дээ. Буруу гэж байдаг гэж бол бидний өмнө орон дээр хэвтэж байгаа энэ амьд хүүрт л байдаг байх>> гэж Дин И Жао инээн өгүүлэв.

<<И Жаогийн багш нь хаан байна вэ?>> <<Яагаад багшийг гутаан өвгийг доромжлогч өөдгүй амьтныг үгүй хийхгүй байна вэ>> хэмээн Жинь Пэн их дуунаар уурсан өгүүлэв.

Дин И Жаогийн багш нь ухасхийн босож шавийнхаа амин судлыг атган авлаа. Энэ үед орон дээрээ үхлүүт хэвтэж байсан Жинь Лэй <<Байз>> хэмээн дуугарав.

Дин Жаогийн багш нь амин судлыг атгасан гараа хойш нь татлаа.

Жинь Лэй хэдийгээр орон дээр хэдэн жил хэвтсэн боловч зөнөж мунхааргүй тул <<Би ямар буруу хэрэг үйлдсэнээ сонсохыг хүсэж байна>> хэмээн өгүүлэв.

Дин И Жао огтхон ч айж эмээсэн зүйлгүйгээр <<Хэрвээ хөгшин та сонсохыг хүсэх аваас би өгүүлсү>> гэжээ.

<<Би дал гартлаа хутга мэс гал усны гашуун зовлонг ханатлаа амссан хүн чам шиг жаахан хүүхдийн хэдэн үгнээс эмээн ширвээднэ гэж үү. Та бүхэн дуулж бай хэн ч байсан наад хүүхдэдээ халдаж болохгүй шүү>> гэж Жинь Лэй хэлээд инээмсэглэв.

Ийн хэлэхдээ үг яриа нь намуун цэгцтэй аргагүй л өвөг дээдэс нь үр хойчоо сургамжилсан өнгө аяс дүүрэн ажээ.

<<Хөгшин та намайг аймшиггүй өч гэж байгаа бол би өгүүлсү. Тэр жил алтан хануур жадат их баатар эр Жинь Лэй та түмэн баатруудын омгийг дарж мөрөн голыг донсолгон өсвөр залуу цагтаа шувуут уулын гурван сайн эрийг эрхэндээ оруулж идэр дунд насандаа хайлааст голын долоон харгисыг устгасан домог түүх мэт үйл явдлыг чинь мэдэхгүй хэн байх билээ. Өтөл насандаа бар өвгөрөвч сүр нь хэвээрээ гэдгийн үлгэрээр гал махбодийнхон танай бүлэгтэй тэрслэн 72 баатар эр нь энэ уулыг зүглэн ял хэлэлцэхээр ирэхэд өвгөн та долоон хануур жадаар тэнгэрт нисэж явсан өнчин галууг харвахад газарт унасан түүний хамаг өд сөд нь ганц ч үлдэлгүй зулгарсан атлаа арьс маханд нь өчүүхэн төдий ч гэм суулгаагүй байсан чинь тэдний зүрхийг чичрүүлж цөсийг нь өвтгөсөн гэдэг. Үүний улмаас 72 хосгүй баатар ял хэлэцэхээр ирсэнээ умартан ял хэлтрүүлэхийг гуйж гувшсан гэдэг...>>

Жин Лэй дуугаралгүй нүдээ анин чих тавин сонсож суух өөрийн эрхгүй инээмсэглэж байлаа. Тэрээр нэгэн насан туршдаа ёсыг сахин журмаар үйлдсэн сайн үйлс тоо тоомгшгүй олныг хийсэн боловч хамгийн дурсууштай нь саяын Ди И Жаогийн өүүлсэн түүх байсан юм.

Дин И Жао цааш өгүүлрүүн <<Алтан уулын их чуулганы дараа өвгөн та мөрөн голын хэрэгт хошуу дүрэхээ байсан боловч урьдын үйлдсэн суутай үйл явдлууд чинь таныг тэргүүн зэргийн баатар эр гэсэн хэргэм чадлыг эзэгнэсэн хэвээр байхад чинь нөлөөлсөөр байсаан. Харин та мөрөн голыг донсолгож явахдаа манай бүлгийн зэвсгийн эрдэм олон бүлгийхний онилсон бай болон хувирсан гэдгийг мэдээгүй. Өөрөөр хэлбэл бусад бүлгийнхэн амтат хоол амгалан нойроо умартан өөрийн бүлгийн зэвсгийн эрдмээ хурцлан байх зуур манай бүлгийнхэн таны хүч нөөлгөнд санаа сэтгэл амаржин дээшээ дэвжиж хөгжихийг бодолхийлэхээ байчихсан юм. Энэ арван хэдэн жилийн дотор 5 махбодийн бүлгийнхнээс дөрвөн махбодийн бүлэг нь зэвсгийн эрдмээр гоц гойд хөгжин гагц манай төмөр махбодийн бүлэг л бахь байдгаараа дороо дэвхцээр үлдлээ. Өнөө 72 шилдэг сайн эрс байтугай долоо найман жулдрай эрс хүрээд ирсэн ч манай төмөр махбодийн бүлгийнхэн түүнийг ялан дийлж чадах болов уу гэдэг эргэлзээтэй. Хөгшин та бие чилээрхүү тул гадна болж буй хэргийг яахин тэр бүхэн мэдэж чадах билээ. Манай бүлгийн бусад хүмүүс таны сэтгэлийг хямраахгүй гэсэндээ нааштай сайн мэдээг л дуулгахаас биш над шиг ийм шулуун шударга хэлэх нь юу л бол. Өвгөн минь та гурван жил хэвтэрт байх хугацаанд чинь манай бүлэг ч бас гурван жил өвдсөн мэт байлаа шүү дээ>> гэжээ.

Жинь Лэйгийн сэтгэл сэрдхийж өөрийн ууган шавь Жинь Пэнгийн зүг хандан <<Жинь Пэн түүний хэлж байгаа үнэн үү?>> хэмээн асуув.

Жинь Пэн шударга хүмүүн тул яахин худлаа хэлж эс зүрхлэх вэ. Гэсэн атлаа багшийнхаа сэтгэлийг түвдүүлэхгүйг хичээн асуудлыг дүйвүүлэн өнгөрөөхөөр шийдэж <<Багшийн баатар сүр урьдын адил хэвээр байхад манай бүлгийг дайран ирэх бөх зүрхтэн хаана байх билээ дээ>> гэж хэлэв.

Жинь Лэй толгой дохин <<Би ойлголоо. Дин овогт хүү минь цааш залгуулан ярь даа гэлээ. Дин И Жао цааш өгүүлрүүн <<Их номын ахын хэлдэг яах аргагүй үнээн. Хөгшин таныг амьсгаатай байхад урьдын баатар сүрийн ул мөрнөөс айгаад манай бүлгийг халдан довтлохоор ирэх хүмүүн гэж үгүй. Харин таныг өөд болох тэр өдрөөс хэлэн үлдэж буй хэдн шавь нарын чинь сурсан эрдмээр дайсны сүр сүлдийг үхүүлнэ гэдэг ч ёстой санасны гарз гэдэг нь ойлгомжтой>>.

Төмөр махбодийн бүлгийн шавь нар нэгэн зэргээр <<Чи бүү дэмий балай донгосоод байж үз. Манай бүлгийхний сүр хүч мөрөн гол даяарыг донсолгож байна. Зуунтаа тулалдавч ялагдах нь үгүй. Энэ муу жулдрай банди ер нь ингэж даварч байх юу юм бэ. Лав дайсны явуулсан заншлаач байх. Бушуухан тонилгоё>> гэлцэн шуугилдав.

Энэхүү толгой эргүүлэм чимээ шуугиан дундуур Жинь Лэй намуувтар дуугаар <<Та нар битгий шуугилдаад байцгаа. Наадхаа цааш нь яриул>> хэмээн хэлэхэд хэдийгээр чанга дуугараагүй боловч дотоод хүчнийхээ чадлаар олон шавь нарын шуугианыг дарж чадлаа.

Дин И Жао амаа мушилзуулан <<Өвгөн багш та харж байгаа биз дээ. Таны олон шавь нар чинь хэдхэн үнэн үг л сонсож чадахгүй өөрийгөө ихэд бодож байгаа нь дороо суурьтай дотроо бодолтой хүний санаа мөн үү. Хий хоосон сүржигнэсэн амьтас болон хувираад байна. Манай бүлэг жил ирэх тусам сүр хүчин нь доройтож байгааг тэд үнэн чанартаа мэдэж байгаа л даа. Харин түүнийгээ хүлээн зөвшөөрөх зүрх зориг дутагдаж байна. Энэ бүхэн хөгшин багш таны буруу биш гэж үү. Хэрвээ та одоо биш арваад жилийн өмнө өөрийн бүлгийн толгойлогчийн сууриа бусдад шилжүүлсэн бол тэр хүн лав дахин шинийг сэдэж нэгийг бүтээх байсан буй за. Яахин энэ мэт байдалд оррох вэ. Эртний үгэнд дал гарчихаад сууриа тавьж өгөхгүй байх нь гэмт хэрэг гэж хэлсэн байдаг бусуу. Миний бодоход хүн жар гараад л үхээд өгөх хэрэгтэй юм. Тэр тусмаа өвчний үүр болон хэвтэх ямар хэрэг байна даа. Өвчтэй атлаа өөрийн байр сууриа өгөхгүй зууралдаад байсан бол үхсэн хойно ч үлдэл нүгэл байх буй>> хэмээхэд

Хэдийгээр уужуу тайван зантай ч гэсэн их шавь Жинь Пэн Ди И Жао багшийг нь ийн гутаан доромжлохыг үзээд уураа барьж тэвчсэнгүй <<Мунхаг зулбасага чи арай дэндэж байна>> гэж их дуунаар хашгираад Дин И Жаогийн зулайн зуун уулзвар цэгийг довтлон орлоо. Жинь Пэнгийн энэхүү <<Хилэнцийг номхотгох>> гэсэн арга нь хэдэн арван жилийн турш сургуулилж ихэд нэрд гарсан тус бүлгийн шилдэг арга мэхүүдийн нэг бөгөөд мөрөн голын хамгийн нэртэй зэвсгийн эрдмийн баатар байгаад ч түүнээс амьд мэнд мултран гарах найдлага үгүй юм. Гэтэл Дин И Жао огтхон ч тэвдэж бултан сандарсангүй. <<Төмөр гүүр>> зогсолтоос ялимгүй хазайж Жинь Пэнгийн цохиолтын эрчийг бууруулан зайлж чадав.

Жинь Лэй хэдийгээр нүдээ аниастай байсан боловч сонсголоороо тэр хоёрын тулалдааны багцааг тоймлон мэдэж дотроо сэрдхийн <<Энэ залууг чинь басамжилан үзэж болохгүй юм байна. Манай бүлгийн хамгийн энгийн <<Төмөр гүүр>> зогсолтоор ийм лут цохилтыг бултан өнгөрөөж чадна гэдэг хэр баргийн хүнд амаргүй>> хэмээн бодлоо.

Дин И Жао юу ч болоогүй мэт Жинь Пэнгийн зүг хандаж <<Номын ах та өчүүхэн дүүгээ өршөөн соёрхоно биз. Би хэдийгээр өнөөдөр эндээс амь мэнд гарахгүйгээ мэдэж байгаа боловч арван хэдэн жил сэтгэлдээ хураасан бухимдлыг тайлахаас наана намайг алах гэсэн хүнд амаргүй байх болно шүү гэдгийг хэлчихье>> гэлээ.

Түүний хэдэн арван жил давтсан зэвсгийн эрдмээр нас туршлагаар хэдэн арав дахин доогуур хүн рүү довтлоод амжилт олоогүй нь түүний нэр төр байр сууринд хэтэрхий харш тул бүүр учраа олохоо байж орхив. Дин И Жао түүнийг дахин тоосонгүй <<Хөгшин багш та цааш миний хэлэхийг сонсох тэнхэл байна уу>> гэлээ.

Жинь Лэй их л тайвнаар <<Ярь ярь>> гэлээ.

<<Манай мөрөн голынхон яахаараа шалихгүй амьтас атлаа бүлгийн толгойлогч болонгуут ихэмсэг хаан зан гаргаад эхэлдэг юм болдоо. Амьсгаатай байх хугацаанддаа л эрхэм сэнтийнээс буухгүй зууралдаад бацгаах мөртлөө бүлгийн их хэргээ тоохоо байчих юм. Хөгшин танд энэ бүхэн инээдтэй санагдахгүй байна гэж үү. Харин аюул гамшиг тохиолдоод эхлэхийн цагт хаан эзэн залгамжлагчаа тодруулж байгаа мэт бүлгийн толгойлогчийг шинээр тодруулж байх ёстой юм гэж үү? Тэгсэн атлаа сонгож байгаа хүн нь өөрт нь таалагдаж байвал л бүлгийн их хэргийг унагаж босгож байсан ч хамаагүй гэсэн ойлголттой байх юм. Энэ танд харамсалтай санагдахгүй байна уу>> гэхэд Жинь Лэй <<Харамсалтай нь ч харамсалтай

инээдтэй нь ч инээдтэй...>> гэснээ гэнэт ортойгоо дээшлэн нисэж түүнийг чиглэн ирэхэд орон дээрээ өвчтэй гурван жил хадагдсан дал гарсан өвгөн ийм лут хөнгөний тамир үзүүлэхийг үзээд Дин И Жаогийн айж гайхсан зэрэгцэнийг өгүүлэх юун. Тэр хэдийгээр <<Алтыг зуун галд хайлуулах>> хосгүй аргыг эзэмшсэн боловч дал гарч гурван жил орондоо хадагдсан хөгшин өвгөнд түүнийхээ ид чадлыг үзүүлж төвдсөнгүй мөнөөх <<Төмөр гүүр>> зогсолтоосоо тахимаараа нугаларч ар гэдэргээ бараг газартай тэнцүү шахам гэдийгээд тэр байрлалаасаа хөлийн хүчээ тулан хөнгөний тамираар хөөрөн нисэв. Жинь Лэй умраас өмнө зүг рүү нисэхэд Дин И Жао хойд зүг рүү нисэх зуур замдаа халз тулгарах агшинд Жинь Лэй алтан хануур жадаа гарган шидэхээр завдав. Харин Дин И Жао илдээ сугалан дээрээс нисэн ирэх хануур жадыг цохин хоёр хэсэг хувааж орхилоо.

Хоромхон зуурын төдий хоёр хүмүүн байраа солин Жинь Лэй ортойгоо цуг зөөлөн газардахад Дин И Жао мөрөг загас биеэ мурих аргаар холбирон эргэж танхимын голд буулаа. Дин И Жао гурван жил өвчтэй хэвтсэн далтай хөгшин ийм лут байх юм гэж санаагүй тул зүрх нь оволзон хөөрнө.

Жинь Лэй түүнээс илүү гайхан бахардаж байсны учир гэвэл тэр насан туршийнхаа хуримтлуулсан ид чадлыг гаргаад ч дөнгөж сүүний үнэр нь хатаж байгаа нусгай бандийг дийлэхгүй байгаадаа халаглах харамсах зэрэгцэж байлаа. Гэвч түүнд ид чадалтныг бахдах сэтгэл төрж амьсгалаа жаал дарж аваад Дин И Жаогийн зүг гараа даллан дуудаж <<Хүү минь нааш ир>> гэв.

Дин И Жао Жинь Лэйгийн орны өмнө очвол өвгөн түүнийг хэсэг зуур анхааралтай ажиглаж байнаа <<Хүү минь чиний зэвсгийн эрдэм муугүй юм. Харин жаахан сөргүү муугийн тэмдэг байна. Хэрвээ өдгөө чамайг алахгүй бол хожим мөрөн гол даяар амар тайвнаа үзэхгүй байх. Харин одоо алчихвал чиний тэнгэрээс заяатай энэ их авъяас билиг бас хайран аа. За яахав чи даруйхан манай төмөр махбодийн бүлгээс холдож өөрийн бүлгийг үүсгэ дээ>> гэжээ.

Дин И Жао өвгөн багшийнх нь үг нь мөрөн гоынхны дайсандаа ялагдаад хэлдэг ёсорхуу үг төдий биш хамаг үнэнээ хэлж байгааг ухаарчээ. Тэрээр эцэг өвгөө хүндлэлгүй эрдэмтэн багшаа гутаан доромжилсон хүнд ял зэмтэй тул төмөр махбодийн бүлгийнхэн нэгэн зэрэг түүний зүг халдаар ирвэл яахин амьд мэнд гарч чадах билээ гэдгээ бас ухаарч байлаа. Өнөөдөр амь мэнд мултарлаа ч гэсэн маргааш бас л тэдний өшөөтэн хэвээр

үлдэнэ гэдгээ мэдэж энэ бүхнийг нэвт шувт урьдчилэн харж чадсан мөрөн голын энэхүү сүмбэр уул шиг баатар эрийг хүндэтгэх сэтгэл өөрийн эрхгүй оволзож иржээ.

<<Чи эндээс холдон өөрийн гэсэн бүлгийг байгуулан түүнийхээ толгойлогч болж их үйлсийг хэрэгжүүлэх ёстой. Харин чи тэр цагт дэлхий дахины хэрэг явдлыг удирдан жолоодох ярьж хэлэхээс хичнээн хүнд бэрх байдгийг ухаарах буй за. За ингээд яв даа хүү минь>> гэж хэлсэн гээг.

Дин И Жао өөрийн эрхгүй Жинь Лэйгийн орны өмнө өвдөг сөхрөн <<Багшаа>> гэж их дуугаар өгүүлэв.

<<Залуу баатар минь битгий ийн өгүүл. Өнөөдрөөс эхлэн манай төмөр махбодийн бүлэгт чи ч би ч байхгүй болох ёстой. Тэнгэрийн хайрласан нас хязгаартай. Ар хойчийн хэрэг өсөн дэгжих уруудан доройтохыг би урьдчилан хэлж чадахгүй. Харин чи хожим манай төмөр махбодийн бүлэгт багахан шиг дайсагнаж явбал би баяртай байх болно>>.

Жинь Лэй ийн өгүүлэхэд санаа сэтгэл нь сэргэн хацарт нь улаа бутраад иржээ. Дин И Жао үхэх хүн нэгэнтээ бяцхан сэргэдгийг мэдэх тул <<Одоо эс явбаас хэзээ явж амжих вэ>> гэж санаад төмөр махбодийн бүлгээс холдон одсон байна.

Үүнээс хойш мөрөн гол даяар нэгэн өвөрмөц сонин бүлэг гарч ирсэн нь <<Тэнгэрт тэрслүү>> бүлэг юм.

Жу Сян Зюнь ийн өгүүлээн дуусах үед И Да Зин өгүүлрүүн <<Тэр Дин И Жаогийн хэлдэг ч бас ортой юм байн шүү. Эзний алба ээлжтай хааны алба халаатай гэж үг байдаг байхад зарим хүн яахаараа заавал насан эцэслэтэл бүлгийн тогойлогчийн суурьтайгаа зууралдаад байх гэдэг юм болоо>> гэв. Жу Сян Зюнь түүний зүг хялайн хараад <<Чи битгий лут хүн болох гээд бай. Тэнгэрт тэрслүү бүлгийнхэн чинь шударга журмын бүлгийнхэнтэй адил номч баатар бумбын ёсонд нэвтэрсэн цэгц журамт баатар эрс байдаггүй. Харин дандаа хүн алахдаа нүдээ цавчдаггүй чөтгөр шуламнууд байдаг юм шүү дээ>> гэлээ.

И Да Зин ярианы сэдвийг өөрчлөн <<Хожим нь тэгээд тэр Дин И Жао яасан бэ?>> гэж асуулаа.

<<Дин И Жаог төмөр махбодийн бүлгээс холдох мөчид Жинь Лэй хөгшин ч гэсэн таалал төгчээ. Дин И Жао түүнээсх ойш мөрөн гол даяар амар амгалан оршин тогтнох хугацаа ч өнө эцэс болсон тул нэгэн туйлын нууцлагдмал газар хүрч очоод нуугдаж суужээ. Төмөр махбодийн бүлгийнхэн бусад дөрвөн махбодийн бүлгийнхэнтэйгээ хүч хамсан олон

жилийн турш түүнийг эрэн хайсан боловч үр дүнд хүрээгүй байна. Тэрээр гучин нас хүрдэг жилээ өөрийн арга мэхийг боловсронгуй болгож <<Нэг галаар зуун алтыг хайлуулах>> арга ухаанд хүрэсэн байна. Тэр үеэс өөрийн <<Тэнгэрт тэрслүү>> бүлгийг байгуулсан аж.

<<Яагаад заавал Тэнгэрт тэрслүү бүлэг гэж нэрийдсэн юм бол доо>> гэж И Да Зин гайхан асуухад Жу Сян Зюнь өгүүлрүүн <<Дин И Жао өөрийн арга мэхийг боловсронгуй болгохын дээр Жинь Лэй өвгөн түүнийг явахаас өмнө захиж хэлж байсан <<Чи тэр цагт дэлхий дахины хэрэг явдлыг удирдан зална гэдэг хэлж ярихаас хэд дахин амаргүй хэрэг байдаг гэдгийн амтыг мэдрэх болно доо>> гэсэн үгийг санаж байсан юм. Тэгээд хожим нь тэрээр өөрийн бүлгээ байгуулаад <<Тэнгэрт тэрслүү>> бүлэг гэж нэрийджээ.

<<Шударга замын бүлгийнхэн тэнгэрт тэрслүү бүлгийнхнийг шулмын талынхан гэдэг нь учиртай үг байж. Эртний үгэнд тэнгэрийн ёс хувирахгүй гэж үзсээр байтал <<Тэнгэрт тэрслүү>> байхыг номлодог чинь юу гэсэн үг билээ. Ёстой дэндүү ёсгүй хэрэг байна даа>> хэмээн И Да Зин хэлжээ.

Жу Сян Зюнь <<Манай бүлэгт И номч баатар тань шиг эрдэм номын хүн нэгээхэн бээр ч үгүй. Гэхдээ Дин И Жао олон эрдэмтдийн бүтээл судар номыг уншсаны хувьд өөрөөс чинь лав хавьгүй илүү байсан болов уу. Тэр эртний мэргэдийн судар номыг зүгрээр л уншиж дагаад зогсдоггүй. Харин түүний өөг олж өөрийн сургаалдаа ашигладаг байсан юм. Тухайлбал Кунз, Мэнзийн ёсонд нэр алдрыг ихэд эрхэмлэдэг. Тэгээд ч нэр хэвгий бол үг шударгуу бус, үг шударгуу бус болбоос үйлс ажил бүтэмжгүй гэж сургадаг. Гэтэл тэр үүнийг эсэргүүцэж өөрийн бүлгийн олон шавь нараа шинэ хуучин гэж ялгаж дугаарлахгүй бүгд л үе тэнгийн чацуутан мэт байх дэг жаяг гаргажээ. Бүлгийн доторх аливаа ажил үйлийг ганцаараа шийддэггүй нийтээр хэлэцүүлж үнэн мөнийг нь ялгаад дараа нь сая өөрөө эцсийн шийдвэрийг гаргадаг байсан юм. Гэтэл эртнээс нааш зэвсгийн эрдмийн ертөнцөд ахас ихсээ хүндлэх ёсыг ихэд дээдэлдэгийн дээр бусад бүлгээс орж ирсэн хүмүүст сэжиглэнгүй хандаж ирсэн бол Дин И Жао огтхон ч тэгж үздэггүй харин өөрийн эзэмшсэн зэвсгийн эрдмийн аргаа хэнд ч өвлүүлэн зааж өгдөггүй байсан юм. Хааяа нэг бүлгээрээ чуулах үедээ 18 зэвсгийн эрдмээр тулалдаж хэн нь эр чадлтайгаа үзэх ба тэр үед жинхэнэ ид чадлаа гайхуулан тулалдаж үхэх сэхээ үзэлцдэг байлаа. Дин И Жао амьд үлдэгсдэд юм хэлэхгүй харин үхсэн хүний эрүүг шөргөөн <<Дүү минь чиний энэ хөгийн аргаар хол явахгүй гэдэгээ ойлгож авав уу? Чи...>> гэж хэлдэг байлаа.

И Да Зин түүнийг сонсоод ихэд гайхан <<Нэгэн бүлгийн улс чинь зэвсгийн эрдмээр тулалдахад шүргэх хатгахын төдий л байна уу гэхээс биш яахин жинхэнээсээ алалцаж болох билээ. Хоорондоо өстөн дайсан болон хувирах биш үү>> хэмээн хэлэхэд

Жу Сян Зюнь өгүүлрүүн <<Шударга замын баатар эрс гэдэг чинь бүгдээрээ худалч хуурамч улс байдаг юм шүү дээ. Хэдийгээр нүдэн дээр хатгах шүргэх төдий байгаа ч гэсэн цаагуураа бусдыгаа хорлож алж хядаж байдаг нь нууц биш. Тэдэнд далдуур хийхгүй муу үйл гэж байхгүй. Харин Дин И Жао бол тэр далд байдаг нууцыг нь ил гаргаснаас өөр юмгүй. Тэнгэрт тэрслүү бүлгийнхэн ийм өндөр шаардлагын дор тулалддаг тул өөрийн зэвсгийн эрдмээ байнга сайжруулж байх хэрэгтэй байсан бөгөөд түүнийг дагалдан мөрөн голын хэр баргийн хүнд тэдэнд зүрхлэн халдаж чаддаггүй байжээ>>.

Тийм байж болох ч танай бүлгийн энэ ёс журамтай чинь яасан ч эвлэрч болшгүй юм байна хэмээн И Да Зин хэлэв.

<<Хүмүүний сэтгэл гэдэг угаас хорон муу. Харин түүнийгээ хэрхэн далдлаж чадаж байна уу үгүй юу гэдэгт л хэргийн гол учир байгаа юм. Зарим хүмүүс шударга журам гэдгээр өөрийн хорон муу санааг халхалж байгаагаас өөр юм байхгүй>> хэмээн Жу Сян Зюнь хэлээд цааш нь <<Дин И Жао бүлгийн толгойлогч болоод аливаа хэрэгт тогтсон ёс жаягийн эсрэг байгаагаа хорвоогийн хүмүүст харуулах гэж боджээ. Тэр гучин насандаа өөрийн бүлгийг байгуулж дөчин насандаа өөрийн бүлгийн толгойлогчийн суурийг бусдад өгье гэж бодсон боловч 5 махбодийн бүлгийнхэн хамсан өөрийн бүлэгт нь байнгын аюул учруулах болсон тул шинэ тутам байгуулагдсан Тэнгэрт тэрслүү бүлгийн суурь бат бөх бусыг бодолцон санаагаа хэрэгжүүлж зүрхлэсэнгүй. Түүнийг 45 нас хүрэхэд тэнгэрт тэрслүү бүлгийн нэр сүр мөрөн гол даяар ихэд дуурсан 5 махбодийн бүлэг ч түүнтэй тэрсэн тэмцэх арагүй хэмжээнд хүрч чадсан байна. Тэгээд тэрээр өөрийн байр сууриа бусдад найр тавин өгье гэж бодсон боловч тэрээр бүлгийн дотор тэнгэр сахиусан мэт тахигдсан нэр нөлөө ихтэй түүнтэй энэ талаар өрсөлдөх халааг авах хүн үгүй тул бүлгийн олон шавь нар бүгдээр түүнийг бүлгийн толгойлогчоор үлдэхийг гуйсан байна. Дин И Жаог тавин нас хүрэх өдөр бүлгийн газар сайгүй тархсан гишүүд нь нэг дор цугларч түүний насан хутгийн их баярыг тэмдэглэхээр болжээ. Тэнгэрт тэрслүү бүлгийнхэн дээр өгүүлснээр ах захын ялгаа зэрэг дэвийн эрх ямба гэж үгүй тул энэ удаагийн насны ойд ирсэн хүмүүсийг архи идээгээр дайлж ирж амжаагүй нэгийг

шийтгэж торгох юм үгүй байлаа. Харин Дин И Жаогийн насан хутгийн баяр ховорхон тохиоолдох их хэрэг тул бүлгийн гишүүд бараг төлөв хүрэлцэн ирсэн байсан юм. Харин энэ баярт Дин И Жао өөрөө алга болоод номын өргөөндөө нэгэн бичиг үлдээснийг нь авч үзвэл өөрийн бүлгийн толгойлогчийн суурийг бусдад шилжүүлэхээр шийдлээ. Бүлгийн ажил хэрэгийг одоохондоо 15 тэнцүү эрхтэй элч нар шийдэж байг. Харин шинэ толгойлогчдыг дээрхи 15 элч нараас нэг жилийн дараа сонгох бөгөөд жилийн дараа мөрөн гол даяар хамгийн их цуутай үйлс бүтээсэн нь болог. Иймийн тулд та бүхэнтэй салах ёс гүйцэтгэлгүй холдон одсондоо хүлцэл өчье гэсэн энгийн хэдэн үг үлдээсэн байсан гэдэг. Дин И Жао манай бүлгийн толгойлогчийн сууринд хорин жил суусан бөгөөд түүнээс хойш манай бүлгийнхэн толгойлогчоо хорь хорин жилээр сонгодог уламжлалтай болсон юм. Тэр цагаас хойш таван хорин жил өнгөрсөн бөгөөд би тэнгэрт тэрслүү бүлгийн толгойлогчийн төлөө яваа 15 тэнцүү эрхт элчийн нэг байгаа юм даа>> гэж Жу Сян Зюнь хэллээ.

<<Та нар бүлгийнхээ алдар сууг мандуулахын төлөө заавал шударга замын баатар эрсийг алж талах ямар хэрэгтэй юм бэ?>> гэж И Да Зин асуулаа.

<<Эртнээс нааш шударга замынхан тэнгэрт тэрслүү бүлгийг дайснаа гэж үздэг. Тэгээд ч бид өөрсдийн ид чадлыг тэдэнд гаргахгүй юм бол өөр хэнд гаргах юм бэ. Тэр цагаас хойш мөрөн гол даяар хорин жил тутамд нэгэн их сүйрэл тохиолддог болсоноор 5 махбодийн бүлгээс үхэх нь үхэж шархдах нь шархдаж хамаг хүчээ бардаг нь бараг уламжлал болжээ. Тэд арайхийн хүчээ авч эхлэх үед нь дараагийн хорин жил тохиолддог>> гэж Жу Сян Зюнь хүйтнээр өгүүлэв.

И Да Зин хэсэг зуур дуугүй байснаа <<Сян дүү минь миний бодлоор чи тэнгэрт тэрслүү бүлгийн толгойлогч болоогүй нь дээр дээ>> гэхэд Жу Сян Зюнь <<Яагаад тэр билээ? Ийм боломж надад дахин гартал дахиад хорин жил хүлээх хэрэг үү?>> гэж асуув. И Да Зин <<Толгойлогч боллоо гээд ямар ашиг байгаа юм бэ. Тэр олон хүнийг аллаа гээд юу болох юм бэ. Эртний үгэнд их нүгэл үйлдвэл...>> гээд цаадахь үлдсэн санаагаа гүйцээлгүй орхив.

<<Их нүгэл үйлдвэл гарцаагүй үхдэг гэж хэлэх гээ юу. Манай тэнгэрт тэрслүү бүлгийнхэн угаас тэнгэрийн ёстой харш улс. Наад үгээрээ номын улсыг л хуурч байвал барав>> гэж Жу Сян Зюнь өгүүлэв.

И Да Зин Жу Сян Зюнийг өөрийн үгэнд оруулж чадахгүйгээ мэдэж санаа алдаад <<Заавал өөрийн бүлгээ мандуулах гээд байгаа бол хортон

муу бүхнийг хоггүй болтол устгаж сайн үйлсийг бүтээж явах нь жинхэнэ эр хүн идтэн баатрын эрхлэх үйл биш үү>> гэхэд

Жу Сян Зюнь инээд алдан <<Би ч ямар эр хүн биш тэгээд ч номч баатар тан шиг эрдэм номын амтыг мэдрээгүй яахин буян нүглийн учрыг гадарлаж чадах билээ. Тийм болохоор мөрөн гол даяар нэр алдраа дуурсгасан 5 махбодийн бүлгийнхэнтэй тулалдаж ид хүчээ үзүүлж явбал барав>> гэв.

И Да Зин үг ч хэлсэнгүй урдах хундагатай архиа л уусаар суув. Түүний байдлыг харсан Жу Сян Зюний баруун зүүн хоёр нүднээс сувдан нулимс мултран хоёр хацрыг нь даган зугуухан урсав. <<Чи ч хүний сэтгэлийг ойлгодоггүй хүн юмаа>> гэж тэрээр хэллээ.

И Да Зин санаа алдаад <<Сян дүү минь би яахин эс мэдэх билээ. Харин би чамайг хэвгий замаа орхин хэрэгтэй үйл бүтээж явбал сая санаа амрах болно. Би өсөх бага наснаасаа хүний цус байтугай гахай тахианы цус үзэж чаддаггүй хүн байсан юм>> гэв.

<<Чамайг л болдож би тэр 1000 гарт тогооч У Зы Пиний гэрт Хуо Шао Чунгийн далны ясыг нь хугалаад орхисон. Би түүнийг алж болох байсан шүү дээ. Тоорын цэцэгт ууланд Му Цин Сятай тааралдахад түүний сэтгэл санаа хичнээн их самуурсан явсан байлаа даа. Түүний амийг авна гэдэг тэр цагт алга урвуулахын төдий л хэрэг байсан. Таван том бүлгийнхнээс хоёрыг нь дарчихаад үлдсэн гурвын хувьд бол тэр шороон толгойт Ту Ди Хан, амьд загасаар хооллодог Шуй Да Юнь нартай тулалдаад ялахад юухан байхав. Төмөр махбодийн бүлгийн толгойлогч Жинь Кан Лунгийн тухайд хэдийгээр зэвсгийн эрдмийн хувьд гоц гойд боловч миний Сян Зюний салхи гүйцэгч 18 илдийн аргын өмнө ганцаараа яах ч юм билээ. Тэгээд 5 махбодийн бүлгийн толгойлогчийн суурийг эзэлсэн байхад бусад арван дөрвөн эн тэнцүү эрхт элч нар надтай юу ярих юм бэ. Би чиний л нүүрийг бодож тэдний амийг өршөөсөн байхад чи сэтгэлийг минь ойлгохгүй байна гэж үү>> гэв.

И Да Зин эргэн бодоход бүгд үнэн байх тул инээд алдан <<Сян дүү чамдаа баярлалаа>> гэв.

<<Чи тэгээд яагаад намайг гэнэт ингэж засарсаны учрыг олов уу?>>

И Да Зин толгой сэгсрэн <<Номын хэнээтэй тэнэг толгой би юу ч ойлгохгүй байна>> гэлээ.

<<Номын хэнээтэй гэнээ. Тэгвэл чи заавал надаар хэлүүлэх гээд байгаа хэрэг үү. За яахав тэгвэл би чамд хэлье л дээ. Би чамд сайндаа л тэр бүхнийг хийсэн юм шүү дээ>> хэмээн Жу Сян Зюнь хэлэв.

Ийн өгүүлэх зуур нүүр нь улсхийн уул нь хүн алахдаа нүдээ цавчдаггүй байсан бяцхан шулам маань эрх танхи охины төрхийг олсон харагдана. И Да Зин хэдийгээр номын томоотой хүн боловч бас ч гэж эр хүний хуйх юм болохоороо өөрийгөө барьж тэвчсэнгүй ухасхийн түүнийг тэврэн аваад тоорын улаан уруул дээр нь шовхийтэл үнсээд авлаа.

Жу Сян Зюнь түүний энгэрт наалдан эрхлэхэд хоёр зүрх нь оволзон цохилох дуулдана.

Хэсэг зуур ийн байгаад Жу Сян Зюнь босож үс гэзгээ янзлаад <<Номын хэнээт минь чи надаас ч муухай амьтан юм даа>> гэхэд И Да Зин өлгөн аваад <<Эртнээс нааш баатар эр эмийн цайзыг ялж чаддаггүй гэдэг биз дээ. Тэгэхээр би ямар хүнээс онцгой хүн биш>> гэлээ.

<<Зин ахаа үнэнээ хэлэхэд би одоо тэднийг алахгүй зүгээр л бүлгийн толгойлогчийнх нь суурийг булаан эзлээд амьд үлдээх болно гэж шийдлээ. Азаар модон махбодийн бүлгийн толгойлогч надад өөрийн сууриа найр тавин өгсөн харин одоо та надад шороон махбодийн бүлгийн толгойлогчийн сууриа өгөх юм байгаа биз дээ?>> гэж Жу Сян Зюнь хэллээ.

И Да Зин хэсэг зуур юу хэлэхээ мэдэхгүй гүлдгэнэснээ <<Сян дүү минь чи хэрвээ миний амийг авъя гэсэн ч надад татгалзах юм байхгүй. Жирийн нэг номын хүн надад энэ шороон махбодийн бүлгийн толгойлогчийн хэргэм ямар хэрэг байх вэ. Тийм болохоор чамд өгчихөд болохгүй юм байхгүй л дээ. Гагцхүү... гагцхүү...>>

<<Гагцхүү... яасан гэж?>> хэмээн Жу Сян Зюнь шавдуулан асуулаа.

И Да Зин угаас худлаа хэлж чаддаггүй тэгээд ч Жу Сян Зюньд багшийн охиныхоо тухай дурсан гэдэг тусгүй гэж бодоод <<Энэ тухай ярьж гэвэл урт үлгэр боно. Ганц хоёр үгээр яахин хэлж ойлгуулж болох вэ. Гэвч Сян дүү минь чи санаа амар бай. Би хожим энэ талаар чамд сайтар ярьж өгөмз>> гэлээ.

Хайрын халуунд шатаж байгаа залуус угаас хар хор ихтэй байдаг. Жу Сян Зюнь хэдийгээр өсөх идэр наснаас мөрөн голоор явж чамгүйг үзсэн боловч хүн л юм болохор энэ дутагдлаас ангижирч чадсангүй сулхан дуугаар <<Наадах чинь юу гэсэн үг вэ? Би юундаа санаа амар байж чадах юм бэ. Шороон махбодийн бүлгийн толгойлогч ямар өөр хүн байгаа биш хэндээ өгөх нь чиний өөрийн хэрэг биш үү. Ямар бүлгийн тэнгэрийн дагина шиг гоо бүсгүйд наад хүндлэл хишиг чинь очих ёстой юм бэ>> хэмээн хэлэв.

Түүний хэлсэн үгс И Да Зингийн сэтгэлийн шархыг хөндөхөд нүүр нь улсхийн <<Усанд 3000 тохой шумбалаа ч ганц хул аяганаас илүү ууж чадах

биш.Тэнгэрийн дагина шиг сайхан хүүхэн байлаа гээд энэ насандаа би Сян дүү чамаасаа урвахгүй. Хэрвээ өөр хүнд сэтгэл урвасан байх аваас үсанд үйлгэж газарт булж галд шатаасан ч гомдох юм алга>> гэж андгай тавив.

Гэтэл эдгээр үгс нь байдлыг улам муутгаж Ж Сян Зюний сэжгийг улам нэмэгдүүлэх нь тэр. Жу Сян Зюнь угийн сэргэлэн хүн тул түүний санааны мухарт нэг юм нуугдаад байгааг гададарлаж сулхан инээгээд <<Ингэж худлаа андгай тангараг тавиад яах гэсэн юм бэ. Хэндээ өгөх нь чиний өөрийн хэрэг шүү дээ. Надад ямар хамаа байх вэ>> гэлээ.

Ийн өгүүлээд өөрийн гарар И Да Зинд архи хунгалж өгөнгөө <<За за олон үг олиг болно гэдэг. Ахиухан ууж цадталаа идэцгээе. Харин энэ орыг би эзэгнэн өнөө шөнөдөө И бүлгийн толгойлогчийг газар залруулах нь дээ>> гэлээ.

И Да Зин бөх гээчийн сайхан унтаж амраад маргааш өдрийн үд хэвийж байхад сая өндийн сэрлээ. Нарны туяа нүдэн дээр нь тусахад цочин харваас нар хэдийн баруунаа ташсан байлаа. <<Би яахаараа ингэтлээ айхтар унтдаг байна вэ. Сян дүү хаачсан юм бол?>> гэж бодоод сандран босож үзвэл Жу Сян Зюнь бараа туруу ч үгүй болсон байв. Яаран сандран буурчийн газрын зарлагыг дуудан <<Жу бүсгүй хаачаа вэ?>> хэмээн асуулаа.

<<Жу бүсгүй гэнээ. Та эхнэрийгээ хэлж байна уу? Өнөө өглөө үүрийн таван жингээр тэр яваад өгсөн шүү дээ. Өөрт нь чухал ажил гарсан тул түрүүлээд явлаа. Харин өөрийг чинь араас гүйцээд ирнэ биз>> гэж байсан хэмээн зарлага өчив.

<<Тэр явчихсан гэнээ. Арай гэж нэг муу юм уулзчихаад яагаад намайг дахин орхин одно вэ>> хэмээн бодох зуур Жу Сян Зюнь ямар нэгэн захиа занга үлдээсэн байж мэдхэ юм гэж юм хумаа онгичиж гарав. Гэвч ямар ч бичиг хар гарсангүй харин өөрийн мөнгөн ембүүнээс хоёр дутсан байлаа. <<Сян дүү хэдэн мөнгөн зоосноос болж хүн алж хүрээ талдагсан харин энэ удаа миний мөнгөнөөс авсан байхыг үзвэл муу замаасаа гаръя гэж шийдсэн бололтой>> гэж бодоод дотор нь жаахан уужрав.

Гэвч тэр яагаад түрүүлээд явчихдаг билээ. Чухал хэрэг гарсан байлаа гэхэд надад хэлж болноо доо. Өчигдөр оройхон л тэр энд хэд хоног амраад хүч тамирааа сэлбээд явъя гэж байсан биш үү. Тэр арай хүчтэй дайсны эрхэнд автсан юм биш биз дээ. Гэтэл энэ буудлын хүний хэлэх нь ганцаараа

явсан гэх юм гэж бодоод буудлын малын хашаанд очвол мөнөөх худалдаж авсан илжиг нь алга байв.

Ямар ч байсан хүчтэй дайсны эрхэнд автаагүй бололтой гэж бодоод И Да Зингийн санаа бүр ч амсхийлээ. Гэвч Жу Сян Зюнь мөрөн гол даяар өстөн дайсан олонтойн дээр дотоод хүчээ алдсанаас зэвсгийн эрдмээ хэрэглэж чадахгүй тул хүчтэй дайсан битгий хэл жирийн нэг зэвсэгтэй хүнийг ч дөнгөж чадахгүй. Ховоод түүнээс өөр түүнийг хамгаалах хүн байхгүй хэмээх бодол сэтгэлд нь төрж яаран сандран буудлын хөлсөө төлчихөөд умард зүгийг зорин хөдлөлөө.

Шөнө орой хүн амьтан үгүй нүдээр И Да Зингийн хөнгөний тамир гаргуун болсон тул замдаа торх юмгүй урагшилж байлаа. Үүр тэмдгэрэхийн үест хоёр зуу гаруй газар замыг туулсан байв. Тийн явсаар нэгэн буурчийн газар хүрэлцэн ирж Жу Ся Зюнийг сураглавал буудлын эзэн ирээгүй гэв.

Тэр өдрөө буудалд амарч өнгөрөөгөөд орой болоход дахин замаа хөөлөө. Харгуй замаар тосох дээрэмчин олон аюул осол ихтэй тул Жу Сян Зюнь лав их замаар явсан байж таарна гэж тэр боджээ. Тэрээр ийнхүү хоёр шөнийн турш түүний араас мөшгөсөөр нийтдээ 400 гаруй газар замыг туулсан байлаа. Зам дагуух хүн хараас асуухад бүгд л толгой сэгсэрцгээнэ. Сян дүү минь арай аюул осолтой тулгарсан юм биш байгаа даа хэмээн И Да Зингийн санаа зовж эхлэв. Хэрвээ харгуй замаар явсан бол хулгайч дээрэмчинтэй учрах магадлал ихийн дээр Сян дүү биеэ хамгаалах чадвараа алдсан хэмэн бодох тусам санаа сэтгэл нь улам тавгүйтнэ. Хөөрхий бие султай бүсгүй хүн өөрт нь найдаж байхад архинд шунаж байгаад түүнийг алдаад явуулчихсан байдаг... гэхдээ өчигдөр ч нэг их шальтай ууж базаагаагүй шүү дээ гэсэн атлаа яасан амархан согтчихоо вэ. Арай тэр архинд ямар нэгэн хольц байсан юм болов уу? Гэтэл тэр архийг Сян дүү өөрийн гараар аягалсан. Элдэв эм тан хийсэн байлаа гэхэд тэр андахгүйдээ хэмээн бодох зуур <<Тэр өөрөө нойрсуулагч эм архинд хийсэн юм биш байгаа>> гэсэн бодол харван орж ирлээ.

Түүний бодол үнээхээр зөв байлаа. Жу Сян Зюнь архинд нойрсуулагч эм холиод И Да Зинг унтаад өгөнгүүт хоёр лан мөнгө авч ганцаараа замаа хөөсөн юм. Тэрээр түүнийг хардах сэтгэлийн улмаас ганцаараа орхин явсан ажээ.

<<Сян дүү хэрвээ надаас хулжин одож байгаа бол их замаар явахгүй харгуй замаар явах нь гарцаагүй. Тийм болохоор би буцаж харгуй замаар

түүнийг сураглан хайя>> гэж И Да Зин бодод өдөр нь сайтар унтаж амран шөнө орой харгуй замаар буцан бэдэрлээ.

Тэр шөнө саран мандаагүй тэнгэрт бөөн бөөн хар үүлс нүүгэлтэнэ. И Да Зин ийн явсаар шөнө дүл болохын хэрд бөөн хүмүүс шуугилдах чимээ гарахыг олж сонслоо. И Да Зин сэрэмжлэн хэсэг бут сөөгний араар орж нуугдав. Түүний хөнгөний тамир даад зэрэгтээ тулсан тул мөнөөх ярилцагч хүмүүс хичнээн ойртсон ч гэсэн тэд ажиг сэжиг авахааргүй байлаа.

Тэд тавуул бөгөд бүгд шөнийн хар өмсгөл өмссөн ажээ. Тэдний дундаас өөхөн бөмбөг шиг намхан тарган хүн <<Шуй ах гурван жингийн алдад энд уулзана гэж байсан атлаа яагаад одоо болтол байхгүй байна вэ?>> гэхэд нэг хүн өлгөн аваад <<Шуй ахын багш нь өнөөдөр хурим найр хийж байгаа бол тэр том шавь нь болохоор яахин орхин одож болох вэ дээ>> гэв. Өөр нэг хүн <<Шуй ах угаас хэлсэн л бол үгэндээ хүрдэг хүн. Гурван жинд ирнэ гэсэн бол ирэх ёстой. Бүгдээрээ тэвчээртэй хүлээцгээе>> гэлээ.

Тэд Шуй ах гэлцэхийг сонсоод И Да Зин өөрийн эрхгүй усан махбодийн бүлгийн эзэн Шуй Да Юнийг саналаа. Усан махбодийн бүлэг бол мөрний өмнөд нутгийн хамгийн том бүлэг бөгөөд өст хүн өлийн даваан дээр гэгчээр Жу Сян Зюнь усан махбодийн бүлгийнхний гарт орчихоогүй байгаа даа.

Нэгэн хүн нөгөө өөхөн бөмбөгөөс асууруун <<Багшаа манай Зян Жоугийн бүлгийнхэн Шуй ахад ийм их тус хүргэж байхад тэр бидэнд их баярлаж байгаа нь лав даа>> гэхэд өөр нэг хүн ярианд оролцон <<Тэрийг хэлэлт юу байхав дээ. Энэ удаа бид түүнд ингэж тусалсан болхоор хожим бидний арилжаа наймааны ажилд Шуй ах ч гэсэн харж хандах нь ойлгомжтой. Тэгэхээр бид хөх мөрөн дээр айх аюулгүй боллоо гэсэн үг>> гэв. Мөнөөх намхан тарган хүн хариу өгүүлрүүн <<Тэр ч ойлгомжтой хэрэг. Нөгөө талаар усан махбодийн бүлгийн толгойлогч ийм шударга бус хэрэг хийчихээд суурин дээрээ заларч байх нь зохимжгүй. Түүний суурийг хэн авна гэж тан нар бодож байна>> гэхэд бас нэг хүн хариуд нь <<Эртнээс нааш мөрөн голын жишгээр ууган шавь нь л бүлгийн толгойлогч болдог жамтай. Тэгэхээр Шуй ах болох нь гарцаагүй>> гэлээ. Тарган эр залгуулан <<Хэрвээ Шуй ах бүлгийн толгойлогч болчихвол бид гавъяатай хүмүүс болох тул усан махбодийн бүлгийн хүндэт сууринд заларч болох юм шүү. Тэр цагт албаны цэрэг, усан махбодийн бүлгийн сайн эрчүүдээс айж муурнаас нуугдах хулгана шиг байдгаа больцгооно>> гэлээ. Бүгдээр хөөр

баяр бололдон <<Багшийн хэлдэг яахын аргагүй үнэн. Хэрэг явдал бүтэмжтэй болсны дараа Шуй ах бүлгийн толгойлогч харин та бүлгийн дэд тэргүүн болох ч юм бил үү. Бид ч гэсэн таны буянаар салбар хайсангийн эзэд бодохыг хэн байг гэхэв дээ>> гэгцгээв.

Нэгэн шавь нь хажуугаас <<Багшаа тэр шулам бүсгүй ямар учиртай хүн бэ?>> гэхэд И Да Зин <<Шулам бүсгүй>> гэсэн хоёр үгийг сонсоод чихээ сортойлгон анхааралтай чагнав.

Өөхөн бөмбөг <<Нарийн учрыг нь би сайн мэдэхгүй л дээ. Усан махбодийн бүлгийн толгойлогчийн хэлэхийг сонсвол урд өдөр санамсаргүй таарладсан бололтой. Тэр шулам бүсгүй биедээ зэвсэг агссан атлаа зэвсгийн эрдэм чадахгүй нь хачирхалтай гэлцэж байна лээ>> гэв.

Шулам бүсгүй, урд өдөр, зэвсэг агсаад, зэвсгийн эрдэм чадахгүй.. гэх зэрэг үгсийг холбон үзвэл Жу Сян Зюнээс өөр хэн байж таарах билээдээ.

<<Арай тэр шулам бүсгүй гоц гойд зэвсгийн эрдэм эзэмшчихээд өөр зүйлд гаргах санаатай байгаа юм биш биз?>> гэж өөр нэг эр асуулаа.

Өөхөн бөмбөг хариу өгүүлрүүн <<Усан махбодийн бүлгийн толгойлогч түүнийг мэдэхгүй байв гэж үү>> гээд шалиглан инээж <<Шуй ахын хэлэхийг сонсвоос усан махбодийн бүлгийн толгойлогч түүний биеийг сайтар шинжиж үзсэн юм байх. Гэтэл өчүүхэн ч дотоод хүч байхгүй байна гэнэ лээ. Харин бие махбодь нь хачин зөөлхөн байсан гэдэг шүү. Хи хи хи...>> гэв.

И Да Зин тэдний яриа улам бүр шалиг завхай болж ирэхэд тэсч чадалгүй уурандаа ухасхийн тэдэн рүү дайрахаар зэхтэл гэнэт хүзүүгээр нь хүйт оргихыг үзвээс нэгэн урт илд түний ар шилэн дээр хөндөлссөн байлаа. Нэгэн хүн <<Эрхэм та юун хүн болод харанхуй шөнө бусдын яриаг эрээ цээргүй сонсож байдаг билээ>> гэж асуух нь тэр.

Мөнөөх хүн хэдийгээр зэвсгийн эрдмийн хувьд И Да Зингийн хаана ч хүрэхгүй боловч тэрээр хамаг анхаарлаа хөвчилөн Зян Жоу бүлгийнхний яриаг чагнаж байгаад араас нь гэтэх хүнийг анзаараагүй байсан нь тэр ажээ. <<Ёстой баларсан юм боллоо. Миний өчүүхэн амь гарзандаа гарахад дүүрсэн хэрэг гэж бодоход ертөнцөд өөр хэн муу Сян дүүг минь авран хамгаалах болж байна даа>> хэмээн тэрээр халаглан бодож амжив.

Зян Жоу бүлгийнхэн зэрэг гүйн ирээд <<Шуй ахаа!>> хэмээцгээв.

Мөнөөх Шуй ах хэмээгч И Да Зингийн хүзүүнээс илдээ холтгосонгүй <<Эрхмүүд яасан болгоомжгүй байх юм. Хамаг юмаа дэлгэн ярьж байхад чинь хажуугаас чинь хүн сонсож байсан байна шүү дээ>> гэлээ.

Энэ үед саран авхай бөөн үүлний завсраар цухуйн гарч ирлээ. Зян Жоу бүлгийнхэн Шуй ахынх нь илдний ирэн доор нэгэн залуу эр хэвтэж байхыг үзээд ихэд цочирдон гайхацгаалаа. <<Энэ хүн бидэнд мэдэгдэлгүй ойртон ирсэн байхыг бодоход зэвсгийн эрдмийн хувьд тун чамгүй хүн байж мэднэ>> гэж мөнөөх багш нь болох хүн бодож амжсан боловч аман дээрээ <<Өмхий золиг минь чи ямар учиртай хүн бэ? Зян Жоу бүлгийнхийг үймүүлээд аминаасаа уйдаа юу>> гэж асуув.

Үнэндээ энэ үед И Да Зингийн сурсан эрдэм өмнөө байгаа 6 хүн бүгдээрээ түүн рүү халдан дайрсан ч дийлдэшгүй болсон байлаа. Гэвч тэр шилэн хүзүүн дээрээ байгаа илднээс болгоомжилохын дээр хамгийн гол нь Жу Сян Зюний аюулгүй байдалд санаа илэрхий зовох тул хөдөлж ч чадахгүй хэвтсээр байлаа. <<Би ямар учиртай хүн байх вэ дээ. Шөнө орой явж байтал замд та нар гэж сүртэй догшин улс шуугилдаад гараад ирэхээр чинь зам тосох дээрэмчин байж мэднэ гэж айгаад энэ сөөгний ард хөдөлж ч чадахгүй хэвтэж байгаа минь энэ шүү дээ. Эрхэм сайн эрчүүл миний амийг хэлтрүүлэн өршөөвөл би бушуухан явж эхнэрээ эрэх минь>> гэж И Да Зин хэллээ.

Зэвсгийн эрдмийн ертөнцөд эрэлхэг баатрууд нэр төрөө хамгаас илүү эрхэмлэдэг бөгөөд өрсөлдөх дайсантайгаа тулалдаж цусаа урсгаж байлаа ч гэсэн өршөөл аврал эрэн гуйхыг цээрлэдэг билээ. Гэтэл И Да Зин нэг талаар зэвсгийн эрдмийн дэг ёсыг мэдэхгүй нөгөө талаар Жу Сян Зюнийг аврах гэж яаравчилсан тул ийн худлаа хэлэхэд хүрсэн юм. Тэдгээр хүмүүс нь бас ч гэж мөрөн голоор хэдэн жил явчихсан улс тул И Да Зин юу юуны тухайд хүрэлгүй амь аврахыг гуйн мөргөхийг үзээд түүний худал үгэнд хэдэн хувь итгэсэн байлаа.

Өөхөн бөмбөг инээд алдан <<Эхнэрээ бусдад өгөөд алдчихсан хэрэг үү?>> гэв.

И Да Зин мөнөөх өөхөн бөмбөг түүнийг гутаан доромжилохыг үзээд нүүр нь улсхийгээд <<Чиний эхнэр л бусадтай явалддаг байлгүй. Муу өөхөн бөмбөг чи дахин ганц булай үг хэлэх аваас би чамтай нэгийгээ үзэх болно шүү>> гэлээ.

Өөхөн бөмбөг тас тас хөхрөн <<Аа энэ чинь уг нь зүсээ нуусан сайн эр байсныг бид мэдээгүй байх нь. Ёс алдаж ёс алдаж>> гэв.

Илд баригч Шуй ах <<За дүү минь би чиний амийг хороохгүй. Харин эхнэрийг чинь олж өгч болох юм>> гэж гэнэт ам нээн өгүүлэв.

Энэ хүмүүс лав Жу Сян Зюний байгаа газрыг мэдэж байгаа бололтой. Хэрвээ түүнийг аврая гэж бодвол эндээс холдож яасан ч болохгүй юм байн гэж И Да Зин бодоод <<Эрхэм сайн эрчүүлд баярлалаа>> гэв.

Шуй ах илдээ буцааж аваад <<За бос бос чиний эхнэр хаана байгааг бид бүхэн мэдэж байна. Эхнэрийг чинь эсэн мэнд эргүүлэн өгөх болно>> гэв.

Ийн өгүүлэх зуур И Да Зинг хүн байна гэж ойшоож үзсэнгүй өөхөн бөмбөгийн зүг эргэж алгаа хамтатгаад <<Толгой хагаравч малгай дотроо, тохой халцравч ханцуй дотроо гэлцдэг. Гэвч энэ тухай ярихаас ичмээр юм. Манай багш уул нь нэг том бүлгийн толгойлогч атлаа бусдын эхнэрийг булаан авч гэрлэх гэж байгаа нь олон шавь бидэнд туйлаас эвгүй хэрэг билээ. Хэрвээ багшийнхаа үйлдэлтэй эвлэрвэл сайн эрийн тангарагаас няцах болно. Энэ шившигтэй хэргийг илчилчихвэл бүлгийн нэр төрөө гутаахын дээр багштайгаа тэрсэлсэн хэрэг болох тул арга буюу Зян Жоугийн бүлгийн ах дүү та нарыг энэ хэрэгт тус болооч гэж гуйсан минь энэ билээ. Энэ хэргийг илчлэхдээ эрхэм ах дүү та нар манай багшийн нэр нүүрийг хэтэрхий гутааж болохгүй шүү. Хамгийн гол нь манай багш олон баатар сайн эрсийн өмнө юу гэж хэлэхийг сонсох нь чухал байгаа юм>> гэлээ.

Өөхөн бөмбөг хариу ёслон <<Шуй ах та ёсорхохын хэрэг юун. Гагцхүү энэ хэрэг дэндүү төвөгтэй юм даа. Усан махбодийн бүлгийн толгойлогчийн хүн чанар зэвсгийн эрдмийн өмнө бид бүхэн ямар ч гэрч баримтгүйгээр ял тулгах аваас эцэст нь үхлээ ч оршуулах газаргүй болно гэсэн үг шүү дээ>> гэв.

Шуй ах инээд алдан <<Гэрч баримт гэвэл уг нь алга байсан юм. Харин одоо бол байгаа гэж үзэж болно>> гэв. Өөхөн бөмбөг гайхсан маягтай <<Тэр чинь тэгээд хаана байгаа юм бэ?>> гэхэд Шуй ах <<Хажуу дэргэд чинь байна даа>> гэлээ. Өөхөн бөмбөг И Да Зинг гайхан харж Шуй ах руу хандан <<Арай энэ биш биз дээ?>> гэлээ. Шуй ах <<Гарцаагүй мөн. Нэг нь эхнэрээ алдаад нөгөө нь шинэ эхнэр олж хурим хийх гэж байдаг ингэж таардаг юм гэж хорвоод өөр хаана байх вэ дээ>> гэлээ. Өөхөн бөмбөг <<Үнэхээр тийм байна шүү>> хэмээн хөөрөн баясав.

Шуй ах И Да Зинд хандан <<Чи ч гэсэн биднийг битгий сайн эрс гээд байж үз. Бид ямар боловч зам тосох дээрэмчид биш. Харин ядууг тэтгэж баяныг талан аюулд учрагсдыг аварч явдаг мөрөн голын жирийн хүмүүс байгаа юм. Чи эхнэрээ бусдад алдсан гэхээр бодвол хэн нэгэн зальхай

амьтанд булаалгасан байна. Тэгэхээр бид сэтгэл хүчээ нэгтгэн танай эхнэрийг буцаан олохын төлөөнөө явцгаавал ямар вэ>> гэв.

Шуй ахын ярианаас шударга үнэний төлөө багштайгаа тэрсэлдэхэд ч бэлэн үнэнч шударга журамтай баатар эрийн дүр төрх тодрох тул И Да Зин түүнд их л элгэмсэгээр хандах болов. Тэр даруй мэхэлзэн ёсолж <<Эрхэм баатар танд баярлалаа>> гэлээ.

<<Ёсорхохын хэрэггүй. Эрхмүүд хэлсэн ёсоороо хөдлөвөл ямар вэ?>> гэж асуухад өөхөн бөмбөг хэсэг зуур бодол болсноо <<Манай Зян Жоугийн бүлгийнхэн Шуй ах таны тушаалыг биелүүлэх болно. Харин энэ золиг олон баатар эрсийн өмнө холиож өгөхгүй байгаа гэж айж байна>> гэлээ.

<<Та нар хэрэв надад Сян дүүг минь олж өгвөл би яаж баярлахаа мэдэхгүй байхад бас намайг холиож өгнө гэж айж байдаг байна шүү>> хэмээн бодох зуур Шуй ах цахилгаан мэт хурднаар хөдөлж түүний хэлгүй болгодог цэг дээр хатгаж орхив. Тэрээр сэтгэлдээ сэрхийн гайхсанаа <<Арга ч үгүй юм даа. Энэ Шуй ах гэгч нь аливаад их хашир ханддаг хүн юм гээч. Намайг нээрэн холиож мэднэ гээд хэлгүй болгогч цэг дээр минь дарж байна. Сян дүүгийнхээ төлөө хэсэг хугацаанд хэлгүй хүн болон жүжиглэхэд ямар хамаа байх вэ>> хэмээн бодлоо. Үнэн хэрэгтээ яаж ч хатгалаа гэсэн И Да Зингийн эмзэг цэгт нөлөө үзүүлэхгүй боловч тэрээр хэлгүй болсон мэт царай гаргаж дуугүй болчихов.

Шуй ах инээд алдаж <<Бид ямар ч байсан энэ хэргийг бүтээх болно. Эр нөхөр нь хэлгүй амьтан байсан байгаа биз. Харин эхнэрийнх нь хувьд яадаг ч байлаа гэсэн манай багш эрхэндээ оруулаад сүрдүүлчихсэн гээд хэлчихвэл тэрээр зуун амтай байгаад ч олон баатруудын өмнө яаж ч чадахгүй. Ха ха ха...>> гэв.

Шуй ах өөхөн бөмбөгийг холхон аваачиж хэсэг зуур ямар нэгэн юм зөвлөж байснаа алга хавсран ёслоод <<За өөрт чинь найдлаа шүү>> гээд ганцаараа яаран явж одлоо.

Зян Жоу бол хөх мөрний дагуухь хар цагаан хоёр замын олон бүлгийн дундах нэр сүр гэх юмгүй өчүүхэн бүлэг байлаа. Усан махбодийн нөлөө бүхий хүний ивээлд багтан гэдэг тэдний хувьд тэнгэрийн умдаг атгаснаас өөрцгүй хэрэг байв. Үүр гэгээрхийн үест өөхөн бөмбөг өөрийн хүмүүс болон хэлгүй хүний дүрд тоглох болсон И Да Зинг аваад нэгэн завинд суулаа.

Хөх мөрний дээгүүр уур манан суунаглаж мандах наран цагаан бөмбөлөг төдийхөн харагдана. И Да Зин умард нутгийн хүн тул анх удаагаа завин дээр сууж их усанд ороод айдас төрөх боловч Жу Сян Зюнийг санаж нөгөө талаар их мөрний өглөөний үзэмжид автан бага зэрэг тайвширч байлаа.

Бүлгийн гишүүд хэдийгээр бүгд хүдэр чийрэг эрс авч мөрний урсгал сөрөн явна гэдэг тэдний хувьд амаргүй байгаа бололтой.

Бяцхан завь үзээс өмнийн турш явсаар нэгэн том усан онгоцны дэргэд хүрч ирж зогслоо. Тэр онгоц туйлын уран тансаг чимэгтэйгээс гадна мөрний голд зангуугаа орхисноос үзвэл хэр зэрэг том болох нь ойлгомжтой буй за. Хөх мөрний урсгал ширүүн салхи эрчтэй байх боловч мөнөөх усан онгоц зоолттой мэт огтхон ч хөдлөхгүй ажээ. Өөхөн бөмбөг завиа усан онгоцны ёроолд зогсоохыг зааварлаж байж үед нэгэн хүн онгоцны хитэг дээр гарч ирээд <<Та бүхэн юун улс вэ хэмээн асуулаа. Өөхөн бөмбөг <<Зян Жоу бүлгийн ахлагч Юань овогт би өөрийн бүлгийн хүмүүсийн хамтаар усан махбодийн бүлгийн тэргүүний хурим найрт баяр хүргэхээр ирлээ>> гэв.

Энэ өөхөн бөмбөгийн овгийг Юань гэдэг байсан байх нь. Аргагүй л оносон нэр өгч дээ (Юань гэдэг нь хятадаар бөөрөнхий гэсэн утгатай) гэж И Да Зин дотроо бодлоо.

Хитэг дээрхи хүн их л омог сүртэйгээр хариу ч ёс үйлдсэнгүй гараа дохиж <<Юань гуай та түр хүлээж байна уу>> гээд цааш эргэн одох нь бодвол дарга даамлаасаа зөвшөөрөл авах гэсэн бололтой.

Төдөлгүй гуч гаруй насны нэгэн эр онгоцны хитэг дээр гарч ирэхийг харваас урьд шөнө И Да Зингийн хэлгүй болгодог цэгийг хатгагч Шуй ах мөн байлаа.

Шуй ах Юань толгойлогчийг танихгүй мэт царай гарган алга хамтатган ёслоод <<Юань тэргүүн манай багш танай бүлэгтэй угаас харилцаагүй тул энэ удаа хүлээн авахаас татгалзаж байна. Та буцах ажаамуу>> гэв.

Юань тэргүүн хариу инээн <<Манай мөхөс дорой бүлгийнхэн танай их бүлгийн нөмөр нөөлөг дор хоргодон хоолоо олж иддэг улс. Ачтай буянтай усан махбодийн бүлгийн тэргүүн хурим найр үүсгэж байхад хаяа дэрлэн суугаа бид яаж зүгээр байж болох билээ дээ. Шуй ах та өгөөмөр сэтгэлээ гаргаж өгөн барих бэлгийн маань нэрсийг өөрийн толгойлогчид уламжлан соёрхох болов уу>> гээд гараа явуулан өврөөс нэгэн улаан шугамтай цаас гаргаж ирвээс тэр нь гараас мултран ниссээр Шуй ахын гарт баригдав. Юань

тэргүүн хэдийгээр зүс царай этгээд үг хэл эгэл боргил боловч дотоод хүчээр чамагүй байх нь гэж И Да Зин бахархан бодож суув.

Шуй ах бэлгийн цэсийг хоёр хуруугаараа хавчин авч их л албархуу янзтай <<Намайг эзэнд айлтгаад иртэл Юань тэргүүн та эндээ хүлээж бай>> гэж хэлчихээд эргэн одлоо.

Удаж төдсөнгүй Шуй ах эргэн ирээд нүүрэндээ ямар ч хувиралгүйгээр <<Юань тэргүүнээ манай багш одоогоор хүндэт зочныг хүлээн авч буй тул өөрийн биеэр тантай уулзаж чадахгүйн учрыг уучилна биз дээ>> гэв.

Юань тэргүүн өчрүүн <<Өчүүхэн би хэн болоод заавал танай бүлгийн толгойлогчтой уулзах гэж зүтгэх билээ>> гэж бөхөлзөн тонголзох нь нэгэн бага шиг отгийн тэргүүн хүнд баймгүй төрх байдлыг харуулна.

Шуй ах гар доорхи хүмүүстээ тушааж олсон шатыг буулгалаа. Юань тэргүүн өөрийн хүмүүстээ өгөх бэлгийг бариулж дээшээ гарахад И Да Зин ч мөн дагалдав.

Усан махбодийн бүлгийнхэн Зян Жоугийн отог хэдийгээр хэрдээ л хүнд бэлэг бэлдэж авчирсныг юман чинээ тоосонгүй хэдэн шинэ шавь нар нь түүнийг гардан авлаа. Юань тэргүүн Шуй ахыг дагалдан арын бүхээгт ороход дотроо их л уужим саруул ажээ. Бүхээгийн дотор баян айлын орд өргөөний их танхим адил уран тансагаар чимэглэж өнгийн гэрэл асаасан нь нүд баясгана. Шуй Да Юнь жирийн загасчны төрхөө орхин гоёмсог хувцас өмсөөд мөрөн голын хэдэн сайн эрстэй хөөрөлдөн сууна. Юань тэргүүн урагш давшин ёслоод мэндлэхэд Шуй ах Юань толгойлогч болон бүлгийн бусад хүмүүсийг дагуулан ширээний адагт суулгалаа.

Шуй Да Юнь хөөрөлдөн буй зочидтойгоо ихэд дотносон ярилцахыг үзвээс хүндтэй зочид бололтой. И Да Зин хэдийгээр мөрөн голын сайн эрсийг танихгүй боловч төмөр, гал, шороо, модон махбодийнхон байхгүйд санаа амран суудлаа эзлэлээ.

Идээ будаа бэлтгэн мөрөн голын хэрэг явдлыг хөөрөлдөхөд ширээний адагт суугаа Юань отгийн ахлагч ярианд оролцож эс зүрхэлнэ. И Да Зин хэлгүй хүний царай гарган суух боловч дотор сэтгэлд нь гал асах мэт санагдаж байлаа. Түүний сэтгэлийг Жу Сян Зюнь эзэмдэн тэр одоо ямар байдалтай байгаа бол гэхээс сэтгэл нь шархирна. Харин Шуй Да Юнь их л баяр хөөртэй суухыг үзвэл ямар ч байсан <<Шинэ бэртэйгээ>> элдэв асуудал үүсээгүй бололтой гэж бодоод жаал уужирлаа.

Шар бүрий тасрахын алдад хэн нэгэн хүн <<Жинь баатар айсуй>> гэх нь дуулдав.

Шуй Да Юнь сандран босч олон зочноо дагуулан онгоцны толгой дээр гаран хүлээв. И Да Зин Юань ахлагчийн ард дагалдан гарч харвал оволзон түрхрэх мөрний мандал дээгүүр цагаан сахлаа намируулсан нэгэн омог төгөлдөр өвгөн хуурай газар дээгүүр явж буй мэт хөнгөний тамираа хэрэглэн үсчсээр айсуу яваа харагдана. И Да Зин хараа тогтоон ажвал өвгөн гартаа атгасан хэдэн удын мөчрөө доош хаяхын зуур усны мандал дээр унахаас өмнө амжиж түүн дээр хөлийн үзүүрээр тулж дээш хөөрөн урагш ахин явсаар яах ийхийн зуургүй онгоцны хормойд тулан ирлээ. Түүний хөнгөний тамир ийм гаргууд болохыг үзээд И Да Зин үнэхээр гайхан бахдах сэтгэл төрж байлаа.

Тэр хүн болвоос 5 махбодийн бүлгийн толгойлогч их нэрээ мөрөн гол даяар дуурсгасан баатар эр Жинь Кан Лун гарцаагүй мөн байв.

Жинь Кан Лун усан махбодийн бүлгийн толгойлогч Шуй Да Юньтэй адил ихэмсэг зан гаргалгүй онгоцны толгой дээр зогсох хүмүүстэй нэгд нэгэнгүй мэндчилж явсаар И Да Зингийн дэргэд хүрч ирээд Шуй Да Юньгээс <<Хөгшин би хүн танихаа байжээ. Энэ залуу баатар чинь хэн билээ?>> гэв.

Шуй Да Юнь энэ хүн Юань ахлагчтай ирсэн болохоор тэдний отгийн хүн биз гэж бодоод <<Юань ахлагчийн бараа бологч>> гэлээ.

Жинь Кан Лун ахлагч И Да Зин хоёрыг шинжин хараад итгэсэнгүй бололтой инээд алдаж <<Юань ахлагч та ийм сэргэлэн шавь олж авсанд баяр хүргэе. Өмнө гарсан чихнээс хойно ургасан эвэр урт болдог. Хожим танай энэ шавь чинь Зян Жоу отог төдийгүй мөрөн голыг шуугиулж мэдэх хүн байна даа>> гэлээ.

<<Манай энэ тэнэг маанаг нь дэндсэн шавь яахин таны итгэлийг дааж чадах билээ дээ>> гэж Юань ахлагч амыг нь дагууллаа.

<<Жинь баатар ганц хараад л өөрийнх нь зэвсгийн эрдмийн чадлыг мэдэж чаддаг ямар хурц соргог хүн бэ. Өнөөдөр ч лав амаргүй хэрэг болох нь дээ>> гэж И Да Зин бодов.

Онгоцны бүхээгт дахин найрын ширээг шинээр сэлбэжээ. Шуй Да Юнь өнөөдөр гол нь Жинь Кан Лунг хүлээж байсан нь илт. Жинь Кан Лун ирүүт л хурим найр албан ёсоор эхлэжээ. Мэдээжийн хэрэг Жинь баатар мөрөн голын бусад нэртэй сүртэй сайн эрсийн хамт найрын магнайд суудлаа эзлэлээ. <<Өвгөн би энэ насандаа олигтой шавь төрүүлээгүй боловч эрдэм чадалтай өсөх идэр залуусыг ихэд хайрладаг юм. Юань ахлагч та өөрийн тэр шинэ шавиа нааш явуулж найрын эхэнд суулгахгүй юу>> гэхэд хурсан

олон бүгдээр Жинь баатар нэр сүргүй нэг муу залууг ийн хүндэлсэнд ихэд гайхсан боловч цаад учрыг нь ухаж чадсангүй.

Юань ахлагч яаран босч мэхэлзээд <<Манай мулгуу шавь хэн болоод Жинь баатар тантай суудал зэрэгцэж болох вэ>> гэв.

Жинь баатар инээд алдан босож ирээд И Да Зингийн дэргэд очин гараас нь хөтөлж <<Залуу баатар болгооно уу>> гэв. Ийн өгүүлэх зуур дотоод хүчээрээ түүнийг довтлохыг мэдрээд түүний улаан гэрд цэгийн язгуурын хий хөдөлж түүнийг эсэргүүцэн биеэ хамгааллаа. Гэвч тэрээр царай нь цонхийн хамаг бие нь бадайран чинэж ирэв.

<<Энэ залуу миний таамагласнаас хол зөрсөнгүй. Дотоод хүч нь чинээндээ тултал боловсорчээ. Гэтэл яагаад энэ нэг муу хөх мөрний жижиг отгийн ахлагчийн бараа бологч болоод явдаг билээ>> хэмээн Жинь Кан Лун бодож амжив.

Өнөөдрийн жүжиг энэ балай хүүхдээс болоод балрах юм биш байгаа даа. Хэрвээ тэр гуулиа цухуйлгачихвал хамаг хэрэг муугаар эргэн хэмээн Юань ахлагч бодоод нүүрэндээ инээд тодруулан <<Манай наад шавь чинь хэлгүй дүлий болохоор Жинь баатар таны баяр хөөрийг хугаслах болов уу...>> гэв.

Ийн өгүүлэх зуур Жинь Кан Лун И Да Зингийн гараас хөтлөсөөр өөрийн суудалдаа хүрч хамтдаа сууцгаалаа.

Мөнөөх Шуй ах нь Шуй Да Юний ууган шавь тул багшийнхаа гэрлэлтийг тохиолдуулсан энэ хурим дээр хүндэт зочдын сөн түшиж байлаа. Тэрээр Юань ахлагчийн өмнө ирж архи хундагалах зуур түүн рүү сэмхэн нүд ирмэлээ.

Шуй Да Юнь баяр хөөрөөр бялхсан байртай босож ирээд хундага өргөн <<Өнөөдөр миний хуримын ёслолд Жинь баатар өөрийн биеэр хүрэлцэн ирсэн явдалд туйлаас их баяртай байна. Энэ хундагыг хамтаар тогтоон баярласан сэтгэлийн илэрхийлэл болгоё>> гэхэд олон баатрууд бүгд хундага өргөн тогтоохоор завдвал Юань ахлагч босож ирээд <<Байзаарай>> гэв. Олон баатрууд бүгд алмайран гайхвал Шуй Да Юнь нам жим байдлыг эвдэн <<Юань ахлагч юу хэлэх гэсэн юм бэ>> гэлээ.

Юань ахлагч түүнийг ойшоож үзсэнгүй Жинь Кан Лунгийн зүг хандан <<Жинь баатраа та бол яах аргагүй зэвсгийн эрдмийн ертөнцийн сүмбэр оргил болсон хүн билээ. Тэгэхээр та үнэн мөнийг нь хэлж соёрхоно>> гэж найдаж байна. Хэрвээ нэгэн нэртэй бүлгийн толгойлогч бусдын эхнэрийг

булаан аваад хүчээр ханилан суух гэж байгаа бол энэ хэргийг явал зохистой билээ гэв.

Энэ нь тун санаанд оромгүй хэрэг болсон тул хурсан олон бүгдээр гайхан гөлөрцгөөв. Шуй Да Юнь ч гэсэн балмагдан хэлэх үгээ олсонгүй.

Жинь Кан Лун юм үзэж нүд тайлсан хүний шинжээр ихэд тайван дөлгөөнөөр инээмсэглэн <<Хэрвээ Зян Жоу отгийнхон мөрөн голын дунд үүссэн маргаантай асуудлыг ёс журмын дагуу тавьж байгаа бол хүндэтгэж үзэлгүй яахав>> гэлээ.

Юань ахлагч түүний үгэнд урамшин <<Жинь баатраа та 5 махбодийн бүлгийн тэргүүний хувьд өнөөдрийн миний ярих хэлэх зүйлийн үнэн мөнийг тогтоож өгнө үү>> гэж гуйлаа.

Жинь Кан Лун түүний санааг сайтар ойлгохоос нааш хариу хэлэхгүй гэсэн бололтой дуугаа хураан сууна.

Юань отгийн ахлагч хүйтнээр инээн <<Мөрөн гол даяар өөрийгөө шударга журамтай гэж нэрийдсэн баатар эрс олон боловч хуурамч төрхөө энэ үгээр халхалсан нь дэндүү олон юм даа. Манай хар замын бүлгийнхэн хэдийгээр хүн алж хүрээ талдаг муу нэртэй луу данстай боловч түүнийгээ та нар шиг халхалж хаацайлдаггүйгээрээ онцлогтой юм. Жинь баатраа Шуй бүлгийн толгойлогчоо нэгэнт үг яриа нийлэхгүй бол миний үгийг дэмий хоосон чалчаа яриа байсан гээд бодчихоорой. Би явъя даа>> гэлээ.

Ийн өгүүлээд босож явах гэтэл <<Юань овогтоо та нэгэнт мөрөн голын шударга баатар эрсийг гутаан доромжилчихоод яваад өгч болно гэж бодоо юу>> хэмээн Жинь Кан Лун инээн босож өгүүлээд нэг мэдэхэд түүний замыг хөндөлсөн зогссон байхыг харж олон баатрууд бүгдээрээ уулга алдан гайхацгаалаа.

<<Жинь баатар та Юань миний амийг авахаар шийдсэн бол заавал өөрөө хөдлөхийн хэрэг юу байсан юм бэ. Усан махбодийн бүлгийн жирийн шавь байсан ч би түүний энд хүрэхгүй шүү дээ. Би өнөөдөр хэрүүл уруул хийх гэж биш шударга үнэн гэж байдаг эсэхийг үзэх гэж ирсэн юм. Хэрвээ та түүнд дургүй байгаа бол би ярихгүй байж болно. Хэрвээ та хүч хэрэглэх гэж бодсон бол та дураараа бологтун. Надад эсэргүүцэх хүсэл алга. Намайг алчихсан нь ч та бүхэнд цэвэр биз дээ>> хэмээн Юань ахлагч өчүүхэн ч айсан шинжгүй өгүүлэв.

Юань ахлагчийн зэвсгийн эрдэм ямар болохыг мэдэхгүй боловч үг хэлийн хурц нь хэнд ч гүйцэгдэхгүй бололтой. Жинь Кан Лун гараа сунган

түүний дал мөрийг найрсагаар алгадахад ер бусын их дотоод хүч үйлчилэн түүнийг өөрийн эрхгүй суудалд нь эргэн суулгахад хүрэв.

<<Эрхэм та суудалдаа суугаад яривал дээр. Юу ч байсан ичих эмээх юмгүй ярь л даа. Гэхдээ та эндүү ташаа ярилаа гээд энд таныг эвгүй байдалд оруулах хүн байхгүй гэдэгт итгэж болно. Бурууг хэлж зөвийг ойлгодог ч гэсэн үг бий. Тийм болохоор амь нас алаан талаанд хүрэх юун>> гэж Жинь Кан Лун хэлэв.

Юань отгийн ахлагч өгүүлрүүн <<Жинь баатар та аргагүй их хүн юм. Харин миний хэлэх гэж буй зүйл танай 5 махбодийн бүлэгтэй хамаатай хэрэг шүү дээ. Тэгэхээр явалал дээр вэ>> гэхэд Жинь Кан Лун <<Хэрвээ буруу зөрүү зүйл байх аваас би цээрлүүлэн шийтгэх болно>> гэв. Юань ахлагч <<Хэрвээ тантай холбоотой хэрэг болбоос яах вэ>> гэхэд Жинь Кан Лунгийн царай барайж <<Эрхэм та юу ярих гээд байн вэ. Хөгшин би эрдэм чадалгүй боловч энэ насандаа тэнгэрийн ёсонд харш зүйл хийж байсан нь нэгээхэн бээр ч үгүй билээ>> гэв.

Олон баатар эрс уулгалан босож нэгэн зэргээр <<Юань овогт чи хэн болоод энэ газар ийн дураар авирлана вэ. Танай Зян Жоугийн отог Жинь Кан Лун баатартай тэрсэж тэмцэх чинь дутаа юу. Жинь баатар их хүн тул чамтай доош ордоггүй юм гэхэд бид чамайг өршөөхгүй шүү>> гэлцэв.

Юань ахлагч тэдний үгийг тоосон шинжгүй Жинь Кан Лунг ширтэж <<Жинь баатраа та миний үгэнд хариулсангүй шүү дээ>> гэв.

<<Хэрвээ би эрийг дарлаж эмийг эзэгнэсэн хэрэг хийсэн байх аваас амиа егүүтгэж гэмээ цагаатгах болно>> гэж Жинь Кан Лун өчлөө.

<<Жинь баатраа амь насаа егүүтгэх дээр тулаад юу хийхэв. Гэхдээ л бүлгийн толгойлогч хийх эрхгүй үлдэх буй за. Олон үг улиг болдог гэгчээр би шулуухан хэлье. Хэрвээ өнөөдөр энэ олон баатруудын дунд хэн нэг нь бусдын эхнэрийг түрэмгийлэн авсан байж ахул Жинь баатар та үнэн мөнийг олоход туслах бизээ гэдэгт найдаж байна>> гэж Юань ахлагч хэллээ.

Жинь Кан Лун хэсэг зуур бодолхийлж байснаа <<Шуй дүү чи чинь эзэн хүн байна даа. Яах эсэх талаар нэг үг хэлээч. Бид чинь жирийн зочин шүү дээ>> гэлээ.

Шуй Да Юнь хүйтнээр инээд алдлаа. Хэдийгээр Зян Жоугийн бүлэгтэй хаяа залган оршдог боловч хар цагаан замынхан хэлхээ холбоо гэх юм байдаггүй билээ. Өнөөдөр Юань ахлагч хүрэлцэн ирж баяр хүргэх гэхэд нь ихэд гайхсан юм. Гэтэл энэ хүн цаанаа бодол агуулсан байжээ. Шуй Да Юнь

хэлэх үггүй балмагдан байх зуур Жинь Кан Лун алга хамтатган дөрвөн тийш мэхэсхийгээд <<Эрхэм баатрууд та бүхэн хөгшин намайг дураар аашилсанд өршөөгөөрэй. Би Юань ахлагчийн хүсэлтийг ёсоор болгоё. Юань ахлагч та үг байвал өчигтүн. Харин худал үг ганцыг хавчуулсан байвал шударга замын бүлгийнхэнд нэр төр гэдэг амь наснаас ч илүү үнэтэй байдгийг санаарай>> гээд гараа өргөн ширээний өнцөг дээр тавихад ширээн дээрхи архи хоол асгаж цалгиагүй хэр нь ширээний өнцөг хугаран уналаа. Түүнийг харсан Юань ахлагч төдийгүй олон баатрууд бүгдээрээ царай барайн сууцгаав. Энэ нь Жинь Кан Лунгийн дотоод тамир хичнээн гаргуун хөгжсөнийг илтгэн харуулж байгаа хэрэг байв.

<<Хэрвээ би шударга замын бүлгийхний ариун нэрд хар сэв суулгах худал үг хэлсэн байх аваас үхэх ялд унасан ч харамсах зүйлгүй>> гэж Юань ахлагч өгүүлэв.

Ийн өгүүлээд Юань ахлагч Шуй Да Юний өмнө хүрэлцэн ирж <<Шуй толгойлогчийн өнөөдөр хуримлах гэж байгаа хүүхэн чинь ямар учиртай хүн байна даа>> гэж асуулаа.

Шуй Да Юнь уурсан <<Юань ахлагчаа танай Зян Жоугийн отгийнхон чинь дэндүү их юманд санаархдаг болсон юм биш биз дээ. Суух гэж байгаа хүүхнийхээ тухай хамаагүй хүнд тэр тусмаа хар замынханд тайлбарлаж байх албагүй>> гэж өгүүлэв.

<<Тэр ч үнэн байж мэдэх юм. Гэхдээ миний сонссоноор таны суух гэж байгаа хүүхэн чинь нөхөртэй хүн байсан гэж үнэн үү? >> гэж Юань ахлагч асуултаа лавшруулав.

Шуй Да Юнь хэсэг зуур таг болсноо <<Урьд нь ч тийм байсаан харин одоо бол үгүй>> гэв.

<<Тэгвэл шинэ бэр чинь бэлбэсэн эхнэр юм биз дээ?>>

Шуй Да Юний царай аажмаар хөхрөн гар нь өөрийн эрхгүй төмөр сэлүүрээ атган авч <<Бэлбэсэн эхнэр байвал юу гэж>> гэв.

<<Бэлбэсэн эхнэр дахин гэрлэхэд хэлээд байх юу байхав. Харин гадуур хэлэлцэх нь шинэ бэр чинь нөхөртэйгөө хэвээр юм байна шүү дээ>> гэж Юань ахлагч хэлэв.

Ийн хэлж дуусаагүй байтал Шуй Да Юнь төмөр сэлүүрээ далайн түүний зүг цохихоор далайв. Юань ахлагч хэдийгээр овор бүдүүн биетэй боловч түргэн шалмаг зайлангаа <<Харав уу Таминь энэ хүн намайг алж гэрч баримтыг устгах гэж боджээ>> гэв.

Жинь Кан Лун хөмсөг атируулан <<Шуй дүү минь наадах чинь худлаа донгослоо гээд юу болох юм бэ. Ийн уурлахын хэрэг юун >> гэлээ.

Шуй Да Юнь ичсэндээ нүүр нь час улайжээ. Энэ удаа олон баатрууд бүгдээрээ нэр алдар нь хол ойр дуурссан Шуй баатар арай ийм ёсгүй муухай хэрэг хийчихсэн юм биш биз дээ хэмээн сэжиглэнгүй харцгаана.

<<Жинь баатар болон олон сайн эрс та бүхэн гэгээн оюундаа тольдон соёрх. Түүний тэр бэлбэсэн гээд байгаа хүүхний нөхөр нь үхээгүйгээр барахгүй амь мэнд байгаа юм>> хэмээн Юань ахлагч өгүүллээ.

Шуй Да Юнь түүнийг сонсоод уур нь замхарч инээд алдан эргэж суугаад <<Хар замынхан хүн алахдаа сийхгүй л дээ. Хэрвээ манай эхнэрийн нөхөр амьд байгаа юм бол чи гэрч баримтаа гаргаад ир л дээ>> гэв.

<<Хэрвээ гэрч баримтыг нь гаргаад ирвэл Шуй баатар та яах юм бэ?>> хэмээн Юань ахлагч амыг нь асуулаа.

<<Чи өөрөө яамаар байна вэ?>> гэж Шуй Да Юнь өөдөөс нь асуув.

<<Хэрвээ үнэхээр тийм бузар хэрэг үйлдсэн байвал ертөнцийн баатар эсрийн нүүрийг харах аргагүй болох тул та зэвсгийн эрдмийн ертөнцөөс үүрд тонилбол таарна>> гэж Юань ахлагч хэлэв.

<<Тэгж бололгүй яахав. Манай эхнэрийн нөхөр нь хаана байгаа болохыг зааж айлдагтун>> гэж Шуй Да Юнь хэлэв.

<<Хэрвээ энэ явдал надтай холбоогүй байсан бол би хэрхэвч энэ хэрэгт оролцохгүй байсан юм>> гэж Юань ахлагчийг хэлэхэд Шуй ах хөндлөнгөөс оролцож манай багш чамайг <<Хурдан хэлээдэх гээд байхад юунддаа олон юм донгосно вэ>> гэв.

Юань ахлагч И Да Зинг зааж <<Шинэ бэрийн хуучин нөхөр нь манай энэ шавь байгаа юм даа!>> гэлээ.

МӨРӨН ГОЛЫН ЖИЖИГ ОТОГ ХЭМЭЭХ АРВАН ХОЁРДУГААР БҮЛЭГ

Шинэ бэрийн нөхөр нь И Да Зинг хэмээн заахад олон баатрууд бүгдээрээ алмайран гайхлаа. Шуй Да Юнь хэсэг зуур гөлөрснөө тас тас инээд алдаж <<Өө за за Юань ахлагчаа манай авгай чинь урьд өмнө энэ залуутай сууж байсан байх нь ээ. Тэр тэгээд хэзээ яаж амилсан болж таарч байна даа. Чи тэр залуугаараа манай авгайгийн нэр ус оршин суугаа хаяг төрсөн өдрийн төөрөг зэргийг тодорхой хэлүүлчихвэл Шуй овогт би эхнэр

нөхөр хоёрыг эргүүлэн суулгаад зогсохгүй мөрөн дээрээ байгаа энэ бөндгөрийгөө ч гэсэн тэдэнд бэлэг болгоод барихад бэлэн байна. Ингэж шийдвэл аль алинд маань шударга санагдана биз дээ>>.

Олон баатар эрс Юань ахлагч гэнэт эвгүй байдалд орохыг ажиглацгаав. Усан махбодийн бүлэг нь 5 махбодийн бүлэг дундаа тодорхой байр суурьтай. Шуй Да Юнь хэдийгээр жаахан бүдүүн хадуун хүн боловч голч шударга зантай тийм ичгүүртэй юм хиймээргүй юм даа гэж бодож сууцгаав. Гэтэл Юань ахлагч их л омог бардам төдийгүй гэрч баримт байгаа гээд байхаар нь бас чиг эргэлзээ төрж байсан билээ. Тэгтэл Шуй Да Юнь ийн зоригтой болохыг хараад тал талаас нь дэмжиж <<Тэр үнэн шүү хэлүүлээдэх. Манай шударга замын бүлгийхний нэрэнд сэв суулгах санаатай байжээ>> гэгцгээв.

И Да Зин бүр ч учраа олохоо байчихав. Түүний сэтгэлд Жу Сян Зюнь эхнэрээс нь өөрцгүй байлаа. Гэвч түүний төрсөн өдөр жил ус зэргийн талаар тэр өөрөө юу ч мэдэхгүй билээ. Тэгээд ч эр эм улсын хооронд хоёр сэтгэл нийлж байвал заавар тэр төрсөн өдрийн төөрөг гарсан өдрийн гаригийг мэдэх ямар хамаатай юм бэ?

Ашгүй Юань ахлагч түүнд тус болж <<Ха ха>> хэмээн инээгээд <<Манай шавь угаас хэлгүй дүлий л дээ. Түүнийг Шуй толгойлогч мэдээд зориуд дамшиглаж байгаа байлгүй. Усан махбодийн бүлгийн толгойлогч та зэвсгийн эрдмээр гоц гойд болчихоод төмөр модноос цэцэг ургуулж хэлгүй хүнийг хэл оруулдаг болчихоогүй биз дээ. Тийм болвоос би өөрийн шавийн өмнөөс танд урьдчилан баяр хүргэе>> хэмээн өчөөд мэхэсхийн ёсоллоо.

Энэ үед Шуй Да Юний их шавь буюу мөнөөх Шуй ах Юань ахлагчийн өмнө ирж хүйтнээр <<Юань ахлагчаа танай шавь чинь хэлгүй байж болно. Харин тэгвэл манай багшийн буулгасан эхнэр хэл амтай хүн шүү. Хэрвээ манай багшийн шинэ эхнэр юу гэж хэлэхээс үүдэн үнэ худлыг тогтоовол ямар вэ>> гэлээ.

Жинь Кан Лун хэсэг зуур бодолхийлж байснаа <<Шуй дүү минь буруу номынхны амыг таглах ганц сайн арга үүнээс өөр байхгүй бизээ>> гэв.

Шуй Да Юнь ч гараа дохин өөрийн шавь нартаа <<Хатагтайг нааш нь аваад ирэгтүн>> гэлээ.

И Да Зингийн санаа сэтгэл жаахан уужирсан боловч уушиг зүрх нь амаар гарах шахан оволзоно. Өнөөдөр шилдэг баатрууд хөвөх үүл мэт хуран цугларсан тул Жу Сян Зюнийг авч гарна гэдэг тийм амар хэрэг биш гэдгийг тэрээр сайтар мэдэж байлаа. Аягүй бол амь насаа хайрлалгүй

тулалдаж гарах хэрэг ч тулгарч магадгүй юм. Ямар ч байсан Жу Сян Зюнийг хамгаалан гарах хэрэгтэй.

Олон баатруудын нүд бүгдээр усан онгоцны тавцангийн зүг чиглэлээ.

Гэнэт олны нүдийг баясган тэнгэрийн дагина мэт үзэсгэлэнтэй хааны хатан мэт тансаг чамин хувцасласан бүсгүй онгоцны тавцан дээр гарч ирлээ. Дугуй цагаан царай тоорын улаан уруул очтон гялалзах нүд зэрэг нь хосгүй үзэсгэлэнтэй үзэгдэнэ. Хорин тав зургаа орчим настай боловуу гэмээр боловч жаахан охин шиг эрхлэн айлгүйтэж <<Шуй ахаа та намайг яах гэж дуудсан юм бэ?>> гэлээ. Тоорон уруулын завсраар гарах дуу хоолой нь биеийн үзэсгэлэнтэйгээ зохицоогүй эрэгтэй хүн шиг цахиртсан бүдүүн ажээ.

Шуй Да Юнь инээмсэглээд <<Хуа дүү минь олон баатруудтай уулзуулах гэсэн юм>> гэхэд нөгөө хүүхэн <<Би тэднийг танихгүй юм чинь уулзаж юугаа хийдэг байна гэлээ. Шуй Да Юнь мөнөөх Юань ахлагчийг онцлон зааж <<Чи энэ Юань ахлагчийг таньж байна уу?>> гэхэд Хуа овогт бүсгүй Юань ахлагчийг өөд уруугүй сонжин харж байснаа уруулаа цорвойлгон <<Би энэ өөхөн бөмбөгийг таньж яах билээ>> гэв. Шуй Да Юнь <<Хуа дүү минь битгий ёс алдаад бай>> гэснээ И Да Зинг зааж <<Энэ эрхмийг ч гэсэн чи танихгүй гэж үү>> гэлээ.

Хуа бүсгүй И Да Зингийн өмнө хүрч ирээд тогой гилжийлгэн харж байснаа сөөнгө хоолойгоор <<Энэ цагаан царайт ч түрүүний өөхөн бөмбөгийг бодвол хавьгүй үзэсгэлэнтэй юмаа. Гэвч түүний ямар байх нь надад юун хамаатай билээ. Ганцхан Шуй ах та байхад л ертөнцийн ямар ч сайхан эр байсан би тэднийг тоохгүй. Би энэ үгийг хичнээн олон удаа хэлдэг билээ дээ. Тэгэхэд та ерөөсөө итгэхгүй юм>> гэв.

Энэ хүүхэн хэдийгээр насаар тийм бага биш боловч олон баатруудын өмнө ичиж зовох ч үгүй эр эмийн хооронд хэлэлцдэг үгсээ нуулгүй хэлэх ажээ. Шуй Да Юнь инээд алдан <<Хуа дүү минь чи надаах залуугаа сайн хардаа. Наадах чинь чиний нөхөр байсан гээд байгаа юм шүү дээ>> гэлээ.

Хуа бүсгүй гарч ирсэн цагаас эхлэн И Да Зин түүнийг цоо ширтэж байгаа билээ. Шуй Да Юнь л Жу Сян Зюнийг булаан авсан нь гарцаагүй гэж бодож байтал шал танихгүй хүүхэн гарч иржээ. Түүний сэтгэл баяр гунигаар зэрэгцэн дүүрлээ. Баярладгийн учир гэвэл Жу Сян Зюнь Шуй Да Юний гарт ороогүй байх нь. Гунигладгийн учир гэвэл зэвсгийн эрдмээ гээсэн ганц бие эмэгтэй хүн хулгайч дээрэмчидтэй тааралдвал яана даа гэж бодсоных билээ.

Хуа овогт бүсгүй өөрийг нь цоо ширтэх И Да Зин рүү хандан өмнөд нутгийн бүсгүйчүүдийн давилуун зангаа гаргаж инээд алдан <<Чи намайг юу болоод ингэтлээ ширтэнэ вэ. Чиний гоо царай надад ерөөсөө хамаа байхгүй. Шуй ахтайгаа танилцсан цагаас эхлэн ертөнцийн эрчүүл надад ганц нь ч сайхан санагдахаа байсан>> гэв.

Хуа бүсгүй өөрт нь сэтгэл алдарснаа олон эрчүүлийн дунд илэн далангүй хэлсэнд ихэд омогшсон Шуй Да Юнь <<Манай Хуа дүү жаахан задгай амтай л даа. Санаж бодсоноо шууд л хэлчихдэг зантай хүн байгаа юм. Эрхмүүд өршөөн соёрхоно буй за>> гэснээ Юань ахлагч руу хандан <<Одоо чамд хэлэх үг байна уу>> гэв.

Юань ахлагч Хуа бүсгүйг харангуут цочмогдон сандарснаа хэсэг зуур юу хэлэхээ мэдэхгүй байснаа Шуй Да Юнийг ингэж хэлүүт сэхээ орсон байдалтай <<Наадахь чинь мөн байна даа...>> гэлээ. Шуй Да Юнь тэсгэлгүй багтран уурлаж <<Байдал иймдээ тулчихаад байхад чи бас хүлээн зөвшөөрөхгүй байна гэнэ ээ. Манай усан махбодийн бүлэг танай Зян Жоугийн отогтой ямар өс зангидсан болоод чи худал хуурмаг санаа дэлгэн манай бүлгийн нэр төрийг гутаахаар шийдээ вэ. Би өнөөдөр хурим найрын өдөр хөрш зэргэлдээ улс байна гэж бодоод чамд хэдэнтээ найр тавиад байтал чи бүр даврах нь ээ. Чи өнөөдөр чамайг яаж ч чадахгүй гэж санаагүй биз дээ>> гээд Юань ахлагч руу дөхлөө.

Юань ахлагч түүнийг хүн чинээ гэж тоосонгүй <<Гарцаагүй мөн дөө...>> гэлээ.

Хуа бүсгүй уран хөмсгөө атируулан <<Шуй ахаа наад хүн чинь чамтай юу гэж маргаад байгаа юм бэ. Наадахиа хэдэн хэсэг болгоод лусын хааных руу илгээчихвэл барав биш үү>> гэв.

Юань ахлагчийн хамаг бие агзасхийн чичирч <<Наадахиа хэдэн хэсэг болоод лусын хааных руу илгээчихвэл барав биш үү...>> гэсэн Хуа бүсгүйн үгийг хэдэнтээ давтсанаа ухасхийн харайж <<Энэ мөн байна. Яах аргагүй мөн>> гэж хашгирав.

Энэ үед И Да Зин ч мөн <<Бишээ наадах чинь биш>> хэмээн уулга алдлаа.

Юань ахлагч И Да Зин Шуй ахад хэлгүй болгодог цэгээ даруулсан тул түүнийг тайлахаас нааш дуугарч чадахгүй гэж баттай итгэн өөрийнхөө хэлгүй шавь гэж бардам хэлсэн боловч И Да Зин ийн гэнэт дуугарах юм гэж огтхонч бодоогүй билээ. Гэтэл И Да Зин шинэ бэр нь Жү Сян Зюнь биш байхыг үзээд сандарсандаа ийнхүү ам алдсан нь энэ ажээ.

Олон баатруудын хараа бүгд Юань ахлагчийн зүг чиглэн байснаа хэлгүй гэнэт дуу орохыг үзээд өөрийн эрхгүй харцаа И Да Зин руу чиглүүлэв. Багш нь болохоор <<Мөн>> гээд шавь нь болохоор <<Биш>> хэмээн хашгираад хэн нь яаж нохойтож байгаагийн учрыг бүр олохоо байлаа. Энэ үед Шуй Да Юнь ахлагчийн зүг довтлон ороход түүний ууган шавь Шуй ах ч гэсэн И Да Зин руу зэрэгцэн довтлов. Юань ахлагчийн зэвсгийн эрдэм Шуй Да Юний хаана ч хүрэхгүйн зэрэгцээ ямар ч тулааны бэлтгэлгүй байсан тул Шуй толгойлогч түүний цээжин хэсэг рүү төмөр сэлүүрээр цохиход арагшаа хэд алхан ухраад амь тавих шинжтэй болосн боловч царайд нь инээмсэглэл тодорсон хэвээрээ байх ажээ.

Харин Шуй ах И Да Зинг довтлон ялна гэдэг тийм ч санаан зоргын асуудал биш байлаа. Тэрээр <<Шидэт луу савраа дэлгэх>> мэхээр И Да Зингийн хоёр нүдийг ухахаар санаархжээ. И Да Зин биеэ ялимгүй зайлан түүний хорт савраас зайлж амжлаа. Шуй ах ихэд балмагдан гайхаж аргаа өөрчлөн <<Нисдэг луу сүүлээ шарвах>> мэх рүү хувиран орж И Да Зингийн хэвлийг довтлов. И Да Зин их биеэ хажуулдан түүний мэхнээс бултлаа.

Шуй ах зөвхөн довтлоод И Да Зин хамгаалаад арван хэдэн удаа тулалдав. Тэдний тулааныг харахад Шуй ах И Да Зингийн хаана нь ч хүрэхгүй нь илт ажээ. Хэрвээ И Да Зин хариу довтолвол тун удахгүй тулааны төгсгөл ойлгомжтой болох нь илэрхий байв. Энэ үед И Да Зингийн унтуулагч цэгэн дээр бадайраад явчихыг мэдэрлээ. Бодвол хэн нэг нь түүн рүү далд зэвсэг харваа бизээ. Энэ завсар Шуй ах нударга далайн ирэх нь нууц зэвсэгтэй яг таарсан бөгөөд хэрвээ жирийн хүн байсан бол нойрсуулагч цэгээ онуулчихаад урагшаа бүдрэн унаж Шуй ахын нударган доор толгойнхоо зуун уулзвар амин цэгээ өгөхөөс гарцаагүй болох байлаа. Гэвч И Да Зин амин цэгийг алга болгогч их аргад суралцсан тул түүний нойрсуулагч цэгийг оносон нууц зэвсэг түүнд шумуул хатгахын төдий часхийгээд өнгөрсөн ба бусдаар ямар ч нөлөө үзүүлээгүй тул Шуй ахын хүнд нударганаас эсэн мэнд зайлж чадав.

Энэ үед Жинь Кан Лу өөртөө дарс хундагалан уухын зуур тэдний тулааныг эс тоосон шинжтэй байлаа.

Шуй ах И Да Зинг цохисон эрчиндээ урагш бүдрэн гараа далайсан чигээрээ Жинь Кан Лунг чиглэн ирэв. Тэрээр биеэ татаж авч чадалгүй түүний улаан нүүрэн дундуур татаад авах чигтэй болоход Жинь Кан Лун огт тоосон шинжгүй архиа ууж суух зуур ханцуйгаа ялимгүй сэгсэртэл хүчит

салхи үүсэн Шуй ахын хүчийг сааруулж арагш арваад алхам ухран зогсоод өөрийн эрхгүй амьсгаадан байлаа.

Шуй Да Юнь шавь нь И Да Зинг дийлэхгүй байгааг хараад тэсэртлээ уурлан <<Зулбасага минь чи аль замын хүн болоод манай усан махбодын бүлгийн гол хайсанг аймшиггүй үймүүлнэ вэ>> гэлээ.

Тэрээр ийн өгүүлээд И Да Зингийн зүг ухасхийтэл Жинь Кан Лун суудлаасаа өмнөө байсан савхыг авч түүн рүү шидвээс амин цэгийг нь онилон хүрч ирэв. Шуй Да Юнь түүнээс бултан алхаагаа сааруулаад уурсан <<Жинь баатраа энэ чинь юу болж байгаа хэрэг билээ?>> гэв.

Жинь Кан Лун тас тас инээд алдан <<Шуй дүү их үер лусын хааны ордныг тойрдоггүй гэсэн мэргэн үг сонссон уу. Чи энэ мэргэн дүүгийн хэн болохыг мэдэхгүй байна гэж үү>> гэлээ.

Шуй Да Юнь Жинь Кан Лунг мэлмэрэн харав.

<<Манай энэ И Да Зин дүү чинь мөрөн гол даяар номч баатар гэж алдаршаад байгаа шүү дээ>> хэмээн Жинь Кан Лун хэлэв.

<<Жинь баатар мөн айхтар хүн юм даа. Өөртэй нь огт нүүр тулгаран учирч байгаагүй атал түүний байр байдлаас өөрийг нь таньчихдаг байна шүү>> хэмээн И Да Зин сэтгэлдээ сэрхийтэл бодож амжив. Тэгээд алга хавсран бөхөлзөж <<Жинь баатраа Шуй баатраа эрхэм сайн эрчүүдээ мөхөс И Да Зин би анх удаа мөрөн голоор мөрөө гаргаж байгаа хүн тул та бүхэн дэмжиж тусалж байхыг хичээнгүйлэн хүсье. Харин номч баатар гэдэг нэрийн тухайд бол надад ахадсан алдар тул нүүр хийх газар алга байна>> гэлээ.

<<Номч баатар И та юунд ийм даруу зан гаргана вэ. Шороон махбодийн толгойлогч Ту Ди Хан чиний гурван арга мэхийг аргалж чадалгүй толгойлогчийн сууриа өөрт чинь алдсан гэдгийг мөрөн гол даяараа дээр дооргүй шуугицгааж байна. Өвгөн би ч тэдний нэгэн адил гүйцэгдэшгүй хүч чадлыг чинь бахдаж байгаа билээ>> гэж Жинь Кан Лун хэлэв.

<<Яалаа гэнэ ээ. Шороон махбодийн толгоойлогч тэгээд энэ хүүхэд болсон юм гэж үү>> хэмээн Шуй Да Юн гайхан асуув. Усан махбодийн бүлэг мөрний өмнөд нутагт байдаг тул хэдэн мянган газрын алсад байх шороон махбодийн бүлгийн тухай тэрээр одоо болтол сонсож мэдээгүй билээ. Харин Жу Сян Зюнь модон махбодийн бүлгийн толгойлогч болсон тухай олон сарын өмнө болсон хэрэг явдал тул сонсож мэдсэн байлаа. Жинь Кан Лун толгой дохин <<Мөрөн гол даяар нэг бүлгийг байгуулах амархан харин олноос онцгой баатар эр төрөн гарна гэдэг хэцүү. Гэтэл шороон махбодийн бүлэг надаас өрсөн И номч баатрыг олж авсан нь харамсалтай хэрэг.

Хөгшин би олон жилийн турш шинэ бүлгийн толгойлогч болгох хүнийг эрж хайж явсан юмсан. Гэтэл учрал тохиол гэдэг хүний санаагаар болдоггүй эд ажээ. Манай бүлэгт сайн шавь нар олон боловч номч баатар Игийн гуравны нэгийн чадлыг авсан хүн байх ахул өвгөн би санаа амар нүд анихсан>> гэлээ.

Ийн өгүүлээд их л гутрангуй нулимс унагаах шахан суулаа.

<<Жинь баатар таны урамтай үг учиртай санаанд баярлан хөөрөвч баршгүй. Өвгөн баатар таны алдар нэр үүлэн цацаг хүртэл мандаж мөрөн гол даяарыг доргиож байгаад чинь мөхөс би гайхан шагшиж явдаг нэгэн билээ>> хэмээн И Да Зин хэллээ.

<<Эрхэм та үнэхээр шороон махбодийн бүлгийн толгойлогч болсон юм биз дээ>> гэж Шуй Да Юнь түүнээс асуулаа.

<<Мөхөс би урьдны толгойлогч Ту Ди Ханы эндүү хайрын ачаар 5 махбодийн бүлгийн толгойлогчдын адагт суух аз завшаан тохиосон юм. Над шиг хүнд ахадсан суудал бололтой юмаа>> гэж И Да Зин хэлэв.

Шуй Да Юнь хүйтнээр <<Эртнээс нааш 5 махбодийн бүлгийн толгойлогчид нэгэн биеийн гар хөл нэгэн айлын ах дүү мэт эвтэй найртай явж ирсэнсэн. И толгойлогч таны үеэс эхлэн энэ байдал өөрчлөгдөх нь шиг байна даа>> гэлээ.

<<Шуй баатар та ямар утгаар энэ үгсийг хэлнэ вэ. Би сайн ойлгосонгүй>> гэж И Да Зин асуув.

<<Ойлгохгүй гэнээ. Тэгвэл И толгойлогч та яахаараа зүсээ нууж зүрхээ будаад шороон махбодийнхоо нэр сүрийг ч хайрлалгүй доош орж Зян Жоу отгийнхонтой нөхөрлөн тэдний талын хүн болж манай хайсанд шургалан орж ирдэг билээ. Түүний далд санаа юу вэ?>> гэж Шуй Да Юнь асуув.

<<Танай хайсанд дураар орж ирсэндээ мөхөс би хэлтрүүлэхийг гуйя. Харин үүний жинхэнэ учир их л төвөгтэй тул Шуй баатар та намайг өршөөн соёрхох ажаамуу>> гэж И Да Зин хэллээ.

<<Би угаас бүдүүн хадуун хүн. Чамтай ном хаялцаж байх ухаанаар мөхөс. Чи манай бүлэгтэй ямар муу учиртай болоод ийн зориглон халдсанаа шулуухан хэлээдэх>> гэж Шуй Да Юнь өгүүлэв.

И Да Зин Шуй Да Юньтэй тэрсэлдэн тэмцэхийг бодоогүй тул <<Шуй баатар та буруугаар ойлгосон байна. Би сая танай хайсанд ирдгийн учир нарийн төвөгтэй гэдэг санаагаа цухуйлгасан. Харин та бүгдтэй өс санан мэс

өвөрлөн ирээгүй гэдгийг санаарай. Би энэ удаа та бүгдээс нэг хүнийг сураглахаар ирсэн юм>> гэж хэлэв.

<<Ямар хүнийг сураглах гэж ирсэн билээ>> гэж Шуй Да Юнь асуулаа.

<<Танай усан махбодийн бүлэг мөрний өмнөд нутагт хэлхээ холбоо ихтэй улс. Тийм болохоор журамт бүсгүй Жу Сян Зюний сураг чимээг сонсоогүй биз дээ>> гэв.

<<Жу Сян Зюнь гэнэ ээ>> хэмээн Шуй Да Юнь хэсэг гайхан алмайрснаа тас тас инээд алдан <<Аа би одоо л ойлголоо. И толгойлогч таны хэлээд байсан нөгөө эхнэр гэдэг чинь тэр бяцхан шулам байсан юмуу. И толгойлогч та ариун номчийн нэрийг хүртчихээд ар хударгаар нь ийм булай үйл эрхэлж шулам бүсгүйтэй ёсгүй бүхнийг хийж байдаг байх нь ээ. Ёстой ичгэвтэр хэрэг>> гэж хэллээ.

И Да Зингийн нүүр улайж <<Шуй баатраа та намайг яаж гутаах чинь хамаагүй хэрэг. Би мөрөн голынхонтой тэрсэлдэж тэмцэх санаагүй тул нэр төрөө яаж ч хөөдсөн хамаагүй хэрэг. Харин миний Сян дүү бол амьсгал ч хүрээгүй алаг цэцэг шиг ариухан бүсгүй юм шүү. Хэрвээ чи түүнийг гутаасан байх юм бол би хэдийгээр чиний энд хүрэхгүй ч гэсэн амь хайрлахгүй тулалдах болно гэдгээ хэлчихье>> гэв.

Шуй Да Юнь ч тулалдахаар зэхэж <<Алив алив хоёулаа гурван зуун удаа тулалдсан ч хамаагүй хэн нь илүү гэдгээ үзэцгээе>> гэлээ.

<<Шуй дүү минь байзаарай. Манай 5 махбодийн бүлэг угаас нэгэн биеийн 5 эрхтэн мэт эвтэй найртай явж ирсэн бус уу. Хүн өөрөө өөртэйгөө тулалдаж болдог билүү. И номч баатар журамт бүсгүй Жу хоёр нэгэнт шороон махбодь, модон махбодийн бүлгийн толгойлогч болсон болохоор би бид бүхэн адилхан анд нөхөд ахан дүүс гэсэн үг шүү дээ. Хэрэв өөр хоорондоо алалцаад эхэлвэл сөргүү хулгай шулмын бүлгийнхэн биднийг юу гэж үзэх вэ>> хэмээн Жинь Кан Лун өгүүлэв.

Шуй Да Юнь хүйтнээр инээж <<Сөргүү хулгай шулмын бүлэг гэнэ ээ. Тэр Жу Сян Зюнь чинь шулмын бүлгийн хүн гэдгийг мөрөн гол даяар мэдэхгүй хүн байхгүй шүү дээ. Гэтэл тэр манай модон махбодийн бүлгийн толгойлогч болчихдог байна шүү. Энэ И овогт ч гэсэн шуламтай орооцолдсон болохоор ямар олигтой амьтан байж таарах вэ. гэсэн атлаа бас л манай шороон махбодийн бүлгийн толгойлогч болчихдог. Жинь баатраа хэрвээ бид өөрсдийгөө сөргүү хулгайгаас цэвэрлэхгүй бол ямар нүүрээрээ мөрөн гол даяар мөрөө гаргаж явах болж байна вэ>> гэв.

Жинь Кан Лун <<5 махбодийн бүлгүүд өөр өөрийн гэсэн эзэнтэй. Тийм болохоор бид хоёр хамаа бусаар бусдын хэрэгт хутгалдаж яахин болох вэ. Тэгээд ч ганц хүн хичнээн их чадал тэнхээтэй байлаа гэсэн нэг бүлгийг өөрчлөх хэцүү. Харин нэг бүлгийнхэн нэгдээд нэг хүнийг өөрчлөнө гэвэл амар хэрэг шүү>> гэв.

<<Жинь баатраа хэрвээ та өнөөдөр миний үгийг итгэхгүй бол хожим харамсавч баршгүй гай барцдад унана даа>> хэмээн Шуй Да Юнь өгүүлэв.

Жинь Кан Лун санаа алдаад <<Шуй дүү минь ч нэгэн өдрийн сэтгэлийн үүдлээс өстөн болсон хүн чинь багадаад байна гэж үү?>> хэмээн асуулаа.

И Да Зин Шуй Да Юньтэй олон таван үг хэлэлцэж суух завгүй байсан тул мэхэсхийн ёслоод <<Мөхөс би журамт бүсгүй Жугийн төлөө ирсэн билээ. Хэрвээ алдаа эндэл гарсан ахул уучилж хэлтрүүлэх буй за. Та бүхэн түүний сураг ажгийг мэдэж байвал надад хэлж айлдваас баярлах болно. Хэрвээ дуулж мэдээгүй бол би ингээд явъя даа>> гэлээ.

Жинь Кан Лун босож ирээд <<И дүү бид нэгэнт энэ газар хүрч ирчихээд Шуй дүүгийн хуримын идээнээс амсахгүй байх нь хаанахын ёсон билээ. Манай И дүү чинь жаахан яаруу сандруу хүн үү дээ>> гэлээ.

Шуй Да Юнь <<Завь бэлтгээд зочныг үдэн гарга>> хэмээн хашгиртал И Да Зин <<Хэрэггүй ээ. Би хэдийгээр Зян Жоу бүлгийнхэнтэй найз нөхдийн харилцаагүй боловч нэгэн завиар ирсэн билээ. Юань ахлагч нэгэнт таны баатар сүрийн дор амь алдсан боловч түүний гарын доорхи хэдэн шавийг өгөөмөр гараа сунган тавьж явуулбал ямар вэ>> хэмээн хэлэв.

<<Та бүхэн хараа биз дээ. Манай шороон махбодийн бүлгийн шинэ толгойлогч номч баатар И хувилгаан бодиства мэт өгөөмөр сэтгэлтэйн улмаас сөргүү хулгайн бүлгийгхнийг ч өөрийн хүн мэт үздэг байх нь ээ>> гэж Шуй Да Юнь өгүүлэв.

<<Хувилгаан бодиства мэт өгөөмөр сэтгэлтэй байхын муу нь юу билээ. Шуй дүү минь зарим үед уучлах газраа уучилж өршөөх газраа өршөөж байх хэрэгтэй байдаг юм даа. Хулгайн толгойлогч нэгэнт амиа алдсан тул үлдсэн хүмүүсийг нь өршөөн явуулбал яасан юм бэ>> гэж Жинь Кан Лун хэллээ.

Жинь Кан Лун 5 махбодийн бүлгийнхэн дотроо хамгийн их нэр нөлөөтэй нь болох тул хэдийгээр сая зөвлөсөн өнгө аясаар хэлээгүй боловч Шуй Да Юнь түүнийг нь дагахаас өөр аргагүй блжээ. Түүний дээр Зян Жоу отгийн хэдэн шавь нарыг бүгдийг нь алалтай биш яая даа гэж бодож байтал

ашгүй түүний ингэж ам ангайсан дээр нь шүүрэн аваад Шуй Да Юнь <<Хурдан тонилцгоохгүй юугаа хийсэн юм бэ. Дахин манай усан махбодийн бүлгийхний гарт орвол уу. Сайхан мэдээрэй>> гэлээ. Ийн хэлэхдээ И Да Зинг ч мөн дайруулж байгааг тэрээр сайтар ойлголоо.

И Да Зин дотроо ихэд хорссон боловч царайдаа түүнийгээ харуулсангүй. Тэр одоо Жу Сян Зюнийг олох явдал чухал байлаа. Тийм учраас Жинь Кан Лунгийн зүг мэхэсхийн ёсолж <<Жинь баатраа мөхс би явъя даа>> гэлээ. Тэгснээ мөн Шуй Да Юньгийн зүг хандаж

<<Замын хүзүү урт зааны хүзүү богино гэдэг. Дараа дахин уулзана биз дээ>> гэлээ. Шуй Да Юнь түүнээс нүүр буруулж дахин түүнийг тоож ч харсангүй амандаа <<Хн>> гэж үл тоосон байдалтай дуугарлаа.

Зян Жоу отгийн шавь нар багшийнхаа хүүрийг өргөн бяцхан завь руугаа зүглэлээ. И Да Зинь завиний хошуун дээр цэнхэр алчуур цагаан дээл өмсөн зогсох нь их л омог төгөлдөр харагдана. Зян Жоу отгийнхон барын амнаас мултараад хоёрхон гартай төрүүлсэн ээж аавдаа бухимдан ухаан зулаггүй сэлүүрдэцгээнэ. Удаж төдөлгүй тэд эрэг дээр тулан очиж голын эргийн шагшуурган дундуур цаашаа зүглэлээ. Одоо усан махбодийн бүлгийнхэн араас нэхэн ирлээ ч гэсэн энэ шагшуурган дунд тэдний нүсэр том онгоц урагшаа явахгүй нь ойлгомжтой байлаа.

Зян Жоу отгийнхон бол мөрөн голын хамгийн өчүүхэн отгийн нэг бөгөөд 45-хан гишүүнтэй ажээ. Тэдгээр нь зэвсгийн эрдэм чадлаар маруухан дөнгөж данган амиа аргацаасан хулгайн арилжаа наймаа эрхлэхийн зэрэгцээ албаны мөрдөгч түшмэлээс айна гэж учиргүй. Албаны цэргүүд мөрдөгч түшмэлүүд усан махбодийн бүлэг мэт том гаруудыг өрөөсөн нүдээ аниад өнгөрөөдөг атлаа Зян Жоу мэтийн багш шиг отгуудад их л дээрэнгүй ханддаг байв. Түүнчлэн том бүлгүүд тэднийг бруу номынхон гэж үзэх тул дээрээс нь дарамтлах нь их юм. Түүний дээр жижиг отгуудын хоорондын өрсөлдөөн тэмцэлдээн их болохоор тэдний амьдрал хичнээн хүнд бэрх байдаг нь ойлгомжтой.

Гэвч жижиг отгууд амиа аргалах талаар бас чиг гэж гаргуун. Тэд хоргодох газраа бусдаас нууцгай сонгож авдаг байв. Хэрвээ гадны хүмүүс тэдний хоргодсон энэ шагшуурган дундаас тэднийг олно гэдэг төөрдөг байшинд зүгээ олохоос ч амаргүй хэрэг юм.

Тэд И Да Зинг шагшуурган дундах нэгэн овоохойд оруулаад хоймор залан суулгаж бүгдээр сөгдөн мөргөлөө. И Да Зин түүнийг үзээд ихэд гайхан асууруун <<Эрхэмүүд юу болоод ингэж ёсорхоно вэ>> гэхэд олон бүгдээр

<<Зян Жоу отог их баатар эр таны гар сунган тусалснаар ийн аврагдлаа. Та бидний өчүүхэн амийг аварсан тул ийн сөгдөн мөргөх ч багадах учиртай билээ>> гэцгээв.

Энэ өдөр усан махбодийн бүлэг рүү хамт очсон дөрвөн хүн энэ отогтоо бас чиг гэж багагүй хэргэм зэрэгтэй улс байсан бололтой. Тиймд усан махбодийн бүлгийнхэн тэднийг толгой дараалан хядахгүй ч гэсэн хөл гарыг нь хугалж зэвсгийн эрдмийг нь эвдлээд буцаахгүй гэх газаргүй байсан юм. Хэрвээ хамаг байдаг удирдагчдаа алдчихвал Зян Жоу отгийнхон хэрхэн өөд нар харж явах билээ дээ. Тэгээд ч эдгээр хүмүүс урьд өмнө ганцаар явахдаа хүн алж хулгай дээрэм хийн багагүй өстөнтэй болсон тул аль нэг отог бүлгийг бараадан эс явбаас толгой хоргодох газар олдохгүй болох юм.

Тийм болохоор И Да Зин санамсаргүй тэдний хэдэн толгойлогчийг аварсан нь тэдний нийт бүлгийг аварсантай адилхан хэрэг болоод байв. Иймд тэд яахин эс баярлах билээ дээ.

Тэгээд мөнөөх дөрвийн нэг нь найрын ширээ засуулж И Да Зинг цайлахаар зэхэцгээв. Тэдний бэлдсэн идээ ундаа нь ихэвчлэн усны гаралтай хавч загас тэргүүтэн байх бөгөөд архи нь хэдийгээр тааруухан боловч бас ууж болохоор эд байлаа. Бүлгийн гишүүд тал талаас хүндэтгэлийн хундага өргөсөөр И Да Зин хэдийгээр архи сайн даадаг боловч шөнө дөл болохын хэрд нилээд согтсоноо мэдлээ.

Ийн ууцгааж байх зуур нэгэн толгойлогч нь нүдээ ирмэтэл бусад шавь нар дагалдан газар сөгдөцгөөж нэгэн дуугаар <<Баатар та дахин ач энэрлээ хайрлан биднийг ивгээлдээ багтаан соёрх>> гэцгээв.

<<Та нар чинь юу болцгоов. Санаж бодсон үг байвал хэлцэж бололгүй яахав. Заавал сөгдөн мөргөхийн хэрэг юун>> хэмээн асуухад олон бүгдээр <<И баатар та бидний хүсэлтийг зөвшөөрөхөөс нааш бид ийн сөгдсөөр байх болно>> гэхэд И Да Зин <<Та нар чухам юу хүсээ вэ?>> гэлээ. Бүлгийн олон бүгдээр <<Хэрвээ та манай бүлгийг авран нигүүлсэхээ илэрхийлбэл бид хэлж болох юм>> гэлээ.

<<Надад та нарыг авран нигүүлсэх ямар арга чарга байх билээ дээ. Гэвч та нар босоцгоо. Би хүн алах хүрээ талахаас бусдыг бол юу ч байсан зөвшөөрнө. Би төрөлхийн цөс нимгэн цус шингэн хүн>> гэлээ.

Отгийн гишүүд бүгдээр баярлан босож <<Сая Жинь баатар таныг мөрөн гол даяар номч баатар гэж өргөмжилдөг болсныг бид дуулсан билээ. Бид чинь хэн болоод номч баатар таныхаа баримталдаг сахил цээрийгэвдүүлж дийлэх билээ>> гэцгээв.

И Да Зин өгүүлрүүн <<Бид бас чиг гэж сайн мууг хамтдаа туулцгаалаа. Тийм болохоор та бүхэнд ямар хүсэлт байгаагаа хэлж болох юм>> гэв.

Тэдний толгойлогчдын нэг нь ам нээн <<Ёсын дагуу өгүүлэх аваас бид үхсэн хүний буруу зөрүүг шүүн хэлэлцэх учиргүй л дээ. Гэвч өнөөдрийн явдалд манай Юань ахлагчийн зохих буруу байгаа юм. Бид тайван амьдралаа бусниулж усан махбодийн бүлэгтэй ийн өс зангидах хэрэг уг нь байхгүй л дээ. Өөрөө өөрсдийн толгой руугаа ус хийж байгаа хэрэг>> гэлээ.

<<Уг нь тийм л баймаар юм. Би ч гэсэн энэ хэргийг гайхаад байсан юм>> гэлээ.

Өөр нэгэн толгойлогч өгүүлрүүн <<Хэргийн жинхэнэ эзэн хэнгэргийн дохиур гэвэл Шуй ах байгаа юм л даа. Тэр л эртнээс нааш эвийг нь олж хэвийг нь тааруулж байгаад өөрийн багш Шуй Да Юний суурийг эзлэх санаа агуулж байсан юм. Гэвч зэвсгийн эрдмийн ертөнцөд багшийгаа дээдлэх үзэл ноёлж байгаа болохоор багшийгаа хөнөөчихвөл гишгэх газар байхгүй болохтой адилхан хэрэг билээ. Өөрийн хүмүүсийг элсүүллээ гэхэд тэд нь багшдаа хов хүргэчихэж мэднэ. Яг ийм эгзэгтэй үед Шуй Да Юнь хаанаасаа ч юм бэ тэр нэг хүүхнийг олоод ирсэн байна. Түүнийг нь ашиглах санаа төрөөд Шуй ах манай отгийн ахлагчийг элсүүлж л дээ. Ахлагч маань ойроын ашиг харж түүний үгэнд ороод эцэс сүүлд нь ийм гай хөөд учрах нь энэ. Ай хөөрхий>> гэлээ.

<<Тэр Шуй ах гэдэг чинь үнэхээр дүүрсэн дотортой эр юм. Та нар яахаараа түүнийг багшид нь илчлээд оноох шийтгэлийг үүрүүлж очих газар руу нь явуулаагүй юм бэ>> гэж И Да Зин асуулаа.

Мөнөөх хүн хүйтнээр инээд алдан <<Шуй Да Юнь тэр хоёр адилхан өөдгүй улс даа>> гэж хэлэв.

<<Миний бодоход Шуй Да Юнь жаахан бүдүүн хадуундуу боловч бас чиг шударга замын хүн шиг санагдсан шүү>> гэж И Да Зин өгүүллээ.

<<Шударга замын хүн гэнээ. Номч баатраа Шуй ах яагаад та нар руу халдан довтлох болсны учрыг та мэдэж байна уу>> гэж мөнөөх толгойлогч асуулаа.

<<Би гэнэт үг алдан юм хэлэхээр л өөрийнх нь булхайг илчилнэ гэж айсан болов уу>> гэж И Да Зинг хэлэхэд нөгөө хүн <<Тэгвэл Шуй Да Юнь яагаад манай багшийг алсны учрыг мэдсэн үү>> гэлээ.

И Да Зин хэсэг зуур бодсоноо учрыг эс олж <<Уурандаа багтраад алдаж цохисондоо амь насанд нь хүрсэн байж мэдэх юм. Тэгэхдээ тэр Юань

ахлагчийг алдаг нь тусгүй хэрэг болсон юм. Хэрвээ тэр үхээгүй айсан бол хамаг үнэнийг илчилж өөрт нь нүүрлэх байсан гай барцад багасах байсан даа>> гэлээ.

<<Номч баатар та аргагүй л номын хүн юм. Ертөнцийн бузар булайг ерөөсөө гадарладаггүй юм байна. Шуй Да Юнь Шуй ахын адилаар хүн алж амьд баримтаа устгаж байгаа нь тэр шүү дээ>> гэж нөгөө толгойлогч хэлэв.

И Да Зин ихэд гайхширан <<Юань ахлагч түүнийг хүний эхнэр булаан авч хүчээр гэрлэх гэж байгаа хэмээн гүтгэснийг нь суух гэж байгаа хүүхэн нь няцаасан шүү дээ. Гэтэл яахаараа заавал түүнийг алдаг билээ>> гэхэд нөгөө хүмүүн хариу хэлэх гэтэл И Да Зин <<Ёо ёо>> хэмээн уулга алдан түүний яриаг таслав. И Да Зин Шуй ахтай тулалдаж байхад хэн нэгний харвасан нууц зэвсэг нойрсуулагч цэг дээр оносныг та бүхэн санаж байгаа байх. Гэтэл сая түүнийг болгоомжгүй хөдөлтөл мөнөөх биед нь үлдсэн нууц зэвсэг түүний махыг өвдтөл хатгасан ажээ. Тэрээр зул барин эрж хайсаар мөнөөх нууц зэвсгийг олж үзвэл нэгэн алтан зүү байлаа.

Зян Жоу отгийнхон хэдийгээр зэвсгийн эрдэмдээ маруухан боловч цэг дарах аргын тухай эрхбиш мэдэлгүй яахав. И Да Зингийн нойрсуулагч цэг дээр алтан зүү хатгасан байхад юу ч болоогүй мэт явахыг үзээд хувилгаан хүнтэй учирсан мэт амаа ангайн алмайрцгаалаа.

И Да Зин мөнөөх алтан зүүг алган дээрээ тавьж <<Хачин юмдаа. Шуй ахтай тулалдаж байхад Шуй Да Юнь Юань ахлагчтай үзэлцээд наашаа харах сөхөөгүй байсан байж таарна. Тэгэхээр түүний урьж ирүүлсэн зэвсгийн эрдмийн нэрт баатруудаас өөр хэн над руу үүнийг харваж чадах билээ>> хэмээн бодов. Гэвч И Да Зин Жинь Кан Лунгийн адилаар өрсөлдөгчдөө нэг хараад ямар учиртайг нь таньж чадахгүй тул удтал бодсоны эцэст хариу гаргаж чадсангүй. Энэ үед тэрээр <<Хэрвээ Сян дүү минь байсан бол ч хичнээн олон дайсан байгаад ямар муу арга хэрэглэснийг ганц хараад мэдэх байсандаа. Сян дүү минь, Сян дүү минь чи минь хаан байна даа>> гэж бодлоо.

Зян Жоу отгийнхон И Да Зин нэгэн алтан зүүг барьсаар ийн удтал гөлрөн суухыг харж <<Адгийн амьтан бас нууц зэвсэг хэрэглэдэг байна шүү. Номч баатар таны эрдэм чадлаар тэр хүнээс өшөөгөө авахад юухан байхав даа>> гэлээ.

И Да Зин өгүүлрүүн <<Тиймээ. Сая та нар надад Шуй Да Юнь танай ахлагчийг алдаг нь цаанаа учиртай гэж хэлж байсан шүү дээ. Түүнийгээ цааш нь залгуулаад хэлээч>> гэлээ.

Мөнөөх толгойлогч өгүүлрүүн <<И баатар та манай ахлагч үхэхээсээ өмнө тэр хүүхний хэлсэн <<Наадхыгаа найман хэсэг тасчиж хаяад лусын хааных руу илгээчихвэл барав биш үү...>> гэсэн үгийг хэдэнтээ давтсаныг санаж байгаа биз дээ. Тэгснээ манай багш гэнэт <<Тэр мөн байна. Яг мөн байна>> гэж хашгирсан байхаа. Тэр хэнийг мөн байна гэж хашгирсан хэрэг байх вэ. Шуй Да Юнь яахаараа түүний үгийг дуустал хэлүүлэлгүй хөнөөсөн хэрэг вэ. Үүнийг тухайн үедээ тэнд байгсад гадарлаагүй байх. Харин жинхэнэ учрыг нь Тун Тянь Янь би мэдэж байсан юм. И баатраа тань шиг шороон махбодийн бүлгийн суурин дээр заларч байгаа их хүн бид мэтийн жижиг отгийхний зовлонг яаж ч ойлгох билээ дээ. Туулай үүрнийхээ орчмын өвсийг иддэггүй гэдэгчилэн бид ч бас энэ хавьдаа ямар нэгэн хэрэг төвөг гарахаас ихээхэн цээрлэдэг юм. Учир нь элдэв хэрэг төвөг гарчихвал албаны цэрэг мөрдөгч түшмэл зэрэг нь эхлээд л тэр хавьдаа байгаа муу нэртэй луу данстай улсыг л юуны түрүүнд санах нь ойлгомжтой шүү дээ. Бид тэр хэргийг хийгээгүй байлаа ч гэсэн нэртэй сүртэй мөнгөтэй төгрөгтэй улсыг мөрдөгч түшмэдүүд тоохгүй бид мэтийгээ л ороогоод байх нь тэр.

Барагцаалбал таван хоногийн өмнө байхаа. Манай эндхийн тэргүүн баян Жао овогт бусдад алуулаад 8 хэсэг огтлогдон мөрөнд хаягдсан байсныг загасчин өвгөн тор хаяж яваад олжээ. Жао баян бол манай эндээ л нэр сүртэй албаны цэрэг болоод мөрөн голынхны аль алинд тал алддаггүй айхтар хүн байсан юм. Тийм хүнийг алчихсан байхад яам тамгынхан яахин зүгээр орхих билээ дээ. Манай ахлагч надад энэ хэргийг мөрдөн чадвал алуурчныг ядвал ямар нэгэн сэжим олоодох гэж даалгасан юм. Тэгснээр хожим албаны түшмэдүүд бидэн дээр хүрч ирвэл хэлэх юмтай байя гэж бодоо бизээ.

Тэр шөнө тас харанхуй сунгасан гар ч харагдахааргүй байлаа. Би ахлагчийн тушаалыг авч шөнийн өмсгөлөө өмсөөд Жао овогтын гэрийн гадаа хүрлээ л дээ. Хонхыг чимээ гаргалгүй тайлахын тулд хонх уясан хүн дээр эхэлж оч гэсэн зүйр үг байдаг шүү дээ.

Би арын хашааг нь дагаж явсаар Жао баяны унтлагын өрөөнд хүрлээ. Өрөөнд маш бүдэгхэн зул асааж дотор нь эрэгтэй эмэгтэй хоёр хүн ярилцах сонсогдоно. <<Өөдгүй амьтан минь чи тэгээд намайг гэргийгээ болгон авах юмуу? Үгүй юу?>> гэж эмэгтэйгээ хэлэхэд эрэгтэй нь <<Би чамтай суухгүй болоод л ийм хэрэг хийж байх уу даа. Чиний нөхөр үхээд тав хоноогүй байхад чи бид хоёр суучих юм бол улс амьтан ч юу гэх юм билээ. Тэгж байгаад хүн хард мэдэгдчихвэл ямар сайн байх вэ>> гэхэд эмэгтэй нь

хүйтнээр инээн <<Би чамайг чинь овоо эр юм гэж бодож байсан чинь хулчгар амьтан байсан юмуу>> гэлээ. Мөнөөх эрэгтэй <<Би хулчгардаа л танай нөхөр Жао овогтыг чинь найман хэсэг цавчин лусын хааных руу илгээхүү дээ>> гэхэд би утасны үзүүрээс барьж авсанаа мэдэж хэлээрээ цонхны цаасыг долоон цоолоод хэн болохыг нь харах гэтэл өчүүхэн чимээ гарган шажигнуулчихав. Гэтэл өрөөний дотроос ямар нэгэн нууц зэвсэг нисэн ирэх чимээнээр би сандран доош нуугдтал хаалга сэвхийтэл онгойн хар өмсгөл хар баг өмссөн хүн намайг чиглэн ирлээ. Тэр хүний зэвсгийн эрдмийг үзвэл би хаана нь ч хүрэхгүй нь ойлгомжтой тул шөнийн харанхуйг далимдуулан зугатаад түүний гараас мултарч амжсан юм даа гэлээ.

<<Тэгээд тэр чинь хэн байсан юм бэ?>> гэж И Да Зинг гайхан асуухад Тун Тянь Янь толгой сэгсрэн <<Түүний царайг харж амжаагүй. Гэвч буцаж ирээд энэ болсон явдлыг ахлагчид нэгд нэгэнгүй хэлсэн билээ. Гэтэл өнөөдөр тэр хүүхэн усан махбодийн бүлгийн ахлагчид <<Наадхаа найман хэсэг цавчиж орхиод лусын хааных руу явуулчих>> гэж хэлэхийг сонсоо биз дээ. Манай ахлагч түүний хэлэхийг сонсоод тэр шөнийн явдлыг гэнэт санасан байх л даа. Тэгээд л <<Тэр мөн байна. >> гэж орилсон хэрэг байж таарна.

И Да Зин багаасаа шударга журам ёс суртахууны чиглэлийн ном судрын нөлөөнд автсан хүн тул угаас зэвсгийн эрдмийн ертөнцийн шударга замынхныг хүндэтгэн үзэж буруу замынхныг жигшин зэвүүцдэг байсан билээ. Гэтэл өнөөдрийн Тун Тянь Яний ярьсан нүдээр үзсэнтэй нь таарч байх тул итгэхээс өөр аргагүй байдалд хүрч <<Усан махбодийн толгойлогч яахаараа ийм өөдгүй хэрэг өдөөж чаддаг байна вэ>> гэв.

<<Тэгвэл тэр яагаад Юань ахлагчийн үгийг гүйцэд сонсолгүй алчихаж байгаа юм бэ. Шударга журамтай гэж хүн бүхэн л хэлж чадна. Харин хэрэгжүүлж чаддаг нь хэд байх болдоо. Нэгэнт энэ хэргийг би мэдэж байгаагаас хойш тэр завхай эр садар эмийн булайг илчилж отгийн ахлагчийнхаа өшөөг авахдаа л авна>> гэж Тун Тянь Янь хэллээ.

Тун Тянь Янь хэдийгээр зэвсгийн эрдэмдээ маруухан боловч ухаантай сэргэлэн хүн байх тул И Да Зин өгүүлрүүн <<Манай Зян Жоугийн отогт Тун Тянь Янь ах мэт ухаалаг хүн олон бол мөрөн гол даяар нэр сүрээ бадруулахад юухан байхав. Цугаараа дахин гурван хундага тогтоож Зян Жоу отгоо мандуулахын төлөө санаа зоригоо нэгтэцгээе >> гэв.

Тун Тянь Янь түүнийг дагалдан гурван хундага тогтоогоод өгүүлрүүн <<И баатраа Тун Тянь Янь миний Зян Жоу отгийг мандаан бадраана гэж юу

байхав. Харин таны хүчинд дулдуйдвал ч тийм боломж гарч мэдэх юм>> гэлээ. Хэдийгээр энэ хүмүүс буруу замаар орсон боловч хүний мөсөөр гайгүй нөхөрлөж болмоор санагдсаны дээр архины халуунд халамцаж <<Хэрвээ та бүхэнд миний хэрэг гардаг юм бол би амь насаа алдахаас ч буцах юм алга>> гэлээ.

Тун Тянь Янь ухасхийн босоод <<Отгийн ахлагчийн хишигт мөргөө>> гэлээ.

Бусад гишүүд ч гэсэн түүнийг дагалдан <<Отгийн ахлагчийн хишигт мөргөө>> гэв.

И Да Зин гайхаж <<Юун отгийн ахлагч вэ?>> хэмээн асуув.

<<Их хүмүүний үг уул мэт хүнд гэж эртний үгэнд бий. И номч баатар та бидний ямар ч хүсэлтийг үг дуугүй биелүүлнэ гэж ам гараагүй билүү. Түүнийгээ мартаагүй биз гэж найдна. Бид бүхэн цугаар таныг эндээ үлдэж манай отгийн ахлагч болохыг гуйж байна>> хэмээн Тун Тянь Янь тэргүүлэн өгүүлэв.

<<Би яахин чадах билээ. Би чадахгүй>> гэж И Да Зинг хэлэхд Тун Тянь Янь өгүүлрүүн <<Та шороон махбодийн бүлгийн толгойлогч хийгээд байгаа хүн яахин манай жижиг отгийг удирдаж чаддаггүй билээ. Арай манай отгийг дэндүү бага гэж басамжилаагүй бизээ. Эсвэл буруу замынх гэж цэрвээ юу>> гэж Тун Тянь Янь хэлэв.

<<Хаанаас даа гэхдээ л та бүхэн өөрийн отгийн ахлагчаар өөр хүнийг томилвол дээрсэн>> гэж И Да Зин хэллээ.

Тун Тянь Яний нүдэнд дургүйцэл тодрон <<И овогтоо чи тэгээд манай ахлагч болохгүй юм биз дээ>> гэхэд И Да Зин <<Би үнэхээр чадахгүй>> гэлээ.

Тун Тянь Янь ухасхийн чичлүүр хутгаа шүүрэн авч <<И овогтоо манай бүлэгт уг нь 47 хүн байсан юм. Ахлагч маань үхчихээд 46 хүн үлдлээ. Бид 46-уулаа чам руу дайраад ч яаж ч чадахгүй гэдгээ мэдэж байна. Гэвч бид тэр 5 махбодийн бүлэг болоод яамны түшмэдийн гарт үхэж байснаас чиний гарт үхсэн нь хавьгүй дээр гэж бодож байна>> гэв.

Үлдсэн дөчин хэдэн хүн бүгд хутгаа сугалан түүн рүү бүчин очоод <<И овогтоо чи хэрвээ бидний ахлагч болохгүй бол биднийг даруйхан алаадах>> гэлээ.

Ертөнцөд хачин сонин юм гэж мөн ч олон байх юм даа. Хэзээ отгийн ахлагчийг ийн сүрдүүлж байж болгодог ёсон хаана байсан юм бэ. И Да

Зингийн уур ч хүрэх шиг инээд ч хүрэх шиг болж <<За тайван сууцгаагаад ярилцая л даа. Ингэж сүр далайлгахын хэрэг юу байсан юм бэ>> гэлээ.

Тун Тянь Янь өгүүллрүүн <<Ярилцаад байх юм байхгүй. Чи манай ахлагч болох хүн үү үгүй юу. Хэрвээ зөвшөөрвөл бид чамд мөргөн сөгдөхөд бэлэн байна. Эс зөвшөөрвөөс бид чамайг алдаг бол алдагаа үзье алуулдаг бол алуулдгаа үзье>> гэв.

Хэдийгээр жаахан бүдүүн хадуундуу ч гэлээ үнэн сэтгэлээсээ өчиж байгааг нь мэдэрч И Да Зин их дуунаар <<За Зян Жоугийн отгийн 46 ах дүүс минь. И овогт би танай ахлагч болохыг зөвшөөрлөө>> гэв.

Отгийн олон гишүүд бүгд хөөр баяр бололдон гартаа барьсан чичлүүр хутгуудаа газар хаялаад нэгэн зэргээр сөгдөн мөргөж <<Отгийн ахлагчид мөргөө>> гэлээ.

И Да Зин энэ үед гэнэт тэнгэрт тэрслүү бүлгийн толгойлогч Дин И Жаог санаж өгүүллрүүн <<Шударга замын бүлгийнхэн манай Зян Жоу отгийг буруу замынх гэж хараан зүхэх нь их байдаг. Гэвч тэглээ гээд юм болох биш. Харин би энэ отгийн ахлагч болсон цагаас эхлэн манай отогт дээр дорын ялгаа байхгүй бөгөөд бүгд бие биесээ ах дүү мэт үзэн дуудацгааж байя. Би ямар дэлхий дахиныг ноёрхох хаан ширээг эзэлчихсэн биш ахлагч дордос зэрэг үгс лусын хааных руугаа тонилбол таарна>> гэлээ.

И Да Зин амьдралдаа анх удаа л ийнхүү хараал зүхэл урсгаж байгаа нь энэ билээ. Тэрээр хэдийгээр номын хүн боловч ийн шавайгаа ханатал хараал урсгасандаа бах нь ханаж эзгүй ууланд чармай нүцгэлчихээд дураар харайн гүйж авсан мэт санагдаж байлаа.

Тэгээд тэрээр Зян Жоугийн бүлгийн дөчин хэдэн ах дүүстэйгээ нохой гурав харагдтал ууж идсэнийг өгүүлэх юун. Мөнөөх жижиг урц нь тийм олон хүнийг багтаахгүй тул гадаа олон завийг баглан нийлүүлээд бүгдээрээ ахай эжий бололцон хутга тавилгүй мах идэж хундага тавилгүй архи ууцгаан бумбын ёсны сургаалтан И Да Зин анх удаа л эгэл хүмүүний жаргал гээч юу болохыг энэ бие дээрээ мэдэрсэн ажгуу.

Маргааш өдөр нь шинээр сонгогдсон ахлагч И Да Зин Тун Тянь Янь зэрэг бусад 4 хэргэмтнийг дуудан ирүүлээд хэлрүүн <<Би уг нь ахлагчийн албыг аваад хийх ажил мэдээжийн хэрэг олон боловч чухал ажил байгаагийн улмаас арван хэдэн хоног яваад ирэхгүй бол болохгүй боллоо. Бидний хийх нэн түрүүний хэрэг бол тэнгэрт хальсан ахлагчийнхаа өшөөг авах явдал. Усан махбодийн бүлэг нэр нөлөө ихтэй өшөө авах амаргүй боловч бид үүнийг зүгээр орхиж яасан ч болохгүй. Тийм болохоор намайг

байхгүй хойгуур та бүхэн сэтгэл хүчээ нэгтгэн Жао баяны үхсэний мөрөөр шалгаж завхай эр садар эмийн үнэн нүүр царайг тодруулах нь чухал>>.

Шинэ ахлагчийн ярьж хэлж байгаа бүхэн үнэн тул тэр дөрөв бүгдээр ам сэтгэл нэгдэж байв.

<<Надад бас өөр нэгэн ёсгүй хүсэлт байгааг та бүхэнд уламжилахыг зөвшөөрнө үү>> гэж И Да Зин хэллээ.

<<Ахлагч танд ямар хэрэг байгааг айлдан соёрхоно уу>> гэж Тун Тянь Янь хэллээ.

И Да Зин өгүүлрүүн <<Энэ хэрэг бол та бүхэнтэй холбоотой юм. Намайг явсны дараа та бүхэн урьдын муу үйл бүхнээ гээж номын дагуу явбал дээрсэн. Саргүй шөнөөр хүн алж салхитай шөнөөр гал тавьж явдаг нь тэнгэрийн ёсонд харш билээ>> гэвэл Тун Тянь Янь инээд алдаж <<Наадах чинь хэдийгээр хэцүү хэрэг боловч ахлагч та тушаасан тул яахин зөрчиж болох билээ. Гэвч бид хувиа хичээж хуулиа хүндлэн өөрсдийн уураа хөх мөрний загас жараахайд гаргаж явахыг хичээе дээ>> гэжээ.

И Да Зин ийнхүү арын ажлаа тэдэнд даатгачихаад эрэг дээр гарч Жу Сян Зюнийг эрэхээр умар зүгийг барин явлаа.

Ингэхдээ тэрээр Жу Сян Зюний хажуу дэргэдүүр гараад явчихсанаа мэдсэнгүй. Тэр өдөр усан махбодийн гол хайсангийн усан онгоцон дээр И Да Зингийн байсан бүхээгийн нэгэн буланд Жу Сян Зюнь баахан загасны торны дор хориотой байсан билээ.

Тэр нэгэн өдөр Жу Сян Зюнь И Да Зингийн архинд нойрсуулагч эм хольж унтуулчихаад туранхай илжигээ унан умрыг барин явсан юм.

И Да Зин угийн номын хүн болохоор тэр талаар даруйхан тааварлаж чадаагүй ажээ. Тэр тусмаа Жу Сян Зюнь түүнийг төөрөлдүүлэн боомт хүрч туранхай илжигээ тавьж явуулчихаад өөрөө нэгэн жижиг завь хөлсөлж урсгал уруудан хөвөх юм гэж яахин бодох билээ.

Өст хүн өлийн даваан дээр гэж мөнөөх завины эзэн усан махбодийн бүлгийн хүн байсан байна. Жу Сян Зюнийг ардаа илд зүүж гартаа арга билгийн муна бариад явахад яахин эс сэжиглэх билээ дээ.

Тэрээр урьд нь Жу Сян Зюнийг зэвсгийн эрдмээр гоц гойд гэдгийг дуулсан тул өөрөө түүний хаана нь ч хүрэхгүй гэдгээ мэдэж усан махбодийн бүлгийн гол хайсангийн ойролцоо хүрээд гэнэт завиа залж том онгоцыг

мөргүүлжээ. Жижиг завь ч зомгол мэт үйрэн унаж хар багаасаа умард нутагт төрж өссөн Жу Сян Зюнь угаас усанд муу тул хахаж цацан живж эхэлсэн байна. Тэгээд сэргэн үзвээс хэдэн газрынхаа хөдөлгөөнгүй болгодог цэгийг даруулаад Шуй Да Юний өмнө хэвтэж байх нь тэр.

Шуй Да Юнь түүнтэй урьд өмнө хэдэн ч удаа гар зөрүүлж айхтар гэдгийг нь мэдэх болсон тул ихэд цэрвэн болгоомжилж байлаа. Тэрээр Жу Сян Зюнь хорч Ду авгайгийн гарт орж хордоод хамаг зэвсгийн эрдэм дотоод хүчээ гээсэн гэдгийг яахин мэдэх билээ. Жу Сян Зюнь уг нь амин цэгийг алга болгогч эрдэм сурсан боловч дотоод хүч байхгүй болохоор яахин тэр эрдэм нь биеийг хамгаалж чадах вэ. Шуй Да Юнь дайснаа амархан гартаа оруулж авсандаа туйлаас их догдлон баярлаж байлаа. Шуй Да Юнь уг нь Жао баяны эхнэртэй нөхцөж нөхрийг нь хороосон хэрэг бусдад сонсогдсонд ихэд болгоомжилон тэр эхнэрийг бас өөрийн онгоцон дээр нууж байсан юм. Тэгээд Жу Сян Зюнийг барьсаны дараа том шавь Шуй ахыг алтан уул руу явуулж хурим найранд оролц гэж урьсан бөгөөд цаад санаа нь Жу Сян Зюнийг өөрийн биеэр авч яв гэсэн утга байв. Тэрээр урьд өмнө Жао баяныд очиж элгэмсэхдээ өөрийн том шавь Шуй ахад ч энэ тухай мэдэгддэггүй байсан тул өөр ямар ч хүн түүний Жао баяны авгайтай сүжирдэгийг мэддэггүй байлаа.

Тийм болохоор Шуй ах Шуй Да Юнь Жу Сян Зюнийг хүчирхийлэн өөрийн эхнэр болгох гэж байна гэж бодсон нь тийм учиртай байжээ. Тэрээр усан махбодийн бүлгийн толгойлогч болохоор эртнээс санаархаж ирсэн тул Зян Жоу отгийн толгойлогчийг олж уулзан далд явуулга төлөвлөснийг бид бүхэн мэднэ. Юань ахлагч ч гэсэн Зян Жоу отгийнхон энэ удаа түшигтэй хүнээ оллоо гэж баярлан хөнгөн хөдөлснөөс амь насаа алдахад хүрсэн юм. Шуй Да Юнь хурдан хөдөлж амьд гэрчийг устгаснаар өөрийн бузар булай явдал дэлгэгдэхээс сэргийлж чаджээ. Нөгөө талаар И Да Зингийн номын хэнээтэй мангуудуу байдлын ачаар Шуй ахын булхай бас илчлэгдээгүй өнгөрсөн юм.

Харин загасны торон доорхи Жу Сян Зюнь хөдөлж ярьж чадахгүй боловч сонсгол нь хэвээр байсан тул тэнд болж байгаа бүхнийг нэгд нэгэнгүй чагнаж байсан юм. И Да Зин өөрийг нь эхнэрээ гэж нэрийдэн усан махбодийн бүлэгт амь насаа ч хайрлахгүй зорьж ирснийг үзээд сэтгэлд нь сайхан байлаа. Тэр тусмаа И Да Зин хүчтэй дайснаас бэрхшээн айлгүй <<Миний Сян дүү болвоос амьсгал ч хүрээгүй алаг цэцэг шиг ариухан амьтан. Хэрвээ чи түүнийг доромжилон гутаах аваас би амь насаа

хайрлахгүй нэгийгээ үзэх болно>> гэж хэлэхийг сонсоод өөрийн эрхгүй сувдан нулимс тасран хоёр хацрыг нь даган урслаа. Эм хүн болж төрөөд хайртай эрийнхээ ийн өгүүлэхийг дуулаад үхсэн ч хамаагүй мэт санагдана.

Шуй Да Юнь И Да Зинг хүн гэж тоохгүй И Да Зин ч гэсэн түүний энд хүрэхгүй гэж бодож байсан боловч Жинь Кан Лун өвгөн л ганцхан өнөөдөр энэ онгоцон дээрхи олон сайн эрчүүдээс ганц нь ч И Да Зинтэй эн зэрэгцэхгүй гэдгийг мэдэж байлаа. Жинь Кан Лун онгоцон дээр гарч ирүүтээ л И Да Зингийн дотоод хүч чамгүй их гэдгийг гадарласан ба гараараа атгаж үзтэл түүний санаснаас ч хавьгүй их болохыг мэдэрч гайхахын дээдээр гайхсаныг өгүүлэх юун. Дараа нь алтан зүүгээр түүний нойрсуулагч цэгийг хатгатал юу ч болоогүй мэт тулалдахыгхараад улам ч балмагдан гайхжээ. <<Энэ хүүхэд чинь нэг л этгээд юм гээч. Хэрэв би түүнтэй тулалдвал ялахын баталгаа байхгүй юм байна даа гэж тэр бодсон билээ. Харин цааш нь үргэлжлүүлэн ажваас дайсантай тулалдах туршлага нимгэн болохыг анзаарч миний ганц даван гарах газар энд л байгаа юм байна. Уулын цаана уул хүний цаана хүн байдаг гэж яасан үнэн үг вэ. Би энэ талаар даанч бодож явсангүй шүү Жинь Кан Лун минь>> гэж санажээ.

Тэгээд дахин ямар нэг санамсаргүй хэрэг гарахаас болгоомжилон И Да Зинг нөгөө Зян Жоу бүлгийнхэнтэй явуулчихаад өөрөө усан бүлгийнхнээс нэг онгоц гаргуулж өөрийн биеэр Жу Сян Зюнийг аван хөх мөрнөөр хөвсөөр зүүн далайн эрэгт хүрч тэндээсээ умрыг барин явсаар өөрийн төмөр махбодийн бүлгийн гол хайсан байх Алтан ууланд очсон юм. Зам зуур Жинь Кан Лун Жу Сян Зюнд эцэг мэт сэтгэл гарган даруулсан цэгийг тайлж чөлөөтэй хөдөлж явах боломж олгожээ. Жинь Кан Лун зэвсгийн эрдмээр гайхалтай санаа бодол гүнзгий тул өөрөө дотоод хүчээ алдсан нөхцөлд түүний гараас мултран гарна гэж санаваас тэнгэрт авиран очье гэж санавал хавьгүй дээр гэдгийг Жу Сян Зюнь мэдэж байлаа. Тэгээд тэр улирсан баларсан угтах ирээдүйг саналгүй зөвхөн идэж ууж биеэ тэнхрүүлэхийг эрхэмлэж байсан нь нэгэн бодлын зөв бизээ.

Онгоцноос бууж Жинь Кан Лун нэгэн морь тэрэг хөлслөн Жу Сян Зюнийг суулгаад алтан уулыг зорьлоо. Жинь Кан Лунгийн орд өргөө хааны өргөө мэт баян тансаг байсныг өгүүлэх юун. Тэр орой Жинь Кан Лун элбэг баян ширээ засаж Жу Сян Зюныг дайлж цайллаа. Жу Сян Зюнь ч хэмжээнийхээ хэрээр ууж идэхийн зэрэгцээ <<Энэ Жинь баатар ямар далд санаа агуулж байгаа болдоо. За яадаг ч байлаа гэсэн сүх далайтал үхэр амар гэгчээр сайн тэнхэрч авах хэрэгтэй>> гэж санана. Жинь Кан Лун

төрөлхийн ухаалаг түүний дээр үзсэн харсан амссан туулсан их тул Жу Сян Зюний юу бодож байгааг андахгүй гадарлаж инээд алдаад <<Журамт бүсгүй Жу минь чи намайг яах бол гэж нэг л сэжиглээд байна аа даа. Үнэн хэрэгтээ бол чи чинь модон махбодийн бүлгийн толгойлогч хүн. Манай 5 махбодийн бүлэг чинь уулаасаа гарын 5 хуруу шиг эвтэй найртай улс бөгөөд адилхан бүлгийн толгойлогч нар чинь хэн нь хэндээ ихэрхэх билээ дээ. Тэгээд ч би чамайг яахин дорд үзэж болох вэ. Харин чинь Шуй Да Юнь дүүтэй харилцаа муу болохоор чамд ямар нэгэн муу юм болж мэдэх юм гээд би түүний гараас чамайг суллан авчирсан билээ>> гэв.

Жу Сян Зюнь нэгэн зулзган хулсны үндсийг ихэд амтархан зажилж <<Мөхөс би өвгөн ахад баярлалаа>> гэлээ.

Жинь Кан Лун өгүүлрүүн <<Нэгэн өрхийн улс чинь бие биестээ талархдаг билүү>> гэв.

Жу Сян Зюнь <<Өвгөн ах та нэгэнт ингэж байгаа бол охин дүү нь хоолны дараагаар гэрийн зүг гэлдэрье дээ>> гэлээ.

<<Журамт бүсгүй та жаахан алжаан саатахгүй яасан юм бэ. Манай ядуу өргөөнд гийгүүлэн ирчихээд хэдэн өдөр өнжин сааталгүй яахав. Тэгээд ч журамт бүсгүй Жу та мөрөн голоор багагүй өстөн дайсантай болсон тул ийм чилээрхүү биетэй буцаж яваад тэдэнтэйгээ тааралдвал яах билээ>> гэж Жинь Кан Лун санаа тавьсан янзтай өгүүллээ.

Жу Сян Зюнь ч дотроо тийм амархан мултран гарчихна гэж найдаж байгаагүй юм. Түүний хувьд Жинь Кан Лунгийн гарт орсон нь Шуй Да Юньгийн эрхэнд байснаас хэдэн хувь илүү аюултай хэрэг байлаа. Тэгээд тэрээр инээд алдан өгүүлрүүн <<Өвгөн ах та ийм өгөөмөр гараа сунган тусалж байгаад чинь талархавч баршгүй. Мөхөс хүн би гар бариад бугуй барихын үлгэрээр таньд нэгэн ёсгүй хүсэлт тавибал зөвшөөрөхсөн болов уу>> гэв.

<<Журамт бүсгүй Жу та ёсорхохын хэрэггүй хэл л дээ>> хэмээн Жинь Кан Лун харилав.

Жу Сян Зюнь <<Мөхөс би дотоод хүчээ алдсаныгаа өвгөн ах таны гэгээн мэлмийнээс яахин нууж чадах билээ. Өвгөн ах танаас өөр ийм их дотоод хүчийг хуримтлуулсан хүн хорвоо дэлхийд дахин байхгүй буй за. Давс хийвэл дуустал гэсэн үг байдаг. Та нэгэнт л тус болж байгаа бол дотоод хүчнээсээ надад өгч туслахгүй болов уу>> гэлээ.

Жинь Кан Лун хөмсөг атируулан <<Наадах чинь харин хэцүү хэрэг байна даа. Тэр өдөр би чиний судсыг барьж үзэхэд мөрний өмнөд нутагт

хорч Ду авгайгийн хорны улмаас дотоод хүчээ алдсан боловч амь насанд чинь аюулгүй болохыг мэдсэн билээ. Харин дотоод хүчээр хэн нэгэн хүн сэлбэхгүй удвал болохгүй нь мэдээж хэрэг. Өнөөгийн мөрөн голд танай багш хүрэн хулсны гэлэнмаагаас өөр надтай дотоод хүчээр тэрсэж тэмцэх хүн байхгүй нь үнэн>> гэж өгүүлэв.

Жу Сян Зюнь өвгөн Жинь үгийн далимд багшийнх нь нэрийг дурсаад авахыг анзааран түүний зэвсгийн эрдэм алсын бодол сонсож дуулсан нь гүйцэгдэшгүй хүн болохыг мэдэж улам ч бишрэх сэтгэл төрж байлаа.

Жинь Кан Лун цааш залуулан өгүүлрүүн <<Энэ мөчид хүрэн хулсны гэлэнмаа У Жи Шань ууланд байгаа тул алсын ус амны цангаа гаргахгүй гэдэг л болж байх шив. Өвгөн би хэрвээ тусалъя гэж шийдвээс жаахан хүчиртэй боловч тав зургаан хоногийн дотор чамайг сэгхийлгээд ирж болох байх л даа. Харин манай бүлгийг үүсгэсэн дээд өвөг маань хойч үедээ өөр бүлгийн хүмүүст дотоод хүчнээсээ хугасалж болохгүй гэсэн зарлиг гаргасныг яалтай билээ. Гэтэл чамайг харсаар байгаад дотоод хүчээр туслахгүй хэд хоновол бие чинь тэнхрэхгүй байсаар эрэмдэг амьтан болон хувирч ч мэдэх юм шүү. Өвгөн би иймийн тул ацан шалаанд орсон ноён шиг болчихоод байна даа>> гэлээ.

Жу Сян Зюнь түүний үгэн дотроо үг хавчуулж өөхөн дотроо зүү хатгасныг үзээд <<Өвгөн ах та миний төлөө санаа зовохын хэрэггүй. Үхэх төрөх заяагаар болж үгүйрэх баяжих тэнгэрээс оноотой байдаг юм гэнэлээ. Тэгэхээр та бид хоёр ямар хамаатай улс биш. Намайг тавиад явуулчихвал яасан юм бэ. Мөхөс би хэрхэвч таны нэгэн үеийг эзэлсэн баатар нэрийг чинь хугалахгүй>> гэв.

Жинь Кан Лун ихэд өгөөмөр журамтай царай гарган <<Журамт бүсгүй Жу минь наадах чинь юу гэсэн үг вэ. Өвгөн би туслана гэж үг унагасан бол түүндээ хүрэх болно. Чи санаа амар байгтун. Чиний дотоод хүчийг нөхөн сэлбэх үүргийг надад оноосугай>> гэлээ.

<<Тэгвэл мөхөс би танд урьдчилан талархая>> гэж Жу Сян Зюнь инээмсэглэн өгүүлэв.

<<Баярлаж талархах яах вэ. Харин өвгөн би нэгэн ёсгүй хүсэлт тавивал болгооно бизээ гэж найднам>> гэж Жинь Кан Лун түүний зүг хяламхийн харвал Жу Сян Зюнь хундагатай архиа зугуухан шимэхийг үзээд залгуулан <<5 махбодийн бүлэг дотроо манайх хамгийн хүчирхэгтээ тооцогддог юм даа. Бүлгийн шавь нар хэдэн мянга гараад явчихсан болохоор хэрийн хүн багад үзэн басамжилж зүрхэлдэггүй. Би өөрийн гарын

шавь болгож хэдэн хүн авсан боловч тэднээсээ шигшээд шигшээд орыг залгачихаар олигтой амьтан гарч ирэхгүй бололтой. Тэгэхээр сүүлийн үед хэдэн зуун жилийн турш нэр алдраа мандаан бадрааж ирсэн төмөр махбодийн бүлэг миний үе дээр ирээд сүр сүлд нь мөхөх юм биш байгаа гэж санаа зовж суудаг боллоо.Тэгээд би өөр бүлгээс нэгэн самбаат шавийг сонгон авч өөрийн бүлгийн хувь заяаг даатгадаг юмуу>> гэж бодож яваад журамт бүсгүй Жу чамайг тохирох болов хэмээн ийн аймшиггүй өгүүлэх байна гэлээ.

Жу Сян Зюнь инээн өгүүлрүүн <<Өчүүхэн эрдэм чадалгүй тогтож томоожоогүй мөрөн гол даяарын хараалыг идсэн бяцхан шулам шүү дээ. Яахин өвгөн ах таны өлмий түших гарын шавь болж чадах билээ>> гэв.

<<Журамт бүсгүй Жу та юунд өөрийгөө ийн дорд үзнэ вэ. Мөрөн голын олон залуу баатруудын дунд тань шиг ийм эрдэм ухаан хосолсон хүн дахин олонгүй болов уу. Шударга буруу замын гэдэг тухайд гэвэл манай нөмөр нөөлөгт орчихсон хүнийг элдэв долооноор нь дуудах хүн гарахгүй гэдэгт баттай итгэж болно. Тэгээд ч журамт бүсгүй Жу таньд би юугаа зааж багш шавь гэж явах вэ. Багш анд нөхөр хоёрын дунд байцаавал болох нь тэр. Хэрвээ багш шавийн барилдлагааг бодож би чамд дотоод хүчээрээ туслахад манай бүлгээс түүнийг буруушаах хүн магад дахин гарахгүйдэг>> гэж Жинь Кан Лун хэлэв.

Жу Сян Зюнь толгой сэгсрэн <<Мөрөн гол даяар хэрэгтэй хэрэггүй дэг ёсон тоо томшгүй олон. Хэрвээ би өөр багшид шавь орлоо гэвэл мөрөн голынхны хэл ам бага юм гэж бодоход манай багш хэрхэвч зөвшөөрөхгүй. Түргэн түүхий зантай багш маань өчүүхэн шавь миний амийг егүүтгээд зогсохгүй өвгөн ах таньтай үзэлцэхээр ирвэл юу болох вэ>> гэв.

Жинь Кан Лунгийн царай барайн <<Журамт бүсгүй Жу минь ертөнцийн хэргийг хямар хүчээр шийдэж болох биш. Хэрвээ журамт бүсгүй та өөр санаатай байгаа бол би багш шавийн барилдлагааг дурсахгүй өнгөрч болноо. Харин модон махбодийн бүлгийн толгойлогч Му Цин Ся уг нь миний өргөмөл охин байсан юм. Түүний эрдэм чадал өөрийн чинь энд хүрэлгүй модон махбодийн бүлгийн толгойлогчийн сууриа өөрт чинь алдсан байна лээ. Чадлаараа эзэгнэн авсаны төлөө чамайг зэмлэх ёсон хаанаас байх вэ. Гал махбодийн бүлгийн толгойлогч Хуо Шао Чунгийн тухайд бол миний өргөмөл охины нөхөр гэдгийг ч юу эс андах вэ. Гэтэл тэр чиний гарт шархдаад хорин жилийн турш цаг хүчээ шавхан олсон зэвсгийн эрдмээ талаар үрсэн байна лээ. Гэвч түүний өөрийн санаа үйлдсэн хэрэг өөдгүй

муугийн дээд байсан тул манай шударга замынхны нэрийг гутааж гүйцэх шахсан байна лээ. Харин журамт бүсгүй чи түүнд зөөлөн хандаж амийг нь өршөөсөн нь их юм гэж бодном. Өвгөн би насан туршдаа мөрөн голоор мөрөө үлдээж явахдаа өргөмөл охин хүргэн хоёроосоо өөр төрөл садан төрүүлсэн үр гэх юмгүй өдий хүрч ирсэн юм. Тэгээд Му Цин Ся Хуо Шао Чун хоёрыг тэжээн тэтгэж алсдаа толгой түшүүлээд үхүүлэх болов уу гэж бодож байлаа. Гэтэл тэр хоёрын маань нэг нь сураг алдарч нөгөө нь хаана явдгийг ч мэдэх арга алга>> гээд өгүүлэх зуур нүдэнд нь хорсол тодрон <<Хэрвээ би чамайг одоо алаад өргөмөл охин хүргэн хоёрынхоо өшөөг авбал яах вэ>> гэлээ.

Жу Сян Зюнь огтхон ч айж эмээсэн шинжгүйгээр инээд алдан <<Миний дотоод хүч алга болж дахин хэд хоног бололгүй эрэмдэг зэрэмдэг амьтан болон хувирах учраас амьд байх нь үхэхээс юугаараа дээр байх ва. Өвгөн ах таны өргөмөл охины бүлгийн толгойлогчийн суурийг би булааж, хүргэний чинь зэвсгийн эрдмийг эвдэлсэн далай мэт өсийг санаж намайг эс алваас аль цагийг хүлээх вэ>> гэв.

Жинь Кан Лун санаа алдаад <<Хөгшин би мөрөн голоор хэдэн арван жил явахдаа тоо тоомшгүй хүний аминд хүрсэн боловч үхлийн өмнө толгой гудайдаггүй хүмүүсийг яаж ч чаддаггүй билээ. Журамт бүсгүй чи ийм шийдэмгий байхад би гар хөдөлгөж яахин зүрхлэх вэ. Чамд бууж өглөө. Харин би чамайг Му Цин Сягийн адилаар надад мөргөн өргөмөл охин минь болохгүй юу гэж хүсэх байна. Би өргөмөл охиндоо дотоод хүчнээсээ хагасалж өргөж тэтгэх нь зүйн хэрэг буй за. Өвгөн би нас дээр гарч хутга мэсний харшилдаанаас залхаад байна. Хэд хоногоос би чиний И Да Зин болон Му Цин Ся, Хуо Шао Чун нарыг олж ирээд та тавыг эвлэрүүлэн би өөрөө мөрөн голын амьдралаас хулжин аглаг ууланд насны бөгсийг үзвээс ямар вэ>> гэж хэлэв.

Жу Сян Зюнь <<Өстөн хүнээ авчирч өргөмөл охиноо болголоо гэвэл мөрөн гол даяар та нүүрээ хийх газаргүй болно биз дээ. Багш маань намайг төрж гаруут эцэг эхийнхээ толгойг залгидаг өөдгүй заяат амьтас гэж хараан зүхдэг юм. Тэгээд одоо дээр нь таны нэр сүрийг гутаавал хийсэн үйлийн үр маань барагдашгүй юм болно биз дээ>> гэв.

Ийнхүү Жинь Кан Лун Жу Сян Зюньд хатуу зөөлөн янз бүрийн аргаар хандсан боловч тэр тухай бүрд эсэргүүцэж байв. Жинь Кан Лун хэдийгээр түүнд ихэд уурлан бухимдаж байсан боловч түүнийгээ царайдаа гаргалгүй

инээмсэглэж бидэнд хоног хугацаа байгаа тул <<Алгуур ярьж хөөрцгөө>> гэжээ.

Жу Сян Зюнь өвгөн Жинь Кан Лунгийн уригдаж ирсэн зочны ёсоор төмөр махбодийн бүлгийн гол хайсан байрлах Алтан ууланд байх болжээ. Өдөр болгон өргөмжлүүлэн дайлуулах боловч их л чанга харуул хамгаалалтын доор байдаг болов. Хэд хоногийн турш Жинь Кан Лунгийн бараа үзэгдэхгүй болсонд Жу Сян Юнь тэр тийм ч амар намайг орхихгүй. Яаж дөнгөх гэж байгаа бол. Ямар ч байсан Зин ах л түүний гарт битгий орсон байгаасай. Би дотоод хүчээ алдсан Зин ах ганцаараа түүнийг дөнгөнө гэж өдий хэмээн бодож байлаа.

Жинь Кан Лун өөрийн хайсандаа эргэн ирсэн даруй Жу Сян Зюньтэй уулзаж <<Журамт бүсгүй Жу минь чи намайг хаашаа яваад ирэв гэж гайхаж байна уу>> гэлээ.

<<Өвгөн ах мөрөн голын сүмбэр оргил болох тул хийх ажил хэлцэх үг олон байдаг байлгүй. Би яахин тааварлаж барах билээ>> гэж Жу Сян Зюнь хэллээ.

Жинь Кан Лун тас тас инээн <<Юуны чинь мөрөн голын сүмбэр оргил байх вэ дээ. Үхэх гэж байгаа хөгшин өвгөнийг мөн ч явуулж байна даа. Харин өвгөн би журамт бүсгүй чамтай учирсан цагаас эхлэн залуу цагийн явдлыг санан дурсах боллоо. Инээдтэй байна уу>> гэхэд Жу Сян Зюнь дуугарсангүй.

Өвгөн ийн өгүүлээд гараа дохин <<Бүгдийг нь наашаа оруулаад ир>> гэвэл төмөр махбодийн бүлгийн шавь нар хоёр хүн дундаа нэг хоригдлыг харгалзан нийт 13 хүнийг оруулж ирлээ. Эдгээр 13 хүн бүгдээрээ эцэж тураад нүднээс гарсан байхыг үзвэл далны ясаа хугалуулж зэвсгийн эрдмээ эвдүүлсэнээс гарцаагүй ажээ.

Тэнгэрт тэрслүү бүлгийнхэн өөрийн шинэ эзнээ тодруулахаар 15 элчээ гавъяа байгуулж бүлгийн нэрээ бадруулаад ир гэж явуулсаны 13 нь ийнхүү Жинь Кан Лунд баригдсан байхыг үзээд Жу Сян Зюнь ихэд балмагдан цочирдлоо. Эдгээр 13 хүнийг Жинь Кан Лун өөрийн гараар барьж зэвсгийн эрдмийг нь эвдсэн ажээ. Нөгөө үлдсэн хоёрын нэг болох Жу Сян Зюнь өөрөө бас баригдан ирээд байгаа ба гагц үлдсэн ганц махсаг лам Чэн Сяо Фог Жинь Кан Лун хараахан олж чадаагүй ажээ. Эдгээр 13 элч нар зэвсгийн эрдмийн хувьд сайтай муутай боловч тийм амархан хүний доор орчихоор улс бас ч бишээ. Гэтэл Жинь Кан Лун хэдхэн хоногийн дотор

тэднийг барьж ийнхүү шийтгэснийг үзэхэд зэвсгийн эрдэм чадал ухаан билгийн гайхамшигийг нь хэлэлтгүй мэдэж болох бизээ.

Гэвч Жу Сян Зюнь үнэн хэрэгтээ өвгөн Жингийн эрдэм чадлыг хэтрүүлэн үнэлсэн хэрэг байлаа. Тэр хэдийгээр зэвсгийн эрдмийн хувьд гоц гойд шалгарсан боловч 13 элчийг хэд хоногийн дотор барьж авна гэдэг саналтгүй хэрэг юм. Тэр 11-ийг нь увуу цувуу бариад хорьж байсан бөгөөд үлдсэн хоёрыг нь саяын явалтаараа нэмж барьсан ажээ. Эдгээр 13 элч хоорондоо ямар ч хэлхээ холбоогүй бөгөөд харин ч бие биеээсээ нууцгай ямар нэгэн хэрэг сэдэж зарим талаар өөр хоорондоо алалцах дайтах тохиолдол ч гаргаж байсан нь өвгөн Жиньд амархан өөш болсныг өгүүлэх юун.

Жинь Кан Лун нөгөө хэд рүү хандан <<Та бүхэн өвгөн миний сэтгэл хорон гар хатуу гэж битгий санаарай. Би арга буюу ийм байдалд хүрснийг ойлгож байгаа бизээ. Мөрөн голын шударга замын бүлгийнхэн 20 жил тутам тэнгэрт тэрслүү бүлгийнхний гайгаар тоо тоомшгүй олон хүнээ алдаж ирснийг мэдэхгүй хэн байх билээ. Энэ удаа өвгөн надтай тохиосны ачаар та бүхэн амьд мэнд үлдэх болно. Зэвсгийн эрдмийн ертөнцийн амар амгаланг бодож та бүхний зэвсгийн эрдмийг эвдэхээс өөр аргагүй болсныг өршөөнө биз. Энэ гай барцад өнгөрсний дараа та бүхэнд амьдрах аргыг чинь зааж амар тайван явуулах болно >> гэлээ.

Жу Сян Зюнь инээд алдан <<Өвгөн ах та их өгөөмөр зан гаргах юм. Зэвсгийн эрдмээр хичээллэдэг хүн түүнийгээ эвдүүлчихвэл үхсэнээс долоон дор хэрэг биш үү. Тэд нэгэнт эрдэм чадлын хувьд тантай эгнэхгүйгээс хойш баатар сүрийн чинь дор үхэхэд бардам тайвнаар эрлэгийн хаалгыг татах биш үү. Харин та нар бөөнөөрөө ингэж дайсныхаа гарт орж байх нь зуу гаруй жилийн турш Тэнгэрт тэрслүү бүлгийн мандаж ирсэн их нэрийг гутааж байна>> гэлээ.

Жинь Кан Лунгийн хуурамч элбэрэл журам Жу Сян Зюний ёстой хорон үгэнд автаад тэдний хэн нь ч хариу хэлж чадсангүй. Энэ бүхэн нь тэдний хувьд ямар ч тамлалаас илүү хүнд тусаж байлаа.

<<Манай шударга замынхан элбэрэл журмыг гол болгодог. Яахин хамаа бусаар хүн алж болох билээ. Наадуулаа аваад яв>> гэж Жинь Кан Лун өгүүлэв.

13 элч бүдчин туугдсаар гарцгаав. Жу Сян Зюнь өгүүлрүүн <<Жинь баатраа одоо үлдээд байгаа хоёрхон элч болох махсаг лам Чэн Сяо Фо бид хоёрыг хэзээ зүйл дуусгах гэж байна даа>> гэлээ.

<<Махсаг лам Чэн Сяо Фо болвоос наанаа бүдүүн хадуун мэт боловч үсний ширхэг мэт нарийн ухаантай хүн. Би түүнийг хэдэн ч удаа араас нь мөрдсөн боловч загас мэт мултран зайлж чадсан билээ. Тэр бол мөрөн голын том барцад болж мэдэх тул түүнийг хэрхэвч уучлан өршөөж эс болно. Хэрвээ журамт бүсгүй чамайг хөнөөхөөр шиддйсэн бол өвгөн би өнөөдрийг хүлээх хэрэг юу байх вэ>> гэв.

<<Өвгөн ах та надад ийм өгөөмөр хандаж байгаа нь өчүүхэн миний хувьд гурван насны азтай тохиол буй за>> гэж Жу Сян Зюнь хэллээ.

<<Гэвч өвгөн миний тэвчээр бас хязгаартай шүү. Журамт бүсгүй Жу минь бид сүүлчийн удаа нэг наймаа ярьж тохирвол ямар вэ>> гэж Жинь Кан Лун өгүүлэв.

<<Өчүүхэн би хичээнгүйлэн сонсоё>> гэж Жу Сян Зюнь хэллээ.

<<Журамт бүсгүй Жу минь хэрвээ чи надад шавь ордог юмуу эсвэл миний хуурай охин болвоос би чиний дотоод хүчийг сэлбэж өгөхөөр үл барам чамайг тэнгэрт тэрслүү бүлгийнхээ толгойлогч болоход тусалж болох юм>> гэж Жинь Кан Лун хэллээ.

Жу Сян Зюнь юу ч эс дуугарна.

<<Харин модон махбодийн бүлгийн толгойлогчийн тухайд гэвэл чи өөрөө хүсвэл байж блох юм. И номч баатар шороон махбодийн бүлгийн толгойлогч болсон төдийгүй чамтай сэтгэлийн гүнзгий харьцаатай гэдгийг би бас мэдсэн. Тэр ч гэсэн тэр чигээрээ явахад болохгүй нь юу байх вэ. Усан махбодийн бүлгийн дотор миний дуулж мэдсэнээр хэд ч хонолгүй их самуун болох шинжтэй. Та хоёр хамтдаа нийлэн довтлон орвол түүнийг эзлэх шиг амархан юм гэж үгүй. Гал махбодийн бүлгийн толгойлогч Хуо Шао чун сураагүй алга болоод удаж байна. Тэр дахин гарч ирлээ ч гэсэн эрэмдэг амьтан чинь яах билээ. Тэгэхээр гал махбодийн бүлгийн толгойлогчийн суур ч гэсэн та хоёрынх боллоо гэсэн үг. Тэгэхээр журамт бүсгүй чи мөрөн голын 4 махбодийн бүлгийн толгойлогч болоод дээр нь бас тэнгэрт тэрслүү бүлгийнхээ эзний суурин дээр суугаад сэтгэл ханахгүй юм гэж үү>> гэж Жинь Кан Лун асуулаа.

Жу Сян Зюнь дуугүй хэвээрээ байв.

<<Журамт бүсгүй Жу чи юу бодно вэ>> гэж Жинь Кан Лун асуулаа.

<<Хамаг ашгийг би ганцаараа эзэгнэчихээр энэ наймаан дундаас өвгөн ах та юу хожих вэ гэдгийг л би бодож сууна даа>> гэж Жу Сян Зюнь хариуллаа.

<<Ха ха ха журамт бүсгүй Жу чи ч аргагүй сэргэлэн охин юм даа. Өвгөн би бахдаж байна>> гэж Жинь Кан Лун инээд алдан өгүүлснээ санаа алдаж <<Журамт бүсгүй Жу минь И номч баатар та хоёрын зэвсгийн эрдмийг гүйцэх чадалтан та хоёрын насныхан дунд ганц ч үгүй гэж хэлж болно. Өвгөн би хэрээ мэдэж бяраа таньж байгаа тул та хоёр манай төмөр махбодийн бүлгийг хөндөхгүй байхад л миний санаа амраад явчихна. Өөр юу хүсэх билээ дээ>> гэлээ.

<<Өвгөн ах таны нас өндөр гарсан ч гэсэн ухаан цэлмэг байгаа тул өөр нэг давхар тооцоо байгаа байлгүй дээ>> гэж Жу Сян Зюнь хэлчихэв.

<<Үнэхээр журамт бүсгүй Жу чиний мэргэн ухаанаас зайлж чадахгүй юм байна. Хэн ч ялгаагүй энэ насандаа нэр алдраа дуурсгасан их үйлийг бүтээгээд өөд больё гэж боддог нь хүний ёс юм шиг байна. Тэгэхээр би хэдийгээр нас дээр гарсан ч гэсэн нэгэн бүлгийн толгойлогч байгаад өөрийн өргөмөл охин маань зэвсгийн эрдмийн ертөнцийг нэгтгэн захирч байвал тэрэн шиг сайхан юм гэж хаана байх вэ>> гэж Жинь Кан Лун хэллээ.

Жу Сян Зюнь инээд алдан <<Өвгөн ахаа хэрвээ би та байсан бол хэзээ ч ингэхгүй байсан даа. Өргөмөл охин шавийн аль нь ч бай зэвсгийн эрдмийн ертөнцийг ноёрхлоо гээд яаж өөрөө байснаас дээр байх вэ. Хэрвээ тийм нэг өдөр байдаг бол шавь өргөмөл охин хэн ч байг хамаагүй түүнийг алчихаад өөрөө хаан сууринд нь заларна шүү дээ>> гэж хэлэв.

Жинь Кан Лунгийн царай барайж өгүүлрүүн <<Чи юу л гэж бодвол бод. Харин чамд ганцхан өнөөдрийн хугацаа байгаа шүү гэдгийг бодоорой. Маргааш болбол чи надад биш наад гөжүүд зандаа л гомдох нь дээр шүү>> гэлээ.

Жу Сян Зюнь өгүүлрүүн <<Өвгөн ах та намайг дэндүү доорд үзэж байх шиг байна. Би маргааш битгий хэл хойтон болсон ч гэсэн өөрийн үгнээс буцаж няцахгүй. Тийм болохоор та өөрийн бодлоо орхисон нь дээр болов уу>> гэв.

Хоёр дахь өдрийн өглөө Жинь Кан Лун өвгөн Жу Сян Зюнийг дагуулан тоорын цэцэгт ууланд авчирлаа. Жу Сян Зюнь дотоод хүчээ алдсан тул хурдан явж чадахгүйн улмаас Жинь Кан Лун түүнийг ардаа үүрэн явлаа. Хэдийгээр нас дээр гарч ардаа нэг хүн үүрсэн боловч тэрээр уулыг давж усыг даван нисэх мэт хурдлан явав. Ийн хоёр зуу гаруй газар замыг хагас өдрийн дотор туулаад зорьсон газраа хүрч иржээ.

Тэрээр замын турш Жу Сян Зюньтэй ганц ч үг ярьсангүй явсаар 8 хүлсийн модтой уулын оргилд ирж сая алхаагаа сааруулан Жу Сян Зюнийг

буулгалаа. <<Тэр арай 8 хүлсийн зургийн учрыг мэддэг юм биш биз дээ. Аягүй бол тэр энэ газрыг олчихоод яаж хичээллэх аргыг мэдэхгүй надаар тайлбарлуулах гэсэн бололтой. Хэрвээ тийм болбоос би аргалж байгаад эндээс зугатах аяа бодох юм шүү>> гэж Жу Сян Зюнь бодсоноо <<Төмөр махбодийн бүлгийн толгойлогч 8 хүлсийн зургийн учрыг мэдэхгүй байв гэж дээ>> гэж саналаа.

Харин Жинь Кан Лун түүнийг өмнө зүг харуулан зогсоов.

Өмнөхөн талд нь цавчим сүрлэг хадан хясаа байх бөгөөд түүн дээрээс унавал амьд гарахын аргагүй эд байлаа.

Жинь Кан Лун түүний ард зогсоод <<Журамт бүсгүй Жу чи урагшаа хар даа>> гэлээ.

Жу Сян Зюнь түүнийг хараад өвгөн яагаад түүнийг энд авчирсны учрыг олов. Алсын цэнхэр уулын дунд урдуураа тунгалаг горхиор эмжигдсэн уулын тосгон байх нь модон махбодийн бүлгийн гол хайсан айжээ. Тэр бол Жу Сян Зюний анх удаа толгойлогчийн эрхийг булаан авсан модон махбодийн бүлгийн хайсан бөгөөд тэнгэрт тэрслүү бүлгийн толгойлогч болохын эхлэл ч байсан байж болох юм. Тун ч магадгүй зэвсгийн эрдмийн ертөнцийн хаан болох гараа нь бас энд байсан ч юм билүү. Хамгийн гол нь энд тэрээр И Да Зинтэй дотносон танилцсанаараа хамгийн дурсгалтай газар билээ. Түүнээс илүү дурсгалтай газар гэж юу байх вэ дээ.

<<Чи доошоо хардаа>> гэж Жинь Кан Лун хэллээ.

<<Доошоо харахын хэрэггүй ээ. Би энэ газрыг чамаас илүү мэднэ. Ийм хадан хясаан дээрээс унаж үхнэ гэдэг над шиг хүнд завшаантай үхэл>> гэж Жу Сян Зюнь хүйтнээр өгүүлэв.

<<Журамт бүсгүй чи ганцхан өөрийгөө бодохын хэрэггүй. Чи бас номч баатар И-г давхар бодож явах учиртай юм шүү. Та хоёр хамтран явбаас халдах дайсан үгүй болно. Харин тэр ганцаар явбал би өөрөө очиж дөнгөхийн хэрэггүй байлгүй>> гэж Жинь Кан Лун инээлээ.

<<Манай буруу номынхны хэлж ярих хийх үйлдэх нь танай шударга замынхнаас хавьгүй ондоо. Намайг хэрвээ үхчихвэл Зин ах маань ганцаараа амьд байгаад байхгүй байлгүй. Бид хоёр хүний хорвоод хамт байж болдоггүй юм бол газар дор цугтаа байж болох байхаа. Жинь баатар та намайг хурдан зүйл дуусга>> гэж Жу Сян Зюнь хэллээ.

Жинь Кан Лун шүд зуун <<За яахав би тэгвэл чамайг зүйл дуусгаад өгье л дөө>> гэв.

Жу Сян Зюнь нүдээ анин хүлээвэл Жинь Кан Лун хоёр алгаа түүний ууц нуруун дээр тавилаа. Одоо тэр дотоод хүчээрээ жаахан л үйлчилэх юм бол түүний хамаг амьдрал зүйл дуусахаар байв. Гэвч Жинь Кан Лун дотоод хүчээ гаргахгүй байв. Харин ч түүний нуруун дээр тавьсалн хоёр гар нь чичрэхийг мэдэрч эргэн харвал Жинь Кан Лун нулимс урсган уйлахад хоёр гар нь чичирч байсан ажээ.

Жу Сян Зюнь туйлаас гайхан <<Өвгөн ах та юу болж байгаа чинь энэ вэ>> гэвэл

<<Би... би... чамайг алж чадахгүй юм байна>> гэж Жинь Кан Лун хэлэв.

<<Яагаад?>>

<<Яагаад гэвэл би нэг хүнийг санан дурслаа>>.

<<Хэн юм бэ?>>

<<Хорин жилийн өмнө би түүнтэй танилцсан юм. Тэр бүсгүй чамтай туйлын адилхан байж билээ>>.

Жу Сян Зюнь түүний энэхүү уяралтай байдлыг хараад <<Яаж тийм байх вэ. Хорин жилийн өмнө би чинь төрөө ч үгүй байсан хүн шүү дээ>> гэлээ.

Жинь Кан Лун толгой дохиж <<Охин минь чиний хэлдэг чинь үнээн. Чи бол тэр биш гэдэг нь ойлгомжтой. Тийм ч байхын учиргүй. Тэр мөн байлаа ч гэсэн хэрвээ миний замд саад боллоо гэхэд би түүнийг ч бас өршөөхгүй>> гэв.

Гэнэт түүний нүдэнд догшин сэтгэлийн оч гялалзаж хоёр алгаараа түүний араас түлхэв...

Гэтэл яг тэр агшинд нэгэн хүчтэй алганы салхи Жинь Кан Лунг довтлон ирэхийг мэдэрлээ...

ХӨХ АСРЫН ЗОЧИН МАХСАГ ЛАМ ХЭМЭЭХ АРВАН ГУРАВДУГААР БҮЛЭГ

<<Та миний Сян дүүг хараагүй биз>> гэж И Да Зин хавьтсан ойртсон улс амьтнаас асууж явлаа.

<<Сян дүү минь чи хаана байна аа>> хэмээн тэрээр уул тал гудамж зээлээр галзуу солиотой мэт гуугачин хашгирна.

<<Сян дүү минь яагаад? Яагаад алга болчихов оо>> хэмээн сэтгэл зүрх нь шархиран өвдөх ажээ.

И Да Зин ухаан мэдрэлээ алдаж толгойгоо тасдуулсан ялаа шиг мөрний өмнөд нутгаар хэрэн хэсэн явлаа. Түмэн бэрх мянган хэцүүг даван туулж байж эргэн учирсан Сян дүү нь түүнийг гэнэт орхин одсонд И Да Зингийн сэтгэл үгээр хэлж боломгүй хүнд цохилтонд өртжээ. Хамгийн гол нь Жу Сян Зюнгийн дотоод хүч байхгүй болсон тул аюулгүй байдалд нь хамгаас илүү санаа зовж байлаа. Тэрээр урьд өмнө мөрөн голын дунд цөөнгүй өс хонзонгийн үрийг тарьсан тул өдгөө дотоод хүчээ алдсан үедээ жирийн нэг хүдэр чийрэг эртэй тулгарахад л хариу хамгаалалт хийж чадахгүй нь ойлгомжтой.

Мөрний өмнөд нутгаар гурван сар гэхэд л эрвээхэй нисэлдэн цэцэг дэлгэрч анхилуун үнэр нь хамар цоргих ажээ. <<Мөрний өмнөд нутаг сайхаан, урин хаврын салхинд усны бидэр тодроод...>> хэмээн шүлэг зохиолд дурьддагчилан үзэсгэлэнтэй байдал нь хараа булаах боловч умард нутгийн эр И Да Зин эдүгээ түүнийг таашаан явах хүсэл хаанас байх билээ дээ.

Түүний үгэнд хариулах хүн байхгүй.

Сүнс сүлд нь харьсан И Да Зин чиглэсэн зүггүй хандсан чиг рүүгээ алхаж явлаа. Ийн явсаар Янжоуд хүрэлцэн иржээ. Янжоу бол эртнээс нааш байгалийн төгөлдөр газар билээ. Баруун дүүргийн Чань Чунь нуур Ханжоугийн Си Ху нууртай харьцуулахад өөрийн гэсэн өвөрмөц өнгө төрхтэй юм. Чанчунь нууран дээгүүр баруунаас зүүн эрэг хүртэл солонгорон нумласан урт гүүр байдгийг Солонгон гүүр гэж олон нэрлэжээ. И Да Зин солонгон гүүрэн дээр ирэх үед үдийн цаг болж байсан боловч гүүрийн үзэмжийг сонирхох хүмүүс шингэрэх яагаа ч үгүй дуу чимээ хөл хөдөлгөөн ихтэй байлаа. Луут бяцхан завьнууд гүүрний доогуур сүлжилдэхийн тэртээгээс цэнгэлтэй инээд хөөр сонсогдон хаврын налгар тэнүүн байдал И Да Зингийн сэтгэлийг байж ядтал бухимдуулна.

Гэнэт нэг завь хөвөн ирэхийг харвал түүний толгойд нэгэн үзэсгэлэнт охин суусан байлаа. И Да Зин гүүрний дээрээс өнгийн үзтэл охины бие хаа зүс царай машид гуа үзэсгэлэн төгс харагдахад тэрээр

<<Сян дүү минь>> хэмээн хашгирлаа.

Хэн ч түүний үгэнд хариулахгүй бөгөөд бяцхан завь нисэх мэт сүнгэнэн өнгөрөв.

И Да Зин олон хүмүүсийн дундуур хага яран гарч солонгон гүүрнээс буугаад нуурын эргийг даган харайлаа.

Завины ард суусан усчин залуу нэгэн жигд биедээ амар сэлүүрдэх боловч И Да Зингийн хөнгөний тамирын хурданд гүйцэгдэхгүй нуурын эргээр хурдлан давхих ажээ.

И Да Зин гүйнгээ <<Сян дүү минь>> хэмээн хашгирав.

Нилээд хол завин дээр сууж яваа бүсгүй эргэн харах нь хөмсөгөө яльгүй зангидсан Жу Сян Зюньтэй тун адил харагдах ажээ. И Да Зингийн зүрх базлах шиг болж ямар ч байсан түүнийг алдахгүй юм шүү гэсэн бодол харван орж ирлээ. Одоо үхдэг ч бай сэхдэг ч байх амаагүй Сян дүүтэйгээр уулзаж хэдэн үг солиод авах нь л түүний сэтгэлд хамгаас илүү дэм болох байлаа.

Тэнгэрийн хаяа улайран шаргалтана. Хос хараацай жиргэн дуулан нисэлдэж малчин хүү үхрээ унан лимбээ үлээнэ. Мөрний өмнөд нутгийн бүсгүйчүүл хоёр хоёр гурав гурваараа нийлэн өмнөд нутгийн уянгат дуугаа дуулцгаан цайн навч хураацгаах үзэгдэнэ.

Гэвч И Да Зинд мөрний өмнөд нутгийн байгалийн үзэмжийг бахдан явах хүсэл хаанаас төрөх билээ. Тэр Жу Сян Зюньтэй салан одсоноос хойш унтах нойр уух идэхээ мартаж орхисон тул хэдийгээр зэвсгийн эрдмээр хичээллэсэнээс хойш түүний бие махбодь чийрэгжин зузаарсан ч ойрдоо ширхэг будаа хэлэн дээрээ тавиагүйн улмаас толгой нь эргэн газар шаргалтана...

И Да Зин сэргэн үзвэл мөнөөх хөөж явсан завиныхаа дээр хэвтэж байлаа. И Да Зингийн өмнө гэгээн сарны бүүдгэр гэрлийн дор нэгэн торгон гивлүүр нүүр рүүгээ унжуулсан насан бага охин цааш харан суух нь түүнд туйлын танил дотно хүнийг нь санагдууллаа.

<<Сян дүү минь>> хэмээн И Да Зин чангаар дуу алдаад завины толгой руу ухасхийн очиж нөгөө охиныг чичирхийлсэн гараараа тэврэн авлаа. Нөгөө охин дуу гарахгүй боловч И Да Зингийн цээжинд наалдан ирлээ.

<<Сян дүү минь, Сян дүү минь>> гэж И Да Зин зөөлнөөр түүний мөрийг илээд <<Би чамайгаа яасан удаан эрэв ээ. Тэнгэр намайг хөөрхийлөөд өнөөдөр чамтай учруулдаг байна шүү. Сян дүү минь. Бүгд миний буруу байсан байна лээ. Хожим намайг буруу хэрэг хийвэл харааж зүхэж зодож занчиж болно. Харин надаас битгий холдон явж байгаарай. Мэдэв үү. Чи за гээд зөвшөөр л дөө...>> гэв.

Мөнөөх охин дуу гарахгүй боловч хоёр гараа сунган И Да Зингийн энгэрт тавьлаа.

И Да Зин нулимс дуслуулан зөөлөн дуугаар <<Сян дүү минь чи мэдэж байна уу. Чи намайг энэ хэдэн хоногийг яаж өнгөрөөж байсан гэж бодно оо. Хэрвээ би чамайгаа байхгүй болчихвол ганц ч өдөр амьд байж чадахгүй юм байна. Хоёулаа тэгэхээр энэ насан туршдаа хоёр биенээсээ холдохгүй амьдарцгаая. Үхсэн ч нэг өдөр үхэх хэрэгтэй...>> гэнэ.

Нөгөө охин мөн л дуугүй хэвээр байх бөгөөд И Да Зингийн өвөрт эрхлэн зөөлөн цагаан гараараа түүний дотуур хувцсыг оролдох ажээ.

И Да Зин гэнэт дуугүй боллоо.

Тэрээр эмэгтэй хүний гиншин янаглах этгээд дууг сонслоо. Тэр гинших дуунд зовлон жаргал хүч чадлын алин агуулагдан буй болохыг ялгахад нэн бэрх ажээ. И Да Зин урьд нь хэдийгээр эмэгтэй хүний ийн гинших дууг сонсож байгаагүй боловч өдгөө сонсоод түүн дотор амьдрал үхэл үүсэх устах эр эм хүйсийн онцлог зэрэг уусан шингэснийг олж мэдлээ.

Мөнөөх хачирхалтай гинших дуун мөнөөх хүүхнээс сонсогдож байлаа. Тэр гинших дуун И Да Зингийн бие эрхтэнд агуулагдан буй ямар нэгэн дотоод хүчийг өдөөн сэрээж зүрхний цохилт нь түргэсэн амьсгал нь бачуурч ирэв. Тэр өөрийн мэдэлгүй түүнийг тэврэн автал цаад хүүхэн нь ч гэсэн өөрөөс нь тас зуурлаа...

И Да Зин гэнэт үүл манан дунд хөвөн орох мэт тархи толгойд нь юу ч санагдахаа больж өөрийн эрхгүй халуу шатах уруулаа нөгөө хүүхний торгон шаан гивлүүрийн доорхи тоорын улаан уруул руу чиглүүлэв.

Гэнэт И Да Зингийн зүрх сэтгэлд ямар нэгэн хүн <<Болиоч ээ чиний Сян дүү бол хэзээ ч ийм хүн биш!>> гэж хэлэх шиг санагдав. Жу Сян Зюнь хэдийгээр зэрлэг догшин дураараа боловч хэзээ ч ийм хөнгөн тачаангуй зан гаргадаггүй билээ. Тэрээр И Да Зинтэй онцгой дотно болсон боловч амьдралд хөл тавьж байгаа гэнэн цайлган охины ичингүй төрхөө цаг ямагт алддаггүй онцлогтой билээ. Гэтэл өнөөдөр юу боллоо гэж ийм этгээд сонин байдал гаргах билээ.

И Да Зингийн сэтгэлд сэжгийн үүл хуралдан нөгөө хүүхнийг түлхээд ууртай өнгөөр <<Чи юун хүн бэ?>> гэлээ.

Нөгөө хүүхэн усны могой мэт өөдөөс нь эргэн ирж амандаа <<Хонгор минь яачихав аа чиний сэтгэлийн галыг л бадрааж байвал миний хэн байх нь ямар хамаа байна вэ?>> гэв.

И Да Зин ухасхийн түүний нүүрийн гивлүүрийг хуу татан хаялаа.

Гэтэл түүний нүдний өмнө хавагнасан ядрангуй байдалтай хөх асрын (Хуучны хятадад янхны газрыг хөх асар хэмээн нэрийддэг байв) хүүхний царай бууж ирэв. И Да Зин сэтгэлийн доторхи бухимдлаа тэвчин дараад түүний энгэр заамнаас шүүрэн авч <<Хэн чамайг нааш нь явуулсан бэ?>> хэмээн зандарлаа.

Мөнөөх янхан хүүхэн царай барайлган ээрч гацаад <<надад ямар ч хамаагүй шүү. Харин тэр л...>> гэж ар тийшээ хуруугаараа заав.

И Да Зин эргэн харвал ард нь өндөр том биетэй усчин эр цувныхаа юүдэнгээр нүүрний ихэнхийг халхлаад сууж байлаа. Тэрээр түүний ард хэр зэрэг удаан ийн суусныг хэн эс мэдлээ. Хэдийгээр хүүхэнд сэтгэл алдран байсан боловч ард нь хэн нэгэн хүн байсныг мэдэлгүй ийн удаан байснаас үзвэл зэвсгийн эрдмийн хувьд жирийн амьтан биш ажээ. Хэрвээ тэр өөр рүү нь довтолсон бол чухам юу болох байсан нь тодорхой.

Ийн бодоход түүний ууц нуруугаар могой гулсах мэт санагдлаа.

Мөнөөх усчин эр гэнэт тас тас хөхрөн <<И өглөгийн эзэн хамаагүй бусадтай садарлахгүй аргагүй сайн эр юм гээч. Манай номын охин дүү ч сайн заяаны ханьтай учирсан юм байна аа>> гэв.

<<Хүүе махсаг лам уу даа>> гэж И Да Зин дуу алдлаа.

Мөнөөх усчинь юүдэнгээ яаран хойшлуулваас үнэхээр махсаг лам Чэн Сяо Фо байлаа.

Махсаг лам инээд алдан <<Манай номын дүү аль насандаа хийсэн буяны үрээ амсаж ийм шударга үнэнч залуутай учирдаг байна даа...>> гэлээ.

И Да Зин царай барайлган өгүүлрүүн <<Ламбугай та юунд мөхөс надаар тохуу хийнэ вэ. Бурхны шавь хүн чинь ийм муу үйлийг хийж болдог билүү>> гэв.

Махсаг лам инээд алдаж <<Арьяабал бурхан минь хөгшин лам би дэмий хэрэг хийснээ хүлээж байна. Ламбугай нь өглөгийн эзэн чамаас хүлцэл өчих нь зөв. Би чамайг эрэг рүү гаргаж өгье дөө>> гэлээ.

<<И Да Зин махсаг ламын үгэнд давхар санаа агуулагдаж байгааг мэдрэн мэхийн ёслоод <<Мөхөс миний мунхаг мулгуугаас хамаг хэрэг үүдсэн билээ. Ламбугайн үгийг сонсоход манай охин дүүгийн байгаа газрыг мэдэж байж магадгүй мэт санагдах юм. Та надад зааж соёрхож болохсон болов уу>> гэв.

Махсаг лам толгой сэгсрэн <<Мэдэхгүй мэдэхгүй дэмий балай юманд хутгалдаж явбал нас богиносдог гэдэг болохоор өвгөн лам би яахин түүнийг мэдэх билээ>> гэв.

<<Сая зохисгүй үгээр дайрсан бол ламбугай намайг өршөөнө биз дээ>> гэж И Да Зин хэллээ.

Махсаг лам ханцуйгаа сэгсрэн <<Ламбугай нь дуртай зүйлээ дүү хүүтэй хуваалцая гэтэл болгоохгүй байсан ажээ. Ямар хамаа байх вэ>> гэв.

И Да Зин угаас бусдаас юм гуйхдаа эхлээд тал олохыг хичээдэг зантай хүн тул <<Ламтан уураа дарагтун. Хэрвээ мөхөс би таны таалалд нийцээгүй үйлдэл хийсэн байх ахул яаж шийтгэхээ өөрөө мэдээрэй. Харин та надад номын охин дүүгийнхээ байгаа газрыг хэлж өгвөөс мөхөс би түмэнтээ баярлах болно>> гэлээ.

Махсаг лам өгүүлрүүн <<Ламбугай нь сайн дураа хүрвэл хэлж өгч бололгүй яахав. Гагцхүү одоо хоосон гэдэс хоржигноод архины хорхой маань гозогноод байж суухын арга алга. Тэгээд ч чиний охин дүүгийн хэргийг хоёр гурван үгээр хэлчих боломжгүй болохоор эхлээд хорхойгоо жаахан дарвал ямар вэ>> гэлээ.

Тэнгэрт тэрслүү бүлгийнхэн угаас хийж гүйцэтгэх хэлэх ярих нь этгээд сонин улс тул махсаг лам нэгэнт одоо хэлэхгүй гэсэн бол яаж ч гуйгаад нэмэргүй хэмээн И Да Зин бодлоо. Тэгээд ч өөрөө хэдэн өдөр хоосон харайлгасан тул махсаг ламын ийн сануулж хэлэхэд хоосон гэдэс нь өлсөх гэж өвдөх мэт болж байгааг сая мэдэрлээ.

Махсаг лам мөнөөх янхан хүүхэнд хандаж <<Том хөлтөө ламбугай энэ цагаан царайт залуу хоёрын гэдэс өлсөж байна гэдэг жигтэйхэн. Архи хоолны ая бодож үзээч>> гэлээ.

И Да Зин том хөлтөө гэж дуудахыг хараад түүний хөл рүү харвал үнэхээр бага эд биш ажээ. Янхан бүсгүй ийн хочлуулчихаад тоосон шинжгүй <<Би та хоёрын өлсөөг гаргаж болох л юм. Харин миний бие сэтгэлийн цангааг хэн чинь тайлах юм бэ>> гэв.

Махсаг лам шалиглан инээж <<Ламбугай нь чамд олж өгсөн энэ цагаан царайт чамд таалагдахгүй байна гэж үү>> гэв.

Том хөлт уруулаа мушийлган <<Номын улс хэзээ л ноолж ноцохдоо сайн байлаа даа>> гэхэд махсаг лам <<Энэ цагаан царайт санаанд чинь нийцэхгүй бол ламбугай нь нэг үзэх үү дээ...>> гэлээ.

Том хөлт <<Чи ч гэсэн наадахиасаа юугаараа дээрддэг юм бэ?>> гэлээ.

Махсаг ламын бэлдсэн зоог ус хуурай газрын амьтад бор цагаан хоол хосолсон тун дажгүй боллоо. Хоёр бортоготой Шао Син газрын дарсны нэгийг махсаг лам барьж том томоор гүд гүд залгилна. Махсаг лам пял шиг том амаа дарвайлган мах архи гудрангаа <<Ид ид! Алаг дэлхийн уудамд амьдрах нас хэд билээ. Алтан хундагатай дарсыг мөнгөн сартай тулга юу>> хэмээн И Да Зинг шахаж байлаа.

И Да Зинд архи ууж шүлэг гиншиж байх ухаан хаанаас төрөх билээ дээ. Хэдэн үмх хоол олж амандаа хийгээд <<Манай охин дүү тэгээд хаана байгаа хэрэг вэ? Ламбугай та эртхэн хэлж гялайлгах болов уу>> гэв.

Махсаг лам өгүүлрүүн <<Ламбугай нь нэг л архины бараа харчихвал тэнгэр бурхан дэргэд ирсэн ч намайг архинаас минь холдуулж чадахааргүй ихээр хорхойсдог юм. Алив ууцгаая ууцгаая>> гэв.

Том хөлт түүний гуян дээр суугаад эрхлэнгүй өнгөөр <<Хөгшин илжиг минь хэдэн аяга муурын шээс амсчихаад намайг тоохоо больчихов уу>> гэлээ.

Махсаг лам нүдээ сүүмийлгэн том хөлтийн нүүрийг илж үзсэнээ инээд алдан <<Ламбугай нь архи өнгө хоёрыг адилхан чухалчилж үздэг юм. Архи бол миний амь гэсэн үг. Хэрвээ өнгийг үзэх юм бол ч амиа ч гээхэд бэлэн шүү. Ха ха... И овогтоо чи яагаад ийм хачин харцаар намайг хараад байна вэ. Ламбугай нь чиний дотоод сэтгэлд юу болж байгааг мэдэж байна. Ертөнцийн сайхан хүүхнүүд ганцхан цагаан царайт чам шиг улсад очоод мань мэтийн сахил санваартай улсад хамаагүй гэж боддоггүй биз дээ. Үнэн хэрэгтээ тоост хорвоод маханбодийг олж төрсөн болохоор төрийн хар хүнч лам хувраг, гэлэнмээ, бумбын хуушаан гээд бүгд л адилхан хүн шүү дээ>> гэлээ.

Тэрээр ийн өгүүлэхдээ түүний сэтгэлийн хөндүүрийг олсон тул И Да Зин өгүүлрүүн <<Багш таны саналтай би нийлэмгүй байна. Ламбугай та бол сахил хүртэж санваартан болсон хүн яахин мань мэт шиг эгэл боргилоор сэтгэж болох билээ>> гэв.

Махсаг лам архины үнэр сэнгэнүүлэн подхийтэл хэхрээд <<Ертөнцийн бүх юм зүүд нойр ший жүжиг мэт хоосон. Их мянган ертөнц ч гэсэн оргүй хоосон байхад юунд арьсанд боосон араг ясны хойноос амиа тавин хөөцөлдөнө вэ>> гэв.

И Да Зин ам нээн юм хэлэх гэтэл махсаг лам тос болсон ханцуйгаа сэгсрэн <<За согтож байх шиг байна. Явж унтаж!>> гээд том хөлтийг дагуулан завины бүхээг рүү явлаа.

Удалгүй тэдний тачаадан инээх дуун чихэнд чийртэй сонсогдоно...

И Да Зин яахин тийм амар унтаж чадах билээ.

Завийг нэгэн хошууны дэргэдэх модноос бөхлөн уяжээ.

Шөнө дундын үест хамаг бие нь жихүүцэн даарч эхлэв. Гол нь И Да Зингийн хамаг сэтгэл зүрх Жу Сян Зюньд сэтгэл зовон тавтай унтаж чадахгүй байлаа. Тэрээр одот тэнгэрийг ширтэн Сян дүүгийн минь од хаана байдаг бол гэж санааширан хэвтэнэ. Завины бүхээгээс махсаг ламын хурхирах чимээ алсын аянга мэт чихэнд чийртэй сонсогдоно.

Удаж төдөлгүй махсаг ламын хурхирах чимээ ойртон ирэх дуулдахыг хараад И Да Зин гайхан нүдээ нээж харвал махсаг лам нүдээ аниатай чигээрээ завины бүхээгээс гарч ирлээ. Хальт харвал яг л үхсэн хүн амилаад ирэх мэт санагдаха И Да Зин айсандаа зүрх нь зогсчих шахав.

Махсаг лам түүний дэргэд хүрч ирээд гар нь цахилгаан мэт хурдан түрнэг атлаа оновчтой хөдлөн түүний нойрсуулагч цэгийг дарж орхилоо.

Хэдийгээр И Да Зин 8 хүлсийн амин цэггүй болгогч их аргыг сурсан боловч махсаг ламын хүнд цохилт түүний нойрсуулагч цэгийг удтал чимчигнүүлэн өвтгөлөө. Тэрээр өвдсөндөө дуу алдах шахсанаа <<Махсаг лам унтаагүй намайг худлаа тэнсэж үзсэн бололтой. Би ч гэсэн түүний аргыг аргаар хариулан яах гэж байгааг үзье>> гэж бодлоо.

Тэгээд нүдээ тас анин нам унтсан дүр эсгэв.

Махсаг лам нүд нь ногоорон гялалзаж И Да Зинг харсанаа инээд алдаж <<Уучлаарай цагаан царайт минь. Саргүй шөнө салхитай өдөр манай тэнгэрт тэрслүү бүлгийнхний ажил үйлээ явуулахад хамгийн тохиромжтой үе байдаг юм. Хэрвээ чи ламбугайнхаа муу үйлийг үзчих юм бол санаа урваж магадгүй. Ламбугай нь арга буюу чамайг ийм байдалтай орхиход хүрлээ. Би эргэж ирээд чамаас өршөөл эрэн хундага барих болно оо>> гэж хэлэх нь сонсогдоно.

Махсаг лам ийн өгүүлээд гэнэт үсрэн арав гаруй алд газар нисээд эрэг дээр буулаа. <<Айхтар золиг байна шүү>> гэж И Да Зин өөрийн эрхгүй шагшин бодлоо.

Махсаг лам далд орсоны дараагаар И Да Зин хэвтээ чигээрээ улаан гэрдийн дотоод хийгээ ашиглан эргийн зүг нисэн хүрэх нь махсаг ламаас

хөнгөний тамираар хэдэн хувь илүү байгаа нь илт байлаа. Тэрээр яаравчлан явсаар удаж төдөлгүй махсаг ламын барааг олж харав.

И Да Зин хөнгөний тамир хэрэглэн араас нь дагахад махсаг лам огтхон ч мэдсэн шинжгүй явна. Нэг хүж шатаж дуусахын хэр удаан явсаар нэгэн томоохон гацаанд орж ирлээ.

Нэгэн бага шиг асарт гэрэл дэн гялалзан эр эм улсын шуугилдах дуун гарахаас өөр гацааныхан бүгд нам унтжээ.

Махсаг лам мөнөөх асарт явж орлоо.

И Да Зин дөхөн очоод үзвэл асрын өмнөх том дэнлүү дээр <<Далд анхилуун асар>> гэж бичээстэй байжээ. Гэтэл тал талаас нь зузаан энгэсэг түрхсэн хүүхнүүд шаван авахыг үзээд сая эмсийн хүрээлэнд орж ирсэнээ ойлголоо.

И Да Зин янхан хүүхнүүдэд татаж чангаалгаж сандрахдаа <<Тавиач та нар чинь юу болж байгаа улс вэ>> гэв.

<<Өө энэ залуу чинь ийм ичимхий байхыг үзэхэд юм үзээгүй амьтан бололтой>>.

<<Одоохон намайг дагаад дээшээ яв эгч нь чамд яаж хийдгийг сайхан заагаад өгье...>>

Ийн бөөн хүүхнүүдэд бүслэгдэн зогсох зуур <<Ингэж байснаас нэгийг нь дагуулаад дээшээ гарчихъя. Тэгээд байдлыг харж байгаад яах учраа бодсон нь дээр бололтой>> гэж бодож амжлаа.

Асрын хоёр дарвахрт олон жижиг өрөөнүүд байх ажээ. Янхны газрын эзэн түүнийг тосон ирээд ямар хүүхэн авахыг асуулаа.

И Да Зин хэзээ язааны энэ газар ирж байсан хүн шиг царай гарган <<Том хөлтийг авъя>> гэв.

Эзэн авгай сандарч <<Эрхэмээ өршөөгөөрэй манай том хөлт өнөөдөр хүнтэй явсан. Та өөр хүүхнийг болгоохгүйсэн болов уу>> гэхэд И Да Зин барьцаа улам лавшруулж <<Чи намайг мөнгөгүй гэж бодоо юу. Түүнийг авсан хүнээс нь хоёр дахин их мөнгө гаргаж байгаад ямар ч байсан том хөлтийг авах болно доо>> гэлээ.

Нөгөө авгай илт сандран <<Гүнтэн та тогтож хайрла. Би 13 наснаасаа эхлэн ийм ажлыг эрхлээд хожим нь хүн өтөлж сувд шарладгийн эрхээр өөрөө хэдэн хүүхэн хөлсөлж энэ асрыг байгуулсан билээ. Гэтэл өнөөдрийн энэ том хөлтийг хөлсөлсөн шиг айхтар зочин үзсэнгүй. Та өөрийн аюулгүй байдлаа бодвол түүнтэй шөргөөцөлдөөд хэрэггүй л болов уу. Тэр зочин манай мөрөн голын 5 махбодийн бүлгийг хүртэл үл ойшоодог хүн

байгаа юм. Тэр хүн өнөөдөр манай том хөлтийг аваад л явсан өдийд хөөрхий минь хаана үйлээ үзэж байгаа бол доо>> гэлээ.

И Да Зин ширээ шаан уурлаж <<Махсаг лам хаана байна вэ. Би түүнтэй уулзах хэрэг байна>> гэв. Түүнийг ийн хэлж дуусаагүй байтал махсаг ламын дуу дээд давхраас дуурсан <<Аль замын ямар баатар эр уураа гаргаад байна вэ. Яриа хөөрөө байвал шууд наашаа хүрээд ирээч!>> гэх нь дуулдав.

Янхны газрын эзэн <<Одоо яадаг билээ. Одоо яадаг билээ>> хэмээн сандчиж байтал мөнөөх залуу номын эр бараа сураггүй болсон байлаа.

Махсаг лам хаа явсан газраа архи идээ бэлдсэн байдаг хойно доо ширээ дүүрэн загас мах архи дарс өрүүлж өвөр дээрээ өөр шигээ тарган янхан хүүхнийг суулгаад найрлаж байлаа.

И Да Зин дуу чимээгүй өмнө нь явж очиход махсаг лам цочисхийн харснаа <<Аа эрхэм та байсан юмуу. Би ташаа боджээ. Номч баатар И та мөрөн голын өс хонзон нэр төрийн тулаанд оролцож өөрийгөө энэ бохир булингартай ус руу дүрээд юу хийх гэсэн юм бэ. Тэр тусмаа тэнгэрт тэрслүү бүлэг 5 махбодийн бүлгийн хоорондох зай завсрыг тань шиг хүн эвлүүлнэ гэж бүүр ч байдаггүй хэрэг. Харин миний үгэнд орж өөрийн Сян дүүгээ эрж хайсан чинь дээр>> гэв.

<<Аливаа ертөнцийн хэрэг явдал ёс зүй гэдэг юмны дагуу явдаг. Тэнгэрт тэрслүү бүлэг ч бай 5 махбодийн бүлэг ч бай ялгаагүй аль алин нь ёсгүй хандаад байвал яахин дэлхий дахины олон баатар эрсийн сэтгэлийг олж чадах билээ...>> хэмээн И Да Зин хүйтнээр инээлээ.

Махсаг лам түүний үгийг сонсоод инээд алдаж <<Номч баатар та аргагүй л номын хүнийхээ үгийг хэлж байх шив. Гэхдээ ертөнцийн аливаа хэргийг ёс зүй гэсэн ганц үгэнд багтаах гэвэл том эндүүрэл байдаг юм даа>> гэлээ.

<<Танай тэнгэрт тэрслүү бүлгийн ёс зүйг чинь би мэдэж дуулсаан. Зэвсгийн эрдмийн ертөнцийг дарж мөрөн голыг захирах зорилготой>> гэж И Да Зин хэллээ.

Махсаг лам түүнийг цоо ширтэж <<Манай номын охин дүү хамаг байдгаа сэтгэлтэй хүндээ тоочсон байдаг байна шүү. Алив номч И баатар та нэг тогтоочих>> гэлээ.

<<Ламбугай та ёсорхохын хэрэггүй>> гэж И Да Зин хэлэв.

Ийн сууцгааж байтал үүдний унжлага сөхөгдөн нэгэн хүн чимээ аниргүй орж ирэв. Мөнөөх хүн хулсны гол мэт намхан туранхай агаад И Да

Зинг харснаа цочих мэт болж гараа цээжин тус газар авч мэхэсхийгээд <<И номч баатар та сайн байна уу>> гэлээ. И Да Зин хараа тогтоон харваас модон махбодийн бүлгийн салбар хайсангийн эзэн Цин Сян Тянь ажээ. Анх И Да Зин Жу Сян Зюнь хоёр модон махбодийн бүлгийн толгойлогчийн суурийг эзэлж байх үест И Да Зингийн бие 7 навчит цэцэгт хордоод байсан бөгөөд Цин Сян Тянь өөрийн бүлгийн гишүүдийг дөрвөн зүгт илгээж хорны ерөндөг сураглуулж байсан ачийг тэрээр яахин мартаж билээ.

<<Цин гуай та сайн явж байна уу>> гэж И Да Зин бөхөлзөн асуув.

<<И баатар таны буянаар эсэн мэндшүү л байна. Харин манай бүлгийн толгойлогч амар мэнд биз дээ>> гэж Цин Сян Тянь асуулаа.

Махсаг лам тэр хоёрыг хүн чинээ тоосонгүй нөгөө тарган янхан хүүхэнтэйгээ садар үг хэлэлцэн тас тас инээлдэнэ.

Тэр байдал нь Цин Сян Тяний уурыг хүргэж <<Шулмын бүлгийн садар шавь чи 5 махбодийн бүлгийнхэн энд байхад тоохгүй байна гэнээ. Хурдан сөгдөж үхлээ эрэхгүй юугаа хийсэн юм бэ>> гэлээ.

Махсаг лам гартаа дүүрэн аягатай архи барьж сууснаа Цин Сян Тянийн хараал зүхэл урсгахыг үзэж хөмсөг атируулан өгүүлрүүн <<Ямар амьтан ирчихээд омогдоод байна аа!>> гэв.

Цин Сян Тянь <<Шулмын...>> гээд цааш хэлэх гэтэл махсаг ламын гартаа барьсан аяга түүний нүүрийг чиглэн нисч ирлээ. Цин Сян Тянь хэдийгээр махсаг ламтай нударга зөрүүлж үзээгүй боловч түүний зэвсгийн эрдэм гоц гойд гэдгийг сонссон тул халз тулахаас эмээн доош бултаж амжлаа.

<<Өөдгүй новш чи нууц зэвсэг хэрэглэнэ гэнээ>> гэж Цин Сян Тянь үгээ гүйцээв.

Гэтэл махсаг ламын гараас мултран ниссэн аяга түүний өмнөхөн нь очоод хүчээ сааруулан өмнөх ширээн дээр нь буулаа. Харин түүнээс ганц дусал архи гадагшаа цацагдсангүй.

И Да Зин эн бүхнийг хараад үнэхээр гайхахын дээдээр гайхав.

Махсаг ламын дотоод хүч үнэхээр сэтгэшгүй өндөр хэмжээнд бүрэлдэж чадсаныг энэ арга нь харуулав.

Цин Сян Тяний нүүр нь нэг цайвартаж нэг хөхөрнө.

Махсаг лам өөртөө нэг аяга архи хийж хөнтөрч орхиод жанчныхаа хормойгоор амаарчин <<Цин хайсангийн эзэн та алсаас ирсэн зочин тул ламбугай нь нэг хундага тогтоохыг хүсье. Ёсорхохын хэрэггүй>> гэлээ.

Цин Сян Тянь хүйтнээр инээн <<Шулмын бүлгийн сайхан сэтгэл л манай шударга замын бүлэгт дутаж гэнэ дээ>> гэв.

Махсаг лам Цин Сян Тянийг удтал дуугүй ширтэн суулаа. Цин Сян Тяний сэтгэл ийн ширтэхэд аягүй санагдана. Ийн нилээд байсны эцэст махсаг лам толгой сэгсрэн санаа алдаад <<Хол явахгүй дээ хол явахгүй>> гэлээ.

<<Хн та нарын үйлс яаж хол явдаг юм бэ>> гэж Цин Сян Тянь хэллээ.

<<Танай 5 махбодийн бүлгийн толгойлогч Жинь Кан Лун яагаад ирсэнгүй вэ. Чамайг орондоо явуулаа юу>> гэж махсаг лам асуулаа.

Цин Сян Тянь өгүүлрүүн <<Жинь баатар шиг эрхэм хүн юу боллоо гэж чам шиг халзан илжиг дээр хүрч ирж байх юм бэ>> гэв.

Махсаг лам огтхон ч уурласангүй <<Ам хэлээ уралдуулах юм бол ламбугай нь өөрийн чинь өмнө гарч дөнгөхгүй байх. Харин зэвсгийн эрдмээр үзвэл миний гурван цохилтыг даах юм болов уу даа>> гэв.

Зэвсгийн эрдмийн ертөнцөд ёс журамтай нь тогтнож байдаг болохоос биш зэвсгийн ир хүчний давуугаар ноёрхдоггүй юм шүү гэж Цин Сян Тянь уурласандаа уруул нь дорволзон өгүүлэв.

Махсаг лам өгүүлрүүн <<Тэр бол танай шударга замынхны гаргасан хэлтгий ёс байхаа. Манай тэнгэрт тэрслүү бүлгийнхэн гагц нударганы хүчээр ярилцдаг улс. Тухайлбал эрхм та мөхөс лам миний гурван цохилтыг даахгүй байж тэнгэрт тулсан их ёс журамтай байгаад ямар хэрэг байх билээ дээ>> гэлээ.

Цин Сян Тянь хүйтнээр инээгээд <<Өчүүхэн би эрхэм ламтны нүдэнд багтаад байвал хэдэн өгөр яс байж л байна. Ламтан хэрвээ хүчээр түрэмгийлж мөхөс намайг алдаг юм гэхэд 5 махбодийн бүлгийнхэн энэ хэргийг зүгээр орхихгүй байлгүй. Түүнийг сайн бодсон биз дээ>> гээд тэрээр И Да Зинг юу гэх бол гэсэн шиг хяламхийн харав.

<<Ха ха ха>> хэмээн махсаг лам хажуудаа хүн айна гэж тоосон шинжгүй тачигнатал инээж <<Та ч мөн мөчид дотортой хүн юм даа. Хэрвээ би И Дүүг өөрийн талд татъя гэж бодох юм бол түүнд шууд л чиний Сян дүүг хаан байгаа газрыг ертөнцөд ганцхан би л мэдэж байгаа шүү. И номч баатраа хэрвээ чи надад туслан энэ мууг алчихвал би чамд Сян дүүгийн чинь байгаа газрыг хэлээд өгөх болно. Ингэж тохирвол ямар вэ?>> гээд хэлчихвэл л боллоо шүү дээ. Та нарын шударга журам гэдэг чинь иймхэн л байдаг юмдаа гэв.

Цин Сян Тянь махсаг ламд амаа таглуулчихаад нэг хэсэгтээ үг дуугарч чадсангүй.

Тэнгэрт тэрслүү бүлгийнхний эн тэнцүү эрхт 15 элч нарын этгээд сонин зэвсгийн эрдэм хорон муу арга чаргыг тэр биеэрээ амсаж байгаагүй боловч тэр тухай дуулж мэдэж байсан зүйл цөөнгүй билээ. Зэвсгийн эрдмийнхэн тэдний тухай сонсоод бүгд царай барайдаг нь нууц бишээ. Гэвч тэрээр зарим талаар төдийлөн үнэмшдэггүй болохоор хэрэг болгож наашаа ганцаар ирсэн нь энэ байлаа. Тэрээр багаасаа мөрөн голоор явж ирсэн болохоор биеэр үзэж тандахаар орж ирээд удаагүй байтал махсаг ламын үзүүлсэн архийг цалгихгүй өмнө нь буулгаж байгаа арга үнэхээр гайхлыг төрүүлэм зүйл байлаа. Гэвч нэгэнт зорьж ирсэн болохоор даруй хулжин зугтахын ёсон хаан байх билээ дээ. Түүний сэтгэлийг жаахан онгойлгож байсан зүйл гэвэл И Да Зин дэргэд нь байгаа явдал байлаа. И Да Зин 5 махбодийн бүлгийн толгойлогчдын нэг болсон болохоор түүнийг хэрхэвч ганцаардуулан орхихгүй гэж бодож байсан юм. И Да Зингийн зэвсгийн эрдмийн талаар тэр урьд өмнө нь дуулж байсан бөгөөд хоёулаа махсаг ламтай тулалдахад учиргүй ялаад байхгүй ч гэсэн юу юугүй ялагдчихгүй нь лавтай. Гэтэл махсаг лам хашир толгой болохоор И Да Зинг хөдлөх аргагүй болгоод авдаг байна.

И Да Зин өөртөө архи хундагалан ууж сууснаа <<Эрхмүүдэд ямар зөрчил маргаан байна вэ. Түүнийгээ өөрсдийгөө шийдэцгээ. Надад одоо Сян дүүгээ бодохоос илүү чухал хэрэг алга даа. Сян дүүтэй холбоотой хэрэг байх юм бол би харин оролцож болох юм. Харин түүнтэй холбоогүй хэрэг байваас би огтхон ч оролцохгүй шүү>> гэлээ.

<<Аргагүй л залуу хүний үг дээ>> гэж махсаг лам инээв.

Түүнийг ийн хэлж барахын алдад Цин Сян Тянь ухасхийн босож арга билгийн мунаа далайн махсаг ламын дэргэд давшин очоод хуй салхин мэт эргүүлэн хэдэн газрын амин цэгийг онилжээ.

Махсаг лам суудлаасаа хөдөлсөнгүй амандаа балгаж байсан архийг Цин Сян Тяний зүг годгдуулан тургиваас Цин Сян Тянь сандран бултвал мөнөөх тургисан архин дуслууд үүдийг цоо нэвтлэн гарлаа.

Цин Сян Тяний хамаг биеийн хүйтэн хөлс асгарна.

Махсаг лам суудлаасаа хөдөлсөнгүй баруун гараа сунган бүргэдийн хошуу шиг хуруугаараа Цин Сян Тяний нүүрийг чиглүүлэн довтлолоо. Цин Сян Тянь арга билгийн мунаараа түүний гарыг цохихоор завдвас махсаг лам түүний муныг шүүрэн авахаар сарвайв. Цин Сян Тянь мунаа зайлуулан

ламын хэвлийг цохихоор чиглүүлэв. Махсаг лам гараа буулган хааваас нэгэн маш эрчтэй дотоод хүч арга билгийн муныг чиглэн хариугүй алдуулах шахав.

Цин Сян Тянь ямар боловч олон жилийн туршлагатай хүн тул амьсгалаа түгжин арагш үсрээд үүдний хавьд буулаа.

Цин Сян Тянь амьсгал даран <<Замын хүзүү урт зааны хүзүү богино>> гэсэн салах ёс гүйцэтгэх үгээ хэлэхээр зэхэж байтал махсаг лам мөнөөх бүдүүн янхан хүүхнээ өвөр дээрээ суулгасан хэвээрээ суугаагаараа өөрийг нь чиглэн нисэж ирлээ. Цин Сян Тянь яаран сандран өрөөнөөс гарахаар зүглэтэл пир пархийн янз бүрийн нууц зэвсэг өөрийг нь чиглэн ирэхэд арга билгийн мунаа хуй салхи мэт эргэлдүүлэн өөрийгөө хамгаалаад өрөө рүү буцаж орохоос аргагүй байдалд хүрэв.

Махсаг лам зугуухан буцаж суурин дээрээ суугаад толгой сэгсрэн <<Чи ламтныхаа хаана ч хүрэхгүйгээ мэдээ биз дээ. Алив өрөө рүү буцаж орсон нь дээр байхаа>> гэлээ.

Тарган хүүхэн <<Халзан илжиг чи хүний хамаг юм тараагаад хаячихлаа>> гэж хараах зүхэх дуулдана.

Сайтар ажиглан харвал махсаг лам мөнөөх хүүхний хамаг байдаг ээмэг бөгж, бугуйвч, шаахай зэрэг ашиглаж болох бүхнийг нууц зэвсгээ болгож шидэлсэн ажээ.

Цин Сян Тянь улам балмагдан сандарч өөрийнх нь зэвсгийн эрдэм түүний хаана ч хүрэхгүй гэдгийг мэдсэн тул <<Ламтны зэвсгийн эрдэм үнэхээр гаргуун ажээ. Мөхөс би таны салхин доор сөгдөн мөргөө>> гэв.

<<Гэмээ мэдвэл гэгээрэхийн тэмдэг дээ>> гэж махсаг лам инээн өгүүллээ.

Цин Сян Тянь өгүүллрүүн <<Гэвч эрхэм ламтан та мэдэж байгаа болов уу. 5 махбодийн бүлгийн сүр хүч нь ганц нэг хүнд биш. Харин арга билэг 5 махбодийн хүрээнд байдаг юм шүү дээ>> гэв.

<<5 махбодийн хүрээ гэнэ ээ. Дуулаагүй юм байна шүү. Чи надад ямархуу юм байдгийг үзүүлээдэх>> гэж махсаг лам толгой сэгсрэн өгүүлэв.

Цин Сян Тянь өгүүллрүүн <<Ламтан бас хошин зантай хүн юм. 5 махбодийн хүрээг таван хүн хийж үзүүлж болохоос биш яахин ганц хүн болох билээ. Тэгээд ч түүнд Жинь Кан Лун баатар өөрөө оролцож байж ламтан тантай жинхэнэ хүчээ үзэлцэж болох шүү дээ. Ламтан минь би энэ удаа хирээ мэдэж бяраа танилгүй тантай хүч үзэх гэж ирсэн хэрэг биш билээ. Харин би Жинь Кан Лун баатрын зараалаар танд нэг үг дамжуулах

гэж ирсэн юм. Өвгөн баатар маргааш шөнийн гурван жингийн үед балар ойд тантай уулзая гэж дамжуулаарай>> гэсэн гэлээ.

Махсаг лам түүний үгийг дуусангуут <<Маргааш бол маргааш өнөөдөр бол өнөөдөр. Өнөөдрийн тооцоо дуусаагүй байгаа шүү>> гэж хэлүүт ухасхийн босож гараа сунган Цин Сян Тяний нүдийг ухахаар дайрлаа.

Цин Сян Тянь ч хэрээ тавьсангүй арга билгийн мунаа далайн тулалдаж хэдхэн агшны дотор долоо найман удаа халз тулаад амжив. Цин Сян Тянь хэдийгээр мөрөн гол заяар зард гарсан баатар биш боловч насаараа зэвсгийн эрдмээр хичээллэж байгаа хүн амь насанд тулсан энэ аюулын үеэр байгаа бүхнээ шавхан тулалдах нь аргагүй юм. Нохой хамартаа хүрэхээр усч гэдгийн үлгэрээр улаан амиа хамгаалахын тулд түүний арга билгийн муна хэд дахин хүч орсон мэт гялалзана. Түний дээр махсаг лам өөртөө хэт эрдэж суудлаасаа хөндийрөхгүй өвөр дэх тарган хүүхнээ тавихгүй байгаа нь түүнд хамгаас илүү тээг болж байлаа.

Тэдний тулалдаж байгаа өрөө угаас зай муутай тул Цин Сян Тянь хөнгөн шингэн хүн учраас эвийг нь олон нааш цааш бултаж сүлжих боломжтой байлаа. Харин махсаг лам шиг тарган цатгалан хүн тулалдахад улам ч хүндрэлтэй байв. Гэвч түүний зэвсгийн эрдэм уран гайхамшигийн манлайд хүрсэн тул дайсандаа давамгайлж гарах боломж олгохгүй байв.

<<Энэ шулмын толгойлогчийн зэвсгийн эрдэм үнэхээр гүйцэгдэшгүй юм гээч. Хэрвээ ийм маягтай байгаад байвал гарцаагүй амь насаа алдах нь>> гэж бодоод Цин Сян Тянь арга билгийн мунадаа дотоод хүчээ шингээн махсаг ламын хэнхдэгийн төв цэг рүү цохилоо. Махсаг лам түүнийг хаахаар гараа сунгатал арга билгийн муна замаа өөрчлөн махсаг ламын сандлыг цохив. Түүний сандал бутран унаж махсаг лам өнөөх тарган хүүхнээ тэвэрсэн хэвээрээ газарт буув.

Махсаг лам гэнэт өвөр дэхь хүүхнийг ор руу шидчихэв. Хүүхэн орь дуу болон орилсоор орон дээр зөөлөн буулаа.

Махсаг лам огцом эргэж нэг гараараа Цин Сян Тяний нүдийг нөгөө гараа зангидан цээж рүү нь цохихоор завдав. Цин Сян Тянь ч хашир хүн тул арга билгийн мунаа далайж түүний нүүр рүү дэлсэхээр чиглүүлэв.

Махсаг лам гандуу газраас сонгино зулгаах мэхээр дээшээ алд хиртэй үсэрч толгойгоороо адар мөргөөд доош буухдаа арга билгийн муна дээр гишгэж дотоод хүчээрээ үйлчилвээс Цин Сян Тяний уушиг зүрхийг мянган жингийн чулуу дарах мэт амьсгал авахын аргагүй болж <<Аа>> хэмээн дуу алдаж ам хамраар нь бөөн цус олгойдлоо.

Махсаг ламын баруун хөл Цин Сян Тяний толгойг өшиглөхөөр шуугиж ирэхэд Цин Сян Тянь хариу үйлдэх тэнхээгүй болсон тул үйлээ эдлэхээр хүлээж <<Хэдэн арван жил мөрөн голоор мөрөө гаргаж яваад энэ газар амиа тавих үйлтэй байжээ!>> хэмээн бодож нүдээ анилаа.

Махсаг лам түүнийг зүйл дуусгахаар завдан байх зуур араас нь нэгэн нууц зэвсэг агаар зүсэн ирэх нь сонсогдов. Хэрвээ махсаг лам шиг хараа сонор хурц хүн биш аваас түүнийг ялгаж мэдэхэд тун хэцүү ажээ. Тэр нууц зэвсэг тэргүүлэгч цэцгийн зүү мэт ямар нэгэн жижиг биет боловч дотроо асар их дотоод хүч агуулаад түүний амин цэгийг онохоор чиглэн ирж байгаа нь мэдэгдэж байлаа. Одоо тэр Цин Сян Тянийг зүйл дуусгах эсвэл түүнийг орхиж нууц зэвсгийг устгах хоёр замын аль нэгийг сонгох хэрэгтэй болжээ.

Махсаг лам олон таван юм бодож завдах чөлөөгүй тул даруй эргэн баруун гараараа мөнөөх нууц зэвсгийг шүүрэн авлаа.

Гэтэл мөнөөх нууц зэвсэг нь үмх хүрэхтэй үгүйтэй болгож шарсан мах байсан ажээ. Мөрөн голынхон гартаа тааралдсан зүйлээрээ нууц зэвсэг болгон ашиглах нь түгээмэл хэрэг боловч ийм хэмжээтэй махыг агаар зүсэн явуулахдаа дуу чимээ бараг гаргахгүй байна гэдэг дотоод хүчээ үнэхээр гаргуун зохицуулж чадаж байгаагийн илрэл тул махсаг лам хирдхийн цочлоо.

<<Ламтан нь чамайг нэг сайн сургаж өгөхгүй бол болохгүйнээ>> гэж хашгираад тэрээр И Да Зингийн өмнө давхин хүрэв.

<<Бурхны шавь хүн чинь ингэтлээ уурлаж болдог билүү. Уур уцаар элэг дотрыг муутгадаг гэж үг байдаг. Ламтан та удаан тулалдаанд ядарч байгаа байлгүй гэж бодсондоо л үмх мах явуулсан юм шүү дээ>> гэж И Да Зин инээд алдлаа.

Махсаг лам сэжигтэй инээгээд <<Лам нь эрхэм таньдаа баярлалаа>> гэж хоёр гараараа наманчилан И Да Зинд мөргөв. Энэ бол махсаг ламын өөрийнх нь буй болгосон зэвсгийн эрдмийн мэх бөгөөд <<Шавь нь хомьсим бодиствад мөргөх>> гэсэн нэртэй юм. Хүн харахад онц юм байхгүй юм шиг мөртлөө гэнэт гараа алдлан дайснаа сэрэмжгүй байхыг ашиглаж яах ийхийн зуургүй далны ясыг нь атган авдагб илээ.

И Да Зин ч алга хавсран <<Ламтан ёсорхохын хэрэггүй>> гэлээ.

<<Мөрөн гол даяар И Да Зингийн зэвсгийн эрдэм гүйцэгдэшгүй болсон гэлцдэг. Гэтэл тийм айхтар юм харагдахгүй байна>> гэж махсаг лам бодох зуур гэнэт И Да Зингийн эрхий хуруу өөрийнх нь бугуйны амин судлыг чиглэсэн байхыг олж харлаа. Тэрээр тэр даруй довтлох санаагаа гээж

<<Номч баатарийн их нэр үнэхээр хоосон алдаршаагүй ажээ. Эрхмийн чин санаа юунд байгааг айлдахгүй юу>> хэмээн инээлээ.

И Да Зин үнэн сэтгэлээсээ <<Ламтна та энэ нөхрийг маань тавиад явуулчихгүй болов уу>> гэв.

<<Ха ха мөрөн гол даяар манай шулмын бүлгийхнийг л хэлсэн амандаа хүрдэггүй гээд байдаг. Гэтэл танай шударга замын бүлгийхэн ч гэсэн хэлснээ буцаж хийснээ булдаг байх нь ээ>> гэж махсаг лам инээд алдан өгүүлэв.

<<Наадах чинь юу гэсэн үг билээ>> гэж И Да Зин гайхан асуулаа.

<<Эрхэм та энэ золиг бид хоёрыг яаж ийгээд учраа олцгоо. Надад хамаа байхгүй гэж хэлээгүй гэж үү. Гэтэл одоо хэлсэн үгнээсээ буцаж байгаа шив дээ>> хэмээн махсаг лам өгүүллээ.

И Да Зин урт хормойгоороо өвдгөө ороон суугаад <<Өө нээрээн тэгэх нь ч тэгсэн л дээ. Гэхдээ би бас Сян дүүтэй минь холбоотой хэрэг бол би зүгээр орхихгүй гэснийг та санаж байгаа биз дээ>> гэв.

<<Тэгээд юу гэж?>> гэж махсаг лам асуулаа.

<<Яах юу байх вэ. Цин Сян Тянь хэдийгээр зэвсгийн эрдэмд чиний хаана ч хүрэхгүй нь үнэн боловч модон махбодийн бүлгийн нэг хайсангийн эзэн. Гэтэл манай Сян дүү чинь модон махбодийн бүлгийн толгойлогч хүн шүү. Тийм болохоор манай Сян дүүтэй тун их холбоотой болж таарлаа. Иймд би энэ хэргийг хамаарахгүй бол яаж болох вэ. Хуучны үгэнд эзнээс нь асууж нохойг нь зод гэсэн үг байдаг. Тэгэхээр эрхэм та модон махбодийн бүлгийн нэгэн хайсангийн эзэнд ийнхүү хандах чинь намайг үл хүндлэх төдийгүй өөрийн номын дүү охиндоо ч таатай бус хандаж байгаагийн илрэл бишүү>> гэж И Да Зин өгүүлэв.

Цин Сян Тянь хашир бурхи тул И Да Зин эхлээд туслахгүй байснаа өөрийг нь махсаг ламын гар дор амь насаа алдахын ирмэгт сая тусламжийн гараа сунган авраад зогсохгүй нохой гахайтай зүйрлэн хэлж байгаад дотроо ихэд хорсон <<Муу хар завхай эр эм хоёр та нар хэзээ нэгэн цагт өвгөн миний гарт ороод ирэх өдөр байх вий. Тэр цагт би та нарын шөрмөсийг сугалж арьсийг өвчих юм хуна даа. Сайн эр өшөөгөө авахад арван жил ч багадахгүй гэж үг бийсэн. За ямар ч байсан энэ хэцүү давааг даваадхая>> гэж бодож суулаа. Тэрээр амьсгалаа түгжин анхаарлаа төвлөрүүлэн дотоод хүчээ зохицуулна.

Махсаг лам үргэлжлүүлэн <<Эрхэм та тэгээд заавал энэ булингартай ус руу хутгалдах гээд байгаа юм биз дээ>> гэлээ.

<<Ламтан та өршөөн соёрх>> гэж И Да Зин хэлэв.

<<Эрхэм та энэ модон махбодийн хоолны савтай нийлчихвэл намайг дөнгөнө гэж бодоод байгаа хэрэг үү>> гэж махсаг лам асуулаа.

<<Заавал хоёулаа нийлэхийн хэрэг юун. Ганц мөхөс би ламтан таны хоёр гурван мэхийг хариулах гээд үзье>> гэж И Да Зин бодлогоширонгуй өгүүлэв.

<<Удтал уулзаагүй байтал эрхмийн байдал өөр болжээ. Гэвч чи ухаалаг хүн сайн бодоорой л доо. Хүний амьдрал зовлонгийн далай дунд үргэлжилж үхэл л тэр зовлонгоос гэтэлгэж чаддаг гэдэг боловч энэ өөдгүй нохойны төлөө амиа золиослох хэрэг юу байна вэ>> гэдгийг сайтар бодож үзэв үү гэж махсаг лам хүйтнээр инээлээ.

<<Хамаа алга, хамаа алга. Муур нохой ч бай хамаагүй. Үхэх төрөх заяанаас үгээгүй баян тэнгэрээс гэж үг бий>> хэмээн И Да Зин хэллээ.

Махсаг лам үгийн солиогүй түүний цээж рүү дайрлаа.

И Да Зин хэдийгээр наанаа номын хэнээтэй болхи бойнгодуу мэт боловч цаанаа их л ул суурьтай хүн билээ. Тэрээр эрт орой энэ тулалдаанд хутгалдаж Цин Сян Тянийг аврах хэрэг гарна гэдгээ мэдэж байсан тул махсаг ламын тулааны онцлогийг гярхай ажиглан харж байсан юм. Гэтэл түүний арга мэхнээс тийм урсгалынх гээд хэлчихээр цэгцтэй юм олж хараагүй билээ. Өөрөөр хэлбэл махсаг ламын зодооны арга нь тогтсон хэв шинжид баригдаагүй тухайн нөхцөл байдлын хувиралтад зохицсон арга мэхийг санаандаа бодож төсөөлөн түүнийгээ хэрэгжүүлж байгаа нь илт байх ажээ.

И Да Зин махсаг ламыг ялъя гэвэл ямар ч онцгой зэвсгийн эрдмийн арга мэх хэрэглээд нэмэргүй өөртэй нь адилхан тухайн нөхцөлд тохирсон эвсэл хөдөлгөөний бодож гаргаад тэмцвэл болох юм гэж санасан билээ. Тэгээд тэрээр хулсан лимбээ шүүрэн авч махсаг ламын нүдний өмнүүр ямар цэг рүү хатгах вэ гэдгээ ч бодож төлөвлөсөн юмгүй учир утгагүй шахам эргэлдүүлж гарав. Энэ нь ч үр дүнгээ өгч И Да Зингийн хулсан лимбэ түүний аль ч цэг рүү хатгаж мэдэх тул махсаг лам түүн рүү ойртон дөтөлж чадсангүй юуны өмнө анхаарлыг нь сарниулах хулсан лимбийг булаан авахаар ухасхийв. Гэтэл И Да Зингийн хулсан лимбэ агаарт дүүлэн эргэлдэх хуй салхи мэт барьцгүй ажээ. Хулсан лимбэ баруун талд нь эргэлдэн бүжиж байсанаа тэр зүгт нь хандвал зүүн талаас нь хатгахаар дайран ирэх жишээтэй.

Зэвсгийн эрдмийн хамгийн өндөр түвшин нь <<Мэхгүй>> арга гээч болдог бөгөөд махсаг ламын арга мэх ийм түвшинд дөхсөн билээ. Өөрөөр хэлбэл тэрээр тийм мэх хийнэ гэж төлөвлөхгүй өрсөлдөгчийнхөө хийсэн мэхэнд тохирох хариуг тухайн үедээ самбаачлан санаж түүнийг хэрэгжүүлдэг гэсэн үг юм. Тодруулваас түүний <<Мэхгүй>> арга нь өрсөлдөгчийнхөө <<Мэхтэй>> арганд тулгуурлан ялалт байгуулдаг байна. Гэтэл өнөөдөр бас л өөр шиг нь мэхгүй аргатай хүнтэй учирчихаар яах учраа олохоо больчихов.

Тэрээр хоёр алгандаа хамаг дотоод хүчээ шингээн И Да Зингийн цээж рүү цохиход И Да Зин ч хоёр алгаараа угтуулан тосож дотоод хүчээрээ мөргөлдлөө.

И Да Зингийн дотоод хүч нь хэдийгээр асар их боловч биеэ засах тэнхрүүлэх чиглэлтэй болохоос бус дайсантай тулалдахад зориулагдаагүй болохоор махсаг ламын хөх мөрний догшин давалгаа мэт их дотоод хүчний түрэлтэд автан амьсгал нь давхцаад тархи толгой нь дүүрээд явчихав.

Гэвч махсаг лам ч гэсэн бас дотроо ихэд гайхаж байсан нь юу гэвээс тэрээр өдий олон жил мөрөн голоор явахад олон сайн эрстэй дотоод хүчээр тулалдаж бүгдийг нь ялж байсан түүхтэй. Гэтэл жирийн нэг муу номын эр түүний асар их дотоод хүчийг даван гарч чадна гэдэг үнэхээр санаанд багтамгүй хэрэг байлаа.

<<Хэрвээ энэ хүнийг устгахгүй бол хожмын их гай барцадын үүд хаалга болох нь>> гэж махсаг лам бодож байлаа. Ийн бодоод тэр өөрийн дотоод хүчнийхээ эрчийг улам нэмлээ.

Хэдэн удаагийн дотоод хүчний давалгааг даван гарсны дараагаар И Да Зин түүнд дасаж харин ч дотоод хүчний мөргөлдөөнөөр тэнцэх байдалтай болж ирэв. Хараажаар түүний дотоод хүчний эх булаг махсаг ламыг бодвол дундаршгүй тул тэр ялах нь гарцаагүй болж эхэллээ. Зэвсгийн эрдмээр махсаг ламыг ялна гэвэл туйлын хэцүү нь ойлгомжтой боловч алганы дотоод хүчээр түүнийг цааш харуулах нь алга урвуулахын төдий хэрэг болжээ. Махсаг ламын хөлс борооны дусал мэт бөнжигнөж эхлэв. Гэвч И Да Зин яахин хүн алах санаа төрөх билээ. Түүний гол зорилго бол Цин Сян Тянийг аврах явдал байсан билээ. Гэвч тэр хоёрын хэн нэг нь үхэхээс наана алганы наалданги салах нь амаргүй хэрэг болоод байв. Хэрэв больё гэж бодоод хүчээ сулруулсан тал нь үхэхээс гарцаагүй байдалд хүрнэ. Тийм болохоор хоёр тал амь тэмцэн алганы хүчээр тулалдах ажээ.

Тэр хоёр ийн байх зуур хажуудаа өөр нэг хүн байгааг мартаж орхисон байлаа.

Цин Сян Тянь хэдийгээр хүнд дотоод шарх авсан боловч сая хэсэг зуур дотоод бясалгал хийж зовиураа нилээд арилгаж чадсан тул арга билгийн мунаа тулан өндийн босож ирээд <<Ха ха эрхмүүд хоёр тийшээ болох юм биш үү. Хэрвээ салж ядаад байвал ах нь та хоёрыг хоёр тийш нь болгож өгдөг юм билүү дээ. Тийм тулалдах дуртай аваас эрлэг хааны ордонд очоод үргэлжлүүлж болно шүү>> гэв.

И Да Зин ихэд гайхан <<Наадах чинь юу гэсэн үг вэ?>> гэвээс Цин Сян Тянь <<Юу байх вэ дээ. Би чинь нэр алдраа дуурсгасан шударга замын талын хүн юу боллоо гэж та хоёр шиг шулмын бүлгийхэнд тусалж байх вэ. та хоёр мөрөн голоор хэрэн хэсэж муу муухай бүхнийг хийж дуусгаад өнөөдөр миний гарт орж үйлээ эдлэн үхэх болно>> гэлээ.

<<Өөдгүй амьтан!>> гэж И Да Зин уулга алдав.

<<Өөдгүй амьтан гэнэ ээ. Зөв дөө өөдгүй нь үлдэж өөдтэй нь хальдаг хорвоо доо. Хэрвээ нэр нүүр амь нас хоёрынхоо аль нэгийг сонго гэвэл би мэдээжийн хэрэг амь насаа авч үлдэх болно... Тэгээд ч махсаг лам бол шулмын тэнгэрт тэрслэгч бүлгийн 15 эн тэнцүү эрхт элчийн нэг. Үйлдсэн муу хэрэг нь мөрөн гол даяар шуугиулж үхэхэд үлдэл нүгэл нь арвин хоцрох байх. Чи ч гэсэн бас өөдтэй амьтан биш дээ. Шулмын бүлгийн өөр нэгэн толгойлогч Жу Сян Зюньтэй нөхцөн шороон махбодийг эзэгнэн модон махбодийн суурийг булаан авсан. Чи намайг юу гэж бодоо вэ. Модон махбодийн бүлгийн толгойлогчийн суурь уг нь надад хамаарах ёстой байсан юм. Гэтэл Му Цин Ся гэж тэр нэг амьтан төмөр махбодийн бүлгийн толгойлогч Жинь Кан Лунгийн өргөмөл охин болохоор түүний нэрийг бодож би өөрт оногдохыгоо түүнд өгсөн хэрэг. Би чамд сайндаа тэр олон хүнийг илгээж чамд хорны ерөндөг хайлгасан гэж чи бодно уу. Үнэндээ тийм ерөндөг байхгүй гэдгийг би мэдэж байсан болохоор зориуд тэгж буянтай царай гаргаж байсан юм шүү. Чиний дараа би уран үгээр илбэдэн шулам бүсгүйг мөрний өмнөх хорч Ду авгай руу илгээсний хүчинд тэрээр одоо дотоод хүчээ алдаад эрэмдэг амьтан болон хувираад байгаа. Одоо би та хоёрыг зэрэг тонилгочихоод дараа нь шулам хүүхнийг очиж устгах болно>> гэлээ.

Ийн өгүүлээд арга билгийн мунаараа И Да Зингийн зуун уулзвар цэгийг цохив. Хэрвээ өөр хүн байсан бол ийн цохиулахад нам үхэх ёстой. Гэтэл И Да Зин 8 хүлсийн амин цэггүй болгогч их аргыг сурсан болохоор

арга билгийн муна зулайн зуун уулзвар цэгт хүрэх агшинд арга билгийн мунаар нь И Да Зин болон махсаг ламын дотоод хүч хамсан гадагшилж Цин Сян Тянь руу нөлөөллөө. Цин Сян Тянь шиг барагтайхан эр яаж тэр хоёр лут амьтны дотоо хүч хавсран ирж байхад зүгээр тэсэн гарч чадах билээ дээ. <<Аа>> хэмээн дуу алдаад цонхоор шидэгдэн хашаа хорооны дундах худгийн амсрын дэргэд унав. Цин Сян Тяний довтолгооноор махсаг лам И Да Зин хоёр ашгүй хоёр тийш салцгаахын сацуу И Да Зин ухасхийн гадагш гүйн гарлаа.

Тэр даруй И Да Зин махсаг лам хоёр асрын дээр Цин Сян Тянь худгийн амсаар дээр завилан сууцгаагаад дотоод хүчээ сэлбэхийн тулд бясалгал хийн сууцгаалаа. Тэр гурвын дундаас И Да Зин л гадаад хийг сорон авсан тул хамгийн ашигтай байдалд байлаа. Хагас цаг ч бололгүй тэрээр нүдээ нээн <<Чи яаж байна вэ?>> хэмээн махсаг ламаас асуулаа.

Махсаг лам бүгт бөглүү дуугаар <<Түүнийг даруй алагтун>> гэв.

<<Хэнийг тэр билээ?>> гэж И Да Зин гайхан асуулаа.

<<Түүнийг алагтун>> гэж махсаг лам давтан хэлэв.

И Да Зин санаа алдаад <<Ламтан минь өршөөн нигүүлсэх хэрэгтэй үед өршөөлтэй хандах учиртай. Хэдийгээр тэр ичгүүргүй муухай зан гаргасан боловч алсуураа бидний амь насыг аварсан ачтан хүн шүү дээ>> гэв.

<<Би чамайг алагтун гэж тушааж байна шүү>> хэмээн махсаг лам хүйтнээр зандрав.

<<Хэрвээ тэрээр гэнэт довтолоогүй болвоос ламтан таны тэнцэшгүй их дотоод хүчийг тайлж чадах хэн байх билээ дээ. Нэг цаг гурван хором ч бололгүй бид хоёрын хэн нэг нь амь насаа алдах байсан биш гэж үү>> хэмээн И Да Зин түүнийг ятгалаа.

Махсаг лам энэ номын хэнээтийн яршигтай үглээ гэдгийг мэдэх тул дуу гарсангүй дотоод хүчээ гүйлгэн бясалгалаа үргэлжлүүлэн үйлдэж гарав. Түүний дотоод хүч нэн зузаан тул удаж төдөлгүй царай нь гэрэлтэн амьсгал нь жигдэрч ирлээ. Ийн хүч сэлбэгдэхийн сацуу махсаг лам босож ирлээ. И Да Зин махсаг лам Цин Сян Тянийг алах гэж байгааг ойлгоод ухасхийн босож үүд халхлан зогсов.

Гэтэл махсаг лам огцом эргэж тарган янхан хүүхнийг шүүрэн аваад И Да Зингийн зүг шидэж орхилоо. Тарган хүүхэн часхийтэл дуу алдан ухаан алдаад махан бөмбөг мэт И Да Зингийн зүг нисэн хүрч ирлээ. И Да Зин ч өөрийн мэдэлгүй түүнийг тосон барьж авав. И Да Зин хэдийгээр бусадтай

харьцуулашгүй их дотоод хүчтэй боловч янхан хүүхэн овор том биетэйн дээр махсаг ламын дотоод хүч нэмэгдсэн тул яаж ч чадалгүй орон дээр өнхрөн унаад өгөв.

<<Ламтаан чи юунд гэмгүй хүний амийг хөнөөнө вэ>> гэж И Да Зин уурсан асуулаа.

Зэвсгийн эрдмийн төв шударга замынхан ёс журмыг эрхэмлэн зодооны сургуульгүй хүн рүү нударга зангиддаггүй уламжлалтай билээ. Тэр тусмаа дотоод хүчээр энгийн хүн рүү халдах бүр ч цээртэй хэрэг юм. Харин махсаг лам мэт тэрс номын бүлгийхэн хүний амь хөнөөнө гэдэг шоргоолж алахтай адилхан хэрэг боловч И Да Зингийн хувьд саяхан л янаг дотно харьцаатай байсан янхан хүүхний аминд хүрчихнэ гэдэг ухаан санаанд багтамгүй хэрэг байлаа.

Энэ зуур махсаг лам бараа сураггүй алга болсон байв. И Да Зинд түүнийг хөөх ухаан сөгөө байсангүй янхан хүүхнийг орон дээр тавиад амьсгалыг нь чагнан үзвэл унтаж байгаа мэт жигд амьсгалж байлаа. Махсаг лам түүний нойрсуулагч цэгийг дарсан хэрэг байжээ. Харсаар байтал түүнийг алчихав уу гэмээр довтолсон боловч үнэн хэрэгтээ түүний унтуулагч цэгийг дарсан төдийхөн байж шүү дээ гэж И Да Зин бодлоо.

Махсаг лам Цин Сян Тянийг алах гэтэл И Да Зин зам хөндөлсөхийг үзээд янхан хүүхнээр анхаарлыг нь сарниулах гэсэн хэрэг байжээ. И Да Зин янхан хүүхний эсэн мэнд байхыг үзээд санд мэнд гадагш гүйн гарлаа. Алтан нарын анхны цацраг уулын цаанаас цухуйн цэлгэр мөрний мандал улаан туяа цацруулна. Махсаг лам Цин Сян Тянь хоёрын бараа сураг ч алга болжээ. Мөнөөх жижиг суурингийн хуучин гармын дэргэд махсаг ламын завь ёроолыг нь хөмрүүлэн хаяад усны мандал дээр хөвөн явах нь үзэгдэнэ.

И Да Зин нэг буурчийн газар олж аваад шунаг аргагүй нойрсож гарлаа.

ШИЙДВЭРЛЭХ ТУЛАЛДААН

Араас довтолох алганы салхи асар хүчтэй тул хэрвээ Жинь Кан Лун Жу Сян Зюнийг ангал хад руу түлхлээ гэхэд өөрөө ч гэсэн амьд үлдэх найдлагагүй болох байлаа. Тэр олон ч юм бодолгүй арагш ухартал хэн нэгэн хүн түүний хажуугаар салхи татуулан Жу Сян Зюнийг булаан аваад ум хумгүй арилж өгөх нь тэр. Энэ бүхэн түүний ухаан санаанд оромгүй хэрэг байсан тул уурлах бухимдах зэрэгцэн сайтар тогтоож харваас И Да Зин байх

нь тэр. Жинь Кан Лун хорин хэдэн жилийн турш мөрөн голоор мөрөө гарган явахдаа алдаж эндэж байсан удаа байхгүй тул уурлах хорсохын туйлд хүрч <<И овогтоо наад хүнээ орхигтун>> хэмээн хашгирав.

И Да Зин мөрний өмнөд нутгаас хайж бэдрэн явсан боловч Жу Сян Зюний сураг чимээг ч гаргаж чадаагүйг уншигч та мэдэх билээ. Харин азаар Жу бүсгүй 8 хүлсийн нарсны нууц агуйд очоод Фу Яогийн амин цэггүй болгогч нууц бясалгалын аргаар хичээллэж суугаа юм биш биз дээ гэж бодсон нь оносон хэрэг байлаа. Тэр энэ бодолдоо хөтлөгдөн 8 хүлсний нарсны дэргэд хүрч ирэх агшинд Жу Сян Зюнь төмөр махбодийн толгойлогч Жинь баатарт олзлогдон ангал хадан дээрээс түлхэгдэн унахад бэлэн болсон байхтай тааралдсан хэрэг байлаа. Тэрээр зэвсгийн эрдмээр мөрөн гол даяар тэргүүн зэрэгт тооцогдохоор болсон боловч дайсантай тулах ухааны уран аргын хувьд гэнэн тэнэг хэвээрээ тул олон ч юм бодох сөхөө байсангүй Жинь Кан Лун рүү шууд алганы салхиар довтлон анхаарлыг нь сарниулж байгаад хайртай бүсгүйгээ салган авч ум хумгүй зугтсан нь энэ байлаа.

И Да Зин араас нь Жинь Кан Лун баатар хөөн ирэхийг үзээд аливаа бүхнийг умартан 7 нарс руу гүйн орж 8 хүлсийн алхаагаар явж гарлаа. Жинь Кан Лун түүний араас хүчлэн хөөх боловч огтхон ч гүйцэж чадахгүй байв. Тэр угаас ухаан саруулын дээр 5 махбодь, 8 хүлс зэрэг нь төмөр, мод, ус, гал, шороо 5 махбодийн бүлгийхний нандин шүтээн гэж болох тул удаж төдөлгүй мөнөөх хэдэн нарсны байрлал болон И Да Зин 8 хүлсийн алхаагаар яваад байгаагийн учрыг олж болдог хүнийхээ өмнө таардаг аргаа хэрэглэж дээ гэж сэтгэлдээ элэглэн шоолов. Тэгээд тэр ухасхийн мөнөөх 8 хүлсийн нарсан дундаас гарч завилан суулаа. <<И Да Зин мэдээжийн хэрэг энэ нарсан дундаа насан туршид гарч ирэхгүй суугаад байхгүй нь лав. Тэр нарсан дундаасаа гараад ирвэл мөнөөх 8 хүлсийн алхаа нь сохор зоосны үнэгүй болон хувирч залуу хосыг барьж авах нь алга урвуулахын төдий амархан хэрэг боно гэж Жинь Кан Лун дотроо бодож байлаа.

И Да Зин нэгэн нарс модыг түшин үгийн солиогүй аахилан зогслоо. Жу Сян Зюнь түүний духан дээрхи хөлсийг арчаад <<И ахаа та ингэж нэг хүрээд ирдэг байжээ>> гэв.

<<Ирэх нь ч ирлээ. Харин явж чадахаа байх шив дээ>> гэж И Да Зин гашуунаар инээвхийлэв. <<И ахаа ийм хэргийг шийдэж ядаад байх юусан билээ. Та намайг өгчихвөл мултран гарч болно шүү дээ>> гэж Жу Сян Зюнь бодолхийлэн өгүүлэхэд <<Тэр яаж болох вэ? Чамайг арайхийж нэг юм олж

авсан болохоор одоо амь насаа алддаг байлаа ч гэсэн дахин салж үхэхгүй шүү>> хэмээн И Да Зин хэлэв. <<Зин ахаа Жинь Кан Лун таныг ганцаараа байхад тогтоож үлдээнэ гэдэг тийм ч амархан хэрэг биш. Таныг явсаны дараа би хэдийгээр түүний гарт үлдэх боловч нэр сүрээ бодоод намайг хорлохгүй нь лавтай. Тэр цагт та өөр нэг сайн арга бодож олоод намайг авран гаргахад юу нь оройтох билээ>> хэмээн Жу Сян Зюнь хэллээ.

<<Болохгүй ээ. Үхсэн ч сэхсэн ч цугтаа байх хэрэгтэй>> гээд И Да Зин толгой сэгсэрлээ.

<<Зин ахаа та үнэхээр сайн хүн юмаа. Би муухай ааш гаргаж мөрний өмнөд нутагт танаас салан явсанд та уурлаагүй биз дээ>> хэмээн Жу Сян Зюнь тормогор хархан нүдэндээ том сувдан нулимс мэлмэрүүлэн асуулаа.

<<Хаанаас даа би өчүүхэн ч гомдоогүй. Би л чамаас юу ч нуух учиргүй байсан юм>> гэж И Да Зин хэллээ. Тэгээд тэрээр багш нь хэрхэн түүнийг өөрийнхөө охинтой суулгах гэж шахамдуулсан боловч өөрөө зөвшөөрөөгүй. Түүний хариуд багш нь хэрвээ 4 махбодийн толгойлогчийн суурийг булаан авч өөрийнх нь охины сүй бэлэг болгох аваас өөрийг нь Жу Сян Зюньтэй суухыг зөвшөөрөх болзол тулгасан зэргийг нэгд нэгэнгүй ярьж өгөв.

Жу Сян Зюнь тас тас инээхэд нүдэнд нь мэлтэрсэн тунгалаг нулимс судал татуулан сувдрах агаад И Да Зингийн цээжийг зөөлөн цохиж <<Манай багш хар багаасаа гэлэнмаа болсон болохоор хаанаасаа охин байх билээ дээ. Тэр намайг охин шигээ хайрладаг байсан юм. Тэр охинтойгоо суу гээд байсан бол суух хэрэгтэй байжээ. Яагаад гэвэл тэр охин нь би байсан юм шүү дээ>> гэв.

И Да Зин түүний хэлээд байгаагийн учрыг ойлголгүй <<Чи чинь юугаа яриад байгаа юм бэ?>> хэмээн асуулаа.

<<Манай багш угаас хорвоогийн эрчүүдийг хог новшноос долоон доор үздэг юм. Тийм болохоор чиний чин шударга гэдэгт яахин итгэх билээ дээ. Тэгээд охинтой хэмээн чиний үнэнч эсэхийг туршин үзсэн хэрэг. Хэрвээ чи өчүүхэн төдий л сэтгэл урвах хандлага гаргасан байх юм бол арван амьтай байгаад ч амьд мултрах найдлага үгүй болох байсан юм даа.

И Да Зин сая л хамаг учрыг ухаж <<Багш даанч надаас салах үедээ шавь минь чиний ийм үнэнч сэтгэлтэй байгаад чинь би үнэхээр сэтгэл ханамжтай байна гээд байсан нь ийм учиртай байжээ>> гэлээ.

<<Тэнэг хүн тэнгэр заяатай гэдэг л энэ дээ>> хэмээн Жу Сян Зюнь инээлээ.

<<Үнэнээр явбал үхэр тэргээр туулай гүйцнэ гэвэл таарах байхаа>> гэж И Да Зин хэлэв.

Сэжгийн бараан үүл арилж Жу Сян Зюний сэтгэл цэлмээд явсан тул баяр хөөрийн сэтгэлээр царай нь улаа бутран гэрэлтэнэ. И Да Зин ч биеэ барьж чадалгүй толгойгоо бөхийн түүний тоорын улаан уруул дээр үнслээ.

<<Нөгөө томоотой хүн чинь энэ үү дээ>> гэж Жу Сян Зюнь эрхлэнгүй хэлэв.

И Да Зин өврөө уудлан шороон махбодийн бүлгийн анжисны хэлтэрхийг гаргаж ирээд <<Номын дүү минь би чиний сүй бэлгийг гардуулж байна>> гэлээ.

Жу Сян Зюнь мөнөөх хатуу ган төмрийг гараараа илбээд <<Өнөөдөр ч бид хоёр Жинь Кан Лунгийн гараас амьд мэнд мулттрахаасаа өнгөрсөн байх даа. Тийм болохоор энэ төмөр бид хоёрыг чөтгөр болсны дурсгал болох байлгүй>> гэлээ.

<<Би уг нь чамтай цуг үхэх гэж наашаа ирсэн билээ. Гэтэл одоо үхмээргүй байна. Тэр тусмаа чамайг бол бүр ч үхүүлэхгүй. Хорвоо ертөнц ийм сайхан байтал юунд үхэхдээ тулдаг билээ. Тийм болохоор би өвгөн Жинь Кан Лунтай гурвантаа халз тулалдаад хоёр ялах юм бол мултран гарвал ямар вэ>> хэмээн И Да Зин хэлэв.

Жу Сян Зюнь И Да Зинг хосгүй эрдэм сурсан гэдгийг мэдэх боловч дотроо сэтгэл зовнин <<Та түүнийг үнэхээр ялж чадна гэж үү дээ?>> хэмээн асуулаа.

<<Манай багш чинь мөрөн гол дотроо эгнэшгүй эрдэм чадалтай хүн шүү дээ. Хэдийгээр шавь би сурсан эрдэм мөхөс боловч тийм сайн багшийн буянаар ганц муу өвгөнийг дөнгөх юуны хэцүү байх билээ>> гээд хэсэг бодолхийлснээ <<Жинь Кан Лун хэдийгээр манай багшийн энд хүрэхгүй боловч бид гурав нийлбэл 5 махбодийн бүлгийн толгойлогч боллоо гэсэн үг. Тийм болохоор гурав тулалдаж гурав ялна гэвэл арай хэтэрсэн хэрэг болно. Тэгэхээр гурав халз тулалдаад хоёр ялна гэж байгаа юм л даа>> гэлээ.

Жинь Кан Лун 8 хүлсний нарснаас гараад завилан сууж бясалгал хийж байсан болохоор нөгөө хоёрын юу ярьж байсныг огт сонсоогүй байлаа. Гэтэл И Да Зингийн дуу гэнэт гарах сонсогдож <<Жинь баатраа хоёулаа гурвантаа халз тулалдаад хоёр ялсныхаа болзлыг хүлээн авбаас ямар вэ>> гэв.

Жинь Кан Лун хэдийгээр И Да Зиний зэвсгийн эрдэм үнэхээр хачин гайхалтай дотоод хүчийг тэнсэж мэдэшгүй гүн гэдгийг мэдэх боловч өөрийн

хэдэн арван жилийн дотоод хүчний бясалгал болон мөрөн голынхоо туршлага дээр үндэслэх юм бол түүнийг ялан дийлнэ гэдэг огтхон ч хэцүү асуудал биш гэдгийг мэдэж байгаа болохоор гурвантаа халз тулалдаад хоёр ялна энэ тэр гэж донгосохыг сонсоод <<Хоёр ялагдах нь битгий хэл ганц удаа ялагдах юм бол Жинь Кан Лун би дахин мөрөн гол даяар мөрөө гарган явах нэр нүүргүй болох буй за>> гэж дотроо басамжилан бодсон боловч угаас хашир хянамгай хүн тул юмыг яаж мэдэх вэ хэмээн <<Яаж тулалдах саналыг чинь сонсоё>> гэж асуулаа.

Хэрвээ жинхэнэ зэвсгийн эрдмээр халз тулалдваас өөрийнх нь толбот хулсны 18 цохилтоор түүнийг ялах найдлага тийм ч их биш тул Жу Сян Зюнийг байтугай өөрөө ч түүний гарт олзлогдон хоцорч мэдэх юм гэж И Да Зин бодоод <<Манай багш надад 18 төрлийн зэвсгээс бүгдийг зааж өгсний дээр бүгд хатуу харгис мэхтэй болохоор өвгөн батар та алдаж эндэх ахул нэгэн үеийн баатар нэрийг гутааж мэдэх талтай тул хоёулаа эхлээд дотоод хүчээрээ халз тулалдваас ямар вэ>> гэж асуулаа. <<Чи төрсөн цагаасаа эхлээд дотоод хүчний бясалгал хийж байсан байлаа ч гэсэн намайг ялна гэдэг юу л бол. Ёстой өөрөө миний аманд ороод ирнэ гэдэг энэ байх даа. Тун удахгүй хөсөр унасан хэвтэж байх байлгүй>> гэж бодсон боловч түүнийгээ ил гаргалгүй <<Хөгшин өвгөн би номч баатар таны дээдийн эрдэм чадлыг харахыг хүсч байна>> гэлээ.

<<Би түүнтэй дотоод хүчээрээ тулалдаж байх зуур чи сэмээрхэн 8 хүлсийн нарснаас гарч явдаг юм шүү>> гэж Жу Сян Зюнд сэмээрхэн хэлснээ дотроо <<Би өмхий өвгөнтэй үхэх сэхэхээ үзэж байхад Сян дүү минь юу боллоо гэж явж зүрхлэх бүилээ>> гэж бодлоо. Тэгээд тэрээр 8 хүлсний нарсан дотроос гарч Жинь Кан Лунгийн өмнө очиж адилхан завилан суугаад <<Өвгөн ах болгоогтун>> гэлээ. Хоёр алга нийлүүлэнгүүт Жинь Кан Лун шууд хамаг хүчээ шавхан дайрсангүй. Харин И Да Зин угаас мөрөн голын туршлага нимгэний дээр дотоод хүч нь багтаж ядан оволзох тул Жинь Кан Лун даруй үнэн хүчээрээ түүнийг тогтоон барив. Тэрээр <<Муу хар хэрээ мэдэж бяраа таньдаггүй номын хэнээтийг дээ>> хэмээн занан бодоод дотоод хүчээ таван хувь хүртэл нэмтэл нэг их сүртэй эсэргүүцэл мэдэгдэхгүй тул долоон хувь хүртэл хүчилтэл сая бие нь тогтвортой болж ирлээ.

Зэвсгийн эрдмийн номын дагуу бусдаас өрсөн довтлохыг сургадаг бол Жинь Кан Лун түүний эсрэг хөдөлж байгаад И Да Зин дотроо баяртай байлаа. Тэрээр хамаг хүчээ шавхан Жинь Кан Лун өвгөнг ялчихаад энэ

золигийн газраас холдон салахын түүс болж байлаа. Жу Сян Зюнь энэ үед 8 хүлсний нарсны хаяанд ирчихээд тэр хоёрын тулааныг харан огсож байсан тул И Да Зингийн ийн яарахыг үзээд дотроо хирдхийн сандарлаа. Тэрээр хэдийгээр насан бага боловч зэвсгийн эрдмийн ёсонг гаргуун сайн мэддэг билээ. Хэдийгээр түрүүлж довтлох нь өөрийн гэсэн сайн талтай боловч хэдэн дайралтын дараа ашгийг олж эс чадах аваас өрсөлдөгчдөө довтлох сиймхий олгодгийг тэр яахин эс мэдэх билээ. Жу Сян Зюнь энэ тухай И Да Зинд сануулъя гэж бодовч дотоод хүчээр халз тулалдаж байгаа үед анхаарал сарниулах хамгаас цээртэй байдаг тул ямар ч арга байсангүй. Гэтэл И Да Зин түүнийг аль хэдийн олж хараад <<Сян дүү чи хурдан зугтахгүй наанаа юу хийж зогсоно вэ>> гэж хэлдэг байна шүү.

<<Тэнэг минь чи ярих юм байвал наадхиа ялчихаад дараа нь болдог юм байгаа биз>> хэмээн Жу Сян Зюнь зандарлаа.

Жинь Кан Лун И Да Зинг юм дуугарахыг хараад анхаарал нь сарнилаа гэж баярлан дотоод хүчээ есөн хувь хүртэл нэмлээ. Гэтэл түүний өөдөөс мөн адилхан хэмжээний хүч ундрэн гарч ирээд эсэргүүцэн тогтоосон тул И Да Зингийн бие ялимгүй доргих төдий болоод тогтож орхилоо. <<Энэ хүн юм ярьж байх үед ч гэсэн дотоод хүч нь сарнихгүй байхыг үзвээс нэн аймшигтай ажгуу>> хэмээн тэрээр дотроо хачирхан бодож байлаа. Тэгээд дайснаа басамжилах сэтгэлээ орхин хамаг анхаарлаа алганы хүчиндээ төвлөрүүлэн суулаа. Жинь Кан Лунгийн хэрсүү хянамгай байдал нь үнэн чанартаа илүүц хэрэг байжээ. Хэдийгээр И Да Зин гайхамшигт учирлаар Фу Яогийн 8 хүлсийн зургийг олж дотоод хүчний бясалгалаар үнэхээр өндөр зэргийг олсон боловч өвгөн баатрын хэдэн арван жилийн сургууль дасгалын үр дүнтэй харьцуулах юм бол бас чиг гэж хувь дутуу байсан билээ. Тийм болохоор Жинь Кан Лун арван хувийн хүчийг гаргасан бол И Да Зин газар дээрээ үхэх нь гарцаагүй хэрэг байв.

И Да Зин усны түрлэг ундрэн гарах дотоод хүчээрээ довтолсоор Жинь Кан Лун есөн хувийн дотоод хүчээрээ хамгаалсаар хагас цаг гаруй хугацаа өнгөрөхөд өвгөн баатрын царай хүрлийн улайж номч баатрын царай цаас мэт цонхийсоор байв. Жинь Кан Лун довтлох цаг болсныг үзээд дотоод хүчээ арван хувь хүртэл нэмэгдүүлэв. Энэ үед И Да Зингийн дотоод хүч арга буюу дийлдэж амь тавихад хариугүй дөхөж амьсгаа нь дээрдэж эхэллээ. Жу Сян Зюнь түүний болохоо байсныг ойлгоод шууд алхсаар Жинь Кан Лунгийн дэргэд хүрч ирлээ. <<Чи хурдан зугтаахгүй юундаа наашаа хүрч ирэв ээ. Би хариугүй болохоо байлаа>> гэж И Да Зин сандран хашгирлаа.

<<Та нар яахав дотоод хүчээрээ тулалддаг юм байгаа биз. Би харин Жинь Кан Лун баатартай жаахан юм ярьж уйтгарыг нь сэргээмээр байна>> гэж Жу Сян Зюнь хэлэв. Жу Сян Зюнь дотоод хүчээ алдсан болохоор И Да Зинд ямар ч тус хүргэж чадахгүй гэдгээ мэдэж байлаа. Харин тэр И Да Зинтэй ярих зуур Жинь Кан Лун юу ч эс дуугарахыг үзээд анхаарлаа сарниулахгүй байхыг эрхэмлэж байгааг ойлгосон билээ. Тэгээд тэрээр даруйхан Жинь Кан лунгийн дэргэд суугаад <<Жинь баатраа дорой охин би вээр хэдэн хэргийн учрыг өнөө хэр ойлгохгүй явдаг тул та түүний учгийг надад тайлан соёрхож болохсон болов уу>> гэв.

<<Муу хар золигийг дээ би энд амь наана там цаана байхад юуных нь чамтай ярих сөгөө байх билээ>> гэж Жинь Кан Лун бодсон боловч аман дээрээ түүнийгээ хэлж зүрхэлсэнгүй.

Жу Сян Зюнь түүний царай гахайн элэг шиг улайхыг үзээд сэтгэлдээ тэсгэлгүй уурлаж байгааг мэдээд үргэлжлүүлэн <<Би мөрөн голоор анх мөрөө гарган гарч ирээд танай 5 махбодийн шавь нарыг алж 4 махбодийн толгойлогч нартай үхэх сэхэхээ үзэлцсэний дараа энэ уулын өвөр дэх тоорын цэцэгт суурингийн ойролцоо тантай тааралдахад та намайг яагаа ч үгүйгээр эс барам надад сувдан цэцэг нэгийг бэлэглэсэн нь хожмын өдөр маш их хэрэг болсон билээ. Гэсэн атлаа та миний дүрд нэгэн охиныг хуурамчаар хувилгаад газар сайгүй хүн алуулж ачаа хөсөг дээрэмдүүлж байсан чинь юуны учир билээ гэдгийгээ хэлж өгөхгүй юу?>>.

Жинь Кан Лун түүнийг ганц цохилтоор алчихмаар байсан боловч угаас хашир хэрсүү хүн тул түүнийг эс тоон хамаг анхаарлаа И Да Зингээс ирэх алганы хүчийг эсэргүүцэхэд хандуулж байлаа.

Жу Сян Зюнь <<Чи үнэн хэрэгтээ нэг сумаар хоёр туулай намнах санаа өвөрлөж байсныг чинь би мэдээгүй гэж чи бодож байна уу? Чи нэг талаар надад саймшран тал олж байгаад миний гараар мод, гал, ус, шороо 5 махбодийн бүлгийг даруулж мөрөн голыг ганцаар захирах гэсэн атгаг санаа агуулж байсан шүү дээ. Нөгөө талаар чи миний дүрд нэг хуурамч охиныг тоглуулан гэмт хэрэг үйлдүүлж хар цагаан хоёр замын бүлгийхнийг бүгд миний эсрэг хандуулахаар би арга мухардан чамайг бараадан ирж гарын дорхи туслагч чинь болохоос өөр замгүй болно гэдгийг чи тооцоолсон биз дээ. Гэвч чи хичнээн нарийн уран арга мэх зохиолоо чг эсэн яахин надаас тэр бүхнийгээ нууж чадах билээ. Тэр өдөр би уулын зам дээр ачаа хөсгийг мөрдөн яваар хариугүй гэмт этгээдийг барихаар завдтал чи нууц зэвсэг харваж түүнийг устгасан шүү дээ. Тэр өдөр би яагаад чи тэр гэмтнийг

устгадаг билээ гээд гайхаж байсан юм. Гэтэл чи хүү шидэж тэрэг хожих арга хэрэглэсэн гэдгийн учир хожим тодорхой болсон билээ. Би нэгэн хөсөг хамгаалагчийн биеэн дээр миний салхи гүйцэгч 18 аргын ор мөр байх боловч түүний наран хэмээх амин цэг дээр алтан зүү хатгаастай байхыг олж мэдсэн юм. Тийм болохоор тэр хүн эхлээд нууц зэвсэгт оногдоод дараа нь илдэнд цавчуулж үхсэн байж таарна>> гэлээ.

Жинь Кан Лунгийн царай зэвтэй төмөр шиг зэвхий дааж ирсэн боловч дуугарах сөхөө байхгүй байлаа. Харин И Да Зин түүний өмнөөс өлгөн аваад <<Сян дүү минь Жинь баатар болвоос төв шударга бүлгийн тэрүүн. Тийм болохоор чи түүнийг гутаан доромжилж яахин болох билээ>> гэлээ.

<<Төв шударга бүлэг гэнэ ээ. Хэрвээ миний үг үнэн биш бол тэр юунд дуугарахгүй байгаад байх билээ>> гээд Жу Сян Зюнь хүйтнээр инээлээ.

Шударга замын бүлгийхэн нэр сүрийг амь наснаас илүү эрхэмлэдэг тул Жинь баатар И Да Зингийн гарт үхдэг байлаа ч хамаагүй Жу Сян Зюнийг цохиод авмаар санагдаж гараа салгах гэсэн боловч яахин салж чадах билээ. Тэрээр <<Чи битгий дэмий донгосоод байгтун>> гэж хэлэнгүүтээ И Да Зингийн дотоод хийний хүчинд цохиулан ам хамраасаа цус годгодуулан үхэдхийн уналаа.

И Да Зин ухасхийн босож очоод дотоод хүчээрээ түүний улаан гэрд цэгт үйлчилэн сэргээхийг оролдвоос удаж төдөлгүй Жинь Кан Лун ухаан орж сэргээд <<Мөрөн голд шинэ үеийн хүчирхэг баатар эр тодрон гарсан ажуу>> гэж хэлээд Жу Сян Зюнийн зүг эргэн харж <<Журамт бүсгүй Жугийн ухаан санаа үнэхээр хурц ажээ. Би бүр биширч гүйцлээ. Харин наад ам хэлээ жаахан дарж байвал гэмгүй байх шүү>> гэж хэлээд завилан сууж үргэлжлүүлэн бясалгалаа хийж гарав.

И Да Зин Жу Сян Зюний гарыг түшин 8 хүлсийн нарсны зүг чиглэн алхлаа.

Гэнэт тэдний араас Жинь Кан Лунгийн дуу гарч <<Хоёр залуу баатар хүлээж байгтун. Дараа сарын энэ өдөр хөгшин би Алтан уулнаа баатар эрсийн их цуглааныг хийх гэж байгаа. Та хоёр ч гэсэн гийгүүлэн ирнэ буй за>> хэмээн хашгирлаа. Ийн хэлээд тэр хоёрын хариу хэлэхийг эс хүлээн уулын уруу одлоо.

И Да Зин арван хэд хоног дотоод хүчээрээ үйлчилсэний эцэст Жу Сян Зюний зэвсгийн эрдэм болоод дотоод хүчийг сэргээж чадлаа. Жу Сян Зюнь зэвсгийн эрдмээ алдсан боловч түүний нарийн арга ухааныг гаргуун мэддэг бол И Да Зин хорвоод хосгүй дотоод хүчтэй атлаа түүнийг нарийн хэрэглэж чадахгүй байгаа нь алтан эрдэнэсийн санг эзэгнэсэн атлаа ганц зоос зарж мэдэхгүй хүнтэй үлгэрлэж болохоор байлаа. Тэр хоёр өнгөрсөн арван хэдэн хоногийн турш энэ бүх дутуу дундуураа харилцан нөхвөрлөсний эцэст мэдлэг ухаанаараа нэгэн ижил түвшинд хүрч иржээ. Жинь Кан Лун баатрын хэлсэн алтан уулан дахь баатруудын цуглаан болоход ердөө хорин хдээн хоног үлдээд байлаа. Хэдийгээр баатруудын цуглаан нэртэй боловч үнэн хэрэгтээ тэнгэрт тэрслүү бүлэгтэй нэгийгээ үзэх тулалдаан болно гэдгийг Жу Сян Зюнь сайн мэдэж байлаа. Тэнгэрт тэрслүү бүлгийн 15 элчээс 13 нь төмөр махбодь бүлгийн толгойлогч Жинь Кан Лунгийн гарт орсон бөгөөд махсаг лам Чэн Сяо Фо болохоор шанаган хорхой мэт гулгамтгайн дээр гагцхүү өөрт ашигтай нөхцөлд л дайсан этгээд рүүгээ дайрах зальтай нэгэн тул баатруудын цуглаан дээр гагцхүү Жу Сян Зюнь л ганц биеэрээ шударга замын баатар эрстэй нэгийгээ үзэлцэх магадлалтай билээ. Тэрээр хэдийгээр өөрийн Сян Зюний салхи гүйцэгч 18 илдийн аргыг Жинь Кан Лунтай тулалдахад зориулан хэнд ч үзүүлээгүй өдий хүрсэн боловч халз тулалдахын цагт ялна гэхийн итгэл тун бага байв. Тийм болохоор И Да Зинтэй хүчээ нэгтгэсэн цагт сая түүнийг ялж чадах нь ойлгомжтой.

Харин И Да Зингийн тухайд шал өөр бодолтой байлаа. Тэрээр мөрөн голоор мөрөө гаргасан ахар богино хугацааны хооронд шороон махбодийн бүлгийн ахлагч, хорч Му Дань Ду авгай усан махбодийн бүлгийн ахлагч болоод Жинь Кан Лун нартай тулалдаж байсан боловч зэвсгийн эрдмээр хичээллэсэн улсын үг хэл үйл явдал нь нэг л этгээд сонин болохыг мэдсэн билээ. Тэрээр толбот хулсны гэлэнмаа авгайгийн өнгөрөөсөн үеэ ямагт дурсан санах болсон юм. <<Хулсан хашаа хулсан байшингийн эргэн тойронд шувуудын жиргээнээс өөр ямар ч анир чимээ байхгүй. Хайртай багш халамжит амраг Жу Сян Зюньтэйгээ цуг хорвоогийн аливаа бухимдал хорслоос ангид нам гүм амьдрахсан>> гэдэг бодол түний ухаан сананад эргэлдэнэ.

Гэвч тэрээр хэрхэвч Жу Сян Зюний бодлыг ятган сэнхрүүлж чадахгүй гэдгээ мэдэх тул ямар арга байх билээ.

Өлзийт өдрийн болзоот цаг боллоо. Хоёр хос янаг сэтгэлийн жаргалд автсаар Алтан уулнаа хүрэлцэн ирэхэд олны хөл хөгжөөн гэхээр юмгүй гагц Жинь Кан Лун өвгөн уулын хормойд тэр хоёрыг тосон авлаа. Тэдний өргөөний их танхимд хүрсний эцэст Жу Сян Зюнь өгүүлрүүн <<Жинь баатраа олон баатар эрс хараахан хүрэлцэн ирээгүй байгаа хэрэг үү. Бид хоёр л яаран эртхэн ирсэн хэрэг болох нь ээ>> хэмээн асуулаа.

<<Мөрөн голын олон баатар эрс танай тэнгэрт тэрслүү бүлгийн 15 эн тэнцүү эрхт элчүүдэд алуулах нь алуулж шархдах нь шархдаад дууссан шүү дээ. Азаар үлдэж хоцорсон ганц нэг нь яахин өөртэй чинь тэрсэж тэмцэхээр зүрхлэн ирж чадах билээ. Тийм болохоор өдгөө баатар нэрэнд дүйцэх нь зэвсгийн эрдмийн ертөнцөд хөгшин би болоод хоёр залуу баатраас өөр хэн байх билээ>> хэмээн Жинь Кан Лун цай барингаа өгүүлэв. Ийн өгүүлээд тас тас хөхрөх дуунд танхимын нуруун дээр тогтсон тоос пургин хийсэх нь нэн сүртэй. Жинь Кан Лун хэдийгээр ийн өгүүлэх боловч Жу Сян Зюнь И Да Зин нарыг огт тоохгүй байгаа нь нүүрэн дээр нь илхэн үзэгдэнэ. Түүний үгийн цаад утга нь мөрөн гол тэнгэрт тэрслүү бүлгийг оролцуулаад тэр аяараа өөрийнх нь өлмийд сөгдөх цаг ирсэн гэдгийг илтгэх ажгуу. И Да Зин угаас бүдүүн хадуун хүн тул түүнийг яахин ялган салгаж ойлгох билээ. Харин Жу Сян Зюнь түүнийг аль эрт мэдэрсэн байв. Гэхдээ тэрээр дотроо ихэд баяртай байлаа. Учир нь мөрөн голын нийт баатар эрс цугларсан байх аваас олны хүч оломгүй далай тул ганц ганцаараа тулалдаад ч гарцаагүй үхэхэ байв. Харин И Да Зинтэй хоёулаа хосолвол ганц Жинь Кан Лун юу болох билээ дээ.

<<Тэгвэл бид хоёр Жинь Кан Лун баатар танаар жаал зугаа юм заалгах хэрэг болох нь ээ>> хэмээн тэр асуулаа.

<<Журамт бүсгүй Жу та юундаа тэглээ яарах билээ. Нэгэнт баатар эрсийн цуглаан зарласнаас хойш хөгшин би та хоёртой гарцаагүй тулалдаж таарна. Харин манай 5 махбодийн бүлэг угаас нэгэн гэрийн ахан дүүс мэт байсаар ирсэн түүхтэй. И Дүү зурхайт номонд мэргэшсэн хүн тул төмөр, мод, ус, гал, шороо нь арга билиг болоод 5 махбодийн ёсноос үүдэлтэй гэдгийг яахин эс андах билээ. Тийм болохоор 5 махбодийн жагсаал нь зуу гаруй жилийн турш бүрэлдэн тогтсон эд байгаа юм. Хэдийгээр миний үед хөгжиж гийгүүлээгүй боловч бас ч гэж урагшлан хөгжсөн үү гэвэл үгүйсгэх аргагүй. 5 махбодийн бүлгийн жагсаалыг сөрж зогсох баатар эр төдийлөн олон байхгүй байсан боловч өнөөдөр хоёр залуу баатар эртэй эрдмийн сайн

илдийн хурцыг үзэлцэх завшаан тохиосон нь хөгшин миний гурван үедээ тохиож буй аз завшаантай хэрэг мөнөөс мөн билээ>>.

Жу Сян Зюнь тас тас хөхрөн <<Хөгшин ах та мэдээж дуулсан байлгүй дээ. Номч баатар И болвоос нэгэнт модон махбодийн бүлгийн толгойлогч болсон. Мөхөс би хэдийгээр эрдэм чадалгүйн туйл боловч хэрээ мэдэхгүй модон махбодийн бүлгийн ахлагч болсон билээ. Харин гал махбодийн тухайд махсаг лам Чэнь Сяо Фо эзэгнээд байгаа. Тийм болохоор 5 махбодийн жагсаал гэдэг хоосон нэрнээс цаашгүй хэрэг болох биш үү>> гэв.

Жинь Кан Лун ч гэсэн өөдөөс нь тас тас хөхрөн <<Хоёр залуу хэдийгээр баатар сүр ихтэй атлаа үг хэл үйл ажил чинь жаахан хүүхдээс өөрцгүй ажгуу. Ганц зэвсэг атгасан төдийгөөр 5 махбодийн бүлгийн толгойлогч болчихно гэвэл та бүхэн биднийг дэндүү басамжилсан хэрэг болох бус уу. Би та хоёрт нарийн учрыг хүүрнэн хэлсү. 5 махбодийн бүлэг бүрд өөрийн гэсэн нууц бясалгалын судар байдаг юм. Бүлгийн толгойлогч болсон хүн тэр судрын дагуу сургууль хийсний эцэст сая 5 махбодийн бүлгийн жагсаалд оролцох эрхтэй болдог юм даа. Та нар хэдийгээр бүлгийн толгойлогч болсон гэх боловч тэр нандин судрын дагуу хичээллэсэн бил үү. Тийм бөгөөс хөгшин надад харуулаадах л даа>> гэв.

Жу Сян Зюнийн сэтгэл сэрдхийгээд түүний үгэнд үнэхээр нэгэн учир байгааг олж мэдэв. <<Хөгшин ах зэвсгийн эрдэмд гаргуун төдийгүй ухаан санаа хурц сэргэлэнгийн хувьд мөрөн гол даяар эгнэж зэрэгцэх хүн үгүй ажээ. Би тэнгэрт тэрслүүбүлэг болоод бусад бүлгүүдтэй тэмцэлдэж байх зуур та таван махбодийн бусад бүлгийхний нууц судрыг олж аваад жагсаалыг эмхлэн байгуулж амжаа шив дээ. Тийм үү?>> гэж асуулаа.

<<Журамт бүсгүй та үнэхээр сэргэлэн гавшгай хүн юм гээч. Энэ хэргийн төлөө хөгшин би та хоёрт баярлах учиртай юм шүү. 5 махбодийн бүлэг хэдийгээр бие биедээ түшигтэй байдаг байсан боловч бас ч гэж бие биенээсээ нилээд зэнзийрхэх байдалтай байдаг байсан юм шүү. Харин хоёр баатар мөрөн гол даяар нэр алдраа дуурсгаж эхлээгүй бол тэд яахин намайг түшин ирж нандин судраа хөгшин надад гардуулах билээ дээ>> хэмээн Жинь Кан Лун өвгөн толгой дохин инээлээ.

<<Жинь баатар та арай амны алдас хийж байгаа хэрэг биш биз дээ. Хэрэвээ таны хэлсэн наад үгийг чинь бид хоёр цааш нь цуурчихвал таны нэгэн үеийн баатар нэрэнд чинь сэв суулгаж мэдэх биш үү?>> гэж Жу Сян Зюнь асуув.

<<Арай үгүй байхаа. Та хоёр өнөөдөр нэгэнт ирсэн боловч явахын цагт үг хэлж чадахаа больсон байх болов уу>> гэж Жинь Кан Лун хариулав.

Түүний хэлэх үг тэр хоёрыг аль хэдийн авсанд оруулснаас өөрцгүй сонсогдох тул И Да Зин ихэд уурсан <<Би өөрийг чинь өвгөн ах гэж хүндэтгэж байтал арай дэндэж байгаа хэрэг биш үү>> гэлээ.

Жу Сян Зюнь харин тэгтлээ уурласангүй <<Өвгөн ах цаг нар яваад өгсөн тул эртхэн илдийн хурцыг үзэлцвээс ямар вэ дээ>> гэлээ.

Жинь Кан Лун хариуд нь <<Та хоёр хүч хавсраад миний зохион байгуулсан 5 махбодийн жагсаалтай тулалдвал зөвшөөрнө биз>> гэлээ.

Жу Сян Зюнь <<И ахаа 5 махбодийн бүлгийн жагсаал туйлын амаргүй эд тул би яахин түүний нарийн учрыг олж дөнгөх билээ. Тийм болохоор ах та эхлэн тулалдаж эвдэхийг хичээгтүн. Таныг ялсаны дараа охин дүү би чинь Жинь баатрын арга мэхтэй тулалдаж үзье>> гэв.

Жинь Кан Лун түүнтэй үг хэлээ уралдуулахыг хүссэнгүй гараа дохивоос таван хүн гарч ирлээ. Тэд болвоос Жинь Кан Лунгийн том шавь, гал махбодийн бүлэг усан махбодийн бүлгийн хоёр шавь нараас гадна модон махбодийн бүлгийн Цин Сян Тянь, шороон махбодийн бүлгийн толгойлогч асан одоо дэд тэргүүн Ту Ди Хан нар байв.

Тэднийг хараад Жу Сян Зюнь модон махбодийн бүлгийхэн угаасаа өөрт нь тийм үнэнч байгаагүй гэдгийг мэдэх боловч Цин Сян Тянь жагсаалын дунд байгааг хараад өөрийн эрхгүй хирдхийн цочиж <<Цин хайсангийн эзэн та өөрийн бүлгээс урван бүлгийн толгойлогчийнхоо өөдөөс тэрсэн тэмцэх санаа агуулна уу>> хэмээн зандарлаа. Тавь гаруй насны Цин Сян Тяний нүүрэн дээр өчүүхэн ч хувирал гаралгүй <<Чи юуных нь бүлгийн толгойлогч байх билээ. Модон махбодь болвоос төв шударга бүлэг тул яалаа гэж чам шиг шулам хүүхнээр бүлгийн толгойлогчоо болгох билээ>> хэмээн хариуллаа.

Харин Ту Ди Хан л нилээд эвгүйрхсэн байдалтайгаар нам дорой дуу гаргаж <<И номч баатраа Ту овогт би таны өмнө буруутайг өршөөж үзээрэй>> гэв.

И Да Зин <<Зүгээр зүгээр>> гэв.

Мөнөөх таван хүн шороо төвд мод зүүн этгээдэд гал өмнө зүгт, төмөр баруун талд, ус умардад гэсэн байрлал эзлэн зогсоцгоов. И Да Зин жагсаал руу дайран ороод толбот хулсны 18 цохилт мэхээ үзүүлэн 5 хүнтэй тулалдаж гарлаа. Тэрээр зурхайт номд мэргэшиж арга билэг таван махбодийн сургаалыг гарын арван хуруу шигээ мэдэх тул аргалж дөнгөнө

гэсэн бодолтой байсан боловч хэрэг дээрээ шал өөр болохыг удаж төдөлгүй мэдрэв. Нэгэн ер бусын далд хүчин түүнийг эзэмдэн амьсгал авахад нэн бэрхтэй болж ирлээ.

5 махбодийн жагсаал болвоос зэвсгийн эрдмийн хувирлаас гадна дотоод хүчний цул нэгдэл байлаа. 5 махбодиос шороо, ус, төмөр гурав билгийн хүчтэй гал, мод хоёр аргын хүчийг агуулсан тул И Да Зин жагсаалын дунд оронгуут хөвөн мэт зөөлөн блгийн хүчнээс гадна далай түрлэг мэт асар хүчтэй аргын хүч дарамтлахыг мэдэрлээ. Хамгийн аймшигтай нь энэ хоёр арга билгийн хүч нэгдэхээрээ амьсгал ч авахад нэн бэрхтэй болгож байлаа. Азаар мөнөөх 5 хүн тэргүүн зэргийн баатар эрс бишийн дээр И Да Зингийн дотоод хүчин хорвоод хосгүй тул тэрхэн зуур ялалт ялагдал шийдэгдэхэд хараахан эрт биш байлаа.

И Да Зингийн толбот хулсны 18 цохилт арга нь хөл гарын суурьтай зогсолтыг шаардсан төдийлөн хурдан хөдөлгөөн хэрэггүйн дээр арга билгийн хүчинд автан бүр ч удааширсан тул өрсөлдөг тав нь түүний арга мэх бүрийг алган дээрээ тавьсан мэт нарийн мэдэж зохих хариу барьж байлаа. Тэр ч байтугай Цин Сян Тянь амжиж арга билгийн мунаараа хоёронтоо И Да Зингийн амин цэгт онож цохисон боловч тэрээр амин цэггүй болгогч их аргаар сургуулилсан тул өчүүхэн ч гэм хор болж чадсангүй.

И Да Зин 5 махбодийн жагсаалыг эвдэх нь бүү хэл харин ч хүний гарын шүүс болоход тун ойрхон очоод байлаа. Нэг жилийн өмнө тоорын цэцэгт сууринд Жинь Кан Лунгаас бусад дөрвөн махбодийн бүлгийн толгойлогчид Жу Сян Зюнь руу дайрах үед И Да Зин чухам өөрөө зааварчилан амь мултруулж байсан түүхтэй билээ. Түүнийг амархан эвдэж чадсаны учир гэвэл төмөр махбодийн Жинь Кан Лун байгаагүй болохоор бүрэн төгс жагсаал болж чадаагүй байсан юм. Харин энэ удаа 5 махбодь бүгдээрээ байгаа болохоор сүр хүчин нэн их болсон байлаа. Энэ жагсаалын нэг онцлог нь дайралт хамгаалалтыг хослуулж аргын дунд билиг, билгийн дунд аргын хүчийг агуулсанд байлаа. Аль ч тал руу нь дайрлаа гэхэд биеийн хоёр талд болон ар талаас өөр нэгэн хүн арга билгийн хүчээр хавсран дайрах тул тун бэрхтэй эд байв.

И Да Зингийн нүдэнд гэнэт баярын оч гялсхийв. 5 махбодь бие биедээ ивээл байхын дээр бас ч гэж харш байдаг их ёсонг тэр саналаа. Тэд нар 5 махбодийн бие биесээ төрүүлдэг ёсоор жагсаалаа бүрэлдүүлсэн бол бие биедээ харш ёсоор хариу дайран эвдэж яагаад болдоггүй билээ гэж тэр бодсон байлаа. Тэр ингэж бодонгуут <<Хаврын салхин хацар илбэх>> арга

мэхээр төвд байрлах шороон махбодийн бүлгийн Ту Ди Ханы хоолой руу хулсан лимбээрээ зангав. Ту Ди Хан урьд өмнө И Да Зинтэй нударга зөрүүлж байсан түүний арга мэх этгээдийг мэдэх болох тул сандран анжисны үзүүрийг дээш өргөж хамгаалваас тэр нь хуурамч довтолгоон байсан ажээ. И Да Зин гэнэт биеийн байрлалаа өөрчлөн <<Хаврын салхин хараацайг хазайлгах>> арга мэх болгон Ту Ди Ханы толгой дээгүүр үсрэн гарч өмнө этгээдэд байгаа гал махбодийн толгойлогч асан Хуо Шао Чунгийн шавийн зүг зангалаа. Гал махбодийн бүлгийн шавь сандран илдээ сунган түүнийг хатгахаар завдахад И Да Зин маш хурднаар түүнээс зайлан бултахад илдийн үзүүр түүнийг биш шороон махбодийн толгойлогч Ту Ди Ханы ар нурууг хатгахаар чиглэв. Ту Ди Хан араас нь илдийн салхи ирэхийг мэдрээд сандран анжисны үзүүрийг ар тийш эргүүлтэл тэрхэн зуур усан махбодийн бүлгийн төмөр сэлүүр араас нь цохихоор чиглэн ирэв. Гал ус хоёр махбодийн шавь нар И Да Зингийн хүчийг хүчээр хариулах арга мэхэнд орсноо мэдэн хариу арга хэмжээ авахаар завдсан боловч амжсангүй түс тас хийх их чимээ гаран хөөрхий Ту Ди Хан ар өврөөсөө зэрэг цохиулан амаараа цус садруулав. 5 махбодийн жагсаал самуурахын зэрэгцээ И Да Зингийн байдал дээрдэн санаачилгыг бүрэн гартаа авлаа. Тэрэн <<Урин салхин унгирлаар наадах>> мэхээ хэрэглэн мөнөөх 5-ыг бүрмөсөн унагаж авлаа. Тэрээр тэдний оногдсон амин цэгүүдийг тайлж босгоход гагц усан махбодийн бүлгийн шавь зуун уулзвар амин цэгтээ онуулсан тул амь тавьсан байлаа.

Жинь Кан Лун тас тас инээгээд <<Үнэхээр гаргуун сайхан арга мэхийг үзүүллээ. Хэдийгээр манай 5 махбодийн бүлгийн жагсаал хорвоод хосгүй ид хүчтэй боловч энэ 5 хоолны сав яахин түүний хэргийг гаргаж чадах билээ. Та 5 хоолны сав шившигээ хутгаж гүйцсэн бол хурдан тонилохгүй юугаа хийсэн юм бэ>> гэж хашгирахад мөнөөх 4 усан махбодийн бүлгийн шавийн шарилыг аван танхимаас гарч одлоо.

Жинь Кан ЛУн зугуухан босож ирээд <<Дараагийн удаа хөгшин би журамт бүсгүй Жу Сян Зюний салхи гүйцэгч 18 илдийн аргын ид хүчийг үзвээс ямар вэ>> гэлээ.

Жу Сян Зюнь илдээ зугуухан хуйнаас нь сугалж <<Мөхөс би вээр мөрөн голоор үзэгдэх болсон нэг жил гаруйн хугацаанд босоо илдийн гурван аргыг хэрэглэн Сян Зюний салхи гүйцэгч 18 аргаа өнөөдрийг хүртэл хэнд ч үзүүлэхгүй байсаар өдий хүрсэн билээ. Жинь баатар та өөрийн гаргуун эрдмээр мэлмий юуг минь мялаах буй за. Харин И ах та миний өмнөөс хавь

ойроыг хянамгай сэрэмжлэн харж байвал зохино. Яагаад гэвэл төв шударга замынхан дунд ичгүүргүй этгээдүүд тун олон байдаг юм. Тэд ил шулуун тулалдаад дийлэхгүй болохоороо нууц зэвсгээр бусдыг хөнөөхөөс сийхгүй. Хэрвээ алтан зүү, мөнгөн хануур жад зэргээр унтуулдаг цэг зэрэг рүү минь онилох аваас И ах та илдийн хүчээр хааж өгөөрэй>> гэв.

Жу Сян Зюний гар хатуу чангаас гадна ам хэл нь ч гэсэн бас адилхан гүйцэгдэхгүй нэгэн билээ. Тэрээр ийн өгүүлэхдээ үг бүхэн нь Жинь Кан Лунгийн хөндүүр газрыг төнхсөн хэрэг байлаа. Жинь Кан Лун энэ удаа мөрөн гол даяар баатар эрсд оон урилга явуулаагүйн учир гэвэл тэд өөрийнх нь гэм булхайг уудлан илчлэх бий гэж болгоомжилсон явдал юм. Тэр Жу Сян Зюний ийн хэлэхийг сонсоод өнгөн дээрээ хэдийгээр тайван дүртэй байх боловч үнэн хэрэгтээ тэсгэлгүй уурсан <<Нас бага атлаа ямар хурц үг хэлтэй золиг вэ. Өнөөдөр чи ч мөн ахынхаа гараас амьд мэнд мултрах байх даа>> гэж бодож байв.

Жу Сян Зюний илд сунан хүрч очиход Жинь Кан Лун яаран илдээ сунгаад хаалаа. Хоёр илд харшихын сацуу тал тал тийшээ оч бутран үсрэхэд өвгөн баатар огт жишим ч үгүй зогсож харагдана. Харин Жу Сян Зюнь зогтусан ухарснаа бат суурийг олон зогслоо.

Хөвөн мэт хөнгөн илд хэмээн эртнээс нааш хэлэлцсээр ирсэн нь учиртай. Яагаад гэвэл 18 төрлийн бусад зэвсгээс ялгарах онцлог гэвэл илд хөнгөн гавшгай уран налархайгаар онцлогтой байдаг юм. Жу Сян Зюний хэрэглэдэг <<Салхи гүйцэгч 18 илдийн арга бүхэн нь гурван хувиралтай гэж үзвэл нийт 54 хувиралтай болох ажээ. Тэд нар бүгдээрээ хурдан гавшгайн туйл гэж болохуйц юм. Тэдгээрийн нэг болох <<Жихүүн салхи тэргүүлэгч цэцгийг тэмтрэх>> арга сум могой мэт Жинь Кан Лунгийн хоолойг чиглэн гялсхийхдээ алтан булаг, тэнгэрийн заадал зэрэг гурван амин цэгийг нэгэн зэрэг онилжээ. Жинь Кан Лун огтхон ч сандарсангүй илдээ цээжний өмнө босоо байрлалтай бариад Жу Сян Зюний илдийн дайралтыг ярж зайлуулангуутаа хариу түүний бугуйг тас цавчихаар заналхийлэв. Ингэснээр хамгаалалт дайралтыг нэгэн амьсгаагаар амжуулсан хэрэг байлаа. Гэтэл Жу Сян Зюнь огтхон гараа хамгаалж ухраасангүйгээр үл барам биеэ хажуу тийш зайлуулангуутаа Жинь Кан Лунгийн илдээр ярах хүчийг дагуулан өөрийн илдийн аргаа өөрчлөөд <<Хүйтэн салхи тэргүүлэгч цэцгээр наадах>> мэхэнд хувирган өвгөн баатрын нар саран нийслэлийн үүд зэрэг гурван амин цэгийг зэрэг онилох нь тэр. Жинь Кан Лун хэдийгээр өдий

наслахдаа юу эсийг үзсэн хүн боловч энэ удаа үнэхээр цочирдон балмагдлаа.

Толбот хулсны гэлэнмаа авгай тэр жил <<Сян Зюний салхи гүйцэгч 18 аргыг>> бодож гаргахдаа эмэгтэй хүн хэрэглэх юм шүү гэдгийг онцгой анхаарсан хэрэг байлаа. Түүний шавь эмэгтэй хүн болохоор дотоод хүчээр хэдий олноос онцгойрсон боловч эрэгтэй хүнтэй тулалдах тул бас ч гэж дутуу дундуур зүйл тохиолдоно. Байгалиас заяасан энэ дутуу гуцууг яаж ч эс болох тул өөрийн буй болгосон аргын хөнгөн зөөлөн хурдан гавшгай тал дээр гол найдлагаа тавьсан байлаа.

Жу Сян Зюний эхний хэдэн дайралтууд өөрийг нь нилээд балмагдуулсан боловч Жинь Кан Лун энэ байтугайг үзсэн хүн тул арга мэх болгоныг хариулж дөнгөөд байлаа. Жу Сян Зюнь ч гэсэн <<Урин салин унгирлаар наадах>>, <<Хаврын салхин хацар илбэх>> зэрэг дараа дараачийн мэхүүдийг угсруулан хийж Жинь Кан Лунгийн амин цэгийг онилсоор байв. Сян Зюний салхи гүйцэгч 18 илдийн арга угаас хөнгөн гавшгайн дээр Жу Сян Зюний цахилгаан мэт хурдан алхаатай хослон Жинь Кан Лунгийн биеийг мөнгөн могой мэт салахгүй тойрон эргэлдсээр байлаа. Жинь Кан Лун өвгөн урт илдээ сунган хариу довтлох сөгөөгүй гагцхүү хамгаалалтад шүтэн байв.

Жу Сян Зюнь шууд тулалдаан эхлүүт Жинь Кан Лунг сандаргаж эхэлсэнд ялах магадлалтай боллоо гэж И Да Зин сэтгэлдээ ихэд баяртай байлаа. Харин Жу Сян Зюнь багаасаа багшийгаа дагаж зэвсгийн эрдмээр хичээллэсэн тул энэ тал дээр тэс өөр бодолтой байв. Жинь Кан Лун хэдийгээр нилээд сандарч байгаа боловч дайралт болгоныг тогтоон огтхон ч ялагдах шинжгүй байгааг тэр сайтар мэдэж байлаа. Түүний дээр өөрийнх нь дотоод хүч Жинь Кан Лунтай жишихийн аргагүй бага тул энэ мэтээр удаад байвал тун удахгүй ялагдах нь гарцаагүй байлаа. Сян Зюний салхи гүйцэгч 18 илдийн арга уран нарийн арга мэхэнд дулдуйдсан зүйл бөгөөд хэрвээ өрсөлдөгч нь хариу мэхийж алдаа эс гаргалгүй зөвхөн хамгаалаад байвал харин ч өөрийнх нь арга мэхний гэм согог танигдаж ялагдахын эхлэл болж мэдэх талтай байв.

Жу Сян Зюнь хоромхон зуурын төдийд өөрийн салхи гүйцэгч 18 аргын 54 хувирлыг хэрэглэж гүйцээд дахин шинээр нэг нэгээр нь хийж эхлэв. Жинь Кан Лун эхэндээ ийм аргыг огт үзэж байгаагүй тул нилээд сандарч байснаа дахин шинээр хэрэглэж эхлэхийг хараад дотроо сэмээрхэн баярлаж байлаа. Яагаад гэвэл энэ салхи гүйцэгч 18 илдийн арга нь хурдан шаламгай гэж гоц

гойдоос өөр нэг их сүртэй юм түүний хувьд алга байв. Жихүүн салхи тэргүүлэгч цэцгийг тэмтрэх арга мэхийн дараа хүйтэн салхи тэргүүлэгч цэцгээр тоглох арга залгана гэдгийг мэдэж яахин хариулахаа андахгүй болсон тул биеэ гялсхийтэл зайлуулаад Жу Сян Зюньд дөхөн түүний улаан гэрд цэг рүү илдээрээ чичлээ. Өвгөн баатрын ийнхүү омог бардам дайралт түүнд том сургамж болж урт илд нь Жу Сян Зюний улаан гэрд цэгээс хэдхэн ямхын төдий ойр ирэх агшинд Жу Сян Зюнь <<Зуны салхи хүрэлзгэнийг илбэх>> нэртэй уран арга хэрэглэн түүний огт бодоогүй талаас довтлон Жинь Кан Лунгийн мөр лүү чичлээ.

Жинь Кан Лунгийн мөрнөөс цус шүүрэн гарахад түүний нүүр төмөр мэт хүрлийж ирлээ. Мөрөн голын дэг жаягаар өөрөөсөө насаар бага хүнд ийн нэг мэхээр дийлэгдсэн бол илдээ буулган ялагдсанаа хүлээх учиртай боловч энэ удаа байдал түүний хувь заяатай холбоотой тул тэгсэнгүй. Хэрвээ ялагдсанаа хүлээх аваас өөрийнх нь нэгэн үеийн баатар нэр арчигдан өнгөрөхөөс гадна 5 махбодийн бүлгийн тэнгэрт тэрслүү бүлэгтэй хийсэн тулалдаан шийдвэрлэгдэн мөрөн гол даяар дахин мөрөө гарган явах эрхгүй болох байв. Тэр тусмаа хэдэн арван жил зэвсгийн эрдмээр сургуулилсан тэрээр яахин дорой эмэгтэйн гарт ялагдан буух билээ.

Жу Сян Зюнь дахин салхи гүйцэгч 18 илдийн аргаа хэрэглэж эхлэв. Жинь Кан Лунгийн царай эхлээд зэвхий дааж байснаа алгуурхан улаан хүрээнтэй эхлэв. Түүнийг дагалдан илдийнх нь өнгө цасан цагаанаас тас харлаж ирэв. Тэр хамаг биеийн дотоод хүчээ илдэндээ шингээсэн тул ийнхүү өнгө нь хүртэл харласан ажээ. Тийм учраас мөнөөх илд нь хэдэн мянган жин хүнд мэт харагдаж байлаа. Жинь Кан Лун илдээ өргөхөд маш хүнд атлаа хөнгөн зугуухан хөдлөнө. Харин Жу Сян Зюнийн хувьд уул нурж далайн түрлэг довтлон ирэх мэт ер бусын далд хүчин хамаг биеийг нь агдлан амьсгалахуйяа нэн бэрхтэй болж байлаа. Жу Сян Зюнь арагшаа долоо найм ухраад сая биеийн тогтворыг олж <<Ганц гал зуун төмөр>> хэмээх арга байна шүү дээ хэмээн гайхан дуу алдлаа.

Уг нь тэнгэр газрын бүлгийг үндэслэгч Дин И Жао анх төмөр махбодийн бүлгийн хүн байсан бөгөөд хожим бүлгээсээ урван гарч өөрийн бүлгийг байгуулсан билээ. Тэрээр төмөр махбодийн бүлэгт байхдаа хэдэн арван жил тархиа гашилган байж <<Зуун галд ширээгдсэн төмөр>> хэмээх аргыг гаргасан юм. Дараа нь өөрийн бүлгийг байгуулаад түүнийгээ улам боловсронгуй болгож <<Нэг гал зуун төмөр>> хэмээх аргыг буй болгосон бөгөөд хожим тэр нь яван явсаар <<Галгүй алтгүй>> хэмээх арга болон

хувирсан билээ. Энэ тухай Жу Сян Зюнь мэдэж байхад Жинь Кан Лун яахин эс мэдэх билээ. Тиймийн тулд тэрээр хэдэн арван жил чармайн оролдсоор байж Дин И Жаогийн бясалгалын гуравдугаар шат болох <<Нэгэн гал нэгэн төмөр>> хэмээх аргад хүрсэнээ өнөөдөр ийнхүү гаргаж байгаа нь энэ ажээ.

Жинь Кан Лун хүйтнээр инээн <<Нусгай жаал чи бас ч нилээд юм үзэж дуулсан байх нь ээ>> хэмээн хэлэнгээ өөрийн довтолгооноо үргэлжлүүлэв. Түүний энэхүү нэгэн гал нэгэн төмөр хэмээх энэ аргыг өнөө цагийн мөрөн гол даяар дахин хэрэглэж чадах хүн үгүй тул үнэхээр айхтар арга мэх гэдэг нь уншигч танаа бэлээхэн ойлгомжтой бизээ. Жу Сян Зюнийн салхи гүйцэгч 18 илдийн арга ч хэргээ өгөх нь өнгөрч байдал тун хэцүүдэж ирлээ. Байдал бишдсэнийг ойлгосон И Да Зин хулсан лимбээ сугалаад Жинь Кан Лунгийн ар хударгаас дайран орлоо. Жинь Кан Лун урьд нь И Да Зинтэй тулалдаж байсан тул түүний дотоод хүч их гэдгийг мэдэх тул даруй эргэн нэгэн төмөр нэгэн гал хэмээх аргаараа түүн рүү дайрлаа. Жу Ся Зюнийн цээжин дээр дарж байсан дотоод хүчин хөнгөрч ирсэн тул шаламгайлан илдээрээ Жинь өвгөний араас чичлээ. Жинь Кан Лун хоёрын хоёр гаргуун баатрын өөдөөс довтолох хүчин мөхөсдөж арга буюу хамгаалалтад шилжлээ. Түүний дотоод хүчин хэдийгээр хорвоод хосгүй нь үнэн боловч залуу хосын дотоод хүчин нийлэхээрээ юунд ч тогтож торохын эрхгүй байх тул энэ байдлаараа удвал өвгөн баатар Жинь гарцаагүй ялагдах нь тодорхой болж ирлээ. Тэрээр хос залуу баатруудын дайралтыг тогтоон зугуухан аргашаа ухарсаар байлаа. Тэгж явсаар хананд тулвал түүнд дахин ухрах газаргүй болох тул эцсийн хүчээ шавхан өөдөөс халдан ирэх илд лимбэ хоёрыг цавчив. Жу Сян Зюнь И Да Зин хоёр ч өөдөөс нь түүний мянган жингийн хүнд илдийг илд лимбээрээ тосон хаахдаа хүчинд нь автсангүй харин ч дээш сэгхийтэл өргөв. Жинь Кан Лун өвгөний царай байдгаараа барайх нь байдал улам дордсоныг илтгэнэ. Тэр дахин томоор уухайлан хашгирахад цагаан үснийх нь боолт тайлагдан задрахын сацуу хоёр алтан зүү чавхдан харваж Жу Сян Зюн И Да Зин нарын цохыг чиглэв. Энэ бол Жинь Кан Лунгийн эцсийн шийдсэн мэх байлаа. Түүнтэй тэрсэж тэмцэлдэх сайн эр тэр болгон үгүй тул Жинь Кан Лун нууц зэвсэг хэрэглэх завдал төдийлөн гардаггүй байв. Гэхдээ мань өвгөн угаас хашир хэрсүү хүн тул юмыг яаж мэдэх вэ хэмээн цус үзүүт хоолой боодог маш хүчтэй хор үсэндээ нууж явдаг байснаа амь нас хутганы ирэн дээр тулсан энэ цэг мөчид гаргаж байгаа нь энэ байлаа. Тэр гурав хэдхэн тохой зайтайн дээр Жинь Кан Лун байдаг дотоод хүчээ шингээн харвасан тул И Да Зин Жу Сян Зюнь нар яахин амжин зайлж чадах билээ. Гагцхүү нүдээ анин

үхлээ хүлээх л боломж үлдээд байлаа. Гэтэл яг энэ үед гэнэт нэгэн хурдан салхи И Да Зин Жу Сян Зюнь нарыг таван алхам хиртэй түлхэн холдууллаа. Жинь Кан Лун ч гэсэн арагшаа ухран газар лагхийтэл сууж орхилоо. Түүний сацуу их танхимын нурууны зовхисоос нэгэн гивлүүр унжуулсан гэлэнмаа авгай нисэн бууж ирэв.

Мөнөөх гэлэнмаа газар буухын зуур урт ханцуйгаа ороолгон ширвэнгүүт хорт зүүг тогтоон барьсан байлаа. Түүний зэрэгцээ дотод хүчээрээ мөнөөх гурвыг дор бүрнээ холдуулав.

И Да Зин Жу Сян Зюнь хоёр нэгэн зэрэг <<Багшаа>> хэмээн баярлан уулга алдацгаав.

Мөнөөх хүмүүн үнэхээр хүрэн хулсны гэлэнмаа авгай мөн байлаа. Тэр аль эрт танхимын нуруу модноо нуугдаж амжсан бөгөөд Жинь Кан Лун нэгэнтээгүүр И Да Зин Жу Сян Зюнь нараас хамгаалахад хамаг анхаарлаа хандуулсны дээр төмөр махбодийн бүлгийн хайсанд ийнхүү зүрхлэн халдах хүн угаас байдаггүй байсан тул энэ тухай бодоо ч үгүй байсны учир энэ юм.

Жинь Кан Лун эн үед гэнэт <<Ваа>> хэмээн бөөн цусаар гулгилаа. Хүрэн хулсны гэлэнмаа авгай И Да Зин Жу Сян Зюнь хоёрыг ч анзаарах сөгөөгүй шууд түүний зүг очоод өвөр дээрээ толгойг нь түшүүлж <<Хуан Лан, Хуан Лан чи тэдэнтэй ийм удаан тулалдахдаа хэн болохыг нь таньж мэдсэнгүй гэжүү дээ. Би чамайг эдэнтэй тулалдаж байх зуураа тэр жилийн нуурын эрэг мяралзах ус болоод тэнд учирч байсан залуу бүсгүйг эргэн дурсах болов уу гэж найдаж байсан юм. Гэтэл чи эс танихаар барахгүй хорт зүү харваж амийг нь авах гэж байдаг байн шүү. Хуан Лан чи эдний хэн болохыг мэдэхгүй байна гэж үү дээ>> хэмээн үглэж байлаа.

Жинь Кан Лунгийн царай цаас шиг цонхийж <<Би би одоо л тааж мэдлээ. Өнгөрсөн жил Сян Арийн гарал үүслийг мэдэх гэж чиний суурьшин амьдардаг уулын аманд нэг удаа очсон билээ. Тэр үед чи гадагш явчихсан үе таарсан юм. Умар зүгт маш ховор тохиолддог толбот хулсыг хашаа хороондоо тарьсан байхыг үзээд би өөрийн чинь хэн болохыг гадарласан билээ. Сян арь чамтай туйлын төстэй болохыг чинь үзээд би түүний хэн болохыг бас тааж ядан байсан юм. Гэхдээ л би чам дээр очих зүрх хүрээгүй. Сян Ариас учрыг мэдэх гээд чадаагүй юм. Яагаад гэвэл би бүтэн хорин жил хүлээсэн юм шүү дээ. Тэр нэг удаагийн гай барцдаас хойш би хэзээ нэгэн

цагт тэнгэрт тэрслүү бүлгийг дарж 5 махбодийн бүлгүүдийг нэгтгээд мөрөн гол даяар өөрийн ноёрхлыг тогтоохыг мөрөөдөж ирсэн юм. Гэтэл Сян Арь тэнгэрт тэрслүү бүлгийн тэнцүү эрхт элч болчихсон байна гэж яахин төсөөлөх билээ. Би түүнийг алчих боломж цөөнгүй тохиолдож байсан боловч сэтгэлд минь ямар нэгэн дуу <<Чи түүнийг алж болохгүйээ. Яагаад гэвэл тэр бол чиний төрсөн охин шүү дээ>> гэж хэлээд байх шиг санагддаг байсан юм. Тийм болохоор би түүний хэн болохыг мэдэхээс нааш түүнийг хөнөөх зүрх хүрдэггүй байлаа. Тэгсэн атлаа түүнийг эс алваас мөрөн голын тэргүүн зэргийн суудалд залрах хүсэл маань бас л талаар өнгөрөх гээд байсан юм. Эр хүн гэдэг чинь энэ хорвоо дээр энгүй алдраа дуурсган амьдрах учиртай юм. Би энэ хүсэлдээ шатан байж хорин жилийг ардаа орхисон юм шүү дээ. Надад дахин хорин жил хүлээх хугацаа байгаа билүү>>.

Жинь Кан Лунг багштайгаа ийн ярих зуур Жу Сян Зюнь И Да Зин хоёр бүр мангартаж орхив. Гэхдээ тэр хоёр сэтгэлийн мухартаа ямар нэгэн юм там тум мэдрээд байлаа.

Жинь Кан Лун нүдээ бүлтийлгэн тэр хоёрыг хараад тамиргүй болсон гараараа тэр хоёрыг даллан инээвхийлээд <<Сян Арь аа, Зин Арь та хоёр нааш ирэгтүн>> гэлээ. Цаад хоёр нь бие биерүүгээ харан бишүүрхсэн байдалтайгаар Жинь Кан Лунгийн өмнө хүрч очицгоолоо. Жинь Кан Лун тэр хоёрыг татан ойртуулаад <<Танай багш бид дөрөв чинь хамгийн дотно садан төрлүүд байсан байна шүү дээ. Сян Арь аа танай багш чиний төрсөн эх харин би гэж бүтэлгүй өвгөн болвоос чиний аав чинь байгаа юм. Тэнэгхэнүүд минь хурдан сөгдөцгөөхгүй юугаа хийсэн юм бэ>> гэлээ.

И Да Зин Жу Сян Зюнь хоёр хүрэн хулсны гэлэнмаа руу хартал цаадах нь толгой дохилоо. Жинь Кан Лунгийн царайд гэнэт буянтай инээмсэглэл тоорч өгүүлрүүн <<Та хоёр лав итгэхгүй байгаа байх даа. Тэгвэл би та хоёрт ямар учиртайг ярьж өгье>> гэлээ. Жинь Кан Лун нүдээ анивхийлэн аль эрт дээр үеийн түүхийг хүүрнэж эхлэв...

<<Хорин жилийн өмнө би гуч шүргэж явах насандаа төмөр махбодийн бүлгийн тэргүүн зэргийн шавь гэгдэж байсан юм даг. Нэгэн орой багш маань намайг дуудан ирүүлээд тэнгэрт тэрслүү бүлгийн арван таван эн тэнцүү эрхт элч мөрөн гол даяар үзэгдэж эхэлсэн байна. Хорин жилийн турш амар түвшин байсан мөрөн гол дахин бужигнаж эхлэх нь бололтой. Төмөр махбодийн бүлгийн тавдахь үеийн толгойлогч болсон би вээр тэдний хувьд хамгийн заналт дайсан нь байх болно. Чи эрдэм чадал авъяас билгийн

хувьд багшаасаа илт даван гарах нь тодорхой. Алсдаа мөрөн голын тэргүүн зэргийн баатар эр болж чадах нь эргэлзээгүй боловч өдгөөгийн эрдэм чадлаараа тэнгэрт тэрслүү бүлгийн арван таван элчийн өмнө яаж ч чадахгүй. Тийм болохоор би чамайг мөрний өмнөд нутаг руу илгээхээр шийдлээ. Аль болох хол явсан чинь дээр шүү. Тэгээд амьд мэнд үлдсэн хойноо төмөр махбодийн үйл хэргийг үргэлжлүүлж өшөөгөө авах найдлагатай болно гэсэн үг>> гэж хэлсэн юм.

<<Би тэр үед насан бага цусан шингэн байсан болохоор Багшаа халдах дайсантай харгалдан тулалддаг гэсэн үг байдаг бишүү. Тэнгэрт тэрслүү бүлгийн эн тэнцүү арван таван элч нар бүгдээрээ гурван толгойтой зургаан гартай улс байдаг гэдэгт би л хувьдаа итгэхгүй байна. Тэгээд ч манай бүлэгт хэцүү бэрх явдал тохиолдоод байгаа энэ үед би яалаа гэж хаяад явж болох билээ>> хэмээн намайг хэлэхэд манай багш хариуд нь <<Чи тэнгэрт тэрслүү бүлгийнхний хэр зэрэг айхтар гэдгийг яахин мэдэх билээ. Хэрвээ тэдний арван таван эн тэнцүү элчүүд тийм айхтар биш байсансан бол багш чинь дөнгөөд явуулчихаж чадалгүй яах вэ. Багш чинь хүртэл дийлэхгүй байхад чи дэмий амиа үрсэн хэрэг болно биз дээ. Хэрвээ чи надтай цуг үхсүгэй гэж байгаа бол цаашдаа манай бүлгийг мандуулах их хэргийг би чухам хэндээ найдаж даалгах билээ>> гэсэн юм.

<<Товчоор хэлбэл би багшийнхаа захиасын дагуу худалдаачин хүмүүний дүрд хувилан өмнө зүгийг зорин явсаар Дун Тин Ху нуурын эрэг хүрсэн билээ. Нэгэн орой тэнгэрийн тааллаар би хийх ажилгүй уйдагдаа усан онгоцон дээрээ бишгүүр үлээн сарыг таашааж байсан юм. Гэтэл миний лимбийн эгшигт нэгэн бүсгүй хүний дуулах яруу дуун сонсогдлоо. Мэдээжийн хэрэг түүний дуулсан дуу нь Сян Зюнь байж таарна. Би мөнөөх дуулж байгаа бүсгүйг эргийн тэндээс урин онгоцон дээрээ гаргаж ирвээс сарны сүүн цагаан гэгээнд торгон өмсгөл нь туяарч тэнгэрийн дагина газарт буун ирэв үү хэмээн эндүүрмээр сайхан хүүхэн байж билээ>>

Хүрэн хулсны гэлэнмаа <<Нялх балчир хүүхдүүдийн дэргэд нас намбаа алдан шалиг завхай үг хэлэлцнэм бус уу>> гэж инээнгээ нүүрний гивлүүрийг хуу татан авбаас дунд эргэм насны гоо үзэсгэлэн төгөлдөр бүсгүй хүн өмнө зогсож байх нь хальт харсан хүнд яг л Жу Сян Зюнийг өөрийн эрхгүй санагдуулна.

Жинь Кан Лун санаа алдан <<Тэр үед би үнэхээр тэнэг мангуу нь дэндсэн хүн байжээ. Тийм гоо үзэсгэлэн төгөлдөр насны хань учраад байхад мөрөн голын эзэн байтугай хаан ширээнээс татгалзсан ч хамаа алга байхад

багшийн захиасыг санагалзан ээжийн чинь өмнө зэвсгийн эрдэмд төгс төгөлдөр гэдгээ мэдүүлэлгүй байсаар нэгэн жилийг ардаа орхисон юм. Тэгээд нэгэн шөнө салах ёс ч гүйцэтгэлгүйгээр мөрний өмнөд нутгийг орхин төмөр махбодийн бүлгийн гол хайсандаа буцан ирэх үед хорин жилд нэг удаа тохиодог гай барцад өнгөрч амар түвшин үе эхэлсэн байсан юм даг. Харин тэр гай барцад манай 5 махбодийн бүлгийн нэртэй цуутай хүн бүхэн өртөж аймшигтай хохирол учирсан байлаа. Би өөрийн бүлгийг дахин сэргээж хорин жилийн дараа дахин тохиох гай барцдад бэлтгэн зэвсгийн эрдэмдээ шамдан сургуулилсаар Дун Тин Ху нуурын эрэг дээрхи хуучин амрагаа таг мартсан нь энэ юм>>.

Хүрэн хулсны гэлэнмаа гунигтайгаар <<Би чиний овог Хуан умар зүгийн худалдаачин гэдгээс өөр юм мэдэхгүй тул Жу Сян Зюнь гэдэг үйлийн үртэй амьтныг гэдсэндээ тээсээр хойд зүгийг чиглэн зам дагуу асуусаар явсан юм. Тийн явах зуураа Ү Жи Шань уулнаа өөрийн багштай учран бурхны зам мөрийг дагахаар шийдсэн билээ. Тэгээд багшийгаа өөд болсны дараа гарсан үедээ зэвсгийн эрдэм сургах үйлийг эрхэмлэн олон жилийн турш тархиа гашилган бодсоор Сян Зюний салхи гүйцэгч 18 илдийн арга, Толбот хулсны 18 цохилт гэсэн хоёр зэвсгийн эрдмийн үндсэн аргыг үүсгэн буй болгоод охи хүү хоёртоо өвлүүлсэн нь энэ билээ. Хуан Лан минь миний энэ болхи бүдүүлэг арга чамд ямар санагдав даа?>> хэмээн асуулаа.

Жинь Кан Лун <<Хэрвээ би нууц зэвсэг хэрэглээгүй байсан бол аль хэдийн энэ хоёрын зэвсгийн эрдэмд дйлдэн ялагдах байсан юм. Гэхдээ би үхсэн ч гэсэн санаа амар нүд аних байсан даа. Сян Арь, Зин Арь хоёр минь би хэрвээ үхсэн бол өөрийн булшин дээр <<Тэнгэрт тэрслүү бүлгийн толгойлогч мөрөн гол даяарын эзэн Жу Сян Зюний эцэг Жинь Кан Луны булш>> гэж бичүүлвээс насны хүсэл маань гүйцэх байсан юм шүү>> гэлээ.

Эрхэм уншигчидаа мөрөн голын тэргүүн суудлын төлөөх хурц тэмцлийг өгүүлсэн манай зохиол ийнхүү өндөрлөж байна. Тэнгэрт тэрслүү бүлэг болоод мөрөн гол даяарын эзэн суудалд заларсан гоо үзэсгэлэн төгс Жу Сян Зюнь бүсгүй номч баатар И Да Зин нарын хурим урьд хожид үзэгдээгүй сүр дуулиантай болсныг өгүүлэх юун. Нэгэн жилийн дараа тэр хоёроос аавыгаа дуурайсан хөөрхөн эрэгтэй хүүхэд мэндэлсэн нь хожмоо зэвсгийн эрдмийн ертөнцөд аав ээж хоёроосоо ч илүү их хэргийг бүтээж нэр

алдраа хөх сударт хадгалан үлдээх од нь эртнээс гялалзан байх ажгуу. Угаас амар түвшингүй далдын хорон муу үйл явдал, атгаг хорон санаагаар дүүрэн мөрөн голынхны дунд эрэмдэг зэрэмдэг болсон ч өшөө хорслоо авахын уур хилэндээ шатан яваа Хуо Шао Чун, мөрөн голын эзний сууринд санаархсаар явдаг махсаг лам Чэнь Сяо Цо зэрэг есөн шидийн улс байгаа болохоор манай хоёр залуу баатар хосын ирээдүй хэрхнээр эргэхийг яахин тааж мэдэх билээ.Хэрвээ энэ мэтээс үүдсэн шинэ тэмцэл өрнөх аваас манай зохиолын баатрууд уншигч олонтойгоо дахин учрахын ерөөл биелэх ч юм билүү хэн мэдлээ.